

# **БАГАНУУР ДҮҮРГИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ**

**КРИМИНОЛОГИ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**2016 он**

*Энэхүү судалгааны тайланг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх албаны болон эрдэм шинжилгээ, сургалтад зориулав.*

**Гүйцэтгэгч:**

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ЦАГДАА СУДЛАЛЫН ТӨВ  
“ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МОНГОЛЫН САН” ТББ

**Захиалагч:**

БАГАНУУР ДҮҮРГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ  
ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛ БАГАНУУР ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН ХЭЛТЭС

**Тайлбар:** Энэхүү тайланг Багануур дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд 2016 оны 12 дугаар сарын 02-нд, Улаанбаатар хотын цагдаагийн газрын дарга, даргын зөвлөлд мөн сарын 27-нд тус тус танилцуулж, хүлээлгэн өгсөн болно.

**Талархал:**

Багануур дүүргийн ИТХ-ын дэргэдэх ГХУСАЗСЗ, Цагдаагийн хэлтэс болон бусад холбогдох байгууллагын удирдлага, ажилтан, алба хаагчид судалгааны ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажилласанд талархал илэрхийлье.

## **АГУУЛГА**

Товчилсон үгийн тайлбар

### **ӨМНӨХ ҮГ**

### **СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ**

#### **БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА**

- 1.1. Судалгааны ажлын хэрэгцээ, шаардлага
- 1.2. Судалгааны зорилго, зорилт
- 1.3. Судалгааны арга зүй
- 1.4. Судалгааны шинэлэг тал, хязгаарлалт
- 1.5. Тайлангийн бүтэц, агуулга

#### **БҮЛЭГ 2. БАГАНУУР ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

- 2.1. Засаг захиргааны нэгж, нутгаг дэвсгэрийн онцлог
- 2.2. Хүн ам зүйн байдал
- 2.3. Нийгэм, эдийн засгийн байдал
- 2.4. Дүүргийн аюулгүй байдлын асуудал
- 2.5. Дүүргийн хөгжлийн чиг хандлага

#### **БҮЛЭГ 3. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН НӨХЦӨЛ**

- 3.1. Гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ
  - 3.1.1. Иргэдийн гомдол, мэдээллийн урсгал
  - 3.1.2. Гэмт хэрэг, зөрчлийн халдлагад өртөж, хохирсон иргэдээс цагдаагийн байгууллагад хандсан байдал
  - 3.1.3. Гэмт хэргийн хөдөлгөөн
  - 3.1.4. Гэмт хэргийн тархалт
  - 3.1.5. Гэмт явдлын түвшин
  - 3.1.6. Хороодын гэмт хэргийн байдал
  - 3.1.7. Гэмт хэргийн бүтэц
  - 3.1.8. Гэмт хэргийн нийгмийн хор аюул
  - 3.1.9. Прокурорын газрын мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ
  - 3.1.10. Шүүхээс ирүүлсэн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ
  - 3.1.11. Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах талаарх хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн мэдэгдэлд хийсэн дүн шинжилгээ
- 3.2. Зөрчлийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ
- 3.3. Зам тээврийн осол, хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ

#### **БҮЛЭГ 4. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

- 4.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ

- 4.2. Хуулийн байгууллага, хороодоос гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, уялдаа холбоо
- 4.3. Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын дэмжлэг, хамтын ажиллагаа, гадаадын зарим улсын туршлага
- 4.4. Багануур дүүргийн хууль сахиулах, төрийн захиргааны байгууллага, хөрш зэргэлдээх нутаг дэвсгэрийн байгууллагаас ирүүлсэн санал
- 4.5. Багануур дүүргийн олон нийтийн аюулгүй байдлыг хангах асуудал
- 4.6. Жижиг хотуудын хөгжил: аюулгүй байдлыг хангах асуудал

## **БҮЛЭГ 5. САНАЛ АСУУЛГААР АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН**

- 5.1. Дүүргийн оршин суугчдаас авсан санал асуулгын судалгааны үр дүн
  - 5.1.1. Гэмт хэргийн нөхцөл байдлын талаарх иргэдийн төсөөллийн судалгааны дүн
  - 5.1.2. Иргэдийн гэмт хэрэгт хохирох явдлын судалгааны дүн
  - 5.1.3. Иргэдийн цагдаад итгэх хандлагын судалгааны дүн
- 5.2. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдаас санал асуулгын аргаар авсан судалгааны үр дүн
  - 5.2.1. Шүүгч нараас авсан санал асуулгын дүн
  - 5.2.2. Прокурор нараас авсан санал асуулгын дүн
  - 5.2.3. Цагдаагийн алба хаагч нараас авсан санал асуулгын дүн
- 5.3. Хороодын хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан нараас санал асуулгын аргаар авсан судалгааны дүн

## **НЭГДСЭН ДҮГНЭЛТ**

## **САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

### **“БАГАНУУР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ: ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АНХДУГААР ХУРЛААС ГАРСАН ЗӨВЛӨМЖ**

Ашигласан материал

## **ХАВСРАЛТУУД**

1. Статистикийн мэдээлэл
2. Санал асуулгын хуудсууд

## Товчилсон үгийн тайлбар

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага;
АНУ	Америкийн Нэгдсэн Улс;
АТШБ	Авто тээврийн шалган байцаах;
ББМБГУ	Бусдын бие мах бодид гэмтэл учруулах;
БГД	Баянгол дүүрэг;
БЗД	Баянзүрх дүүрэг;
БНД	Багануур дүүрэг;
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
АИХТ	Ардын Их Хурлын Тэргүүлэгчид;
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс;
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс;
БХД	Багахангай дүүрэг;
Га	Гектар (талбайн хэмжүүр);
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх;
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл;
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл;
ГХУСТХ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль;
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль;
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар;
ЗАА	Захирагчийн Ажлын алба;
ЗЦГ	Замын цагдаагийн газар;
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал;
Км	Километр (уртын хэмжүүр);
КомпСтат	Компьютержсэн статистик мэдээ;
М	Метр (уртын хэмжүүр);
МУ	Монгол Улс;
МУИС	Монгол Улсын Их сургууль;
НИТХ	Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал;
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага;
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар;
ОУ	Олон улс;
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо;

СХД	Сонгинохайрхан дүүрэг;
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани;
ТХХАБЖЭГХ	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг;
УБ	Улаанбаатар;
УИХ	Улсын Их хурал;
ҮСХ	Үндэсний статистикийн хороо;
ХЗЯ	Хууль зүйн яам;
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам;
ХУД	Хан-Уул дүүрэг;
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани;
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар;
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар;
ЭАБИ	Эрүүл аюулгүй байдлын индекс;
ЭБША	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа;
ЭМН	Эрүүл мэндийн нэгдэл;
SPSS	Statistical Package for the Social Sciences (Статистик, мэдээлэл боловсруулалтын програм);

## ӨМНӨХ ҮГ

Багануур дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн хэлтсийн санаачилга, захиалгаар “Багануур дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл” сэдэвт криминологи судалгааг Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төв, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Монголын сантай хамтран гүйцэтгэлээ.

Тус дүүргийн иргэдийн аюулгүй байдлын нэгэн хэсэг болсон гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг харьцангуй богино хугацаанд судалгаанд, суурилан зөв тодорхойлон гарсан дүгнэлт, саналыг хөгжлийн бодлого шийдвэртээ тусгахаар зорьж байгаа нь нэн сайшаалтай.

Аливаад урсгалаараа явах, зүг чигээ олж зорихын ялгааг та бид сайн мэднэ. Сэтгэгдэл биш, судалгаанд суурилсан бодлого шийдвэр, үйл ажиллагааг хэвшүүлэхээр биеэ даасан, мэргэжлийн судалгааны байгууллагаар судалгааг хэрэгжүүлэхээр манай байгууллагыг сонгосон Та бүхэнд талархал илэрхийлье.

Бид орчин үеийн нийгмийн шинжлэх ухааны судалгааны зарим аргыг ашиглан гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлтийг нийслэлийн бүсийн болон тогтвортой, ногоон хөгжил, аюулгүй таатай орчныг жигд бүрдүүлэх, дүүргийн ирээдүйн чиг хандлагатай уялдуулан гаргалаа.

Судалгааны тайланд туссан дүгнэлт, санал нь тус дүүргийн хэмжээнд иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг сайжруулахад судалгааны үндэслэл, эх сурвалж болно хэмээн найдаж байна.

Тайланд туссан тоон мэдээлэл, судалгааг холбогдох албан байгууллагаас авсан бөгөөд дүгнэлт, санал нь захиалагч байгууллагын санал, дүгнэлт бус, харин эрдэмтэн, судлаачдын байр суурь гэдгийг харгалзан үзнэ үү.

Судалгааг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн, хамтран ажилласан байгууллага, албан тушаалтан, иргэдэд талархал илэрхийлье!

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ХӨГЖЛИЙН  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ, ХУУЛЬ ЗҮЙН УХААНЫ ДОКТОР (Ph.D),  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА М.ЭРДЭНЭБАЯР

*М.Эрдэнэбаяр*

## **БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ**

1. Багануур дүүрэг нь нутаг дэвсгэрийн хувьд Төв аймгийн Мөнгөнморьт, Баян, Баянжаргалан, Эрдэнэ, Баяндэлгэр, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумдтай хил залгаа оршин байрлахаас гадна Хэнтий, Дорнод, Сүхбаатар чиглэлийн мянганы замын хэвтээ тэнхлэгийн автозамын нэгдсэн сүлжээ, байгалийн, түүхийн, адал явдалт зэрэг олон төрлийн аялал жуулчлалын сүлжээ, малын хөлийн, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний борлуулалт, тээвэрлэлтийн идэвхтэй хөдөлгөөний сүлжээ, цахилгаан-эрчим хүч, үйлдвэрлэл-үйлчилгээ, соёл боловсролын нэгдсэн сүлжээ бүхий байрлалтай бүс болон хөгжих чиг хандлагатай байна. Багануур дүүргийн ирээдүйн төлөв нь хүн ам өссөн, амьдрах таатай бодит нөхцөл бүрдсэн, үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих зах зээлийн нөхцөл, соёл боловсролын үйлчилгээний төвлөрөл, аж ахуйн нэгжийн тоо, аялал жуулчлалын идэвхтэй, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим зэрэг үзүүлэлт жил тутам эрчимтэй өсч байна.

Цаашид их сургуулиудын хотхон ашиглалтад орсноор 17916 өрхийн 66250 хүн, 100.000 оюутан, нийт 166.250 хүн ам бүхий шинэ суурьшлын бүс, хөгжлийн шинэ төв бий болж, улмаар Монгол Улсын боловсрол, шинжлэх ухаан, инновацийн төв болох боломжтой учир “Ирээдүй судлал”-ын ухааны үүднээс бодлого, үйл ажиллагаагаа оновчтой тодорхойлох шаардлага тулгарч байна.

Иймд Багануур дүүрэг нь бие даасан, зүүн бүсийн төв болон хөгжих нь Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулахад чухал ач холбогдолтой гэж Нийслэл, дүүргийн удирдлагууд дэмжиж байгаа ба эхний ээлжид Нийслэлийн алслагдсан Багануур, Налайх дүүргүүдэд дэлхийн хотуудын жишиг дүрмийг туршихаар болсон зэрэг эрх зүйн үндэслэл нь цаашид Багануурт их, дээд сургуулиудын “Оюутны хотхон” тус дүүрэгт байгуулагдсанаар ойрын 20 жилийн дараа 200 орчим мянган хүн амтай Монгол Улсын уул уурхай, оюуны үйлдвэрлэлийн томоохон төв болж өргөжин хөгжих бололцоо бүрдэнэ.

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 мөрийн хөтөлбөрт Багануур дүүрэгт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах шийдвэр гарч, төсөв хөрөнгө 2017 оны төсөвт сууж, энэ ажлын эхлэл тавигдаж байна.

Энэ нь зорилтод болон дамжин өнгөрч байгаа хөдөлгөөний эрчим цаашид ч асар эрчимтэй өсөх хандлага ажиглагдаж байна.

УИХ, Засгийн газар, НИТХ, Дүүргийн ИТХ, Дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, иргэд, оршин суугчдын санаачилга зэрэг бодлого, шийдвэр, үйл ажиллагааны үр дүнд “Их сургуулиудын хотхон”<sup>1</sup>, “Цахилгаан станц”<sup>2</sup>, “Үйлдвэрлэл технологийн парк”, “Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэр” зэрэг төсөл хөтөлбөр бодитой хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан дүүргийн хууль сахиулах байгууллагуудын бүтэц, орон тоо, үйл ажиллагаанд бүтээлч шинэчлэл хэрэгжүүлэх өнөөгийн бодит нөхцөл байдал бий болжээ.

Эдгээр төсөл, хөтөлбөр хэрэгжсэнээр Багануур дүүрэг нь эдийн засгийн хувьд биеэ даасан, ажилгүйдэл ядуурлыг бууруулсан, байгаль орчинд сөрөг нөлөө багатай, орчин үеийн дэвшилтэт технологи дээр суурилагдсан хүнд, хөнгөн үйлдвэрийн хот болон хөгжинө гэж тодорхойлсон байгаа нь гэмт хэрэг, зөрчлийн суурь шалтгаан, нөхцөл, бусад хүчин зүйлсийг арилгахад эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

2. Судалгааны ажлын хүрээнд мэдээлэл цуглуулах, хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор **“Багануур дүүргийн иргэдийн аюулгүй байдал: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам”** сэдэвт онол, практикийн анхдугаар бага хурлыг 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдөр

<sup>1</sup>Төслийн хүрээнд байгаа боловч харьцангуй боломжтой төсөл учир хэрэгжих үндэслэл 85%

<sup>2</sup>Монгол Улс, БНХАУ-н Засгийн газар хоорондын гэрээгээр төсөл хэрэгжиж эхэлсэн бөгөөд бүтээн байгуулалт, ашиглалтын өмнөх, дараах бүх асуудлыг хятадын тал хариуцах бөгөөд 2017 оны эхэнд 800, сүүлчээр 400, нийт 1200 мэргэжилтэн Багануур дүүрэгт гэрээний хугацаанд амьдарч, ажиллах болсон.



“Өргөө” соёлын төвд амжилттай зохион байгуулсан. Уг онол, практикийн хурлын арга хэмжээнд “Тодорхой нутаг дэвсгэр дэх гэмт хэргийг хэмжих арга зүй: Багануур дүүргийн жишээн дээр”, “Аюулгүй амгалан хороо” зэрэг онол, практикийн ач холбогдол бүхий 8 илтгэл хэлэлцүүлж, оролцогчдоос үнэтэй санал, зөвлөмж гарсан. Тус онол, практикийн анхдугаар бага хуралд Улаанбаатар хотын цагдаагийн газар, Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэн, Цагдаагийн сургууль, тус дүүргийн нутгийн захиргаа, хууль сахиулах байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, хөршийн хяналтын бүлгийн төлөөлөл, иргэд, хөрш зэргэлдээ Хэнтий аймаг, Төв аймаг, Баянзүрх дүүрэг, Налайх дүүргийн хууль сахиулах байгууллагын төлөөлөл зэрэг нийт 150 оролцогч хамрагдсан.

3. Энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд судалгааны түгээмэл аргуудыг хэрэглэв. Тухайлбал, тус дүүрэгт оршин суугч иргэдээс санамсаргүй түүврийн аргаар болон цагдаагийн алба хаагч, прокурор, шүүгч нараас санал асуулгын анкетаар судалгаа авч, дүнг SPSS програм ашиглан мэдээллийг нэгтгэн дүнг боловсруулсан. Судалгааны ажлын явцад цугларсан мэдээлэл, судлаачдын таамаглалыг батлах, нотлох үүднээс ажиглалтын аргаар тандалт хийж, нөхцөл байдалд үнэлгээ дүгнэлт хийх зэргээр судалгааны орчин үеийн арга, технологийг өргөнөөр ашигласан нь судалгааны арга зүйн шинэлэг тал байв.

4. Нийслэлийн эрүүл аюулгүй байдлын индексийн 2015 оны шалгуур үзүүлэлтийн түвшинг үзэхэд Багануур дүүрэг 0.8 буюу хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Уг тайланд дурдсанаас аюулгүй байдлын индексийн хувь хүний аюулгүй байдлын хэсэгт 1000 хүнд ногдох гэмт хэргийн тоо /1000 хүнд/ 0.891, 1000 хүнд ногдох зам тээврийн осол гэмтлийн тоо /1000 хүнд/ 0.977, 21-ээс дээш насны 1000 хүнд ногдох архи, согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг цэгийн тоо /1000 хүнд/ 0.929, 1000 хүнд ногдох теле хяналтын камерын тоо /1000 хүнд/ 0.139 үзүүлэлттэй байна.

5. Багануур дүүргийн суурин хүн амын тоо 1990 онд 12.9 мянга байсан бол 2015 онд 28.4 мянга болж, даруй 2.2 дахин өсчөө, түүнийг дагаад аж ахуйн нэгж, үйлдвэр, уурхай олноор байгуулагдаж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, зорчигч иргэдийн хөдөлгөөн төв зам даган ихсэж байна. Үүнийг даган гэмт хэргийн гаралт нэмэгдэх хандлага байна.

6. Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс нь хоногт дунджаар гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослын талаарх 20-30 орчим дуудлага, мэдээлэл хүлээн авч, шалгадаг байна. 2011-2015 онд 39234 гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авч. Жилд дундажаар 7847, хоногт дундажаар 21 гомдол, мэдээлэл хүлээн авч, шалган шийдвэрлэжээ. 2016 оны эхний 10 сард 3516 гомдол мэдээлэл бүртгэн шалгасан нь Улаанбаатар хотын хэмжээнд бүртгэсэн 293974 гомдол мэдээллийн 1.2 хувийг эзэлж байна. 2016 оны эхний 10 сарын байдлаар нийслэлд бүртгэсэн нийт гэмт хэргийн 1.6 хувь нь Багануур дүүрэгт хамаарагдаж байна.

7. Багануур дүүргийн хэмжээнд 10000 хүнд ногдох гэмт хэргийн түвшин 158.1 байгаа нь Багахангай, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн үзүүлэлтүүдээс өндөр, хүн амд ногдох гэмт хэргийн түвшин, эрсдэл өндөр байгааг харуулах үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн тоон үзүүлэлт бага боловч хүн амд ногдох гэмт хэргийн түвшин эрүүгийн нөхцөл байдал хүнд гэгдэх Сонгинохайрхан дүүргээс өндөр байгаа нь анхаарал татсан асуудал гэж үзэж болно.

8. Гэмт хэргийн халдлагад иргэд хохирсон коэффициент Багануур дүүргийн хэмжээнд 16 ба түүнээс дээш насны 10000 хүн амд 165.7 байна. Энэ нь Багахангай, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргээс өндөр байна. Энэ үзүүлэлт 10000 ногдох гэмт хэргийн тархалттай төстэйгээс гадна тухайн дүүргийн гэмт хэрэгт өртөж хохирох эрдслийн түвшинг илэрхийлж буй үзүүлэлт юм.

9. 2011-2015 он, 2016 оны эхний 10 сарын байдлаар Багануур дүүргийн 5 хороонд бүртгэсэн гэмт хэргийн мэдээллийг авч үзвэл 27.1% нь 1-р хороонд, 25.7% нь 3-р хороонд, 21.2% нь 5-р хороонд тус тус үйлдэгдсэн байна. Хамгийн их гэмт хэрэг үйлдэгддэг хороо 1, 3, 5-р хороо байна.

10. Багануур дүүрэгт сүүлийн 25 жилд бүртгэгдсэн нийт 7042 гэмт хэргийн хамгийн их буюу 39.7% нь хулгайлах, 22.2%-г бусдын бие махбодид гэмтэл учруулах, 10.3%-г танхайрах, 4.2%-г тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих хэргүүд эзэлж байна.

11. 2016 оны эхний 10 сарын байдлаар бүртгэгдсэн гэмт хэргийн 37.5% нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, 25.1% нь хулгайлах, 6.0% нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 6.0% нь зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах, 4.4% нь залилан мэхэлж авах хэргүүд эзэлж байна. Түүнчлэн, 2.8% нь хүчиндэх, 2.4% нь орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах хэрэг байна.

12. Багануур дүүрэгт сүүлийн 25 жилийн хугацаанд үйлдэгдэж, бүртгэгдсэн 7042 гэмт хэргийн улмаас 307 хүн нас барж, 2833 хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрээр гэмтэж<sup>3</sup>, 4.5 тэрбум төгрөгийн хохирол учирсаны 1.3 тэрбум төгрөг буюу 29.1 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад нөхөн төлүүлжээ.

13. Багануур дүүрэг дэх 2015 онд бүртгэсэн зөрчил өмнөх оныхоос 41 хувиар өссөн, цаашид өсөх хандлагатай байна.

14. Багануур дүүргийн 2016 оны эхний 10 сарын байдлаар бүртгэсэн зөрчил нь дүүргүүдийн хэмжээнд бүртгэж буй зөрчлийн 6.2 хувийг эзэлж байна. Гэмт хэргийн гаралтын хувьд 1.6% эзэлж байсан бол захиргааны зөрчлийн хувьд өндөр үзүүлэлт байна.

15. Багануур дүүргийн прокуророос гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авах, шалгах ажиллагаанд 2014 онд 1232, 2015 онд 1120, 2016 оны эхний хагас жилд 542<sup>4</sup> гомдол, мэдээлэлд тус тус хяналт тавьсан байна.

16. Нийслэлийн Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр сүүлийн таван жилийн хугацаанд шийдвэрлэгдсэн хэргийг авч үзвэл 2011 онд нийт 79 хэрэг, 2012 онд 82 хэрэг шийдвэрлэгдэж байсан бол 2013 онд 50 буюу өмнөх оноос 39% буурсан байна. Харин 2014 онд 108, 2015 онд 125 хэрэг тус тус шийдвэрлэгдсэн нь тогтмол өссөн үзүүлэлттэй байна.

17. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 190-р зүйлд заасны дагуу гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн мэдэгдлийн хэв, загвар, агуулга нь харилцан адилгүй, нэг мөрдөн байцаагчийн бичсэн мэдэгдэлүүдийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга хэмжээний саналууд хэргийн төрлөөр төстэй байгаагаас үзэхэд мэдэгдэл бичихдээ тухайн нэг гэмт хэргийн онцлогт хамаарах шалтгаан, нөхцөлийг тодорхойлж гаргадаггүй хуулийн шаардлагыг хэрэгжүүлэх төдийхнөөр хандаж байгаа нь харагдаж байна. Түүнчлэн, шалтгаан, нөхцөлд үндэслэсэн арга хэмжээний санал, даалгаварыг өгч байх нь зүйтэй гэж үзсэн.

18. Иргэдийн аюулгүй байдлыг хангах, аюулгүй, тайван амьдрах орчин бүрдсэн эсэх, цагдаад итгэх олон нийтийн хандлагыг хэмжих хэд хэдэн онолын үзэл баримтлал хөгжиж ирсэний хамгийн түгээмэл нь инструментал, эспрессив онолууд юм. Инструментал онол нь иргэдийн аюулгүй тайван амьдрах орчин нөхцөлийг цагдаад бүртгэгдсэн гэмт хэрэг, түүний өсөлт, бууралт, иргэдийн гэмт хэрэгт хохирох явдал, гэмт хэргээс айх түгшүүр зэргээр хэмжигдэнэ гэж үздэг. Эспрессив онол нь иргэдийн аюулгүй байдлыг гэмт хэрэг, гэмт хэрэгт хохирох явдал, халдлагад өртөж болзошгүй гэсэн айдсын мэдрэмжээр

<sup>3</sup>Гэмтлийн зэрэг тогтоолгосон байдлаар

<sup>4</sup>Нийслэлийн прокурорын газрын тоон мэдээллээс.

хэмжих нь учир дутагдалтай гэж үзээд иргэдийн аюулгүй байдлыг орчны нөхцөл, оршин суугчдын хоорондын харилцааны нягтаршил, цагдаад итгэх олон нийтийн хандлага зэрэг өргөн хүрээний ойлголтуудаар тодорхойлдог.

Бид судалгааны ажлын хүрээнд Багануур дүүргийн оршин суугчдын аюулгүй байдлын түвшинг тодорхойлох төсөөллийн судалгааг 2016 оны 7 дугаар сард 14 хоногийн хугацаанд санал асуулгаар дүгнэлт хийсэн. Гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах нь цагдаагийн байгууллагын үндсэн үүрэг бөгөөд иргэдийн цагдаад итгэх хандлага, сэтгэл ханамжийг тодорхойлох хэмжүүр нь цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаагаар тодорхойлогддог. Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллага гэмт хэргийг бүрэн хяналтандаа байлгаж гэмт хэргийн гаралтыг бууруулж чадвал иргэдийн аюулгүй байдал хангагддаг. Иргэдийн аюулгүй байдал хангагдаж, гэмт хэрэгт хохирох явдлын түвшин буурсан тохиолдолд иргэдийн цагдаад итгэх хандлага өсдөг байна. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цагдаа зохион байгуулах чадвартай гэж би итгэдэг” гэсэн асуултанд нийт оролцогчдын 59 буюу 37.7 хувь нь “Нийлнэ”, “Бүрэн нийлнэ” гэж хариулжээ.

Нийт судалгаанд оролцогчдын хариултын өгсөн байдлыг дунджаар орон нутгийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамжийн байдалд тулгуурлан үнэлгээ өгвөл 7.2 хувь нь огт сэтгэл ханамжгүй, 18.3 хувь сэтгэл ханамжгүй, 45.2 хувь нь сэтгэл ханамж дүнд зэрэг, 20.44 хувь сэтгэл ханамжтай, 7.2 хувь сэтгэл ханамж өндөр гэж хариулжээ. Нийт оролцогчдын 25.5 хувь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй байгаагаар илэрхийлсэн бол оролцогчдын 74.5 хувь нь ямар нэгэн хэлбэрээр итгэдэг гэж илэрхийлж байгаа нь дэлхийн болон Монгол Улсын дунджаас дээгүүр үзүүлэлт юм.

АНУ-ын Мичиганы Их сургуулийн профессор Сяо 2012 онд цагдаад итгэх хандлагын судалгааг ардчилал хөгжсөн 50 улсын хүрээнд явуулсан бөгөөд судалгааны үр дүн нь дэлхийн улсуудын цагдаад итгэх хандлага дунджаар 58 хувьтай байна гэж дүгнэсэн. Харин доктор Б.Энхболд 2015 онд Монголчуудын цагдаад итгэх хандлагын судалгааг 1000 иргэний дунд явуулсан бөгөөд судалгааны үр дүн нь Монголчуудын цагдаад итгэх хандлага дунджаар 53 хувьтай байна гэж дүгнэгджээ.

19. Багануур дүүргийн шүүхийн 28 шүүгч, шүүгчийн туслах, бусад ажилтан, 14 прокурор, цагдаагийн 55 алба хаагч, 1, 3, 4 дүгээр хорооны 19 зохион байгуулагч, хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан, бусад ажилтнаас санал асуулгаар судалгаа авч, дүнг нэгтгэв. Эдгээр судалгааны үр дүн нь гэмт хэрэг, зөрчлийн статистик, бидний хийсэн судалгааны бодит үр дүнгүүдтэй нийцэж байв.

20. Багануур хот нь цахилгаан станц, оюутны хотхон, аялал жуулчлалын бүс болж байгаа учир олон улсын эрх зүйн үйлчлэлийн шинж бий болох нөхцөл бүрдэж байна. Ийм учраас Багануур дүүргийг хөгжүүлэх бодлогыг цогц байдлаар тодорхойлох нь зүйтэй.

Хууль бус аливаа үйлдлээс, соёлын шинэ тулгаралтууд бий болох учир стратегийн бодлого боловсруулж, урьдчилан сэргийлэх ёстой. Бий болсон бодит нөхцөл байдал, гадаад болон дотоодын олон соёлын уулзварт орших болсонтой уялдуулан хууль сахиулах байгууллагуудыг өргөтгөх, үйл ажиллагааг нь бэхжүүлэх, бүтэц, орон тоо, мэргэжлийн тусгай бэлтгэлтэй /хэлний, тусгай мэргэжил, орчинд зохицсон чиглэл гэх мэт/ хүний нөөц, үйл ажиллагааны чиглэлд бэлэн байх үүднээс анхан, дунд, дээд шатанд тусгайлан шинжлэх ухаан, амьдралын бодит орчинд тохирсон үндэслэлтэй бодлого боловсруулж ажиллах шаардлагатай гэсэн дүгнэлт, саналууд гарсан.

## **БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА**

### **1.1. Судалгааны ажлын хэрэгцээ, шаардлага**

Нийслэлийн Багануур дүүрэг нь Улаанбаатар хотоос 130 км зайд алслагдсан, 62,000 мянган га/кв.м нутаг дэвсгэртэй, 8462 өрх, 28419 хүн амтай, газар зүйн байрлалын хувьд зүүн аймгуудын зангилаа нутаг, Мянганы замын хэвтээ тэнхлэгийн дагуу байрладаг бөгөөд Хэнтий аймаг, Төв аймгийн 6 сумтай хил залгаа оршдог онцлогтой.

Багануур дүүргийн хэмжээнд 2016 оны эхний 10 сард 3516 гомдол мэдээлэл бүртгэн шалгасан нь Улаанбаатар хотын хэмжээнд бүртгэсэн 293974 гомдол, мэдээллийн 1.2%-ийг эзэлж байна. Бүртгэсэн нийт 3516 гомдол мэдээллийн 548 буюу 15.5 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2968 буюу 84.5% нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна.

Багануур дүүрэгт сүүлийн 25 жилийн хугацаанд бүртгэсэн 7042 гэмт хэргийн улмаас 307 хүн нас барж, 2833 хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрээр гэмтэж<sup>5</sup>, 4.5 тэрбум төгрөгийн хохирол учирсаны 1.3 тэрбум төгрөг буюу 29.1 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад нөхөн төлүүлжээ.

Өөрөөр хэлбэл, энэ тоон үзүүлэлт бол Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт заасан “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах...”, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасан “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалтын хэрэгжилт дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хэмжих үзүүлэлт болно.

Иймд Багануур дүүргийн хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг шинжлэх ухааны үндэстэйгээр судалж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар санал, зөвлөмж боловсруулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тодорхойлох хэрэгцээ, шаардлага байсан тул тус дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн хэлтсээс санаачилга, захиалгаар “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Монголын сан” судалгааны байгууллага, Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төв хамтран гүйцэтгэлээ.

Судалгааны үр дүнд криминологи судалгааг гэрээ, удирдамжид заасан хугацаанд чанартай гүйцэтгэснээр Багануур дүүргийн хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчил, ослыг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлийн ажилд бодитой ахиц гарна гэж төсөөлж байна.

Судалгааны үр дүнд тус дүүргийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал ямар түвшинд байна, түүнээс урьдчилан сэргийлэх ажил хир үр дүнтэй явагдаж байна, цаашид баримтлах бодлого, ямар ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай, ялангуяа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг бүх субъект жигд, үр дүнтэй хэрэгжүүлэх зөвлөмж боловсруулан төр захиргааны байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэх, уламжлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, аж ахуйн нэгж, олон нийтийн оролцоог хэрхэн нэмэгдүүлэх, ингэснээр дүүргийн иргэдийн амар тайван ажиллаж, амьдрах орчинг бүрдүүлэхэд түлхүү чиглэгдэнэ гэдгийг захиалагч байгууллагаас хүсч байсан.

Судалгааны ажлын хүрээнд мэдээлэл цуглуулах, хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор **“Багануур дүүргийн иргэдийн аюулгүй байдал: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам”** сэдэвт онол, практикийн анхдугаар бага хурлыг 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдөр “Өргөө” соёлын төвд амжилттай зохион байгуулсан.

<sup>5</sup>Гэмтлийн зэрэг тогтоолгосон байдлаар

Уг онол, практикийн бага хурлын арга хэмжээнд “Тодорхой нутаг дэвсгэр дэх гэмт хэргийг хэмжих арга зүй: Багануур дүүргийн жишээн дээр”, “Аюулгүй амгалан хороо” зэрэг онол, практикийн ач холбогдол бүхий 8 илтгэл хэлэлцүүлж, оролцогчдоос үнэтэй санал, зөвлөмж гарсан.

Тус онол, практикийн анхдугаар бага хуралд Улаанбаатар хотын цагдаагийн газар, Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэн, Цагдаагийн сургууль, тус дүүргийн нутгийн захиргаа, хууль сахиулах байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, хөршийн хяналтын бүлгийн төлөөлөл, иргэд, хөрш зэргэлдээ Хэнтий аймаг, Төв аймаг, Баянзүрх дүүрэг, Налайх дүүргийн хууль сахиулах байгууллагын төлөөлөл зэрэг нийт 150 оролцогч хамрагдсан.

Онол, практикийн анхдугаар бага хурлаас тус дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, уг ажилд төр захиргаа, хууль сахиулах байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулах, тэдний хамтын ажиллагааг сайжруулах, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 126 дугаар тогтоолоор батлагдсан “Хөршийн хяналт хөтөлбөр”, кримнологи судалгааны үр дүнг ажил хэрэг болгох зорилгоор 11 чиглэлээр зөвлөмж гаргасныг судалгааны тайлангийн зөвлөмж хэсэгт оруулав.

## **1.2. Судалгааны зорилго, зорилт**

**Зорилго:** Багануур дүүргийн хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судалж, түүнээс урьдчилан сэргийлэх санал, зөвлөмж бүхий судалгааны тайлан боловсруулах, судалгааны явцад зохион байгуулагдах онол, практикийн хурлын үйл ажиллагаанд судалгааны үр дүнг танилцуулахад оршино.

### **Зорилт:**

1. Багануур дүүргийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах, үйлдэгдсэн байдалд дүн шинжилгээ хийж, чиг хандлагыг тодорхойлох;
2. Зам тээврийн гэмт хэрэг, зөрчил, ослын байдалд дүн шинжилгээ хийх;
3. Багануур дүүргийн нийгэм, хүн ам зүйн үзүүлэлттэй гэмт хэргийн тоон үзүүлэлтийг харьцуулж, мөн бусад дүүргийн нөхцөл байдалтай харьцуулж, бодит байдлыг тодорхойлох;
4. Багануур дүүргийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх;
5. Цагдаагийн хэлтсийн албад, нэгжийн үйл ажиллагаа, шүүгч, прокурор, прокурор, шүүхийн байгууллагын ажилтнуудаас санал асуулгаар судалгаа авч, дүн шинжилгээ хийх;
6. Судалгааны ажлын явцад анкетаар судалгаа авах болон ярилцлага хийх, газар дээр нь ажиглалт хийх;
7. Зохион байгуулагдах онол, практикийн хурлын зохион байгуулалтад зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
8. Санал, зөвлөмжийг тусгасан судалгааны тайлан боловсруулан, захиалагчид хүлээлгэж өгөх.

## **1.3. Судалгааны арга зүй**

Энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд судалгааны зарим түгээмэл аргыг хэрэглэв. Тухайлбал, тус дүүрэгт оршин суугч иргэдээс санамсаргүй түүврийн аргаар болон цагдаагийн алба хаагч, прокурор, шүүгч нараас санал асуулгын анкетаар судалгаа авч, дүнг SPSS програм ашиглан мэдээллийг нэгтгэн үр дүнг боловсруулав.

Багануур дүүргийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн бодлого, үйл ажиллагаанд харьцуулалт хийх, нэгтгэн дүгнэх, холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийх, инструментал, эспрессив онолын арга зүйг ашиглалаа.

Багануур дүүргийн нутаг дэвсгэрт аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, илрүүлэх талаар хороодын Засаг дарга, нутгийн захиргааны байгууллага, хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагуудаас албан бичгээр санал авч, дүнг нэгтгэн боловсруулалт хийлээ.

Иргэдийн аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагын зарим мэргэжилтэн, алба хаагч нартай ганцаарчилсан болон фокус ярилцлага хийж, судалгааны үр дүнд боловсруулалт хийж ажиллав.

Түүнчлэн, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын бичсэн мэдэгдэлд дүн шинжилгээ хийв.

Судалгааг хийхдээ цугларсан мэдээлэл, судлаачдын таамаглалыг батлах, нотлох үүднээс ажиглалтын аргаар тандалт хийж, нөхцөл байдалд үнэлгээ дүгнэлт хийх, дискрептив анализ зэргээр судалгааны орчин үеийн арга, технологийг өргөнөөр ашиглав.

#### **Судалгааны хугацаа:**

Судалгааг 2016 оны 07-11 сар хүртэлх, 5 сарын хугацаанд гүйцэтгэв.

#### **Гүйцэтгэгч:**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Монголын сан, Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн хамтарсан судалгааны багаар гүйцэтгэж, судалгааны ажлын хүрээнд зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлын бэлтгэл ажил, зохион байгуулалтад мэргэжэл, арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Судалгааны багт хууль зүйн ухааны доктор (Ph.D) Б.Энхболд, хууль зүйн болон математикийн магистр Б.Мөнхдорж, хууль зүйн магистр Л.Цогтбаяр, Д.Сумъяацэрэн, Б.Мөнхсэргэлэн, О.Уулзахжаргал, зөвлөхөөр хууль зүйн ухааны доктор (Ph.D) М.Эрдэнэбаяр, хууль зүйн магистр Г.Оюунболд нар ажилласан болно.

Багануур дүүргийн ИТХ-ын дэргэдэх ГХУСАЗСЗ, Цагдаагийн хэлтэс болон бусад холбогдох байгууллагын удирдлага, ажилтан, алба хаагчид судалгааны ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажилласанд талархал илэрхийлье.

#### **Санхүүжилт**

Энэхүү судалгааны ажлыг Багануур дүүргийн ГХУСАЗСЗ-ийн санхүүжилтээр гүйцэтгэв.

### **Судалгаа явуулахад баримталсан зарчим**

Судалгааг аливаа улс төрийн байгууллага, албан тушаалтны бодлого, нөлөөллөөс ангид бие даасан байдлаар, шинжлэх ухааны арга зүйг ашиглан, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмыг баримтлав.

#### **1.4. Судалгааны хязгаарлалт, шинэлэг тал**

##### **Судалгааны хязгаарлалт:**

Судалгааны ажлын хамрах хүрээ, цаг хугацаа нь Багануур дүүргийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэргийн хөдөлгөөнийг гаргахын тулд сүүлийн 25 жилийн статистикийн

мэдээлэл, судалгааг ашигласан ба судалгааны зарим хэсэгт нөхцөл байдлыг тодруулах үүднээс сүүлийн 5 жил, 2016 оны эхний 10 сарын байдлаар гарсан мэдээллийг ашиглав.

Нөхцөл байдлын судалгааг тухайн үеийн цаг хугацаагаар тооцоолсон бөгөөд судалгааны хамрах хүрээ Багануур дүүргийн хэмжээнд явагдав.

Монгол Улс, түүнээс нийслэл, дүүргүүдийн нутаг дэвсгэрт сүүлийн 5 жилд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол төдийгүй өргөдөл, гомдол, мэдээллийн бүртгэл, шийдвэрлэлтийг авч үзэн Багануур дүүргийн хэмжээнд үйлдэгдэж болзошгүй гэмт хэргийн хандлага, прогнозыг дүгнэв.

Түүнчлэн, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах төв байгууллагын статистик мэдээлэл, үйл ажиллагаанаас гадна нийслэлийн төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар дүн шинжилгээ хийв. Гэмт явдалтай тэмцэх асуудалтай холбоотойгоор зарим эрдэмтэн судлаач, мэргэжлийн хүмүүстэй уулзаж, ярилцлага хийв.

Судалгааны ажлын хязгаарлалтыг Багануур дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол, хэргийн хүрээнд тогтоож, аюулгүй байдлыг хангах асуудлыг товчхон дурдсан болно.

#### **Судалгааны шинэлэг тал:**

Судалгааны ажлын хүрээнд боловсруулсан санал, зөвлөмж нь Багануур дүүргийн хэмжээнд иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад чиглэсэн баримт бичиг болгон ашиглах бүрэн боломжтой;

Иргэдийн аюулгүй байдлыг хангах, аюулгүй, тайван амьдрах орчин бүрдсэн эсэх, цагдаад итгэх олон нийтийн хандлагыг тодорхойлохдоо инструментал, болон эспрессив онолын үзэл баримтлалд тулгуурлан хийсэн;

Дүүргийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах, цаашид нийслэл, бусад дүүрэг, аймгийн ГХУСАЗСЗ-үүдэд жишиг туршлага болоход судлагааны шинэлэг тал тодорхойлогдоно.

#### **1.5. Тайлангийн бүтэц, агуулга**

Энэ судалгааны тайлан нь Өмнөх үг, Судалгааны хураангуй, 5 бүлэг, дүгнэлт, санал, зөвлөмж, ашигласан материал, хавсралт хэсгээс бүрдэнэ.

## **БҮЛЭГ 2. БАГАНУУР ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

### **2.1. ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ, НУТАГ ДЭВСГЭРИЙН ОНЦЛОГ**

Багануур дүүрэг анх БНМАУ-ын АИХТ-ийн 1980 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 43 дугаар зарлигаар Улаанбаатар хотын Багануур район нэртэй байгуулагдсан бол одоо Улаанбаатар хотын Багануур дүүрэг статустайгаар нийслэлийн алслагдсан засаг захиргааны томоохон нэгж болон хөгжиж байна.

Багануур нь засаг захиргааны хувьд Монгол Улсын нийслэлийн 9 дүүргийн нэг бөгөөд тус дүүргийн нутаг дэвсгэрт Багануур хот оршино.

Нийслэлийн Багануур дүүргийн “Багануур хот” нь Улаанбаатар хотоос зүүн тийш 130 км зайд, өвөг дээдсийн өлгий нутаг Хан Хэнтийн нуруунаас эх авсан Хэрлэн голын сав газар дагуу 14 км сунасан байрлалтай.

Багануур дүүрэг нь газар зүйн байршлын хувьд зүүн аймгуудын авто зам, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн эдэлбэр газар, мал аж ахуйн бэлчээрийн зангилаа нутаг төдийгүй автозамын хэвтээ тэнхлэг дүүргийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрдөг.

Тус дүүрэг нь Засаг захиргааны 5 хороотой бөгөөд хил залгаа Хэнтий аймаг, Төв аймгийн 6 сумтай залгаа, хүн ам, үйлдвэрлэл үйлчилгээ, эрүүл мэнд, соёл боловсролын хувьд нэгдмэл шинжтэй зэрэгцэн оршдог.

Багануур дүүрэг нь Монгол орны үзэсгэлэнт байгаль, ой мод, уул нуруу, гол горхи, ан амьтан, ургамал, түүх соёлын дурсгалын арвин баялагтай, Их Монгол Улсын Их хаадын алтан ургийн өлгий болсон голомт нутаг гэж үздэг. Энэ үүднээсээ байгалийн арвин баялаг, түүхийн арвин өв, соёл, уламжлал хадгалагдан байдаг учир сүүлийн жилүүдэд гадаад, дотоодын аялал жуулчлал эрчимтэй хөгжихийн зэрэгцээ үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ тасралтгүй нэмэгдэн бүсийн тулгуур болж хөгжиж байна.

Багануур дүүрэг нь нийт 62.0 мянган га нутаг дэвсгэртэйгээс 41.6 мянган га нь хөдөө аж ахуй, 19.4 мянган га нь хот суурины, 472.2 га нь зам, шугам сүлжээний, 14.26 га нь улсын тусгай хэрэгцээний, 541.6 га нь ойн болон усны сан бүхий газар нутаг эзэлдэг<sup>6</sup>.

Улсын төсөвт байгууллага 36, төрийн бус байгууллага 95, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 5, хувьцаат компани 5, хязгаарлагдмал хариуцлагатай компани 332, бусад хэвшлийн 104 аж ахуйн нэгжид 9223 иргэн хөдөлмөр эрхэлж байгаа нь 2010 оноос хойш нийт дүнгээр 3 дахин өссөн, УИХ<sup>7</sup>, Засгийн газар<sup>8</sup>, НИТХ, Засаг даргын үйл ажиллагааны бодлого, үйл ажиллагаа, гадаад хамтын ажиллагааны идэвхийн үр дүн, дүүргийн ИТХ, Засаг даргын зүгээс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнд цаашид тасралтгүй өсөх хандлага ажиглагдаж байна.

### **2.2. ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ**

Багануур дүүрэг нь 2015 онд жилийн эцсийн байдлаар 8462 өрхтэй, суурин хүн ам нь 28419 байна. Суурин хүн амыг хороодоор нь ангилан үзвэл хамгийн их буюу 30% нь 1-р хороонд, хамгийн бага буюу 2% нь 2-р хороонд оршин суудаг.<sup>9</sup>

График 1. Багануур дүүргийн суурин хүн ам (хороодоор, 2015)


<sup>6</sup>ҮСХ-ны 2014 оны тайлан, [www.statistic.mn](http://www.statistic.mn)

<sup>7</sup>“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага” баримт бичгийг УИХ-н 2013 оны 02 сарын 8-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан.

<sup>8</sup>Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 149, 2011 оны 367 дугаартай тогтоол, Засгийн газрын 2014 оны 06 сарын 21-ний өдрийн хуралдааны тэмдэглэл.


<sup>9</sup> Багануур дүүргийн Статистикийн албаны мэдээллээр.





Суурин хүн амын тоо нь 2015 оныг 2006 онтой харьцуулахад 10.8 хувиар буюу жилд дунджаар 310 хүнээр тасралтгүй өсөн нэмэгджээ.

График 2. Багануур дүүргийн суурин хүн ам (2006-2015)



Хүн амын 30.7 хувь нь 0-16 насны хүүхэд, 8.8 хувь нь 55-аас дээш насны өндөр настан байгаа бол 60.4 хувь нь хөдөлмөрийн насны хүн ам байна.

Нийт өрхийн 40.4 хувь буюу 3427 өрх байшин хороололд, 59.6 хувь буюу 4714 өрх гэр хороололд амьдардаг. Үүнээс гэр хороололд амьдарч буй хүмүүсээс 28 өрхийн 82 хүн орон гэргүй амьдарч байна.

Бидний авсан мэдээллээр 2014 онд 1139 хүн шилжиж ирсэн бол 1365 хүн шилжин явсан, бүртгэлтэй ажилгүйчүүд 418 байна.

Төрийн болон хувийн өмчийн ерөнхий боловсролын 4 сургуульд 5149 хүүхэд суралцаж, сургуулийн өмнөх боловсролын 5 цэцэрлэгт 2031 хүүхэд хүмүүжиж байгаагаас хувилбарт сургалтын 3 бүлэгт, нийт 1987 хүүхэд суралцаж байна. Өнөөгийн байдлаар 480 хүүхдийн 3 цэцэрлэг шинээр баригдаж ашиглалтанд хүлээлгэн өгсөнөөр нийт 4400 гаруй хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын асуудлыг шийдвэрлэх бололцоо бий болжээ.

Хэдийгээр бүртгэлтэй хүн ам 28.4 мянга байгаа ч хил залгаа сум, суурин газрын хүн амын болон амралт, сувилалын үйл ажиллагаа эрхлэдэг аж ахуйн нэгж, уурхайн, үйлдвэр үйлчилгээний зэрэг салбарт түр болон удаан хугацаагаар оршин сууж байгаа ажилчдын

механик өсөлт жил тутам эрчимтэй өсч, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 8924 орхийн 31830 орчим хүн ам<sup>10</sup> байна гэсэн албан бус судалгаа гарсан байна.

Хил залгаа сумдын хүн ам нь 2015 оны байдлаар Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Мөнгөнморьт, Баяндэлгэр, Архуст, Баянжаргалан сумдын хүн ам 15 мянга орчим байнгын оршин суугч байна<sup>11</sup>. Багануур дүүрэг нь нутаг дэвсгэрийн хувьд Төв аймаг, Хэнтий аймгийн 6 сумдтай хил залгаа оршин байрлахаас гадна Хэнтий, Дорнод, Сүхбаатар чиглэлийн мянганы замын хэвтээ тэнхлэгийн автозамын нэгдсэн сүлжээ, байгалийн, түүхийн, адал явдалт зэрэг олон төрлийн аялал жуулчлалын сүлжээ, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний борлуулалт, тээвэрлэлтийн идэвхтэй хөдөлгөөний сүлжээ, цахилгаан-эрчим хүч, үйлдвэрлэл-үйлчилгээ, соёл боловсролын нэгдсэн сүлжээ бүхий байрлалтай бүс болон хөгжих чиг хандлагатай.

Багануур дүүрэг нь суурин хүн амаас гадна албан бус бүртгэлтэй оршин суугч ихтэй учир зүүн бүсийн аймаг, сумдын иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн асар ихтэй байдаг.

### 2.3. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

#### **Эдийн засгийн хөгжил:**

Багануур дүүргийн бүс нутгийн эдийн засаг төдийгүй Улаанбаатар хотын эдийн засаг, үйлдвэрлэл, цахилгаан эрчим хүч, дулаан хангамжийн салбарт гүйцэтгэж байгаа үүрэг, ач холбогдол нь улам бүр өссөөр байна.

Багануур дүүрэг нь тухайн бүс нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, соёл, боловсрол, зам харилцаа, санхүүгийн үйлчилгээ, шуудан харилцаа холбоо, эрүүл мэндийн үйлчилгээг дангаараа хангахаас гадна ихээхэн төвлөрөл бий болгон орших болжээ.

Тухайн бүс нутаг дахь эдийн засаг, харилцаа холбоо, соёл, зам харилцааны талаас илүү хувийн эргэлт Багануур дүүрэгт явагддаг хэдий ч засаг захиргааны үйлчилгээ, хангамжийг бие даан санхүүжүүлэх, бодлого хэрэгжүүлэх бололцоо хязгаарлагдмал байдаг нь ажиглагдлаа.

Багануур дүүрэг нь жилд 10 тэрбум гаруй төгрөгний төсөв төвлөрүүлж байгаагаас улсад 4.1 тэрбум, нийслэлд 5.4 тэрбумын татвар төлж, дүүрэг өөрөө 0.8 тэрбумын татварын орлого төвлөрүүлж байна. Учир нь бие даасан хотын статус байхгүй учир орлогоо алдаж байна гэсэн үг.

Багануур дүүргийг Нийслэлийн дагуул хот болгох тухай асуудлыг “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр”-т тусгасан бөгөөд 2015 онд оршин суугчдын санал асуулгаар 95 гаруй хувь нь бие даасан байдлыг дэмжсэн тул ойрын ирээдүйд хэрэгжих эдийн засаг, соёл боловсрол, зам харилцаа, эрүүл мэнд, аюулгүй байдлын үзэл баримтлалаа шинэчлэх бодлогын судалгаа, шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх, бодлого боловсруулах шаардлагатай болсон гэж үзэж байна.

Өөрөөр хэлбэл, тус дүүргийн хөгжлийн бодлогын системийн анализ (system analysis) хийх байдлаар хөгжлийн загвар гаргах нь зүйтэй.

#### **Мал аж ахуйн хөгжил:**

Одоогоос 30 жилийн өмнө буюу 1986 оноос хойш хөдөөгийн хүн амын 80 хувь нь мал маллан амьдарч байсан малчид өнөө цагт цагийн ажил, сүү цагаан идээ, малын гаралтай түүхий эдийн борлуулалт зэрэг олон төрлийн ажил хөдөлмөр эрхлэх нь түгээмэл

<sup>10</sup>Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсийн 2016 оны хагас жилийн тайлан.

<sup>11</sup>Хүн ам, орон сууцны тооллогын мэдээ, 2015 он.


үзэгдэл болсон. Өнөөдөр Монгол Улсад 294 мянган малчин өрх 55 сая 957.6 мянган толгой<sup>12</sup> мал маллаж байгаагаас нийт өрхийн 24.8 хувь нь амжиргааны хувьд ядуу, ойролцоогоор 200 хүртэл малтай гэсэн судалгаа гарсан.

Багануур дүүргийн 2015 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр мал сүргийн тоо 154983 толгойд хүрч, өнгөрсөн оныхоос 5860 толгой малаар буюу 3.9 хувиар өссөн.

Хүснэгт 1. Багануур дүүргийн мал (төрлөөр)


Малын тоо, төрлөөр	2012 он	2013 он	2014 он	2015 он
Тэмээ	100	97	110	93
Адуу	7142	9336	10937	11665
Үхэр	6937	8617	11091	12319
Хонь	58178	64746	77437	80103
Ямаа	37082	40170	49548	50693
<b>Нийт мал</b>	<b>109439</b>	<b>122966</b>	<b>149123</b>	<b>154983</b>

График 2. Багануур дүүргийн мал (2006-2015)



2015 оны мал тооллогоор хувийн малтай 675 өрх, үүнээс 333 өрх мал аж ахуй эрхэлж байна. Өөрөөр хэлбэл, тус дүүргийн нийт өрхийн 8% нь малчин өрх байна.


График 3. Нийт мал бүхий өрх (хороогоор)



2015 оны байдлаар хувийн малтай 675 өрх байгаа нь өнгөрсөн 2014 оны мөн үеэс 34 өрх буюу 5.3 хувиар өссөн ба, мал аж ахуй эрхэлж, малын ашиг шимийг амьжиргааны эх үүсвэрээ болгон амьдарч байгаа малчин өрх 333 байгаа нь өнгөрсөн оноос 10 өрх буюу 2.9 хувиар буурсан байна.

<sup>12</sup> Үндэсний статистикийн хорооноос “Мал тооллогын 2015 оны урьдчилсан дүн”, 2015 оны 12 дугаар сар.

График 4. Нийт малчин өрх (хороогоор)



Энэ жилийн малын өсөлтөд бэлэн тоологдсон төлийн өсөлт, худалдаж авсан болон шилжиж ирсэн малчин өрхийн малын өсөлт, төллөх насны хээлтэгч малын өсөлт зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн гэж дүгнэж болно.

### Эрүүл мэнд

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний салбарт 147 ортой Эрүүл мэндийн нэгдэл, өрхийн эрүүл мэндийн 4 төв, хувийн хэвшлийн эмнэлэг 7, эмийн сан 5, иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг 3 салбараар үйлчилж байна. Багануур дүүрэг нь өөрийн бүртгэлтэй өрхийн хүн амын эрүүл мэндийн бүх тусламж, үйлчилгээнээс гадна хил залгаа сумдын болон дамжин өнгөрч байгаа иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг өргөн хүрээнд хэрэгжүүлдэг бүс нутаг.

Энэ үүднээс үзэхэд нийт 10 гаруй мянган хүнд эмнэлгийн анхан болон дараагийн шатны үйлчилгээг цаг алдалгүй хүргэж байна.

### Боловсрол

Төрийн болон хувийн өмчийн ерөнхий боловсролын 4 сургуульд 5149 хүүхэд суралцаж, сургуулийн өмнөх боловсролыг 5 цэцэрлэгт 2031 хүүхэд хүмүүжиж байгаагаас хувилбарт сургалтын 3 бүлэгт нийт 1987 хүүхэд суралцаж байна.

Өнөөгийн байдлаар 480 хүүхдийн 3 цэцэрлэг шинээр баригдаж ашиглалтанд оруулсанаар нийт 4400 гаруй хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын асуудлыг бүрэн шийдвэрлэх нөхцөл бүрдсэн.

## 2.4. БАГАНУУР ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ

### Эрүүл аюулгүй байдлын индексийн үзүүлэлт

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас “Эрүүл аюулгүй байдлын индекс тооцох аргачлал”-ын 2 дахь хэвлэлтийг сайжруулан 2014 онд гаргасан байдаг. Эрүүл аюулгүй байдлын индекс нь Нийслэлийн оршин суугч иргэдийн эрүүл, аюулгүй, ээлтэй орчинд амьдрах нөхцөлийг бүх талаар бүрдүүлэхэд дүүрэг, хороо, иргэд, олон нийтийн зүгээс эрүүл аюулгүй байдлыг хэрхэн хангаж буйг илэрхийлэх нийлмэл үзүүлэлт юм. Нийслэлийн хэмжээнд ЭАБИ-ийг эрүүл аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн бодлого боловсруулах, шийдвэр гаргахад үндсэн баримт бичиг болгон ашигладаг.

Нийслэлийн Засаг даргын Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан орлогчийн 2014 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн “Эрүүл аюулгүй байдлын индекс тооцох аргачлал”-ыг хэрэгжүүлэх тухай А/658 дугаар захирамжаар Нийслэлийн Эдийн засаг, нийгмийн жил бүрийн зорилтыг Эрүүл аюулгүй байдлын индексийн хариу арга хэмжээний

төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөж иргэдийн ажиллаж, амьдрах эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх, Нийслэл, дүүргийн Эрүүл аюулгүй байдлын индексийн 2012 оны суурь үзүүлэлтүүдийг сайжруулахад чиглэсэн тодорхой ажил зохион байгуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газрын дарга нарт үүрэг болгожээ.

Нийслэлийн эрүүл аюулгүй байдлын индексийн 2015 оны шалгуур үзүүлэлтийн түвшинг<sup>13</sup> үзэхэд Багануур дүүрэг 0.8 буюу хамгийн өндөр үзүүлэлттэй байна. (Зураг.1)


Тайлбар: Эрүүл аюулгүй байдлын индексийн ололт амжилтын түвшинг өнгөөр ялгана.

■ - Үйл явц сайн дүүрэг ■ - Үйл явц дунд зэрэг дүүрэг ■ - Үйл явц муу дүүрэг ■ - Мэдээлэл байхгүй  
 ■ ■ Ногоон байгууламжийн мэдээлэл газрын зураг дээр харуулах

Багануур	Багахангай	Баянгол	Баянзүрх	Налайх	Сонгинохайрхан	Сүхбаатар	Хан-Уул	Чингэлтэй	НИЙСЛЭЛИЙН дундаж
0.8	0.25	0.06	0.04	0.28	0.06	0.06	0.25	0.04	0.04

Сонгоно уу

- Нийслэл
- Багануур дүүрэг
- Багахангай дүүрэг
- Баянгол дүүрэг
- Баянзүрх дүүрэг
- Налайх дүүрэг
- Сонгинохайрхан дүүрэг
- Сүхбаатар дүүрэг
- Хан-Уул дүүрэг
- Чингэлтэй дүүрэг



Уг тайланд дурдсанаар аюулгүй байдлын индексийн хувь хүний аюулгүй байдлын хэсэгт 1000 хүнд ногдох гэмт хэргийн тоо /1000 хүнд/ 0.891, 1000 хүнд ногдох зам тээврийн осол гэмтлийн тоо /1000 хүнд/ 0.977, 21-с дээш насны 1000 хүнд ногдох архи, согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг цэгийн тоо /1000 хүнд/ 0.929, 1000 хүнд ногдох теле хяналтын камерын тоо /1000 хүнд/ 0.139 үзүүлэлттэй байна. Мөн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн нэг үзүүлэлт болох амьжиргааны зохистой түвшин хэсэгт хөдөлмөр эрхлэлтийн түвшин 0.001 үзүүлэлттэй байгаа нь хөдөлмөр эрхлэх үйл явц муу байгааг харуулж байна.

### Аюулгүй амгалан Багануур хот

Багануур дүүргийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлсэн мөрийн хөтөлбөрт “хотын иргэдийн санаачилга, хүсэл зорилго, засаг захиргааны бодлого зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Багануур дүүрэг нийслэлийн засаг захиргааны дагуул “**Хот**” болон хөгжих, засаг захиргааны үйл хэрэгт шууд оролцох эрх, орон нутгийнхаа амьдрал, нийгмийн баялгийн хуваарилалт, нийтийн эрх ашгийг хөндсөн аливаа асуудал, орон нутгийн төсвийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилтийг иргэдийн шууд оролцоотойгоор шийдвэрлэн, төрийн үйл ажиллагааг хянах эрхийг баталгаатай эдлэх нөхцөлийг хангасан нийтийн албатай, авлигагүй, шууд ардчилал-иргэний оролцооны загвар хот болж хөгжих, нийтийн аюулгүй байдлыг хангах бодлогыг тэргүүлэх зорилт болгон хэрэгжүүлснээр эрүүл аюулгүй амгалан орчинд амьдрах жишиг хот болон хөгжинө” гэж тусгасан.

#### Дээрх мөрийн хөтөлбөрт:

#### Хотын аюулгүй байдлыг ханган, хэв журмыг сахиулах хүрээнд:

1. Архи, тамхи худалдан борлуулахад тавих хяналтыг чангатгаж, тэдгээрийн хэрэглээг үл тэвчих орчин ба соёлыг төлөвшүүлэн архи согтууруулах ундаа хэрэглэдэггүй,

<sup>13</sup> <http://eabi.ub.gov.mn/report.php?action=cityReport>

эрүүл идэвхтэй амьдралын төлөөх клуб, холбоо байгуулах иргэдийн санаачлагыг бодлогоор дэмжих,

2. Гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд гардаг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, “хөршийн хамгаалалт” иргэдэд суурилсан амгалан тайван байдлын тогтолцоо бүрдүүлэх,

3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг сайжруулж, гамшгаас хамгаалахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх,

#### **Иргэндээ ээлтэй эрүүл, аюулгүй, тохилог орчин бүрдүүлэх хүрээнд:**

1. Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, явган зам, нийтийн үйлчилгээний газрууд, гэр хороололд гэрэлтүүлэг, аюулгүй байдлын хяналтын сүлжээ бий болгох,

2. Тусгай зориулалтын зам, шат, хаалга, бие засах газрууд байгуулах ажлыг дэмжиж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нийгмийн үйлчилгээг нэмэгдүүлэн ээлтэй орчин бүрдүүлэх,

3. Хүүхдийн цэцэрлэг, нийтийн эзэмшлийн талбай дахь хүүхдийн тоглоомын талбайг олон улсын стандартад нийцүүлэн тохижуулах,

4. Нийтийн тээвэр болон хүүхдийн автобусны үйлчилгээг сайжруулах,

5. Ослыг тэглэх хөдөлгөөн, хөтөлбөрийг хэрэгжүүлэх,

6. Гэр хороолол болон хорооллын доторх авто замын сүлжээ, нийтийн тээврийн маршрутын шороон замыг хатуу хучилттай болгох,

#### **Гамшгийн эрсдэл ба дамжин өнгөрөх хөдөлгөөний эрчимжилт:**

Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, мал эмнэлэг хамтран 2016 оны 8 дугаар сарын 1-нээс Хэрлэн шалган бүртгэх товчоон дээр 24 цагийн хяналт шалгалт тавьж ажиллах шаардлага бий болжээ. Үүний нэг жишээ нь “Хүн, малын гоц халдварт өвчин, тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” Нийслэлийн Засаг даргын 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/594 дүгээр захирамж, Багануур дүүргийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/248 дугаар захирамжийг үндэслэн, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2016 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан хуваарийн дагуу “Хэрлэн” автотээврийн шалган бүртгэх товчоон дээр Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Багануур дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн улсын байцаагч нар, дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Мал эмнэлгийн эмч, ариутгагч нартай хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, ажиллаж тээврийн хэрэгсэл, зорчигчдын ачаа тээшинд тарваганы арьс, түүхий эдийг илрүүлэх үзлэг, хяналт шалгалтанд 5631 тээврийн хэрэгсэл, 12564 зорчигч хамрагдсан байна.

Хяналт шалгалтаар тарвага хууль бусаар агнахтай холбоотой 1 зөрчил, Мал эмнэлэг ариун цэврийн гэрчилгээгүй мал тээвэрлэсэн 16 зөрчил тус тус илрүүлжээ.

Зарим суманд малын гаралтай шүлхий өвчин дэгдсэнтэй холбоотойгоор ариутгал халдваргүйтгэл, хяналт шалгалтыг сайтар хийх, Багануур дүүрэг болон Улаанбаатар хотруу халдвар оруулалхгүй байх, Зүүн аймгаас Улаанбаатар хотруу оруулж буй мал мах, малын гаралтай түүхий эд Багануур дүүргийн “Хэрлэн”-н товчоогоор дамжин өнгөрдөг учраас холбогдох албаныхан урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Энэ ажлыг улам чанаржуулж, хяналтын цэгийг өргөтгөх хэрэгтэй.



**Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын стандартад нийцсэн хяналтын цэг буюу ариутгалын пост: Зураг-2.** Мал амьтны гоц халдварт өвчин дэгдсэн үед зүүн аймгуудаас Багануур, Улаанбаатар хотруу, Багануураас зүүн аймгуудруу халдвар оруулахгүй байхад дүүргийн “Хэрлэн” АТШБ товчоо чухал үүрэгтэй газар.

Одоогийн байдлаар “Хэрлэн” товчоогоор дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслүүдэд ариутгал халдваргүйтэлийг гар аргаар гүйцэтгэж байна. Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын стандартад нийцсэн хяналтын цэг буюу ариутгалын пост ажиллуулах нь цаг үеийн тулгамдсан асуудал болсон байна. Мал эмнэлгийн ариутгал халдваргүйтэлийн цэг нь тоног төхөөрөмжийн хувьд нь мал эмнэлгийн гараар хийдэг ариутгалыг орчин үеийн автомат төхөөрөмжинд шилжүүлснээрээ онцлог болжээ.

## 2.5. БАГАНУУР ДҮҮРГИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Бие даасан хот болоход Багануур дүүргийн давуу тал нь **“Үйлдвэрлэл хөгжүүлэх, инноваци, оюуны төв болгох чиг хандлага”**<sup>14</sup> мөн гэж дүүргийн хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлсон. Багануур дүүргийн хөгжлийн чиг хандлага нь байгалийн баялаг, түүхий эдийн нөөцөө ашиглан, нүүрсийг гүн боловсруулах, өндөр технологи нэвтрүүлж үндсэн болон дагалдах бүтээгдэхүүн үйлдвэрлэх дагнасан хэлбэрийн үйлдвэрлэл технологийн парк, эрдэм шинжилгээ, сургалт судалгаа, инноваци, оюуны санаачлагын төв барьж байгуулах явдал туйлын чухал гэжээ.

Үйлдвэрлэл, технологийн парк байгуулагдсанаар Багануур дүүрэг нь эдийн засгийн хувьд биеэ даасан, ажилгүйдэл ядуурлыг бууруулсан, байгаль орчинд сөрөг нөлөө багатай, орчин үеийн дэвшилтэт технологид суурилагдсан хүнд, хөнгөн үйлдвэрийн хот болон хөгжих эрх зүй, эдийн засгийн үндэслэлийг тодорхойлсон.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 149, 2011 оны 367 дугаар тогтоолуудаар Багануур дүүрэгт Их сургуулиудын хотхон байгуулахаар шийдвэрлэсэн, Засгийн газрын 2014 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар **“Их сургуулиудын хотхоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэлэлцэн дэмжээд, хотхоны бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулах нь зүйтэй”** хэмээн шийдвэрлэсэн явдал нь Улаанбаатар хотын хүн амын механик өсөлтийг бууруулах, Нийслэлийн авто замын ачаалал, агаар, хөрсний бохирдол зэрэг хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой шийдвэр болсон гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаас Багануур дүүрэгт Их, дээд сургуулиудын оюутны хотхоныг байгуулахаар шийдвэрлэсний хүрээнд дүүргийн ИТХ-с хотхоны байршилд зориулан 10000 га газрыг олгохоор шийдвэрлэсэн. Цаашид их сургуулиудын хотхон ашиглалтад орсноор 17916 өрхийн 66250 хүн, 100.000 оюутан, нийт 166.250 хүн ам бүхий шинэ суурьшлын бүс, хөгжлийн шинэ төв бий болж, улмаар Монгол Улсын боловсрол, шинжлэх ухаан, инновацийн төв болох боломжтой учир **“Ирээдүй судлал”**-ын ухааны үүднээс бодлого, үйл ажиллагаагаа оновчтой тодорхойлох шаардлага тулгарч байна.

Иймд Багануур дүүрэг нь бие даасан, зүүн бүсийн төв болон хөгжих нь Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулахад чухал ач холбогдолтой гэж Нийслэл, дүүргийн удирдлагууд дэмжиж байсан ба эхний ээлжинд Нийслэлийн алслагдсан Багануур, Налайх дүүргүүдэд дэлхийн хотуудын жишиг дүрмийг туршихаар болсон зэрэг эрх зүйн үндэслэл нь цаашид их, дээд сургуулиудын “Оюутны хотхон” тус дүүрэгт

<sup>14</sup> “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага” баримт бичгийг УИХ-н 2013 оны 02 сарын 8-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан.

байгуулагдсанаар 20 жилийн дараа 200 орчим мянган хүн амтай Монгол Улсын уул уурхай, оюуны үйлдвэрлэлийн томоохон төв болж өргөжин хөгжих бололцоо бүрдэж байна.

## Хүснэгт 2. Улаанбаатар бүсийн хүн амын хэтийн төлөв<sup>15</sup>

Хот суурин гийн нэр	Нийслэлийн статистик		Төлөвлөлтийн хүн ам					
	2010	%	2020	Өсөлт %	%	2030	Өсөлт %	%
	Улаанбаатар хот	1.058.1	91.1	1.235.5	116.8	80.5	1.400.0	132.3
Дагуул, хаяа хот тосгод	103.7	8.9	298.5	288.0	19.5	363.0	350.2	20.6
Улаанбаатар бүсийн хүн ам	1,161.8	100.0	1,534.0	132.0	100.0	1,763.0	151.8	100.0

### Үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжлийн хандлага:

Багануур, Налайх дүүргийг нийслэлийн дагуул хот болгохоор дүүргийн ард иргэдийн санал асуулгын дүнд үндэслэн 2015 онд шийдвэрлэсэн.

Эдийн засаг, дэд бүтцийг тэнцвэртэй хөгжүүлж, хүн амын хэт төвлөрөл, хотын хангамж, үйлчилгээ аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах, оршин суугчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, байгаль орчны зохистой харьцааг хадгалах зорилгоор ийнхүү дагуул хотуудыг байгуулахаар болжээ.

Аливаа нэг дүүргийг дагуул хотын хэмжээнд хөгжүүлэхэд бүхий л талаас нь шинжлэх ухааны үндэслэлтэй, тодорхой аргачлалаар судалдаг. Мэргэжилтнүүдийн зүгээс Багануур, Налайх дүүргийг бие даан хөгжих хэмжээний нөөц бололцоо, ирээдүйтэй бүс гэж тодорхойлдог. Ирээдүйд хотын хөгжилд хувь нэмрээ оруулаад зогсохгүй улсын төсөвт ихээхэн хэмжээний орлого хуримтлуулах боломжтой гэж үздэг.

Багануур дүүрэг нүүрсний уурхай, эрчим хүч, цахилгаан станц, нүүрс боловсруулах, нано технологи, барилгын материал, хөнгөн хүнсний үйлдвэр, эрүүл мэнд, соёл боловсрол, тээвэр ложистикийн төв болж, 2030 он гэхэд 200 мянга орчим хүн амтай хот болон хөгжих ирээдүйтэй гэж тооцоолж байна.

Нано био технологийн туршилт, сургалт, судалгаа, үйлдвэрийн цогцолбор, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, нүүрс баяжуулах үйлдвэр, гумины бордооны үйлдвэр, барилгын материалын үйлдвэр, нүүрс шингэрүүлэх төсөл, аялал жуулчлал, байгалийн нөхөн сэргээлт гэсэн цогц үйлдвэрлэлтэй технологийн паркийг Багануурт байгуулах төлөвлөгөөтэй байна.

Ингэснээр Багануур дүүрэг эдийн засгийн хувьд биеэ даасан, ажилгүйдэл ядуурлыг бүрэн арилгасан, байгаль орчинд сөрөг нөлөө багатай, иргэдийн эрүүл, аюулгүй орчин

<sup>15</sup>“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага” баримт бичгийг УИХ-н 2013 оны 02 сарын 8-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан.



нөхцөл бүрдсэн, орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан хүнд, хөнгөн үйлдвэрийн хот болон хөгжинө гэж үзэж байгаа.<sup>16</sup>

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 мөрийн хөтөлбөрт Багануур дүүрэгт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах шийдвэр гарч, төсөв хөрөнгө нь 2017 оны төсөвт сууж, энэ ажлын эхлэл тавигдсан байна.

#### **Дагуул хотуудын хөгжлийн чиг хандлага:**

Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд дагуул хот, алслагдсан дүүргүүдийг боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээний тодорхой чиглэлээр төрөлжүүлэн эрчимтэй хөгжүүлж, инженерийн болон нийгмийн нэн шаардлагатай дэд бүтэц барьж байгуулахад хөрөнгө оруулалтыг чиглүүлэн, татвар, санхүүгийн бодлогоор дэмжих төлөвлөгөөтэй байна.

**Налайхыг** 4194 га нутаг дэвсгэртэй, 65 орчим мянган оршин суугчтай, технологи нутагшуулах парк, тээвэр ложистик, боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээ төвлөрсөн, хаяа хот болгож хөгжүүлнэ гэжээ.

**Багануурыг** 5982 га нутаг дэвсгэртэй, 200 орчим мянган хүн амтай, уул уурхай, эрчим хүч, хими технологи, барилгын материалын үйлдвэрлэл түлхүү хөгжсөн стратегийн ач холбогдол бүхий үйлдвэрийн хот, дүүргийн төв болгохоор төлөвлөжээ.

**Багахангай** тосгоныг 3235 га нутаг дэвсгэртэй, 10 орчим мянган хүн амтай, дүүргийн төв, тээвэр ложистик, агуулах, бөөний худалдаа, хүнс, барилгын материалын үйлдвэрлэл хөгжсөн, татваргүй тосгон болгох судалгаа, төлөвлөгөө батлагдсан байна.

#### **Хүрээлэн байгаа орчны хүрэн дэх хөгжил**

Монгол Улсын Нийслэлийн алслагдсан дүүрэг нь газар зүйн байршлын хувьд зүүн аймгуудын автозам, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн эдэлбэр газар, мал аж ахуйн бэлчээрийн зангилаа нутаг төдийгүй автозамын хэвтээ тэнхлэг дүүргийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрдөг, хил залгаа Хэнтий аймаг, Төв аймгийн 6 сумтай хүн ам, үйлдвэрлэл үйлчилгээ, эрүүл мэнд, соёл боловсролын хувьд нэгдмэл шинжтэй зэрэгцэн оршдог, хөдөлгөөний эрчим ихтэй, түүх, соёлын дурсгалт газруудын бүсэд тооцогддог.

#### **Түүх, соёлын дурсгалт газрыг дагасан хөгжил:**

4-р хорооны нутаг дэвсгэр Хэрлэн голын “Бүрэг эрэг”- Монголын нууц товчооны 96-д “Тэмүжин нарын Сэнгүр горхиноос нүүж нутагласан нутаг” хэмээн тэмдэглэгдсэн.

- “Аягын ам”- Монголын шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч Их зохиолч Дашдоржийн Нацагдоржийн төрсөн нутаг, гэрийн буурь.

- Хан Хэнтийн нурууны төрийн тусгай хамгаалалттай байгалийн цогцолборт газар Бурхан Халдун уул нь Багануур дүүргээс хойд зүгт 140 км-т оршдог учраас түүн рүү чиглэсэн аялал жуулчлалын урсгал их байдаг тул цагдаагийн хүч, хамгаалалт ихээр шаардагддаг.

- Тэмүжинг Чингис хаанд өргөмжилж Монголын Нууц Товчоог бичиж дуусгасан Хэрлэнгийн хөдөө арал нь Багануур дүүргээс зүүн өмнөд зүгт 140 км-т оршдог

- Ар халхын Утай гэгдэх шашин мөргөлийн төв Балдан бэрээвэн хийд нь дүүргээс зүүн хойд зүгт 140 км-т оршдог.

- Мөнгөнморьт сумын байгалийн үзэсгэлэнт газар,

- Хэрлэн голын дагуу байрлалтай байгалийн үзэсгэлэнт, цогцолбор газар зэрэг гадаад, дотоодын аялагчдын амарч, зугаалах гол бүс нутаг Багануур дүүргийн бүсэд

---

<sup>16</sup>Давхардаваагийн Саруул, 2015 оны 04 дүгээр сарын 13, Өдрийн сонин.

хамаарч байдаг тул дүүргийн эдийн засаг, хууль эрх зүй, соёл, эрүүл мэнд, хүнс, амралтын маш олон үйлчилгээ өргөн хүрээнд хүрч үйлчилдэг.

### **Хүрээлэн байгаа орчны хөгжлийн нөхцөл, боломж**

1. Газар зүй, бүс нутгийн байршил
2. Эрдэс баялаг түүнийг дагасан ажлын байр, хүний нөөц
3. Монгол Улсын төв болон зүүн бүсийг холбосон авто зам
4. Олон улсын төмөр замын сүлжээ
5. Эрчим хүчний сүлжээний хуваарилах төв
6. Ундны болон хэрэглээний усны эх үүсвэр
7. Холбоо мэдээллийн сүүлийн үеийн дэвшилтэт технологи
8. Дулааны эрчим хүчний найдвартай эх үүсвэр
9. Банк санхүү, хөрөнгийн зах зээлийн цогц үйлчилгээ
10. Төрийн төвлөрсөн үйлчилгээ
11. Их, дээд сургуулиудын оюутны хотхон
12. Цахилгаан станц
13. Техник, технологийн парк, инновацийн төвийг Багануур дүүрэгт байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын шийдвэр гарсан нь цаашид хурдацтай хөгжих хандлага илэрхийлэгдэж байна.

### **Зам, тээврийн хөгжил**

Багануур нь зүүн бүсийн автозамын гол зангилаа төдийгүй Багахангайд гол замтай нийлдэг Монголын төмөр замын салаа замын төгсгөл болдог тээвэрлэдэг гол ачаа нь Багануурын нүүрсний уурхайгаас олборлодог нүүрс.

Монгол Улсын хэвтээ тэнхлэгийн авто зам дайран өнгөрдөг ба Улаанбаатар-Багануур гэсэн чиглэлд 130 км орчим урттай хатуу хучилттай авто замтай.

Багануур дүүргийн хувьд зөвхөн “БРА” серийн дугаартай тээврийн хэрэгсэл 6850, хил залгаа Төв аймгийн Мөнгөнморьт суманд 237, Баяндэлгэр 152, Хэнтий аймгийн Цэнхэрмандал 172 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй учир орон нутгийн хэмжээнд өдөр тутам хөдөлгөөнд оролцдог 7000 гаруй тээврийн хэрэгсэл хүн, ачаа тээврийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Үүнээс гадна Хэнтий, Дорнод, Сүхбаатар чиглэлийн мянганы замын хэвтээ тэнхлэгийн автозамаар амралт аялалын зорилгоор зорчигч зуны улиралд хоногийн дотор нийт 5631 тээврийн хэрэгсэл, 12564 зорчигч Багануур дүүргийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрсөн судалгаа гарч байна<sup>17</sup>.

Энэ нь зорилтод болон дамжин өнгөрч байгаа хөдөлгөөний эрчим асар их, цаашид ч эрчимтэй өсөх хандлага ажиглагдаж байна.

### **Хөдөлгөөний менежмент**

Багануур дүүрэг нь нутаг дэвсгэрийн хувьд Төв аймаг, Хэнтий аймгийн 6 сумтай хил залгаа оршин байрлахаас гадна Хэнтий, Дорнод, Сүхбаатар чиглэлийн мянганы замын хэвтээ тэнхлэгийн автозамын нэгдсэн сүлжээ, байгалийн, түүхийн, адал явдалт зэрэг олон төрлийн аялал жуулчлалын сүлжээ, малын хөлийн, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний борлуулалт, тээвэрлэлтийн идэвхтэй хөдөлгөөний сүлжээ, цахилгаан-

<sup>17</sup> 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/594 дүгээр захирамж, Багануур дүүргийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/248 дугаар захирамжаар “Хэрлэн” автотээврийн шалган бүртгэх товчоон дээр хийсэн судалгаа.

эрчим хүч, үйлдвэрлэл-үйлчилгээ, соёл боловсролын нэгдсэн сүлжээ бүхий байрлалтай бүс болон хөгжих чиг хандлагатай.

Зүүн бүсийн хэмжээний аялал жуулчлал, зорилтод хүн, мал, тээврийн хэрэгслийн, худалдаа үйлчилгээний, уул уурхайн үйлдвэрлэлийн хөдөлгөөний нягтрал улам бүр нэмэгдэж, эрчимжиж, хөгжих хандлагатай байна.

#### **Үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжил**

Багануур дүүргийн хөгжлийн чиг хандлага нь байгалийн баялаг, түүхий эдийн нөөцөө ашиглан, Багануурын нүүрсний уурхайг түшиглэн нүүрсийг гүн боловсруулах, өндөр технологи нэвтрүүлэх замаар үндсэн болон дагалдах бүтээгдэхүүн үйлдвэрлэх дагнасан хэлбэрийн үйлдвэрлэл технологийн парк барьж байгуулах явдал гэж хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон.

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор Улаанбаатар хотын бүсийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан “Улаанбаатар хотын бүсэд аж үйлдвэр, технологийн парк” байгуулах тухай шийдвэрт:

“Багануур” үйлдвэрлэл технологийн паркийн хүрээнд байгуулагдах үйлдвэрүүдийн чиглэлүүд:

- ✓ Нано био технологийн туршилт, сургалт, судалгаа, үйлдвэрийн цогцолбор
- ✓ Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр
- ✓ Нүүрс баяжуулах үйлдвэр
- ✓ Гумины бордооны үйлдвэр
- ✓ Барилгын материалын үйлдвэр
- ✓ Нүүрс шингэрүүлэх төсөл
- ✓ Аялал жуулчлал
- ✓ Байгалийн нөхөн сэргээлт гэх мэт.

Эдгээр төсөл, хөтөлбөр хэрэгжсэнээр Багануур дүүрэг нь эдийн засгийн хувьд биеэ даасан, ажилгүйдэл ядуурлыг бүрэн аргилгасан, байгаль орчинд сөрөг нөлөө багатай, орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан хүнд, хөнгөн үйлдвэрийн хот болон хөгжинө гэж тодорхойлсон байгаа нь гэмт хэрэг, зөрчлийн суурь шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг арилгахад эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

## **БҮЛЭГ 3. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, НӨХЦӨЛ**

### **3.1. ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Улаанбаатар хот өнөөдөр саяас дээш 2 сая руу дөхсөн хүн амтай хот болж өргөжлөө. Хүн амын шилжилт хөдөлгөөн, суурьшлыг дагаад хотын тэлэлт асар ихсэж, хотын ачаалал улам нэмэгдэж байна. Нийслэлийн хүн амын тоо 1990 онд 560.000 байсан бол 2015 онд 1372.000<sup>18</sup> болж 2.5 дахин өсчээ. 2015 оны байдлаар Монгол Улсын хүн амын 46.8 хувь нь нийслэлд албан ёсны бүртгэлтэй байна. Гэтэл гэмт хэргийн тоо 6.2 дахин өссөн байна. Нэг дүүргийн хорооны хүн амын тоо нэг аймгийн хүн амтай дүйцэж байна.

Албан бус мэдээллээр Монгол Улсын хүн амын 60-65 хувь нь Улаанбаатар хотод ажиллаж, сурч, амьдарч байгааг дагаад нийслэл хотын аюулгүй байдал, иргэдийн аюулгүй, амгалан тайван байдлыг хангах асуудал онцгой анхаарал татсаар байна. Тухайлбал, гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол тасралтгүй үйлдэгдэж, олон мянган иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирсоор байгаа нь эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж байна.

Нийслэлийн нутгийн захиргаа, хууль сахиулах байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, тэмцэх тодорхой арга хэмжээ авч байна. Гадаадын улс оронд саяас дээш хүн амтай хотыг “megapolis city” хэмээн томъёолж, хот төлөвлөлтийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгайлсан бодлоготой хослон хэрэгжүүлдэг жишиг, туршлага байдаг.

Улаанбаатар хотын Засаг даргаас 2016-2020 онд дэвшүүлсэн иргэдийн аюулгүй байдлыг хангах, нийслэл хотын аюулгүй байдлыг хангах “Аз жаргалтай хот” хэмээх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

**Багануур дүүргийн тухайд** төв зам дагуу, зүүн бүсийн аймгуудын зангилаа нутаг, улмаар үйлдвэрлэл, техникийн хот болохоор хөгжиж байгаа ба тус дүүргийн суурин хүн амын тоо 1990 онд 12.9 мянга байсан бол 2015 онд 28.4 мянга болж, даруй 2.2 дахин өсчөө, түүнийг дагаад аж ахуйн нэгж, үйлдвэр, уурхай олноор байгуулагдаж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, зорчигч иргэдийн хөдөлгөөн төв зам дагасан хөдөлгөөн ихсэж байна. Үүнийг даган гэмт хэргийн гаралт сүүлийн жилүүдэд тогтмол нэмэгдэх хандлагатай байна. Хотжих үйл явц гэмт явдалд хэрхэн нөлөөлж, хамаардаг болохыг нээн илрүүлэхэд хот дахь гэмт явдлын түвшин, хөдөлгөөн, бүтэц гэсэн тоо болон чанарын үзүүлэлтэд гарсан статистик бодит өөрчлөлтүүдийг тодорхой цаг хугацааны үечлэлтэй харьцуулан судлах нь уг асуудлын мөн чанарыг илэрхийлэхэд онцгой ач холбогдолтой.

Иймд Улаанбаатар хотын хэмжээнд, ялангуяа Багануур дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, хүчин зүйлсийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох шаардлага тулгарч байна.

#### **3.1.1. Иргэдийн гомдол, мэдээллийн урсгал:**

Цагдаагийн Мэдээлэл, шуурхай удирдлагын төв нь иргэдээс гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага мэдээллийг 102 тусгай дугаарын утсаар 24 цагийн турш тасралтгүй авч байна. Нийслэл хотын хэмжээнд машинт болон явган эргүүлийн офицер, цагдаа, цагдаагийн газар, хэлтсүүдийн шуурхай албадыг мэргэжлийн удирдлагаар хангаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэгдсэн шуурхай удирдлага,

<sup>18</sup> <http://ubstat.mn/StatTable=11>

зохицуулалтын ажиллагааг явуулж, улсын хэмжээний эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын мэдээллийг нэгтгэн ЦЕГ-ын болон төр, засгийн удирдлагыг мэдээллээр хангадаг.

Тус Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн 102 дугаарын утсанд 2016 оны эхний 11 сарын байдлаар 1.312.274<sup>19</sup> гэмт хэрэг, хэв журмын зөрчил, зам тээврийн ослын дуудлага, мэдээлэл хүлээн авчээ.

(Зураг.3)



Үүний 510.100 буюу 38.9% нь гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослын талаарх мэдээлэл байжээ. Харин 43.6% нь зөвлөгөө авсан, цагдаагийн газар, хэлтсийн байршил асуусан зэрэг бусад мэдээлэл, үлдсэн 18% нь андуурсан, тоглосон, хариу өгөөгүй дуудлага мэдээлэл байжээ.


Улаанбаатар хотын хэмжээнд дүүргүүдийн цагдаагийн 10 хэлтэс, замын цагдаагийн газар, тасгийн хэмжээнд хоногт дунджаар 1545 орчим гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослын талаарх мэдээ, мэдээлэл хүлээн авч, холбогдох шалгалтын ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Багануур дүүргийн тухайд алслагдсан дүүрэг учраас Цагдаагийн хэлтэс нь 7021-102 дугаарын утсаар хоногт дунджаар гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослын талаарх 20-30 орчим дуудлага, мэдээлэл хүлээн авч, шалгадаг байна.

### 3.1.2. Гэмт хэрэг, зөрчлийн халдлагад өртөж, хохирсон иргэдээс цагдаагийн байгууллагад хандсан байдал:

Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс 2011-2015 онд **39234** гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авчээ. Жилд дунджаар **7847**, хоногт дунджаар **21** гомдол, мэдээлэл хүлээн авч, шалган шийдвэрлэжээ.

График 5. Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсийн хүлээсэн авсан гомдол, мэдээлэл



Дүүрэг

Гомдол, мэдээлэл

2011 2012 2013 2014 2015 Бүгд Жилийн Эзлэх


<sup>19</sup> <http://eincenter.police.gov.mn/news/content/id/3259/type/33>

							дундаж	%	
1	Баянгол	17769	23959	22899	38874	50553	<b>154054</b>	<b>30811</b>	<b>14,8</b>
2	Баянзүрх	14460	18882	27995	88545	82982	<b>232864</b>	<b>46573</b>	<b>22,4</b>
3	Сүхбаатар	7668	12017	24207	29087	28148	<b>101127</b>	<b>20225</b>	<b>9,7</b>
4	Сонгинохайрхан	7009	19848	52485	72407	72941	<b>224690</b>	<b>44938</b>	<b>21,6</b>
5	Хан-Уул	6802	8173	11074	22125	32666	<b>80840</b>	<b>16168</b>	<b>7,8</b>
6	Чингэлтэй	6559	11149	16942	50819	47182	<b>132651</b>	<b>26530</b>	<b>12,8</b>
7	Багануур	8459	11581	9857	4749	4588	<b>39234</b>	<b>7847</b>	<b>3,8</b>
8	Багахангай	5702	8821	7641	180	210	<b>22554</b>	<b>4511</b>	<b>2,2</b>
9	Налайх	10596	14641	15629	5035	5097	<b>50998</b>	<b>10200</b>	<b>4,9</b>
Улаанбаатар хотын дүн		<b>85024</b>	<b>129071</b>	<b>188729</b>	<b>311821</b>	<b>324367</b>	<b>1039012</b>	<b>207802</b>	

Хүснэгт 3. Дүүргүүдийн Цагдаагийн байгууллагын гомдол, мэдээлэл хүлээн авсан байдал  
Багануур дүүргийн хувьд Нийслэлийн дүүргүүдийн цагдаагийн байгууллагын хэмжээнд хүлээн авсан гомдол, мэдээллийн дүнгийн 3.8 хувийг эзэлж байна. Гомдол, мэдээллийн ихэнхийг танхайрах, хулгайлах, бусдын бие махбодид гэмтэл учруулах, зам тээврийн осол, хэргийн дуудлага мэдээлэл эзэлдэг байна.

**Улаанбаатар хотын хэмжээнд** 2016 оны эхний 10 сард **293974** гомдол мэдээлэл шалгасан. Улсын хэмжээнд бүртгэгдсэн 406137 гомдол мэдээллийн 72.4 хувийг эзэлж байна. Бүртгэгдсэн гомдол мэдээлэл урд оны мөн үеэс 31893 нэгжээр буюу 12.2 хувиар өссөн. Гомдол мэдээллийн 290209 буюу 96.8 хувийг шийдвэрлэсэн байна.

График 6. Улаанбаатар хотын цагдаагийн газрын хэмжээнд бүртгэсэн нийт гомдол, мэдээлэл



Нийт бүртгэсэн гомдол мэдээллийн 90.2 хувийг танхайрах, бусдын эд хөрөнгийг хулгайлах бусад төрлийн гомдол мэдээлэл эзлэж байна.

**Багануур дүүргийн хэмжээнд** 2016 оны эхний 10 сард 3516 гомдол мэдээлэл бүртгэн шалгасан нь Улаанбаатар хотын хэмжээнд бүртгэсэн 293974 гомдол мэдээллийн 1.2 хувийг эзэлж байна.

Нийт бүртгэсэн 3516 гомдол мэдээллийн 548 буюу 15.5 нь гэмт хэргийн шинжтэй, 2968 буюу 84.5 зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Нийт бүртгэсэн гомдол мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулхад 284 нэгж буюу 7.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн гомдол мэдээллийн шийдвэрлэлтийг авч үзвэл:

- Эрүүгийн хэрэг үүсгэсэн шалгасан 252 гомдол мэдээлэл
- Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай прокурорт хүргүүлсэн 292 гомдол мэдээлэл
- Харьяаллын дагуу шилжүүлсэн 8 гомдол мэдээлэл

Захиргааны зөрчлийн шинжтэй 1954 гомдол мэдээллийг:

- 1391 торгуулийн хуудсаар
- 248 шийтгэвэрийн хуудсаар
- 56 баривчлуулсан
- 192 тээврийн хэрэгсэл жолоодох эрх хассан
- 46 Хөөн хэлэлцэх хугацаа зогсоосон
- 20 Зөрчил гаргасан этгээд нь зөрчил үйлдэх үедээ захиргааны хариуцлага хүлээх насанд хүрээгүй эсвэл эрх зүйн чадамжгүй байсан үндэслэлээр
- 1015 зөрчлийг бусад шийдвэрлэлтээр тус тус арга хэмжээ тооцогдсон байна.


Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 407 буюу 74,2 хувийг 5 хоногт, 142 буюу 25,9 хувийг 6-19 хоногт 1 буюу 0,2 хувийг 20 хоногт шийдвэрлэсэн байна. Зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 1932 буюу 65 хувийг 14 хоногт, 22 буюу 35 хувийг 15-28 хоногт шалгаж шийдвэрлэсэн байна.

### 3.1.3. Багануур дүүрэг дэх гэмт хэргийн хөдөлгөөн:

Гэмт хэргийн хөдөлгөөн гэдэг нь тодорхой цаг хугацаанд гэмт хэргийн мөн чанарт гарсан тооны ба чанарын өөрчлөлт. Гэмт хэргийн хөдөлгөөний үзүүлэлт нь гэмт хэргийн үнэмлэхүй өсөлт, бууралт өсөлтийн хурдац /бууралт/ хэмжээ буюу түвшинг илэрхийлнэ.

Багануур дүүргийн хэмжээнд Монгол Улс чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжсэн шилжилтийн үеээс эхлэн сүүлийн 25 жилийн байдлаар гэмт хэргийн хөдөлгөөнийг график 7-д дүрслэн үзүүлэв.

График 7. Багануур дүүрэгт бүртгэсэн гэмт хэрэг



Багануур дүүрэгт 1991-2015 онуудад жилд дунджаар 282 гэмт хэрэг бүртгэжээ. 2015 оныг 25 жилийн өмнөх үетэй харьцуулахад жилд 8 хэргээр тасралтгүй өсөн нэмэгдэж иржээ.

Зах зээлийн эдийн засагт шилжээд нийгэмд тогтворгүй байдал бий болж, архидан согтуурах, нийгмийн дэг журам зөрчих явдал 1997 онд дээд цэгтээ хүрч улсын хэмжээнд гэмт хэргийн үзүүлэлт сүүлийн 20 жилд байгаагүй түвшинд хүрч 24657 бүртгэсэн байна. Энэ тоо бүртгэсэн гэмт хэргийн тооны өндөр үзүүлэлт, үүний цаана бүртгээгүй дарагдсан, нуугдмал гэмт хэргийн түвшин мөн өндөр байсан нь тухай үеийн нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсээс тодорхой ажиглагддаг.

Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал хүндхэн үе буюу 1997 онд Багануур дүүрэгт мөн л 464 гэмт хэрэг бүртгэсэн, сүүлийн 25 жил дэх бусад оны үзүүлэлтээс өндөр гарч байна.

Багануур дүүрэгт 1997 оноос хойш гэмт хэргийн гаралт буурах хандлагатай байгаа ч 2015 онд 311 гэмт хэрэг бүртгэсэн нь 2014 оныхоос 75 буюу 31.8%-иар өссөн нь тухайн дүүрэг дэх нийгэм, эдийн засгийн байдал, төв зам дагасан хүн, автомашины хөдөлгөөний эрчимжилтийн улмаас шалтгаалсан байна.

### 3.1.4. Гэмт хэргийн тархалт:


Улсын хэмжээнд 2016 оны эхний 10 сард 15257 гэмт хэрэг бүртгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 252 хэргээр буюу 1.7 хувиар өссөн. Улсын хэмжээнд бүртгэсэн нийт гэмт хэргийн 66.1 хувь нь Улаанбаатар хотод үйлдэгдсэн байна.

Нийслэлд бүртгэсэн нийт гэмт хэргийн 3519 буюу 23.2 хувь нь Баянзүрх дүүрэгт, 2704 буюу 18.1 хувь нь Баянгол дүүрэгт, 2497 буюу 16.8 хувь нь Сүхбаатар дүүрэгт, 2440 буюу 16.1 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 2028 буюу 13.2 хувь нь Чингэлтэй дүүрэгт,




1381 буюу 8.3 хувь нь Хан-Уул дүүрэгт, 417 буюу 2.5 хувь нь Налайх дүүрэгт, 251 буюу 1.6 хувь нь Багануур дүүрэгт, 20 буюу 0.1 хувь нь Багахангай дүүрэгт тус тус бүртгэсэн байна.

График 8. Багануур дүүрэгт бүртгэсэн гэмт хэрэг




Баянзүрх дүүргийн тухайд хамрах нутаг дэвсгэр том, хүн ам ихтэй, Нарантуул, техникийн зах, худалдааны төвүүд үйл ажиллагаа явуулдаг, Баянгол дүүрэг хотын төв дүүрэг, худалдаа, үйлчилгээний аж ахуйн нэгжүүд, хүн ам төвлөрсөн онцлогтой дүүрэг. Сонгинохайрхан дүүргийн тухайд хүн ам ихтэй, газар нутгийн хэмжээ том, гэр хорооллын гудамж талбай, амралтын газар, зуслан ихтэй байдал зэрэг өөр өөрийн өвөрмөц онцлог нөлөөлсөн байх талтай.

График 9. Нийслэлд бүртгэсэн гэмт хэрэг (дүүрэг, хэлтсээр)



### 3.1.5. Гэмт хэргийн түвшин

Гэмт явдлын түвшин гэдэг нь /level standart of criminality/ криминологид эрүүгийн хариуцлага хүлээлгэх насанд хүрсэн 1000, 10.000, 100.000 хүн тутамд ноогдох тодорхой хугацааны туршид тодорхой нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад бүртгэсэн гэмт явдлын түвшинг тогтооход ашигладаг



эрүүгийн хариуцлага хүлээлгэх насыг 16 насаар авч үзэн тодорхойлдог.

### 10.000 хүнд ногдох гэмт хэргийн үзүүлэлт:

График 10. 16 ба түүнээс дээш насны 10000 хүн амд ногдох гэмт хэрэг  
Гэмт хэргийн бодит нөхцөл байдлыг илэрхийлэх, бусад бүс нутаг дэвсгэрт бүртгэсэн гэмт хэрэгтэй харьцуулах гол үзүүлэлт бол 16 ба түүнээс дээш насны 10.000 хүн амд ногдох гэмт хэрэг юм.

Багануур дүүргийн хэмжээнд 10000 хүнд ногдох гэмт хэрэг 158.1 байгаа нь Багахангай, Хан-Уул, СХД-ийн үзүүлэлтүүдээс өндөр, хүн амд ногдох гэмт хэргийн түвшин, эрсдэл өндөр байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн тоон үзүүлэлт бага боловч хүн амд ногдох гэмт хэргийн түвшин эрүүгийн нөхцөл байдал ачаалал ихтэй гэгдэх Сонгинохайрхан дүүргээс өндөр байгаа нь анхаарал татаж байна.


### Гэмт хэрэгт хохирлыг илэрхийлэх аюулгүй байдлын индекс:

Улаанбаатар хотын шинэ удирдлагаас гэмт явдлаас зөвхөн урьдчилан сэргийлэх байдлаар хязгаарлах бус, иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах, амар тайван амьдрах нөхцөл бүрдүүлэхэд ихээхэн анхаарч байгаа билээ. (Зураг.4)

Нийслэлийн ард иргэдийн аюулгүй байдлыг илэрхийлэх коэффициентыг 10000 хүнд ногдох байдлаар тооцож үзэв<sup>20</sup>.



График 11. Нийслэлийн ард иргэдийн аюулгүй байдлыг илэрхийлэх коэффициент /10.000 хүнд ногдох/



Гэмт хэргийн халдлагад иргэд хохирсон коэффициент Багануур дүүргийн хэмжээнд 16 ба түүнээс дээш насны 10000 хүн амд 165.7 байна. Энэ нь Багахангай, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн үзүүлэлтээс өндөр байна.


Энэ үзүүлэлт нь 10000 хүнд ногдох гэмт хэргийн тархалттай төстэйгээс гадна тухайн дүүргийн гэмт хэрэгт өртөж хохирох эрдслийн түвшинг илэрхийлж буй үзүүлэлт юм.

### 3.1.6. Хороодын гэмт хэргийн байдал:

<sup>20</sup>16 ба түүнээс дээш насны хүн амын тоог гэмт хэргийн халдлагад өртөж хохирсон иргэдийн тоотой харьцуулах байдлаар тооцов.

2011-2015 он, 2016 оны эхний 10 сарын байдлаар Багануур дүүргийн 5 хороонд бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээллийг авч үзвэл 27.1% нь 1-р хороонд, 25.7% нь 3-р хороонд, 21.2% нь 5-р хороонд тус тус үйлдэгдсэн байна. Хамгийн их гэмт хэрэг үйлдэгддэг хороо 1, 3, 5-р хороо байна.

График 12. Багануур дүүргийн хороодод бүртгэгдсэн гэмт хэрэг (2011-2015, 2016 оны эхний 10 сар)



Хүснэгт 4. Багануур дүүргийн хороодод бүртгэгдсэн гэмт хэрэг (2011-2015, 2016 оны эхний 10 сар)

Он	Хороогоор						Бүгд
	1-р хороо	2-р хороо	3-р хороо	4-р хороо	5-р хороо	Бусад	
<b>2011</b>	81	6	75	39	45	6	252
<b>2012</b>	81	19	81	45	66	11	303
<b>2013</b>	87	14	74	59	69	11	314
<b>2014</b>	62	16	79	30	61	67	315
<b>2015</b>	100	15	88	48	80	23	354
<b>2016</b>	73	14	63	42	59	-	251
<b>10 сар</b>							
<b>Дүн</b>	<b>484</b>	<b>84</b>	<b>460</b>	<b>263</b>	<b>380</b>	<b>118</b>	<b>1789</b>
<b>Эзлэх %</b>	27.1	4.7	25.7	14.7	21.2	6.6	

2016 оны эхний 10 сарын байдлаар Багануур дүүрэгт бүртгэсэн гэмт хэргийн тухайд 1-р хороонд бусдын бие махбодид гэмтэл учруулах, хулгайлах, 2-р хороонд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг, 3-р хороонд бусдын бие махбодид гэмтэл учруулах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний

аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг, 4-р хороонд хулгайлах, бусдын бие махбодид гэмтэл учруулах, 5-р хороонд бусдын бие махбодид гэмтэл учруулах, хулгайлах гэмт хэргүүд зонхилон үйлдэгддэг байна.

Хүснэгт 5. Багануур дүүргийн хороодод бүртгэгдсэн гэмт хэргийн төрөл (2011-2015, 2016 оны эхний 10 сар)

Гэмт хэргийн төрөл	Хороогоор					
	1-р хороо	2-р хороо	3-р хороо	4-р хороо	5-р хороо	Бүгд
1. Бусдын эд хөрөнгийг хулгайлах	18	2	9	16	18	63
Үүнээс: Мал хулгайлах						
2. Танхайрах	5			4	1	10
3. Бусдын бие махбодид гэмтэл учруулах	25	2	28	13	26	94
4. Дээрэмдэх	1		1			2
5. Булаах						
6. ТХХАБАЖ-ын эсрэг	4	10	12	4	3	33
7. Хүчиндэх	3		1		3	7
8. Хүнийг санаатай алах					1	1
9. Бусдыг амиа хорлоход хүргэх						
10. Байгаль хамгаалах журмын эсрэг						
11. Залилан мэхлэх	4		3	1		8
11.Бусад	13		9	4	7	33
Дүн	73	14	63	42	59	251


### 3.1.7. Гэмт хэргийн бүтэц:

Гэмт хэргийн бүтэц гэдэг нь /structure of crime/ гэмт явдлын тодорхой хэв шинж, төрөл буюу төрөл зүйлийн харьцааг тодорхойлдог гэмт хэргүүдийн тодорхой байгууламж. Гэмт хэргийн бүтцийн үзүүлэлт нь нийт гэмт хэрэг дотор тодорхой гэмт хэргийн хэв шинж, төрөл ба төрөл зүйлийн эзлэх хувийн жинг илэрхийлнэ. Хотод гарч байгаа гэмт хэргийн бүтцэд хөдөө орон нутагтай харьцуулахад олон тооны хэрэг багтаж байгаа ч хэргийн дийлэнх хувийг цөөн тооны хэдэн төрлийн хэрэг эзэлж байна.

Тухайлбал: Багануур дүүрэгт сүүлийн 25 жилд бүртгэгдсэн нийт 7042 гэмт хэргийн хамгийн их буюу 39.7% нь хулгайлах, дараа нь 22.2% нь бусдын бие махбодид гэмтэл


учруулах, 10.3% нь танхайрах, 4.2% нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих хэргүүд эзэлж байна. /Хавсралт 2. Гэмт хэргийн статистикийн үзүүлэлтээс үзнэ үү/.

График 13. Гэмт хэргийн төрөл (1991-2015 он)



Багануур дүүрэгт 2016 оны эхний 10 сарын байдлаар бүртгэсэн гэмт хэрэг нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19 буюу 0.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

График 14. Гэмт хэргийн төрөл (2016 оны эхний 10 сар)




Бүртгэсэн гэмт хэргийн 37.5% нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, 25.1% нь хулгайлах, 6.0% нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 6.0% нь зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах, 4.4% нь залилан мэхлэх хэргүүд эзэлж байна. Түүнчлэн, 2.8% нь хүчиндэх, 2.4% нь орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах хэрэг байна.

### 3.1.8. Гэмт хэргийн нийгмийн хор аюул:


Багануур дүүрэгт сүүлийн 25 жилийн хугацаанд үйлдэгдсэн 7042 гэмт хэргийн улмаас 307 хүн нас барж, 2833 хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрээр гэмтэж<sup>21</sup>, 4.5 тэрбум төгрөгийн хохирол учирсаны 1.3 тэрбум төгрөг буюу 29.1 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад нөхөн төлүүлжээ.

График 15. Багануур дүүрэгт бүртгэсэн гэмт хэргийн улмаас хүн нас барсан, ГЭМТСЭН ТОО



Гэмт хэргийн улмаас хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрээр гэмтэх явдал нэмэгдэх хандлагатай байна.

График 16. Багануур дүүрэгт бүртгэсэн гэмт хэргийн улмаас учирсан эд материалын хохирол (сая төгрөг)



Багануур дүүрэгт 2016 оны эхний 10 сарын байдлаар 258 иргэн, 10 байгууллага гэмт халдлагад өртөн хохирч, 13 хүн нас барж, 141 хүн гэмтэж, 253.8 сая төгрөгийн эдийн хохирол учирснаас 101.2 сая төгрөгийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлэн, хохирол нөхөн төлөлтийн хувь 39.9 хувьтай байна.

2016 оны эхний 10 сарын байдлаар 259 хүн гэмт хэрэгт холбогдож шалгагдсанаас 46 буюу 17.7 хувь нь эмэгтэй, 13 буюу 5.0 хувь нь насанд хүрээгүй хүмүүс, 140 буюу 54.0 хувь нь 18-34 насны, 84 буюу 32.4 хувь нь согтуугаар, 69 буюу 26.6 хувь нь урьд ял шийтгэлтэй хүмүүсээс гэмт хэрэг үйлдсэн байна. Гэмт хэрэгт холбогсодын нийгмийн байдал: 156 буюу 60.2 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 51 нь хувийн хэвшилд ажилчин, 15 нь төрийн албан хаагч, 9 нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 7 нь малчин, 7 нь оюутан, 6 нь сурагч, 2 нь тэнэмэл хүмүүс үйлджээ.

<sup>21</sup>Гэмтлийн зэрэг тогтоолгосон байдлаар.


### 3.1.9. БАГАНУУР ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Багануур дүүргийн прокуророос гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авах, шалгах ажиллагаанд 2014 онд **1232**, 2015 онд **1120**, 2016 оны эхний хагас жилд **542<sup>22</sup>** гомдол, мэдээлэлд тус тус хяналт тавьсан байна.

2014 онд 1232 гомдол, мэдээлэл байсан бол 2015 онд 1120 гомдол, мэдээлэл хүлээн авах, шалгах ажиллагаанд хяналт тавьсан нь 112 нэгжээр буюу 9.1%-иар буурсан үзүүлэлттэй байна.

2016 оны эхний хагас жилээр дүн мэдээ гарсан тул бүтэн жилтэй харьцуулах нь өрөөсгөл тул 2014, 2015 онтой харьцуулаагүй бөгөөд тоон үзүүлэлтүүдээс дүгнэхэд жил ирэх тусам иргэд, аж ахуйн, нэгж байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо буурсан байгаа нь харагдаж байна.

График 19. Багануур дүүргийн Прокурорын үйл ажиллагааны мэдээлэл



2014 онд 1232 гомдол, мэдээлэл хүлээн авах, шалгах ажиллагаанд хяналт тавьснаас 336 эрүүгийн хэрэг үүсгэсэн нь 27.2 хувьтай, 848 эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан нь 68.8 хувьтай, 10 харьяаллын дагуу шилжүүлсэн нь 0.8 хувьтай байна.

2014 онд Нийслэлийн прокурорын газраас 59962 гомдол мэдээлэл хүлээн авах, шалгах ажиллагаанд хяналт тавьснаас Багануур дүүргийн хувьд 1200 орчим гомдол мэдээлэл буюу энэ нь нийслэлийн хэмжээний нийт гомдол, мэдээллийн 2 хувийг эзэлж байна.

2015 онд 1120 гомдол, мэдээлэлд хяналт тавьснаас 338 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэсэн нь 30.1 хувьтай, 746 гомдол, мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан нь 66.6 хувьтай, 28 гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлсэн нь 2.5 хувьтай байна.

2015 онд Нийслэлийн прокурорын газраас 66711 гомдол мэдээлэлд хяналт тавьснаас Багануур дүүргийнх 1.67% болж буурсан үзүүлэлттэй байна.

2016 оны эхний 6 сард 542 гомдол, мэдээлэлд хяналт тавьснаас 231 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэсэн нь 42,6 хувьтай, 292 гомдол, мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан нь 53,8 хувьтай, 22 гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлсэн нь 4 хувьтай байгаа бөгөөд 2016 оны эхний хагас жилд Нийслэлийн прокурорын газраас 49831 гомдол, мэдээлэлд хяналт тавьснаас Багануур дүүрэг 1,08 хувийг эзлэж байна.


<sup>22</sup>Нийслэлийн прокурорын газрын тоон мэдээллээс.

Мөн нийслэлийн дүүргийн прокуроруудтай харьцуулахад Баянзүрх дүүргийн прокурорын газар тайлангийн хугацаанд хамгийн их буюу 13328 гомдол, мэдээлэлд хяналт тавьсан нь Багануур дүүргийн прокурортой харьцуулахад 12,786 нэгжээр илүү байна. Тоон мэдээнээс үзэхэд хяналтын прокурорын шийдвэр жил бүр дээд шатны прокурорын шийдвэрээр өөрчлөгдөж байгаа нь өссөн дүнтэй байна.

2016 онд нийслэлийн болон хамгийн их дээд шатны прокурор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан материалтай танилцсан талаарх мэдээллийг Баянгол дүүрэгтэй харьцуулахад Багануур дүүргийн прокурор нь нийслэлийн прокурорын 0,2 хувийг эзлэж байгаа бол Баянгол дүүргээс 219 нэгжээр бага байна.

Нийслэлийн прокуророос 945 эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан материалтай танилцаад 331 материалд эрүүгийн хэрэг үүсгэсэн нь 35 хувьтай, Баянгол дүүргийн прокурор 221 эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах материалтай танилцаад 60 материалд эрүүгийн хэрэг үүсгэсэн нь 27.1%-тай байгаа бол Багануур дүүргийн прокурор 2 эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах материалтай танилцаад 1 материалд эрүүгийн хэрэг үүсгэсэн байна.

График 20. Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан материалтай танилцаад эрүүгийн хэрэг үүсгэсэн мэдээлэл




Нийслэлийн бусад дүүрэгтэй харьцуулахад Багануур дүүрэг нь хэрэг, зөрчил бага гардаг хамгийн тайван дүүрэг гэж үзэж болохоор байна.

### 3.1.10. БАГАНУУР ДҮҮРГИЙН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРААС ИРҮҮЛСЭН МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Нийслэлийн Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр сүүлийн таван жилийн хугацаанд шийдвэрлэгдсэн хэргийг авч үзвэл 2011 онд нийт 79 хэрэг, 2012 онд 82 хэрэг шийдвэрлэгдэж байсан бол 2013 онд 50 буюу өмнөх оноос 39% буурсан байна. Харин 2014 онд 108, 2015 онд 125 хэрэг тус тус шийдвэрлэгдсэн нь тогтмол өссөн үзүүлэлттэй байна.


График 21. Шүүхээр шийдвэрлэсэн хэргийн төрөл





Дээрх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хүмүүсийг он тус бүрээр авч үзвэл,

График 22. Шүүхээр ял шийтгүүлсэн хүмүүс



2011 онд 108 хүн гэмт хэргийн улмаас ял шийтгүүлж байсан бол үүнээс 7 нь эмэгтэй, 8 нь хүүхэд байжээ. 2012 онд нийт 115 хүн ял шийтгүүлснээс 10 нь эмэгтэй, 9 нь хүүхэд байсан байна.

Харин 2013 онд ял шийтгүүлсэн хүний тоо өмнөх жилүүдээс харьцангуй бага буюу дунджаар 45% буурсан үзүүлэлт харагдаж байна. Үүнээс хойш ял шийтгүүлсэн хүний тоо тогтмол өссөн үзүүлэлттэй байна.

Дээрх тоон үзүүлэлтээс харахад, 2014, 2015 онуудад шүүхээр шийдвэрлэсэн нийт хэргийн 20 орчим хувийг хулгайлах гэмт хэрэг дангаар эзэлж байгаа бол 10 орчим хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Мөн ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүүхдийн тоо сүүлийн гурван жилд харьцангуй өссөн нь харагдаж байна. Тухайлбал, 2013 онд 3, 2014 онд 5 байсан бол 2015 онд 15 болж огцом өсчээ.

Иймд ял эдлээд суллагдсан болон гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг төлөвшүүлэх, нийгэмшүүлэхэд нутгийн захиргааны болон төрийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, гэр бүл, ахуйн хүрээнд үйлдэгдсэн болон хүүхдээс үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдалд сар бүр нутаг дэвсгэр бүрээр дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгч, шалтгаан нөхцөлийг арилгах, саармагжуулах чиглэлээр тодорхой ажлуудыг үр дүнтэй, далайцтай зохион байгуулах нь зүйтэй.

Улмаар шүүхээс Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй явуулахад анхаарах нь зүйтэй байна.

### 3.1.11. ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛИЙГ АРИЛГУУЛАХ ТАЛААРХ ХЭРЭГ БҮРТГЭГЧ, МӨРДӨН БАЙЦААГЧИЙН МЭДЭГДЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 190-р зүйлд заасны дагуу гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар мэдэгдэл хүргүүлж, 1 сарын дотор түүний дагуу шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаар хариу авч ажилладаг. Энэ талаар мөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн нарийвчилсан зохицуулалт үйлчилж байна.

Үүний дагуу Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтсийн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн өнгөрсөн он буюу 2015 онд бичсэн давхардсан тоогоор 104 мэдэгдэлд дүн шинжилгээ хийлээ.<sup>23</sup>

**Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн мэдэгдэлд хийсэн дүн шинжилгээний тоон үзүүлэлт: (Хүснэгт.7)**

№	Хамаарах зүйл анги	Мэдэгдэл
1.	99 дүгээр зүйл. Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах	18
2.	215 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих	16
3.	145 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг хулгайлах	12
4.	211 дүгээр зүйл. Ойн тухай хууль тогтоомж зөрчих	3
5.	181 дугаар зүйл. Танхайрах	3
6.	98 дугаар зүйл. Бусдын бие махбодод хүндэвтэр гэмтэл санаатай учруулах	2
7.	148 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах	2
8.	96 дүгээр зүйл. Бусдын биед хүнд гэмтэл санаатай учруулах	1
9.	146 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг булаах	1
10.	150 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх	1
11.	91 дугаар зүйл. Хүнийг санаатай алах	1
12.	151 дүгээр зүйл. Алдуул мал, гээгдэл буюу санамсаргүй олдсон эд хөрөнгө завших	1
13.	110 дугаар зүйл. Доромжлох	1
	Нийт	62

**Хандсан байгуулга, аж ахуйн нэгж, албан тушаалтан: (Хүснэгт.8)**

№	Хэнд хандаж бичсэн	Мэдэгдэл
1.	Хороодын Засаг дарга, хэсгийн байцаагч нарт	32
2.	Аж ахуйн нэгж байгууллага, компаны захиргаанд	31

<sup>23</sup>Нийт бичсэн мэдэгдлүүдийн зарим хэсэгт дүн шинжилгээ хийсэн болно.

3.	Ерөнхий боловсролын сургуулийн захиргаанд	8
4.	Сумын засаг даргад	5
5.	Цагдаагийн хэлтсийн Архидан согтуурахтай тэмцэх ажил хариуцсан байцаагчид	4
6.	Хилийн тусгай ангийн захирагчид	3
7.	Мал бүхий иргэдэд	1
8.	Ахмадын хороонд	1
	Нийт	85

### Хэргийн төрлөөр гаргасан шалтгаан, нөхцөл:

#### 1. Хүний амь, бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөл (91, 96, 98, 99):

- Архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ бусадтай маргалдаж гэмтэл учруулсан.
- Гэмт хэрэг, зөрчил үйлдэгч этгээд хууль, эрх зүйн мэдлэг муу, биеэ авч явах чадвар, хувь хүний хүмүүжил доголдолтой зэрэгтэй холбоотой.
- Хувийн таарамжгүй харьцаа,
- Насанд хүрээгүй хүүхдийг зодох, дээрэлхэх, гэмтэл учруулах, эд зүйлийг нь дээрэмдэх явдал их байна.
- Үйлдвэр, аж ахуйн газар ажлын цагаар архи согтууруулах ундааны зүйл хэрэглүүлэхгүй байх. Хэрэглэсэн тохиолдолд хуулийн дагуу арга хэмжээ авч байх.
- Зочид буудал, караоке зэрэг олон нийтэд үйлчилгээ үзүүлдэг газрын ажилчдад хууль сурталчлах. Эдгээр газар шөнө оройн цагаар цагийн хуваарь хэтрүүлэн ажиллаж, архи, согтууруулах ундаагаар үйлчлэх, ажилчид нь иргэдтэй зүй бусаар харьцаж байна.
- Гудамжны гэрэлтүүлэг муу.
- Байрны орцны жижүүр ажилд авахдаа сайн судлах, бусадтай харьцахдаа ёс зүйн хэм хэмжээтэй байх, оршин суугчдаа таньдаг, бүртгэлтэй байх
- Тэмдэглэлт баяраар шалтаглан архидах явдал газар авсан
- Гэр бүл дэх таарамжгүй уур амьсгал
- Ёс суртахууны доголдолтой, гэр бүлийн хувьд тогтворгүй иргэдийн бодлогогүй үйлдэл
- Удаа дараа ял шийтгүүлж байсан, тогтворгүй зантай, ёс зүйн доголдолтой иргэдэд тавих хяналт сул
- Ахуйн хүрээнд байнга архи ууж, агсам тавьдаг, эрүүлжүүлэгддэг, архины эмчилгээнд хамрагддаг, захиргааны арга хэмжээ урьд нь авагдаж байсан, дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүсийн бүртгэл судалгаа нарийвчлан гаргах
- Тэдэнд хууль тайлбарлан өгч, таниулга хийн, гэмт хэргийн хор уршгийн талаар яриа хийх
- Нутаг дэвсгэрийн хэмжээнд олон нийтийн газар, хүн олноор цуглардаг газарт сэжигтэй хүмүүсийн биед үзлэг хийх, зэвсгийн чанартай авч яваа хутга мэсийг хурааж авах
- Ахуйн хүрээнд гэр орондоо байнга архи уудаг, агсам тавьдаг, жижгээр танхайрдаг иргэдийг бүртгэл, судалгаанд оруулах, тэдэнд хууль сурталчлах, таниулах, тайлбарлах
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлах ажил хангалтгүй байгааг анхаарч ажиллах

- Хүчирхийллийн шинжтэй, байнга гэр орондоо агсам, согтуу тавьдаг, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулдаг, байнга эрүүлжүүлэгддэг, архины эмчилгээнд явдаг, захиргааны арга хэмжээ авагдаж байсан, гэмт хэрэг үйлдэж болзошгүй иргэдийн судалгаа гаргаж ирүүлэх.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Захиргааны хариуцлагын тухай хуулиудыг иргэдэд таниулах, тайлбарлаж өгөх.
- Гэр бүлийн хүрээнд таарамжгүй харьцаа үүсгэж, байнга хэрүүл маргаан гардаг өрх айлыг бүртгэл судалгаанд авах.
- Иргэд хүнтэй зөв боловсон харьцаж чадахгүй, ёс суртахууны доройтлоос үүдэж, хоорондоо хэрэлдэж, маргалдах улмаар бие биендээ гэмтэл учруулах.
- Аж ахуйн нэгж, байгууллагад нэг дор ажиллаж байгаа ажилчид бие биеэ үл хүндэтгэх, ёс суртахуун, зан харьцааны соёлгүй байдал гаргаж, үл ойлголцох.
- Архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, хэрүүл, маргаан гаргаж, зодоон үймээн дэгдээх, бусдыг үл хүндэтгэх, хоорондоо үл ойлголцох, бусдыг хэл амаар доромжлох, замын хөдөлгөөнд соёлгүй оролцох, нэг нэгнээ үл тоомсорлох.
- Цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг үл тоомсорлон биед нь халдах.

## **2. Танхайрах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл (181):**

- Архидан согтуурсан үедээ танхайрах гэмт хэрэг үйлдсэн этгээд өмнө нь ял шийтгүүлж байсан, хэсгийн байцаагчийн тавих хяналт хангалтгүй, иргэдийн дунд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил хангалтгүйтэй холбоотой,

## **3. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөл (145, 147, 148, 150, 151):**

- Овор ихтэй эд зүйл авч яваа хүмүүсийг шалгах
- Хулгайн эд зүйл тээвэрлэсэн, зөөж үйлчилсэн, хувиараа таксины зориулалтаар явж буй, зогсоол, буудал дээр байнга зогсдог машин, тэдгээрийн жолоочийн судалгаа гаргах
- Орон байранд гарч байгаа хулгайлах гэмт хэргээс сэргийлэх зорилгоор иргэдэд энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэн гарахад юу нөлөөлж байгаа, урьдчилан сэргийлэх талаар яриа, таниулга хийх
- Хорооны хэсгийн байцаагч, эргүүлийн цагдаа нарын хяналт, сонор, сэрэмжийг сайжруулах.
- Тухайн хороо бүрт гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй этгээдүүдэд тавих хяналтыг сайжруулах, шөнө оройн цагаар, олон нийтийн эргүүл, жижүүр ажиллуулах.
- Албан байгууллагуудын орох, гарах хаалга, гадна, дотно талбайд гэрэлтүүлэг, камер байрлуулж, камержуулах талаар албан байгууллагуудад мэдэгдэл өгөх.
- Хорооны нутаг дэвсгэрт байгаа гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдийн бүртгэл, судалгааг шинэчилдэг байх.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг олон нийтэд таниулж, ухуулах, сурталчилгаа хийх талаар дорвитой арга хэмжээ авах.
- Тухайн хорооны нутаг дэвсгэрт хичнээн хүн хулгайлах гэмт хэрэгт холбогдоод байгаа талаар судалгаа гаргах.
- Шатахуун түгээх станцуудын харуул хамгаалалт, дотоод хяналт сул, дохиололгүй, холбооны хэрэгсэл дулимаг, бэлэн мөнгө хадгалах сейфгүй, гадна орчны гэрэлтүүлэг муу, түгээгчид ээлжиндээ ганцаараа үүрэг гүйцэтгэдэг учир дээрэм, булаалтын хэрэг удаа дараалан гарч байна.
- Эзэн холбогдогч нь тодорхойгүй хулгайлах гэмт хэргийн холбогдогчийг олж, тогтоох талаар тодорхой арга хэмжээ зохиох.

- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр тээврийн хэрэгслийн хяналтын цэгийг оновчтой тогтоон, шалгах ажил зохион байгуулах.
- Архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, өөрсдийн эд зүйлээ хараа, хяналтгүй орхиж, эд зүйлээ алдах нь их.
- Бэлчээрээс мал хулгайд алдагдаж байна.
- 2-р хорооны нутаг дэвсгэрт, тэр дундаа мянганы засмал зам дагуу малаа хараа хяналтгүй бэлчээдэг, малаа хариулгагүй орхисноос зам дээр тээврийн хэрэгсэлд мал дайрагдан зам тээврийн осол, зөрчил гарч байна.
- Аж ахуйн нэгж, байгууллага хүнд ажил олгохдоо хувийн байдал (өмнө нь ямар ажил хийж байсан, ямар шалтгаанаар гарсан, хувийн ёс зүй, хариуцлага хүлээх чадвар)-ыг сайтар судалдаг байх.
- Байгууллагын ажилчдын дунд сургалт зохион байгуулж, хариуцуулан өгсөн эд зүйлийг хадгалах, хамгаалах талаар баталгаа бичгээр авдаг байх.
- Камерын хяналт суурилуулж, бичлэгийг хадгалдаг байх.
- Виза карт гээгдүүлснийг олж, ашиглаж, мөнгө завшсан.
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд шунахайн сэдэлттэй гар утас, ухаалаг төхөөрөмжний хулгайн гэмт хэрэг ихээр гарах болсон, нийгмийн сүлжээгээр дамжуулан бусдыг гутаан доромжилсон, гүтгэсэн, садар самуунд уруу татсан гэх зэрэг хэрэг гарч байна.
- Өршөөлийн хуулиар суллагдсан болон энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдийн талаар судалгаа гаргаж, гэмт этгээдийг олж тогтоох талаар дорвитой ажил зохиох.

**Мэдэгдэлд тусгагдсан шалтаан, нөхцөлд үндэслэн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний санал:**

1. Гэмт хэрэг үйлдэж болзошгүй захиргааны болон хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй этгээдийн бүртгэлийг шинэчлэн, судалгааг баяжуулах, хяналт тавих,
2. Аж ахуйн нэгж, байгууллагуудын гадна орчинг стандарт шаардлага хангасан камер тавих, бичлэгийг тодорхой хугацаанд хадгалдаг байх /камертай боловч бичлэг хийдэггүй тохиолдол байдаг/
3. Байрны гадна, орц дотор, туслах замуудыг ч камержуулах нь зүйтэй.
4. Байрны СӨХ, орцны жижүүрүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах шаардлагатай байна. Орцны жижүүрээр ажилд авахдаа хэн, ямар хүн гэдгийг сайтар, шалгаж авах нь зүйтэй. Цагдаагийн байгууллагын туслах тоо бүртгэлийн санд орцны жижүүрийн судалгааг нарийвлчлан оруулж, баяжуулж байх,
5. Аж ахуйн нэгж, байгууллагуудад хэсгийн байцаагч, засаг дарга нар ухуулга, сурталчилгаа, сэрэмжлүүлэг тогтмол хийж байх,
6. Архидан согтуурдаг, бүлэг бөөгнөрөл үүсгэдэг айл өрхийг хэсгийн байцаагчтай хамтран ажиллаж тараах, албадан ажил хийлгэх нь зүйтэй,
7. Архаг архичид болон орчиндоо түгшүүр төрүүлэгч, эрсдэлтэй этгээдүүдийн судалгааг гаргаж, хяналт тавьж ажиллах,
8. Нутаг дэвсгэрийн хүрээнд гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй гэрэлтгүүлэггүй орчны судалгааг гаргаж, зохих албан тушаалтнаар дамжуулан дүүргийн ЗДТГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх,
9. Цахим орчин, ухаалаг төхөөрөмжийн зүй бус хэрэглээнээс үүдэн гарах хор, уршигийн талаар эцэг, эхчүүд, хороо хариуцсан хэсгийн байцаагч нарыг оролцуулан сургалт зохион байгуулах.

10. Хороодын засаг дарга, хэсгийн байцаагч, ГХУСАЗСЗ, олон нийтийн байцаагч, хэсгийн ахлагч нар хамтарч, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар үр дүнтэй ажил зохион байгуулах,
11. Аж ахуйн нэгж, байгууллага, ялангуяа архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдаалдаг газрын харуул манаа, харуул хамгаалалтын ажилтныг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах,
12. Ойн тухай хууль тогтоомж зөрчих, ялангуяа мод, модон материал хууль бусаар бэлтгэх, тээвэрлэх талаар хууль хяналт, нутгийн төрийн захиргааны холбогдох ажилтнуудад сургалт явуулах, энэ талаарх мэдээллийг иргэдэд хүргэх,
13. Гэмт хэргийн замаар олдсон эд зүйлийг авч болзошгүй цэг, хүмүүсийн дунд хяналт тавьж, гэмт бүлэг, бөөгнөрлийг тогтоон, тэдний дунд гэмт хэргийн талаар мэдээлэл олох ажиллагаа явуулж ажиллах,
14. Бусдаас мөнгө зээлж, бусдад өндөр хүүтэйгээр зээлүүлэх замаар санхүүгийн үйл ажиллагааг хяналтгүй явуулж байгаагийн улмаас залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэгдэж байгаа тул цагдаагийн байгууллага, хороод, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, холбогдох албан тушаалтан хяналтаа сайжруулах,
15. Бага насны хүүхдүүдэд тавих эцэг, эхийн хараа хяналтыг сайжруулах,
16. Хараа хяналтгүй болон эрсдэлд орж болзошгүй хүүхдийн зорилтод чиглэсэн ажил, арга хэмжээг Гэр бүл, хөгжлийн хэлтэс, цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх
17. Гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлд чиглэсэн арга хэмжээг хэсгийн ахлагчаар дамжуулан урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, тэдэнд дэмжлэг үзүүлж ажиллах,
18. Гэмт хэрэг, зөрчилд өртсөн, энэ талаарх мэдээ, мэдээллийг мэдсэн, дуулсан, харсан даруй цагдаагийн байгууллагад мэдэгдэж байх зурагт хуудас хэвлүүлж, нийтэд тараах, сэрэмжлүүлэх.

### **Дүгнэлт**

Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтсээс ирүүлсэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн мэдэгдэл нь тодорхой хэдэн төрлийн гэмт хэргийн шалгаан, нөхцөлийг арилгуулахаар хуулийн шаардлагын хүрээнд хүргүүлж, хариу арга хэмжээ авч ажиллаж байна. Тухайлбал, бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын бие махбодид хүнд, хөнгөн гэмтэл учруулах, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, алдуул мал, гээгдэл буюу санамсаргүй олсон эд хөрөнгө завших, бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах, танхайрах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, хүнийг санаатай алах зэрэг гэмт хэрэгт холбогдуулан шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл хүргүүлж ажилласан байна.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн мэдэгдлийн хэв, загвар, агуулга нь харилцан адилгүй, нэг мөрдөн байцаагчийн бичсэн мэдэгдэлүүдийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга хэмжээний саналууд хэргийн төрлөөр төстэй байгаагаас үзэхэд мэдэгдэл бичихдээ тухайн нэг гэмт хэргийн онцлогт хамаарах шалтгаан, нөхцөлийг тодорхойлж гаргадаггүй хуулийн шаардлагыг хэрэгжүүлэх төдийхнөөр хандаж байгаа нь харагдаж байна. Түүнчлэн, шалтгаан, нөхцөлд үндэслэсэн арга хэмжээний санал, даалгаварыг өгч байх нь зүйтэй гэж үзлээ.


Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 190-р зүйлд “гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тогтоомогц хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нь зохих хуулийн этгээдэд тэрхүү шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авахуулахаар мэдэгдэл бичиж хуулбарыг хэрэгт хавсаргана” гэж заасан байдаг. Гэтэл мөрдөн байцаагч нарын бичиж байгаа мэдэгдэл нь нэг загварт баригдсан, хэтэрхий товч, тухайн гэмт хэрэг гарахад чухам ямар шалтгаан, нөхцөл нөлөөлсөн талаар тодорхой дурддаггүй, мэдэгдлийн хариу авалт болон биелэлтийг газар дээр нь очиж шалгадаггүй, хэв журмын ажилтан хариуг өгөхдөө тодорхой ажил зохиодоггүй зэрэг байдал судалгааны явцад

ажиглагдав. Иймд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн ур чадвар, ажлын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

### 3.2. ЗӨРЧИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Зөрчил, дутагдлыг сайн илрүүлж, арга хэмжээ авах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлж буй гол үзүүлэлт гэж үздэг.


График 17. Багануур дүүрэгт бүртгэсэн захиргааны зөрчил



Багануур дүүрэгт 2015 онд зөрчил өмнөх оныхоос 41 хувиар өссөн, цаашид өсөх хандлагатай байна.

Багануур дүүргийн 2016 оны эхний 10 сарын байдлаар бүртгэсэн захиргааны зөрчил нь дүүргүүдийн хэмжээнд бүртгэж буй зөрчлийн 6.2 хувийг эзэлж байна. Гэмт хэргийн гаралтын хувьд 1.6 эзэлж байсан бол зөрчлийн хувьд өндөр үзүүлэлт байна.

График 18. 2014 оны эхний 10 сарын байдлаар бүртгэсэн зөрчил (дүүргээр)



**Багануур дүүргийн хэмжээнд 10191** зөрчил бүртгэсэн нь өмнөх оны мөн үеэс 35.6 хувиар буурсан байна.

Зөрчил гаргасан 9932 иргэн, 2 аж ахуйн нэгж, байгууллагыг 306.8 сая төгрөгөөр торгосон, 63 хүнд баривчлах шийтгэл тус тус оногдуулсан.

Захиргааны зөрчил гаргасан этгээдүүдэд **9616** буюу **94.4 хувьд нь 220.2 сая төгрөгөөр торгуулийн хуудсаар** Захиргааны хариуцлагын тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, бусад хуульд зааснаар арга хэмжээ авчээ.

- Торгуулийн хуудсаар арга хэмжээ авсан зөрчлийн 7762 буюу 80.7 хувь нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомж, дүрэм зөрчсөн зөрчил байна. Үүнд нийт 210.9 сая төгрөгийн торгууль ногдуулжээ.
- Торгуулийн хуудсаар арга хэмжээ авсан зөрчлийн 1750 буюу 18.2% нь Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан танхайрах (21 зүйл), 25 нь Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх, цагдаагийн байгууллагад худал мэдээлэл өгөх (30<sup>2</sup> зүйл), 31 нь Бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах (36 зүйл), 43 нь Худалдаа, үйлчилгээний журам зөрчих (42 зүйл) зөрчил байна.

Зөрчил гаргасан этгээдүүдэд **575** буюу **15.6 хувьд нь 316 иргэн, 2 аж ахуйн нэгж байгууллагад 86.6 сая төгрөгөөр шийтгэврээр торгосон болон тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, баривчлах шийтгэл оногдуулж, арга хэмжээ авчээ.**

- Шийтгэврээр арга хэмжээ авсан зөрчлийн 492 буюу **85.6%-г цагдаагийн алба хаагч**, 83 буюу 14.6%-г шүүгч шийдвэрлэжээ.
- Шийтгэврээр арга хэмжээ авсан **зөрчлийн Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан 173 буюу 30.0% нь** зөрчил байна. Үүний 122 буюу 18.2% нь танхайрах (21 зүйл), 29 нь Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх, цагдаагийн байгууллагад худал мэдээлэл өгөх (30<sup>2</sup> зүйл), 2 нь төрийн төлөөлөгчийн хууль ёсны шийдвэрийг биелүүлэхгүй байх, эсэргүүцэх /32/, 13 нь Бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах (36 зүйл), 7 нь Худалдаа, үйлчилгээний журам зөрчих (42 зүйл) зөрчил байна.
- **351 буюу 61.0% нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заасан**, 18 буюу 3.1% нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, 23 нь Тамхины хяналтын тухай хууль, 8 нь Галт зэвсгийн тухай хуульд заасан зөрчил байжээ.

### 3.3. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ БАЙДАЛ

Багануур дүүргийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг илэрхийлэх жилийн дундаж үзүүлэлтээс үзэхэд зам тээврийн ослын дуудлага 250 байдаг ба хэрэг, түүний улмаас нас баралт, хүн гэмтэх явдал нэмэгдэх хандлагатай байна.

Хүснэгт 9. Багануур дүүргийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг илэрхийлэх үзүүлэлт (2011-2015, 2016 оны эхний 10 сар)

Он	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг илэрхийлэх үзүүлэлт						
	Зам тээврийн осол, хэргийн дуудлага	Зам тээврийн осол, хэрэг	Хэрэг	Илрүүлж шийдвэрлэсэн зөрчил	Жолоочийн эрх хассан	Хүн нас баралт	Хүн гэмтсэн
2012	149	98/38	11	7275	236	4	17
2013	241	162/42	19	5753	311	5	21
2014	329	253/57	15	12518	459	4	27
2015	137	97/13	22	14062	342	4	13
2016 оны эхний	196	112/24	33	4521	95	6	28



10 сар							
--------	--	--	--	--	--	--	--

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/284 дугаар тушаалаар баталсан орон тоогоор тасгийн дарга 1, зохицуулагч 4, цагдаа зохицуулагч 7 нийт 12 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр дүүргийн нутаг дэвсгэрт болон Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудаас зүүн чиглэлийн мянганы хэвтээ тэнхлэгийн дагуух замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслүүдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 24 цагийн үйл ажиллагаагаар хяналт шалгалтыг явуулж байна.

2010 онд Нийслэлийн ИТХ, дүүргийн Засаг даргын тамгын газар, Замын цагдаагийн газрын даргын шийдвэрээр зүүн чиглэлийн мянганы хэвтээ тэнхлэгийн замд хяналт тавих үүрэг бүхий 24 цагийн үйл ажиллагаатай байнгын хяналтын цэгийг ашиглалтанд оруулж, зөвхөн хяналтын цэгт 4 зохицуулагч, 4 цагдаа зохицуулагчийг 24:72 цагаар үүрэг гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн.

Тус тасгийн албан хэрэгцээнд Кио Рио маркын тээврийн хэрэгсэл 1, согтуурал шалгах драйвер багаж 1, хурд хэмжигч багаж 1, утаа хэмжигч багаж 2, бэлэн бус торгуулийн төхөөрөмж 2, байнгын хяналтын постонд хяналтын камер 3, тасгийн хэмжээнд компьютер 6, хувилагч машин 3, фото зургийн аппарат 4 зэрэг техник тусгай хэрэгслийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

2015 оны тээврийн хэрэгслийн улсын үзлэг оношлогоонд 6874 тээврийн хэрэгсэл хамрагдсанаас “БРА” серийн дугаартай тээврийн хэрэгсэл 5850, “УБ” серийн улсын дугаартай 1024 тээврийн хэрэгсэл бүртгэлд хамрагдсан байна.

Мөн хил залгаа Төв аймгийн Мөнгөнморьт суманд 237, Баяндэлгэр суманд 152, Хэнтий аймгийн Цэнхэрмандал суманд 172 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байдаг.

Эдгээр сумын иргэд нь мянганы болон дүүргийн нутаг дэвсгэрийн замаар байнга зорчин, дамжин өнгөрч замын хөдөлгөөнд оролцдог нь зам тээврийн осол гэмт хэрэг, захиргааны зөрчлийн өсөлтөнд нөлөөлдөг байна.

Дүүргийн нутаг дэвсгэрт 7435 орчим тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцдог. Дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд 3 цагдаа зохицуулагч хяналт тавьж байна.

Мянганы хэвтээ тэнхлэгийн авто замд 24 цагийн үйл ажиллагаатай хяналтын цэгээр дайран өнгөрч байгаа тээврийн хэрэгслийг 2015 оны 06 сарын 05-ны өдрийн өглөөний 09:00 цагаас 2015 оны 06 сарын 06-ны өглөөний 09:00 цаг хүртэл хоногийн 24 цагийн хугацаанд тооллого явуулахад 1550-1680 тээврийн хэрэгсэл өнгөрч байгаа нь хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байгаа 2 албан хаагчид тус бүр 840 тээврийн хэрэгсэл ногдож байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 153 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Цагдаагийн байгууллагын зарим ажил үйлчилгээ, хангалтын жишиг нормативд заасан Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий 1 алба хаагчид 350 тээврийн хэрэгсэл ноогддог жишигтэй харьцуулахад 490 нэгжээр их буюу 49%-р их байна.

Тасгийн албан хэрэгцээнд Кио-Рио маркийн суудлын 1 тээврийн хэрэгсэл ашиглаж байгаа бөгөөд хоногт 75 км замд хяналт тавих нормтой. Энэ нь дүүргийн нутаг дэвсгэрт болон хариуцсан зам маршрутанд хөдөлгөөнт эргүүлээр ажиллах, мөн баталгаат бус автозамд хяналт тавьж мал хулгайлах, байгаль орчны эсрэг гэмт хэргийн илрүүлэлтийг ахиулах, нөхцөл бололцоо бүрдэхгүй байна.

Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Төв аймгийн Мөнгөнморьт, Баяндэлгэр суманд гарсан зам тээврийн осол, хэргийг гомдол, мэдээллийг хүлээн авч хойшлуулшгүй ажиллагаа явуулан шалгаж шийдвэрлэх, тухайн сумдад болон орон нутгийн замд гарч байгаа зам тээврийн осол хэргийг бууруулах зорилгоор хяналт шалгалтыг тогтмол явуулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой төрлийн арга хэмжээ зохиох, дүүргийн байгууллага, аж ахуйн нэгжид гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт

явуулах, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ажиллах хүн хүч, техник хэрэгсэл, шатах тослох материалын хүрэлцээ, норм хангалтгүй байна.

24 цагийн үйл ажиллагаатай хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагч нараас ээлжийн амралт авах, урт хугацааны сургалтанд хамрагдах, өвчлөх гэх мэт шалтгаанаар албан хаагчдын ажил амралтын хуваарьт өөрчлөлт орж ачаалалтай ажилладаг.

Тус тасгийн алба хаагчдаас 1 зохицуулагч ээлжийн амралттай, 1 зохицуулагч жирэмсний хяналтанд байгаа тул ажлын байрны нөхцөлөөс шалтгаалан гомдол мэдээллийн шийдвэрлэлтэд ажиллаж, 2 зохицуулагч 24 цагаар дуудлага хүлээн авч, мөн замын цагдаагийн хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж, байнгын хяналтын цэгээс буусан цагдаа зохицуулагч буусан өдрөө амарч, дараа өдөр нь дүүргийн төвийн замд хяналт шалгалтанд ажиллаж дахин дараа өдөр нь байнгын хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байна.

#### **БҮЛЭГ 4. БАГАНУУР ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Багануур дүүргийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн “Аюулгүй амгалан Багануур хот” хэсгийн гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх талаар үндсэн үйл ажиллагаа, түүний биелэгдсэн байдал, дүүргийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх зорилт, засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт<sup>24</sup>-тай уялдуулан зорилгыг хангах хүрээнд дүүргийн иргэдийн аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хууль сахиулах байгууллагуудтай хамтран олон нийтийн оролцоонд түшиглэн үйл ажиллагааг зохион байгуулан гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилтыг хэрэгжүүлэх олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлсэний үр дүнд зорилго тодорхой түвшинд хангагдаж, зорилтоо хэрэгжүүлж ирсэн гэж тайлан гарсан байна.

##### **4.1. “АЮУЛГҮЙ АМГАЛАН БАГАНУУР” ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

**Санаа өгдөггүй судалгааг хэрэгжүүлэх боломжгүй, Судалгаагүй санаа үр дүнгүй**<sup>25</sup> гэдэг анхааруулгын санаа нь аливаа эрх зүйн үндэс, угсаа гарвал, ирээдүйн хандлага, амьдралд өрнөж байгаа үйл явц, зөрчилдөөний гарал үүсэл, хандлагыг, өөрөөр хэлбэл аливаа үзэгдлийн философийг сайтар танин мэдэх хэрэгтэй.

Энэ нь нэгэнт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг арга буюу шийтгэхээс өмнө тухайн гэмт үйлдэл, үйл ажиллагаа бий болохоос урьдчилан сэргийлэх явдал өнөөгийн соёлт хүн төрөлхтний өмнө тулгамдсан асуудал болсон.

Аюулгүй байдлын нэг чухал хэсэг нь хүний аюулгүй байдал<sup>26</sup>, тэдэнд аюулгүй орчин нөхцөлийг бий болгох нь аль ч улс орны засгийн газрын нэн тэргүүний үүрэг төдийгүй цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны анхдагч хэсэг мөн.

Багануур дүүрэг засаг, захиргааны анхан шатны нэгжийн хувьд нийт 5 хороотой хүн амын тооны хувьд нийслэлийн дүүргүүдтэй харьцуулахад харьцангуй цөөн боловч зорилтод болон дамжин өнгөрөх хүний хөдөлгөөний эрчим ихтэй, уул уурхай, эрчим хүч, мал аж ахуй, аялал жуулчлалын салбар зэрэгцэн оршиж, эрчимтэй хөгжиж байгаа төдийгүй 2 аймгийн 6 сумтай хил залгаа оршдог тул нийт сумдын иргэдэд соёл боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийтийн тээвэр, худалдаа үйлчилгээгээр бүрэн хангаж

<sup>24</sup>Багануур дүүргийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн заалт.

<sup>25</sup>Аливаа сургалт, судалгааны зорилго, үнэт зүйл нь үүнд оршино. Сургалт, судалгаа нь боломж, чадварт суурилсан, зорилгод чиглэсэн, сэтгэлгээнд өөрчлөлт оруулах цогц үйл явц гэж тодорхойлж болно:

<sup>26</sup>Монгол Улсын Үндсэн хууль 1992, 2 бүлэг 19 зүйл “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”.

байдаг өвөрмөц онцлогтой алслагдсан дүүргийн нэг бөгөөд гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх жингээрээ (гэмт хэргийн тоог хүн амд харьцуулсан байдлаар) бусад дүүрэгтэй харьцуулахад харьцангуй тайван мэт боловч байгаль орчны болон нийгмийн аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх нөхцөл, эрсдэл зарим дүүргээс харьцангуй их байна.

Нийслэлийн Багануур дүүргийн хэмжээнд сүүлийн 3 жилийн хугацаанд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжилт, үр дүнд анализ дүн шинжилгээ хийхдээ 2015 оны урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн нэг бүрийг Цагдаагийн хэлтсийн албад, нэгжээс гаргаж ирүүлсэн баримт бичиг, тайлангийн хүрээнд авч ашигласан.

Тус ажлын хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй амгалан тайван байдлыг хангах талаар нийслэл, дүүргийн үйл ажиллагааны бодлого<sup>27</sup>, цагдаагийн байгууллагын зорилтын хэрэгжилт, үр дүн, үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, дүүргийн онцлогыг тодорхойлохыг зорьсон ба түүнчлэн гэмт хэрэг, зөрчлийн өнөөгийн шалтгаан, нөхцөл байдлыг бүхий л цар хүрээнд баримт бичигт дүн шинжилгээ хийх аргаар дэлгэрэнгүй гаргасан болно.

### **Нэг. Хотын аюулгүй байдлыг ханган, хэв журмыг сахиулах хүрээнд:**

**Зорилт-1:** Архи, тамхи худалдан борлуулахад тавих хяналтыг сайжруулах, тэдгээрийн хэрэглээг үл тэвчих орчин ба соёлыг төлөвшүүлэн архи согтууруулах ундаа хэрэглэдэггүй, эрүүл идэвхтэй амьдралын төлөөх клуб, холбоо байгуулах иргэдийн санаачлагыг бодлогоор дэмжинэ<sup>28</sup>.

**Төлөвлөсөн ажил:** Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд архи, тамхины зохисгүй хэрэглээнд тавих хяналтыг сайжруулах, залуу үеийг зөв төлөвшүүлэхэд чиглэсэн ажлыг хэрэгжүүлэх.

#### **Гүйцэтгэх ажил:**

1. Архи, тамхи худалдан борлуулахад тавих хяналтыг сайжруулах, архи, тамхины хэрэглээг үл тэвчих орчин ба соёлыг төлөвшүүлэн архи согтууруулах ундаа хэрэглэдэггүй, эрүүл идэвхтэй амьдралын төлөөх клуб, холбоо байгуулах иргэдийн санаачлагыг бодлогоор дэмжих.

2. Архинд донтох өвчтэй хүмүүст зориулан архины хор хөнөөлийн талаар сургалт явуулах, тэднийг нийгэмшүүлэх зорилгоор мэргэжлийн сургалтад (үсчин гоо сайхан, мужаан, гар урлал зэрэг) хамруулах арга хэмжээ авах.

3. Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих үйл ажиллагааны цахим мэдээллийн санг боловсронгуй болгож мэдээлэл, сургалт, сурталчилгаанд өргөнөөр ашиглахаас гадна онлайн сүлжээгээр зөвлөгөө өгөх ажлыг эрчимжүүлэх.

4. Жил бүрийн 5 дугаар сарын эхний долоо хоногийн Бямба гарагт “Архи, тамхигүй ирээдүй” сэдэвт биеийн тамир, спортын арга хэмжээг залуусын дунд зохион байгуулах.

5. Гүн галуут цогцолбор, 125 дугаар сургуулийн захиргаатай хар тамхи, мансууруулах бодисын хор уршиг, аюулын талаар түүнтэй тэмцэх хүүхдийн сайн дурын бүлгэм байгуулах ажлыг сургуулийн захиргаа, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.

<sup>27</sup>Нийслэл, дүүргийн нийгэм эдийн засгийн 2016 оны зорилт, нийслэл, дүүргийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн тодорхой заалтын хэрэгжилт, үр дүн.

<sup>28</sup>Багануур дүүргийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн заалт, зорилтын 5.1.1. дэх заалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө.

6. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэх, нэвтрүүлэх, богино хэмжээний сурталчилгааг бэлтгэн явуулах.

7. Тамхины хяналтын тухай хууль, холбогдох эрх зүйн баримтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх болзолт уралдааныг зохион байгуулах.

8. Тамхигүй аж ахуйн нэгж байгууллага шалгаруулах болзолт уралдааныг зохион байгуулах.

9. Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих сайн дурын идэвхтэнүүдийг бэлтгэх сургалт зохион байгуулах.

10. “Тамхи татахгүй, худалдаалахгүй өдөр”-үүдэд тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа үйлчилгээ, хэрэглээнд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран хяналтыг хийх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах.

11. Тамхины хяналтын хуулийн хэрэгжилтэнд жил бүр хяналт тавьж үнэлгээ хийх.

#### **Хэрэгжүүлсэн ажил:**

1. Архины хортой хэрэглээг бууруулах чиглэлээр архинд донтох эмгэгтэй гэх дүгнэлт гарсан 22 хүнээс 2 хүний архины албадан эмчилгээнд хамруулж, сайн дурын эмчилгээнд 8 хүнийг хамруулсан, дүүргийн ерөнхий боловсролын 2 сургуулийн 227 сурагчдад архи, тамхи, мансууруулах бодисын хор хөнөөл сэдвээр сургалтыг 2015 оны 10 сарын 08-ны өдөр зохион байгуулж ажилласан, Архины эсрэг ассоциацитай хамтран архины хор хөнөөлийг харуулсан “**Түлхүүр**” сургалтын кино хичээлийг архины хамаарал бүхий 23 хүнийг харуулсан сургалтаар санал хүсэлт авч, цахим хэлбэрээр зөвлөгөө өгөх ажлыг 2 удаа зохион байгуулсан.

2. Дэлхийн зөн, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвтэй хамтран архинд донтох өвчтэй 10 хүнийг гэр бүлийн хамтаар сургалтанд хамруулж тэдний зан төлөвийг өөрчлөх чиглэлээр 40 цагийн сургалт явуулсан. Мөн архинд донтох өвчтэй 2 хүнийг дүүргийн архины эсрэг ассоциацийн мэргэжилтнүүдтэй уулзуулж сургалт явуулж тэднийг нийгэмшүүлэх гэртэй болгох асуудлыг дүүргийн засаг даргаар шийдвэрлүүлсэн. Дүүргийн архины эсрэг ассоциацийн ажилтан Анхбаяр, Отгонбат нарын хамт 2015 оны 10 дугаар сарын 21-ны өдөр 15-17 цагийн хооронд хэлтсийн хурлын зааланд архины хамааралтай 23 иргэнийг хамруулан “**Түлхүүр**” нэртэй архины хор уршгийн талаар хийсэн кино хичээлийг үзүүлж тэдний зан төлөвийг өөрчлөх чиглэлээр сургалт зохион байгууллаа.

3. Дүүргийн архины эсрэг ассоциацийн ажилтнуудтай хамтран олон нийтийн сүлжээгээр сургалт явуулах, зөвлөгөө өгөх ажлыг хэрэгжүүлж цахим сүлжээгээр зөвлөгөө өгөх ажлыг 2015 оны 10 дугаар сарын 13-нд эхлүүлсэн. Цахим сүлжээгээр нэгдсэн хүмүүст дүүргийн архины эсрэг ассоциациас тогмтол зөвлөгөө өгч өргөжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

4. Бүх нийтийн гүйлтийн арга хэмжээг дүүргийн хэмжээнд 2015 оны 05 дугаар сарын 09-нд зохион байгуулж явуулсан.

5. Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, ахуйн хийн хор уршгийн талаар орон нутгийн телевиз болон төв талбайд байрлах дэлгэцээр 4 удаа сэрэмжлүүлэг явуулсан.

6. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээлийн зуны амралтын үеэр Тэмүүлэл зусланд амарсан 45 сурагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвийн мэргэжилтнүүдтэй хамтран 4 удаа сургалт зохион байгуулсан. Хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг төрийн бус байгууллагатай хамтран гэр бүлийн хүчирхийллийн байдалд мониторинг хийхээр санаачилсан судалгаа мэдээллээр хангах ажилд туслалцаа үзүүлж хамтран ажиллаж байна. Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2015 оны 09 дүгээр

сарын 21-ний өдөр ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтнууд, дүүргийн боловсролын хэлтэстэй хамтарсан уулзалтыг зохион байгуулж хичээлийн жилийн сургалтын төлөвлөгөөнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр хийх сургалтын саналыг авч ажилласан.

7. Дүүргийн Гүн-галуут, Боловсрол цогцолбор, 125-р сургуулийн 8-11 ангийн 227 сурагчид 2015 оны 10 дугаар сарын 8-ний өдөр дүүргийн ЭМН-н төвийн эмч нартай хамтран “Архи,тамхи, мансууруулах бодисын хор хөнөөл” Архидан согтуурахтай тэмцэх тухай, Тамхины хяналтын тухай хуулийн талаарх сургалтыг “Өргөө соёлын төв”-н танхимд 13-14 цагийн хооронд зохион байгуулан ажиллаа.

8. 2015 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс зохион байгуулж энэ ажлын хүрээнд олон нийтийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, эрсдлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар гарын авлага 400 тарааж санамж сэрэмжлүүлэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хамтын ажиллагааг эрчимжүүлж эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэхэд хүн бүрийн оролцоо чухал шаардлагатай байгааг ойлгуулах зорилгоор дүүргийн төв талбайд байрлах лед дэлгэцээр 2015 оны 10 дугаар сарын 5-с 7-ны хооронд өдөр бүр шторк 5-г явуулсан. Мөн проектороор энэ төрлийн сурталчилгааны шторкуудыг явуулж олон нийтэд мэдээлсэн. Архи тамхины хор хөнөөлийг сурталчлан 2015 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр ерөнхий боловсролын сургуулийн 260 сурагчыг хамруулан сургалт сурталчилгааны ажлыг явуулсан.

9. 2015 оны 09 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 02-ны хооронд архи, тамхи, мансууруулах бодисын хор хөнөөл сэдэвт гар зургийн уралдаанд дүүргийн ерөнхий боловсролын 4 сургуулийн 137 сурагч хамрагдсан. Дүүргийн Гүн-галуут, Боловсрол цогцолбор, 125-р сургуулийн 8-11 ангийн 227 сурагчдад 2015 оны 10 дугаар сарын 8-ний өдөр дүүргийн ЭМН-н төвийн эмч нартай хамтран “Архи, тамхи, мансууруулах бодисын хор хөнөөл”, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хуулийн талаар сургалтыг “Өргөө соёлын төв”-н танхимд 13-14 цагийн хооронд зохион байгуулан ажилласан байна.

10. Цагдаагийн хэлтсээс аж ахуйн нэгжүүдийн дунд тамхигүй орчин бүрдүүлсэн аж ахуйн нэгж шалгаруулах уралдааныг зохион байгуулж дүүргийн Гүн галуутай цогцолбор сургуулийг шалгарууллаа. Энэ ажлын хүрээнд зохион байгуулсан гар зургийн уралдаанд Гүн галуутай цогцолбор сургуулийн 5 сурагч, Сод сургуулийн 5 сурагч, 125-р сургуулийн 2 сурагчийн бүтээл шалгарч бүтээлд олгох шагналын 150000 төгрөгийн санг дүүргийн Гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс гаргуулжээ.

11. Эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэхэд хүн бүрийн оролцоо чухал шаардлагатай байгааг ойлгуулах зорилгоор дүүргийн төв талбайд байрлах лед дэлгэцээр 2015 оны 10 дугаар сарын 5-с 7-ны өдрүүдэд шторк 5-г явуулсан байна.

Тамхины хор хөнөөл дам тамхидалтаас үүдэх эрсдэл тамхинаас үүдэлтэй өвчлөлийн талаар мэдээллийг орон нутгийн “Сүлжээ-3” телевизээр 8 удаа явуулж ажиллажээ.

12. Тамхины хяналтын тухай хуулийг зөрчсөн 49 зөрчил илрүүлж нийт 49 хүнийг 2450000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан. Үүнээс давтан зөрчил гаргасан 4 аж ахуйн нэгж байна. Зөрчлийг арилгуулахаар 4 мэдэгдэл бичин хариуг авсан байна.

**Дүгнэлт:** Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн зорилт-1 дэх хэсэгт төлөвлөсөн 11 ажлыг хэрэгжүүлэх хүрээнд Цагдаагийн хэлтэс хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу нийт 13 ажлыг тодорхой төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгуулсан ажилласан нь үр дүнгээ өгсөн байна.

Гэвч хэрэгжүүлсэн ажил нь урьдчилан сэргийлэх онолын хувьд нийтлэг шинжтэй, шинэлэг биш нэг хэв маягтай, өөр хоорондоо давхцсан томьёололтой, урд жилийн

төлөвлөгөө, биелэлтийг хуулбарласан, шинжлэх ухааны мэдлэг, арга зүй, техник хэрэгсэл ашиглалт хангалттай биш, төлөвлөлт, тайлан гаргахдаа бодит үр дүнг илэрхийлээгүй, бичилт нь утга найруулга, эрх зүйн соёл, үгийн сонголт оновчтой бус хэрэглэх хандлагатай байна.

**Зорилт-2:** Гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд гардаг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, “**хөршийн хамгаалалт**” иргэдэд суурилсан амгалан тайван байдлын тогтолцоо бүрдүүлнэ<sup>29</sup>.

#### **Гүйцэтгэх ажил:**

1. Хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг шуурхай таслан зогсоох,
2. Хохирогч болон гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэндийг мэргэжлийн түвшинд шуурхай хамгаалах,
3. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах тухай шүүхийн шийдвэрийг шүүхээс нэн даруй гаргуулах,
4. Хохирогчийн аюулгүй байдлыг хангасан түр хамгаалах байрны сүлжээг бий болгох ажлыг зохион байгуулах,
5. Гэр бүлд мэдээлэл, зөвлөгөө, туслалцаа өгөх зорилгоор 24 цагийн утас ажиллуулах, үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй болгох.
6. Нийгмийн ажил, сэтгэл зүй, эрх зүйн үйлчилгээг нэг цэгийн буюу хамтарсан багийн хэлбэрээр хүргэх,
7. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сэтгэл засал, зөвлөгөө өгөх, чадавхжуулахад чиглэсэн албадан сургалтын хөтөлбөр гарган сургалт явуулах, хэрэгжүүлэх,
8. Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настны эсрэг хүчирхийллийн тархац, тандалтын талаарх судалгааг хийх.
9. Бүх шатны боловсролын байгууллагад сургалт орох.
10. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах,
11. Хохирогчийг чадавхжуулахад чиглэсэн ухуулга, сурталчилгаа, сургалт явуулах,
12. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ойлголт, мэдлэг, хандлага, ухамсарыг дээшлүүлэх энэ талаарх хууль тогтоомжийг сурталчлахад зориулсан зөвлөмж, гарын авлага, материалуудыг боловсруулах,
13. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх иргэд, олон нийтийн ойлголт, мэдлэг, эрх зүйн ухамсрыг дээшлүүлэх, энэ төрлийн хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах,
14. Олон нийтэд зориулсан албан бус сургалт, сурталчилгааны ажлыг төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулах.
15. Гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх ажлыг архидан согтуурахтай тэмцэх үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлэх,
16. Хүчирхийлэлтэй гэр бүл болон хүчирхийлэл үйлдэгчийн тархалтын судалгааг хийх.
17. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг цуглуулж сан бүрдүүлэх, статистик мэдээллийг боловсронгуй болгох замаар мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгон хөгжүүлэх,

<sup>29</sup>Багануур дүүргийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн заалт, зорилтын 5.1.2 дэх заалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө.

18. Цагдаагийн албан хаагч нарт хууль тогтоомжоор хүлээлгэсэн нийтлэг болон тусгай үүрэгтэй нь холбогдуулан цогц сургалтыг тогтмол зохион байгуулах.

19. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, үйлчилгээний чанарт хяналт тавьж, үр дүнг нь үнэлж дүгнэн, сайжруулах ажлыг зохион байгуулах,

20. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн санал санаачлагыг дэмжин, хөрөнгө нөөцийг бүрдүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх,

21. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түр хамгаалах байрны үйл ажиллагаа, хамтарсан багийн ажлыг эрчимжүүлэх арга зүйн зөвлөмж өгөх сургалтанд албан хаагчдыг хамруулах,

22. Гэр бүлийн хүчирхийлэл, хүн худалдаалах, хар тамхи, мансууралтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, олон нийтэд холбогдох хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулах,

23. Гэр бүлийн хүчирхийлэлд байнга өртдөг хүүхдүүдийн судалгааг гаргах, хүчирхийллээс өөрийгөө хэрхэн хамгаалах талаар тэдэнд мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалтыг явуулах,

24. Гэр бүлийн асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэх харилцааг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион явуулах тусгай танхим байгуулах, уг сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу явуулах,

#### **Хэрэгжүүлсэн ажил:**

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр дуудлага мэдээлэлд 164 удаа очиж, хүчирхийлэл үйлдэгч 136 хүнийг саатуулан 13 хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах санал хүргүүлсэн, хүүхэд гэр бүл хөгжлийн төв болон хорооны нийгмийн ажилтнуудтай хамтран 15 хүнд хяналт тавьж ажиллаж байна.

2. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон 28 иргэний гомдлыг эрүүгийн хэрэг үүсгэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн сэжигтэн А-г сэжигтнээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан. Хохирогч иргэн болон гэр бүлийн гишүүдийн амь нас эрүүл мэндэд хохирол учирсан зөрчил, дутагдал гараагүй.

3. Гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 3 дугаар шүүхэд 13 этгээдийн эрхийг хязгаарлах хүсэлт гаргаж эрхийг хязгаарлах арга хэмжээ авахуулсан ба 2 этгээдийн нарын эрхийг хязгаарлах хүсэлтийг шүүхэд хүргүүлээд байна.

4. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл хүлээн авах 107 болон дүүргийн цагдаагийн хэлтсийн жижүүрийн шуурхай албаны 7021102 дугаарын утаснуудад дуудлага мэдээллийг хүлээн авахаас гадна дүүргийн цагдаагийн хэлтэст үүрэн телефоны Юнителийн 88220089, Мобикомын 94945443, Жи мобайлын 93022370 дугаарын утас 24 цагаар ажиллаж байна.

5. Тус дүүргийн 5 хороонд хэсгийн байцаагч, хорооны нийгмийн ажилтан, хамтарсан багийг ажиллуулж тэдний үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын тамгын газрын нийгмийн хөгжлийн хэлтсээс хамтарсан багийн дунд болзолт уралдаан зохион байгуулсан. Хороодын хамтарсан багаар нийгмийн ажилтан, өрхийн эмнэлэг, сургуулийн нийгмийн ажилтан, халамжийн ажилтан, хэсгийн байцаагч нар хорооны ажлын байранд нөхцөл байдлын үнэлгээг хамтран хийж ажиллаж байна. Сар бүрийн 25-нд хийсэн ажлын мэдээг авч нийгмийн хөгжлийн хэлтэст дүгнэн ажиллаж байна.

6. Шүүхээс албадан сургалтанд хамруулах шийдвэр гаргасан 6 хүнд 2015 оны 10 дугаар сарын 28, 29-нд хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвтэй хамтран гаргасан төлөвлөгөөний дагуу 2 удаа сургалтыг зохион байгуулж ажиллаа. 2015 оны 05 дугаар сарын 15-наас хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвийн сургагч багш нартай хамтран Дэлхийн

зөн олон улсын байгууллагын санхүүжилтээр архи хэтрүүлэн хэрэглэдэг 10 иргэнийг гэр бүлийн хамтаар тэдний зан төрхийг өөрчлөх чиглэлээр 40 цагийн сургалт зохион явуулсан.

7. Сар бүр судалгааг гарган гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэст хүргүүлж ажиллаж байна. 2015 оны 10 дугаар сарын байдлаар дээрх судалгааг гаргаж хүргүүлсэн.

8. Хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвтэй хамтран 2015 оны 03 дугаар сарын 12-ны өдөр дүүргийн удирдах 18 албан тушаалтан, 5 мэргэжилтэн хамруулан “Боловсрол” цогцолбор, “Гүн галуутай”, “Сод”, 125 дугаар сургуулийн 9-11 дүгээр ангийн 90 сурагчдын дунд **“танд хүргэх бидний үг”** сэдэвт уулзалтыг зохион байгуулан, гэмт хэргийн улмаас хүүхдэд учрах хор уршиг болон хүүхдийг гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгч сурталчилан ажилласан. Тус дүүрэгт их дээд сургууль байхгүй болно. 2015 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтнууд, дүүргийн боловсролын хэлтэстэй хамтарсан уулзалтыг зохион байгуулж хичээлийн жилийн сургалтын төлөвлөгөөнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр хийх сургалтын саналын авч ажиллаа.

9. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 7 хохирогчийг дүүргийн хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвийн сэтгэл зүйч нартай нэн даруй уулзуулж зөвлөгөө өгүүлсэн. 2015 оны 07 дугаар сарын 08-ны өдөр 3 дугаар хорооны 35 иргэнийг хамруулан цагдаагийн хэлтэс, хорооны хэсгийн байцаагч нарын хагас жилийн ажлын тайланг танилцуулж, гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр иргэдээс санал асуулга авсан.

10. Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвтэй хамтран гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга сэдвээр 5 хороодын 250 иргэнд 8 удаа сургалт зохион байгуулсан.

11. Ахуйн хүрээнд гэр бүлийн маргаан үүсгэсэн иргэдтэй уулзаж, холбогдох хуулийн заалтыг танилцуулан баталгаа гаргуулан авч, хэсгийн байцаагч нар гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвөөс боловсруулсан 34 санамж, сэрэмжүүлэг тараан ажилласан. Хууль тогтоомж сурталчлах өдөрлөгийг 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 11-16 цагийн хооронд дүүргийн Засаг даргын тамгын газрын хурлын зааланд “Нээлттэй хаалга”-ны өдрөөр гэр бүлийн хүчирхийллийн эсрэг 100 ширхэг гарын авлага, сэрэмжлүүлэг тараан ажилласан.

12. Олон нийтэд зориулж иргэд, байгууллагыг гэмт хэрэг, зөрчилд өртөх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, зорилгоор телевизээр 10, гарын авлага 1, аж ахуйн нэгж байгууллага 45, иргэд 1500 хүнд яриа таниулга, сэрэмжлүүлэг, 7 хоног бүрийн 1 дэх өдөр иргэдэд BBS, Сүлжээ-3, Наран телевизээр иргэд олон нийтэд мэдээлэл хийж ажиллаа. Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвтэй хамтран гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга сэдвээр 5 хороодын 250 иргэнд 8 удаа сургалт зохион байгуулсан.

13. Байнга архидан согтуурч орчиндоо түгшүүр төрүүлдэг 23 хүнийг дүүргийн Эрүүл мэндийн үзлэгт хамруулж архинд донтох өвчтэй дүгнэлтийг гаргуулж дүүргийн иргэний хэргийн 3 дугаар шүүхэд архины албадан эмчилгээнд хамруулахаар материалыг шилжүүлсэн. Сайн дурын эмчилгээнд 6 хүн хамруулж, архины албадан эмчилгээнд 1 хүнийг шүүхийн шийдвэрээр хамруулж, 1 хүнийг албадан эмчилгээнд явуулахаар 2015 оны 11 дүгээр сард материалыг шүүхэд хүргүүлсэн.

14. Сар бүр судалгаа гарган гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэст хүргүүлж ажиллаж байна. 2015 оны 05 дугаар сарын байдлаар дээрх судалгааг гаргаж хүргүүлсэн. 2015 оны 05 дугаар сарын 05-с гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн ойлголт мэдлэгийг тандах зорилгоор 700 иргэнээс судалгаа авч боловсруулж байна.



15. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч 51, гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон 28 хүний судалгааг цагдаагийн байгууллагын нэгдсэн санд бүртгэсэн.

16. “Дэлхийн зөн” олон улсын байгууллагатай хамтран 2015 оны 03 дугаар сарын 5, 6-ны өдрүүдэд Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах хорооны хамтарсан багийн сургалтыг зохион байгуулж хороо хариуцсан хэсгийн байцаагч, хүүхдийн байцаагч нарыг хамруулан ажилласан. 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдөр дүүргийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан хамтарсан багийн сургалтанд хороо хариуцсан хэсгийн 5 байцаагч, олон нийтийн цагдаагийн 4 ажилтанг хамруулсан. 2015 оны 07 дугаар сарын 07-ний өдөр дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс, хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвийн мэргэжилтнүүдийг оролцуулан хороодын хамтарсан багийн хагас жилийн ажлыг дүгнэн “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар хамтарсан багуудад зургийн аппарат, нуруулдагчаар хангалаа. Цаашид анхаарах асуудлын талаар 2 цагийн сургалтыг зохион байгуулав. Энэ арга хэмжээнд 5 хорооны засаг дарга нар, нийгмийн ажилтнууд, хорооны 6 хэсгийн байцаагч, 5 хорооны цагдаа, 6 олон нийтийн цагдаагийн ажилтнууд, өрхийн эмч нар, халамжийн хэлтсийн ажилтнууд хамрагдсан

17. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хийсэн ажлыг сар бүр ажил дүгнэх хүснэгтэнд заагдсан үзүүлэлтээр дүгнэн сар бүр ажлын үр дүнг алба хаагч бүрээр дүгнэн үр дүнг тооцон ажиллаж байна.

18. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр дүүргийн төсөвт хөрөнгөний эх үүсвэрийг орон нутгийн хөгжлийн сангаас хүүхэд хамгааллын үйлчилгээнд зориулж тусгуулахаар хүүхэд гэр бүлийн хөгжлийн төв, “Дэлхийн зөн” олон улсын байгууллагаас гаргасан санаачлагыг дэмжин гарын үсэг зурах ажилд цагдаагийн хэлтсийн 52 алба хаагч оролцсон.

19. 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдөр дүүргийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан хамтарсан багийн сургалтанд хороо хариуцсан хэсгийн 5 байцаагч, олон нийтийн цагдаагийн 4 ажилтанг хамруулсан. 2015 оны 07 дугаар сарын 07-ны өдөр дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс, хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвийн мэргэжилтнүүдийг оролцуулан хороодын хамтарсан багийн хагас жилийн ажлыг дүгнэн “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар хамтарсан багуудад зургийн аппарат, нуруулдагчаар хангалаа. Цаашид анхаарах асуудлын талаар 2 цагийн сургалтыг зохион байгуулав. Энэ арга хэмжээнд 5 хорооны засаг дарга нар, нийгмийн ажилтнууд, хорооны 6 хэсгийн байцаагч, 5 хорооны цагдаа, 6 олон нийтийн цагдаа, өрхийн эмч нар, халамжийн хэлтсийн ажилтнууд хамрагдсан.

20. Хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвтэй хамтран 2015 оны 03 дугаар сарын 12-ны өдөр дүүргийн удирдах 18 албан тушаалтан, 5 мэргэжилтэн хамруулан “Боловсрол” цогцолбор, “Гүн галуутай”, “Сод”, 125 дугаар сургуулийн 9-11 дүгээр ангийн 90 сурагчын дунд “танд хүргэх бидний үг” сэдэвт уулзалтыг зохион байгуулан, гэмт хэргийн улмаас хүүхдэд учрах хор уршиг болон хүүхдийг гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгч сурталчилан ажилласан. 2015 оны 05 дугаар сарын 15-с хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвийн сургагч багш нартай хамтран “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын санхүүжилтээр архи хэтрүүлэн хэрэглэдэг 10 иргэнийг гэр бүлийн хамтаар тэдний зан төрхийг өөрчлөх чиглэлээр 40 цагийн сургалт зохион явуулсан.

21. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй 18 хүүхдийг бүртгэн авч хорооны нийгмийн ажилтнуудтай хамтран тэдэнд чиглэсэн сургалтыг хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвөөс явуулсан.

22. Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвтэй хамтран гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалтыг 5-р хорооны 43 иргэнийг хамруулан 2015 оны 04 дүгээр

сарын 29-ний өдөр явуулсан, орон нутгийн 2 телевизээр сурталчилгааг 5 удаа явуулж, Төв талбайд байрлах лед дэлгэцээр 9 удаа өдөрт 4 удаагийн давтамжтайгаар явуулсан. 2015 оны 09 дүгээр сарын 05, 10 дугаар сарын 07-ны өдрүүдэд олон нийтэд сургалт сурталчилгааны ажлыг зохион явуулж 120 санамж сэрэмжлүүлэг, гарын авлага тараасан.

23. Хорооны хэсгийн байцаагчийн өрөөнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр самбар гаргаж хорооны хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтнууд 926 айл өрхөөр орж яриа таниулга хийж ажилласан.

### **Дүгнэлт**

Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн зорилт-2 дахь хэсэгт төлөвлөсөн 24 ажлыг хэрэгжүүлэх хүрээнд Цагдаагийн хэлтэс өөрийн хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу нийт 23 ажлыг тодорхой төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгуулан ажилласанаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх эрсдлийг тодорхойлж, нэг бүрчилсэн арга хэмжээ авч нийтийн дунд тодорхой үр дүнгээ өгсөн боловч дүүргийн хэмжээнд хохирогчийг түр хамгаалах байр одоогоор байхгүй, хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх мөнгөн хөрөнгийн нөөц бүрдүүлэх, зарим сургалт явуулах зэрэг цөөнгүй ажил биелэгдсэн эсэх нь тодорхойгүй байна.

Гэвч хэрэгжүүлсэн ажил нь урьдчилан сэргийлэх онолын хувьд нийтлэг шинжтэй, нэг хэв маягтай, давхцал ихтэй, хуучин төлөвлөгөө, биелэлтийг хуулбарласан, шинжлэх ухааны мэдлэг, арга зүй, технологийн дэвшлийн ашиглалт хангалттай биш, төлөвлөлт, үр дүнг бодитой илэрхийлээгүй, бичилт нь утга найруулга, эрх зүйн соёл, үгийн сонголт оновчтой бус хэрэглэх хандлагатай байна.

**Зорилт-3:** Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хор аюулыг олон нийтэд сурталчлах, үр нөлөөх сайжруулна<sup>30</sup>.

**Төлөвлөсөн ажил:** Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд

#### **Гүйцэтгэх ажил:**

1. Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулах,

2. Олон нийтийн газар (зочид буудал, зоог, цэнгээний газар)-т хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлсэн сэрэмжлүүлэг бүхий зурагт самбар, хуудас байрлуулах,

3. Хүн худалдаалах болон бусад төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр богино хэмжээний сэрэмжлүүлэг бэлтгэж, кинотеатр, бусад хэрэгслийг ашиглан нийтэд хүргэх,

#### **Хэрэгжүүлсэн ажил:**

1. Хүн худалдаалах гэмт хэргийн талаар давхардсан тоогоор ерөнхий боловсролын 4 сургуулийн 184 сурагчид мэдээлэл хийсэн.

2. Тус дүүргийн нутаг дэсвгэрт үйл ажиллагаа явуулдаг 8 зочид буудалд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг бүхий зурагт самбар байрлуулсан.

3. Хүн худалдаалах гэмт хэргийн талаар 3 минутын шторкыг төв талбайн дэлгэцээр 9 удаа явуулж сэрэмжлүүлэг хийв.

### **Дүгнэлт**

<sup>30</sup>Багануур дүүргийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн заалт, зорилтын 5.1 дэх заалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө.

Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн зорилт-3 дахь хэсэгт төлөвлөсөн 3 ажлыг хэрэгжүүлэх хүрээнд Цагдаагийн хэлтэс өөрийн хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу нийт 3 ажлыг тодорхой төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгуулан ажилласанаар хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг тодорхойлж, нийтлэг арга хэмжээ авч нийтийн дунд тодорхой үр дүнгээ өгсөн боловч дүүргийн хэмжээнд зорилтод хэсэгт чиглэсэн зарим сургалт зохион байгуулах зэрэг цөөнгүй ажлын биелэлт тодорхойгүй байна.

Хэрэгжүүлсэн ажил нь урьдчилан сэргийлэх онолын хувьд нийтлэг шинжтэй, нэг хэв маягтай, давхцал ихтэй, бүтээлч биш, шинжлэх ухааны мэдлэг, арга зүй, технологийн дэвшлийн ашиглалт хангалттай биш, төлөвлөлт, үр дүнг бодитой тодорхойлох боломж хомс, бичилт нь утга найруулга, эрх зүйн соёл, үгийн сонголт оновчтой бус хэрэглэх хандлагатай байна.

**Зорилт-4:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг сайжруулж, гамшгаас хамгаалахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ<sup>31</sup>.

#### **Дүгнэлт**

Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн зорилт-4 дэх хэсэгт төлөвлөсөн ажлыг хэрэгжүүлэх хүрээнд Цагдаагийн хэлтэс өөрийн хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу нийт тодорхой ажлыг зохион байгуулсан эсэх нь тодорхойгүй учир дүгнэх боломжгүй.

Багануур дүүрэг нь байгалийн онцгой бүс төдийгүй, шатах, тэсрэх аюулын эрсдэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээний объектод атал төлөвлөсөн ажил байхгүй харин ЦЕГ болон Улаанбаатар хотын Цагдаагийн газраас ирүүлсэн даалгавар гүйцэтгэх байдлаар ажилласан тайлан гаргасан, үр дүн тодорхойгүй байна.

---

<sup>31</sup>Багануур дүүргийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн заалт, зорилтын 5.1.3 дахь заалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө.

## **Хоёр. Иргэндээ ээлтэй эрүүл, аюулгүй, тохилог орчин бүрдүүлэх хүрээнд:**

**Зорилт-5:** Гэр хорооллын гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг олон нийтэд нээлттэй, ил тод, оролцоог нэмэгдүүлэх<sup>32</sup>.

**Төлөвлөсөн ажил:** Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх талаарх мэдээлэл, сурталчилгааны ажлыг иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах.

### **Гүйцэтгэх ажил:**

1. Гудамж талбайд үйлдэгдэж буй гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхийн тулд цагдаагийн алба хаагчдын үйл ажиллагаа, эргүүлийн чиглэл, байршлыг оновчтой тодорхойлж, үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авах,

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлэг, зурагт хуудас бүхий материалыг хэвлүүлэн олгож, иргэд олон нийтэд тараах, гудамж талбайд сурталчилгааны самбарт байрлуулах, лед дэлгэцээр гаргах зэрэг ажлыг зохион байгуулах,

3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шилдэг нийтлэл, нэвтрүүлэг шалгаруулах уралдааныг хэвлэл мэдээллийн байгууллага /телевиз, радио, сонин сэтгүүл/-ын сэтгүүлчдийн дунд зарлан явуулах,

4. Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг сурталчлах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Аргай”, “Шагай”, “Шүгэлхүү” хүүхэлдэйн 3 дүрийг бүтээж, уран сайхны нэвтрүүлэг бэлтгэн иргэд, олон нийтэд тогтмол хүргэх,

5. “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны өдөр”-г бий болгон энэ өдрөөр иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны ач холбогдол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сурталчлах, соён гэгээрүүлэх ажлын зохион байгуулах,

6. “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийг сурталчлах, иргэд, олон нийтийн хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвар, дадал, гэмт хэрэг, зөрчлийг үл тэвчих нийгмийн ухамсар хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн аян зохион байгуулах,

7. Оюутан, залуусыг сайн дурын үндсэн дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, жуулчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор “Оюутан цагдаа” хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх,

8. Иргэдийн сайн дурын санаачлагын бүлгийн төлөөлөгчдийн нэгдсэн уулзалт, ярилцлагыг зохион байгуулах,

9. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын аюулгүй суралцах орчинг бүрдүүлэх, тэднийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд эцэг, эхчүүдийг татан оролцуулах зорилгоор “school police” төсөл, арга хэмжээг орон нутагт зохион байгуулж, амжилттай хэрэгжүүлж байгаа сургуулийг шалгаруулж, урамшуулах,

10. Хүүхдийн үүсгэл санаачлагын /өсвөрийн цагдаа клуб, энхийг сахиулагч, зохицуулагч, ёс зүйн бүлэг г.м/ байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх,

11. Иргэдийн сайн дурын үүсгэл санаачлагын бүлгийн журмын үлгэрчилсэн загвар боловсруулан тараах,

12. Дүүргийн “Иргэдэд үйлчлэх төв”-н үйл ажиллагааг тогтмолжуулах

13. Хүүхэд, өсвөр үе, залуучуудыг цахим тоглоомонд донтохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр их, дээд сургууль, коллежийн оюутан, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургалт зохион байгуулах

<sup>32</sup>Багануур дүүргийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн заалт, зорилтын 5.2.1-5.2.6 дахь заалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө.

14. Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн аюул тохиолдсон үед хорио цээрийн дэглэмийг сахиулах үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг боловсруулах,

15. Иргэдийн сайн дурын үүсгэл санаачлагын бүлгийн журмын үлгэрчилсэн загвар боловсруулан тараах,

#### **Хэрэгжүүлсэн ажил:**

1. Гэмт хэрэг зөрчлийн шалтгаан нөхцөлийг 14 хоног бүр гаргасан судалгаанд тулгуурлан гудамж талбайд үйлдэгдэн гарч буй гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүлийн 6 бүсийг тогтоон явган хөдөлгөөнт эргүүлийн хуваарийг 7 хоногоор гарган хэлтсийн даргаар батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна.

2. 2015 оны 09 дүгээр сарын 22, 23-нд дүүргийн хэмжээнд гамшгаас хамгаалах иж бүрэн сургалт дадлагын ажлыг зохион байгуулахад бие бүрэлдэхүүнийг бүрэн хамруулж гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу өгөгдсөн газар хөдлөлт, объектын гал түймэр, тарваган тахал, хөрсний нуралт гэсэн 4 цагийн байдлын үед алба хаагчдыг дадлага сургуулилтанд хамруулж ажиллаа.

3. 2015 оны 10 дугаар сарын 07-ний өдөр дүүргийн Засаг даргын тамгын газарт Хөршийн хяналт хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлын талаар иргэдэд сурталчилж бусад орны хөршийн холбооны арга туршлагын талаар проектороор харуулж дүүргийн 5 хороонд байгуулагдсан 9 хөршийн холбоодын 34 гишүүнийг оролцуулж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тэргүүн туршлагыг сурталчлах арга хэмжээг зохион байгуулсан.

4. 2015 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр дүүргийн боовсролын хэлтэс, хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвтэй хамтран **“School police”** эргүүлийн үйл ажиллагаа хэрхэн явагдсан талаарх ерөнхий боловсролын 4 сургуулийн илтгэлийг хэлэлцэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг авч ажиллав.

5. Хүүхдийн сайн дурын үүсгэл санаачлагаар бий болсон өсвөрийн цагдаа бүлгийн үйл ажиллагааг идэвхижүүлэх чиглэлээр ерөнхий боловсролын 4 сургуулийн нийгмийн ажилтнуудад зөвлөмж хүргүүлсэн.

6. Эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэхэд хүн бүрийн оролцоо чухал шаардлагатай байгааг ойлгуулах зорилгоор дүүргийн төв талбайд байрлах ЛЕД дэлгэцээр 2015 оны 10 дугаар сарын 5-7-ны хооронд өдөр бүр шторк 5-ыг явуулсан.

7. Хүүхэлдэйн дүр бүтээх ажил хийгдээгүй. 2015 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр “Буруугүй буруутан” сэдэвт хүүхдийн эсрэг гэмт хэргийн талаар нэвтрүүлгийг орон нутгийн BBS телевиз, дүүргийн хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвтэй хамтран бэлтгэн нэвтрүүлсэн.

8. Хууль тогтоомж сурталчлах өдөрлөгийг 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 11-16 цагийн хооронд дүүргийн Засаг даргын тамгын газрын хурлын зааланд **“Нээлттэй хаалга”**-ны өдөр болгон зохион байгуулж 550 иргэн хамрагдан 350 иргэн үйлчлүүлж гэмт хэрэг зөрчлийн улмаас хохирсон 4, галт зэвсэг эзэмшихийг хүссэн 2, жолоодох эрхээ сэргээлгэх хүсэлт гаргасан 115 хүний гомдол хүсэлтийг шийдвэрлэлээ. Цагдаагийн байгууллагаас орон байрны болон малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 100, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг 100, байгаль орчны эсрэг гэмт хэрэг 20, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 100, архи дан согтуурахтай тэмцэх, тамхины хяналтын хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр гаргасан 80 ширхэг нийт 5 төрлийн 400 санамж сэрэмжлүүлэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоо, хөршийн хяналт холбоо,

9. Төв талбайд байрлах ЛЕД дэлгэц болон проектороор цагдаагийн сэдэвтэй 3 дууны клип, багануурын цагдаа дууны клип, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг харуулсан 4 төрлийн сурталчилгаа, 5 төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шторк, санамж сэрэмжлүүлгийг явуулж иргэдэд танилцуулсан.

10. Улаанбаатар хотын цагдаагийн газраас ирүүлсэн удирдамжийн дагуу Олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг хөтөлбөрийг иргэдэд танилцуулах “**Нээлттэй хаалганы өдөрлөг**”-ийг 2015 оны 10 дугаар сарын 23-ны өдөр дүүргийн 5 хорооны ажлын албатай хамтран 320 иргэний хамруулан зохион байгуулж иргэдээс гаргасан 5 саналын хүлээн авч, цагдаагийн хэлтсийн болон хорооны хэсгийн байцаагчийн 3 дугаар улирлын ажлын тайланг танилцуулсан.

11. 2015 оны 09 дүгээр сарын 05-ний өдөр Хөршийн өдөр арга хэмжээг дүүргийн 5 хорооны иргэдийн нийтийн хурал засаг даргын ажлын албатай хамтран хороодын нутаг дэвсгэрт зохион байгуулсан “Нээлттэй хаалга”-ны өдрийн арга хэмжээнд хөршийн бүлгийн ажиллах журам танилцуулж иргэдийн үүсгэл санаачлагаар 9 хөршийн бүлгийг байгуулж ажилласан.

12. Хорооны хэсгийн байцаагч нарын хагас жилийн ажлын тайланг танилцуулж, гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр иргэдээс санал асуулга авч, иргэдийн нийтийн эргүүлийг 3 дугаар хорооны 35 иргэнийг хамруулан 2015 оны 07 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулж ажилласан.

13. Хөршийн хяналт хөтөлбөрийг хэрэгжүүлэх журмыг 2015 оны 09 дүгээр сарын 05-ний өдөр танилцуулж ажилласан.

14. 2015 оны 09 дүгээр сарын 05-ний өдөр дүүргийн 5 хороонд алба хаагчдыг хуваарилан хороодын нийтийн хурал, засаг даргын ажлын албатай хамтран Хөршийн хяналт хөтөлбөрийг хэрэгжүүлэх журмыг 2015 оны 09 дүгээр сарын 05-ний өдөр танилцуулж ажилласан.

### **Дүгнэлт**

Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн зорилт-5 дахь хэсэгт төлөвлөсөн 15 ажлыг хэрэгжүүлэх хүрээнд Цагдаагийн хэлтэс өөрийн хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу нийт 15 ажлыг тодорхой төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгуулсан боловч иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах бодит нөхцөл бүрдсэн эсэх бодит үр дүн тодорхойгүй, хөршийн хэдэн холбоо ажилладаг, урамшуулалын хэмжээ, аюулын эрсдлийг тодорхойлж, нийтлэг, нэг бүрчилсэн арга хэмжээ эсэх тодорхойгүй, зөвхөн сурталчилгааны баримт тараасан мэт ойлгогдож байна.

**Гурав: Гэмт хэргээс урьдчидан сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг хангах, хүрээлэн байгаа орчны бохирдлыг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх хүрээнд:**

**Зорилт-5:** Аюулгүй амгалан орчин нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааны хүрээнд байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн нөхөрлөл, олон нийтийн оролцоог өргөжүүлэх ажлыг сайжруулах<sup>33</sup>.

**Төлөвлөсөн ажил:** Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх талаарх мэдээлэл, сурталчилгааны ажлыг иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах.

### **Гүйцэтгэх ажил:**

<sup>33</sup>Багануур дүүргийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн заалт, зорилтын 5.3.1-5.3.5 дахь заалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө.

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн онцлогт тохирсон бүсчилсэн сургалтыг зохион байгуулж алба хаагчдыг хамруулах,
2. Хууль зөрчсөн үйл ажиллагааны талаар иргэдээс мэдээлэл авах, мэдээлэл нэг бүрийг урамшуулдаг тогтолцоог бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлэх,
3. “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны өдөр”-ийг бий болгон энэ өдрөөр иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны ач холбогдол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сурталчлах, соён гэгээрүүлэх ажлын зохион байгуулах,
4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шилдэг нийтлэл, нэвтрүүлэг шалгаруулах уралдааныг хэвлэл мэдээллийн байгууллага /телевиз, радио, сонин сэтгүүл/-ын сэтгүүлчдийн дунд зарлан явуулах,
5. “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийг сурталчлах, иргэд, олон нийтийн хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх эрсдлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвар, дадал, гэмт хэрэг, зөрчлийг үл тэвчих нийгмийн ухамсар хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн аян зохион байгуулах,
6. Хууль зөрчсөн үйл ажиллагааны талаар иргэдээс мэдээлэл авах, мэдээлэл нэг бүрийг урамшуулдаг тогтолцоог бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлэх,
7. Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах,
8. Байгаль орчныг хамгаалах иргэдийн сайн дурын бүлгүүдийн үйл ажиллагааг сурталчлах, тэдний үйл ажиллагааг дэмжин урамшуулах,

#### **Хэрэгжүүлсэн ажил:**

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2015 оны 04 дүгээр сарын 01-02-нд Төв аймгийн Эрдэнэ суманд Төв аймгийн Эрдэнэ, Архуст, Мөнгөморьт сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа, Налайх дүүргийн цагдаагийн хэлтэстэй хамтарсан **“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх”** сэдэвт бүсчилсэн сургалтыг зохион байгуулж эрүүгийн тасгийн дарга, эрүүгийн 2 төлөөлөгч, 2 мөрдөн байцаагчийг хамруулсан.
2. Дүүргийн 2 дугаар хорооны малчин бүлгийн гишүүн Ө.Түмэн-Өлзийг Цагдаагийн хэлтсийн баярын бичгээр шагнаж урамшууллаа. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн хүрээнд иргэд аж ахуйн нэгж байгууллага цагдаагийн байгуулагаас авч хэрэгжүүлж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хэрхэн оролцох талаар мэдээлэл өгч ажилласан.
3. 2015 оны 10 дугаар сарын 23-нд Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны өдрийг зохион байгуулахаар төлөвлөсөн.
4. 2015 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс зохион байгуулж энэ ажлын хүрээнд олон нийтийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, эрсдлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар гарын авлага 1, санамж сэрэмжлүүлэг 400 тарааж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хамтын ажиллагааг эрчимжүүлж эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэхэд хүн бүрийн оролцоо чухал шаардлагатай байгааг ойлгуулах зорилгоор дүүргийн төв талбайд байрлах ЛЕД дэлгэцээр 2015 оны 10 дугаар сарын 5-7-ны хооронд өдөр бүр шторк 5-ыг явуулсан.
5. Дүүргийн 2 дугаар хорооны малчин бүлгийн гишүүн Ө.Түмэн-Өлзий нь идэвхи санаачилгатай ажиллаж байгааг үнэлэн Цагдаагийн хэлтсийн баярын бичгээр шагнаж урамшууллаа. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн хүрээнд иргэд аж ахуйн нэгж байгууллага цагдаагийн байгуулагаас авч хэрэгжүүлж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хэрхэн оролцох талаар мэдээлэл өглөө. Хууль зөрчсөн үйлдлийг цагдаагийн хэлтсийн 7021102 дугаарын утсанд болон 94945443, 88220089, 96164417, 93022370 дугаарын утсаар сүлжээнд үнэ төлбөртгүй мэдээлэл авах утсыг ажиллуулж байгаа талаар мэдээллийг иргэдэд орон нутгийн 2 телевизээр болон, төв талбайд байрлах ЛЕД дэлгэцээр тогтмол явуулж байна. Иргэдээс төлбөртэй мэдээлэл авахаар орон нутгийн телевизийн зарыг 2015 оны 05 дугаар сард явуулахад мэдээлэл ирээгүй. Иргэдээс төлбөртэй мэдээлэл авсан тохиолдол гараагүй.

6. Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 04,05,06 дугаар сард нийт 4 удаа 2015 оны 10 дугаар сард 2 удаа байгаль орчны байцаагчтай хамтран нийт 34 айл өрхөөр орж 73 хүнд сэрэмжүүлэг өгч ажиллаа.

7. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр сайн дурын 5 морин эргүүлийн үйл ажиллагааг орон нутгийн телевизээр 4, 5-р сард 2 удаа сурталчлав.



## **Дүгнэлт**

Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн зорилт-6 дахь хэсэгт төлөвлөсөн 8 ажлыг хэрэгжүүлэх хүрээнд Цагдаагийн хэлтэс өөрийн хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу нийт 7 ажлыг тодорхой төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгуулсан ажилласан боловч байгаль орчныг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нийтлэг, нэг бүрчилсэн, тусгай арга хэмжээ бодитой зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрсэн, зорилтод орон зай, цаг хугацаа, бүлэгт чиглэсэн ажлын биелэлт тодорхойгүй байна.

**Зорилт-7:** Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 410 дугаар тогтоолоор баталсан “Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын хэрэгжилтэнд Багануур дүүргийн Цагдаагийн хэлсээс хяналт тавьж ажиллах

**Төлөвлөсөн ажил:** Хүүхэд залуучуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах.

### **Гүйцэтгэх ажил:**

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Ерөнхий боловсролын сурагчдад зориулсан сургалт, мэдээлэл /шторк, нугалбар хуудас гаргах/-ийн ажлыг зохион байгуулах,

2. Хүүхэд, өсвөр үе, залуучуудыг цахим тоглоомонд донтохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр их, дээд сургууль, коллежийн оюутан, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургалт зохион байгуулах,

3. Өсвөр үе, залуучуудыг гэмт хэрэгт орохоос урьдчилан сэргийлэх ажлыг хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн оролцоотой өргөжүүлэх,

4. Бүх шатны сургуульд суралцагсдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх арга хэмжээг өсвөр үе, залуучуудын оролцоонд тулгуурлан зохион байгуулах талаар иргэний нийгмийн байгууллагын санаачлагыг дэмжин хамтран ажиллах,

5. Гэмт хэрэг, зөрчилгүй тайван орчныг бүрдүүлэх, өсвөр үе, залуучуудын санал санаачлагыг дэмжин холбогдох байгууллагатай хамтран ажиллах,

6. Мэдээллийн аюулгүй байдлын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сурагчдын дунд сургалт явуулах,

7. Мэдээллийн аюулгүй байдлын талаар жижиг, дунд бизнес эрхлэгчдэд ойлголт, мэдлэг олгох зорилгоор сургалт явуулах,

8. Интернэтийн зүй зохистой хэрэглээ болон болзошгүй эрсдэл, аюулын талаар хүүхэд, эцэг, эх болон багш, сурган хүмүүжүүлэгчдэд зориулсан сургалт, сурталчилгаа явуулах,

9. Өсвөр үеийнхний дундаас үе тэнгийнхэндээ нөлөөлж, үлгэр дууриал болж чадахуйц сурагчдыг сонгон авч сургагч багшаар бэлтгэх,

10. Ерөнхий боловсролын сургуульд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, бүлгэм байгуулахыг дэмжиж, түүнд сурагчдыг татан оролцуулах,

11. Цагдаагийн байгууллагын холбогдох хууль тогтоомжоор нууцад хамааруулснаас бусад асуудлын талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах асуудлаар сургалт зохион байгуулах,

12. Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн болон ял эдлүүлэхийг хойшлуулсан, хорих байгууллагаас суллагдсан хүүхдүүдийг нийгэмшүүлэх чиглэлээр уулзалт ярилцлага, сургалт зохион байгуулах, тэдэнд амьдрах арга барил олгох талаар нийгмийн ажилтан, багш нартай хамтарч ажиллах,

### **Хэрэгжүүлсэн ажил:**

1. Дүүргийн нутаг дэвсгэр дээр цахим тоглоомын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 6 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд 2015 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр шалгалт явуулан илэрсэн зөрчлийг засуулах зөвлөмж хүргүүлэн ажилласан. 2015 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр цахим тоглоомын 6 газрын үйл ажиллагааг шалгаж Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 410 дугаар тогтоолоор батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллах талаар 2015 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр 98 дугаартай мэдэгдлийг хүргүүлсэн. Цахим тоглоомын газруудыг эргүүлийн чиглэлд тогтмол шалгаж цагийн хуваарьт хяналт тавьснаар цагийн хуваарь хэтрүүлсэн, гэмт хэрэг үйлдэгдсэн зөрчил дутагдал гараагүй.

2. Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг “Тэмүүлэл” зуслангийн үйл ажиллагаанд 08 дугаар сарын 15-нд хяналт тавьж гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүүхдийн зусланд амарч байгаа 42 хүүхдэд Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвийн сэтгэл зүйч Т.Даариймаа сургалт явуулав. Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан Дүүргийн Засаг даргын 2015 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн “Сургуулийн орчинд үйлдэгдэн гарч буй гэмт хэрэг, зөрчил болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ухаалаг гар утасны хэрэглээг сургуулийн орчинд хязгаарлах тухай” А/299 дугаар захирамжийг хэрэгжүүлж ажиллах талаар сургуулийн удирдлагууд нийгмийн ажилтнууд дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвийн мэргэжилтнүүдийг оролцуулсан хэлэлцүүлгийг 2015 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн 5 байранд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээллийн самбар байрлуулж гарын авлага санамж сэрэмжлүүлэг байрлуулсан.

3. Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг цахим тоглоомын 6 цэгийн үйл ажиллагааг шалгаж, ерөнхий боловсролын 2 сургуулийн 227 сурагчдад архи тамхины хор хөнөөл, цахим тоглоомонд донтохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтарсан сургалтыг 2015 оны 10 дугаар сарын 08-нд зохион байгуулсан.

4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааны хөтөлбөрийг эрчимжүүлэх сарын аяныг зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулийн 350 сурагчдад сургалт зохион байгуулж, дүүргийн 5 хороонд хэлтсийн алба хаагчдыг хуваарилан 2015 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр эрүүл аюулгүй амар тайван орчин бүрдэх талаар сурталчилгааны ажлыг зохион байгуулж явуулсан.

5. Дүүргийн орон нутгийн Сүлжээ-3 телевизтэй гэрээ байгуулан 14 хоног бүр гэмт хэрэг, зөрчлийн талаар хүүхэд, өсвөр үе, залуучуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 5 төрлийн санамж сэрэмжлүүлэг явуулж ажиллаж байна.

6. Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр яриа таниулгыг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахтай хамтатган яриа хийсэн.

7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мэдээллийн аюулгүй байдал, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль сурталчлах зорилгоор 22 аж ахуйн нэгжийн захирал эрхлэгч нарыг хамруулан 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдөр яриа хийв.

8. Интернетийн цахим сүлжээгээр хүүхдүүд бие биенээ доромжлох, хориглосон сайтад нэвтрэх зэрэг зүй зохисгүй үйлдлийг таслан зогсоох зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагч, нийгмийн ажилтан, багш нарын дунд яриа хийсэн.

9. Хүүхдийн байцаагч сар бүр 4 хүүхдийг сонгон сургагч багшаар бэлтгэн шалгалт авч ажиллаж байна.

10. Өсвөр үеийнхий дунд өсвөрийн цагдаа бүлгэмийг 4 сургуульд зохион байгуулж нийт 100 сурагчдыг хамруулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Сургуулийн нийгмийн ажилтнууд өсвөрийн цагдаа бүлгэмийн үйл ажиллагааг хэрхэн явуулах талаар зөвлөмж хүргүүлсэн.

11. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын /код 135/ Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах журмаар хэлтсийн бие бүрэлдэхүүнд 2 удаа 2 цагийн сургалт зохион байгуулсан.

12. Шүүхээс ялыг хойшлуулсан 2 хүүхдэд холбогдох материалыг Өршөөл үзүүлэх тухай хуульд хамруулж, 1 хүний материалыг хугацаа дууссан тул хувийн хэргийг хаасан. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 4 хүүхдэд хяналт тавин сар бүр засрал хүмүүжлийн талаар тайлбар авч, гэмт хэрэг захиргааны зөрчилд холбогдсон эсэх талаар лавлагаа авч сургуулийн нийгмийн ажилтнуудад мэдээлэл солилцон ажиллаж байна.

### **Дүгнэлт**

Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн зорилт-7 дахь хэсэгт төлөвлөсөн 12 ажлыг хэрэгжүүлэх хүрээнд Цагдаагийн хэлтэс хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу нийт 12 ажлыг тодорхой төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгуулан ажилласан нь хэтэрхий ерөнхий, “цахим орчинд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчил”, “цахим орчны донтолт, эмгэг”-с урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох нийтлэг, нэг бүрчилсэн арга хэмжээ авч нийтийн дунд тодорхой үр дүнгээ бодитой тодорхойлсон, дүүргийн хэмжээнд зорилтод хэсэгт чиглэсэн ажил тодорхойгүй байна.

Дүүргийн Эдийн засаг, нийгмийн 2013-2016 оны зорилтын “Аюулгүй амгалан Багануур” хэсгийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилго чиглэл бүхий холбогдох заалтуудыг авч үзлээ.

Хөтөлбөрт тусгагдсан гэмт хэрэг, зөрчилтэй холбогдох дээрх заалтын хүрээнд 2015 онд 3 багц зорилт хэрэгжүүлэхээр:

- Зорилт-1 гүйцэтгэх ажил 11, хэрэгжүүлэх ажил 13,
- Зорилт-2 гүйцэтгэх ажил 24, хэрэгжүүлсэн ажил 23,
- Зорилт-3 гүйцэтгэх ажил 3, хэрэгжүүлсэн ажил 3,
- Зорилт-4 гүйцэтгэх болон хэрэгжүүлсэн ажил тодорхойгүй,
- Зорилт-5 гүйцэтгэх ажил 15, хэрэгжүүлсэн ажил 15,
- Зорилт-6 гүйцэтгэх ажил 8, хэрэгжүүлсэн ажил 7,
- Зорилт-7 гүйцэтгэх ажил 12, хэрэгжүүлсэн ажил 12 **НИЙТ** 68 ажил гүйцэтгэхээр төлөвлөн 73 төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

Зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлын биелэлтийн хувьд тус бүрдээ 75-95 хувийн биелэлттэй байна гэж үзэж байгаа бөгөөд энэ нь дундажаар 91.5% байна.

Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөсөн ажил тодорхой бүхэллэг шинжээр багцлаагүй, гүйцэтгэх ажил тодорхой чиглэл, зорилтод тулгуурлаагүй учир хэрэгжүүлэх ажил урсгалаараа, урдны ажлыг давтсан, хэлбэрдэх маягтай, шинэлэг санаа, бүтээлч санаачилга дутагдалтай гэж дүгнэгдэхээр байгаа тул хэрэгжүүлсэн арга хэмжээг дүгнэн цаашид сайжруулах чиглэлээр санал, зөвлөжид тодорхой тусгаж оруулав. Үүнд:

### **Зөвлөмж-1**

“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж талбай, гэр хорооллыг телекамерын системд хамруулж, гэрэлтүүлгийг сайжруулна” гэж төлөвлөсөн ажлын хүрээнд хэрэгжүүлж буй ажлууд нь хөрөнгө санхүүгийн байдлаас шалтгаалан тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Иймд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилготой телекамерын системийг улам сайжруулах шаардлагатай байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Тухайлбал: “Аж ахуй нэгж, байгууллагуудтай орчныхоо газарт гэрэлтүүлэг, хяналтын камер нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллана” гэж бүхэллэг шинжээр ажлаа

тодорхойлж ажиллах шаардлагатай. Хэдэн байгууллагад камер, гэрэлтүүлэг байршуулах шаардлагатай гэх мэт ажлыг цаашид боловронгуй болгох, хамгаалалтын алба байгуулахад нь бодлогоор туслах, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулах ач холбогдолтойг сурталчлах нь зүйтэй.

Телекамерын системд нэвтрүүлэх ажилтай хамтатган гэмт хэргийг цахим зураглалын систем (**Crime mapping system**)-г нэвтрүүлбэл дүүргийн хувьд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шинэлэг алхам болно. Гэмт хэргийн цахим зураглал нь гэмт хэргийн болон цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаатай холбоотой асуудлуудын талаарх дүн шинжилгээг өргөн хүрээнд хийхэд газар зүйн мэдээллийн системийг ашиглах үйл явц тул гэмт хэргийн цахим зураглалын ач холбогдол буюу гол зорилго нь гэмт хэргийн талаарх дүн шинжилгээ хийх цаашилбал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдал.

Өөрөөр хэлбэл, хаана гэмт хэрэг үйлдэгдэж байгааг тодорхойлсоноор гэмт хэргийн талаарх дүн шинжилгээ хийх олон үүргийг хангаж чадна.

Аюулгүй амгалдан дүүргийг бий болгоход гэмт хэргийн цахим зураглалын системийг нэвтрүүлэх нь өндөр үр дүнтэй.

### **Зөвлөмж-2**

“Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, иргэд, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 96 аж ахуйн нэгж, байгууллагатай түншлэлийн гэрээ байгуулж “Гэмт хэргээс урьчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх үйл ажиллагаанд идэвх санаачлагатай ажилласан иргэд байгууллагын урамшуулах тогтолцоог бий болгох” ажлыг эхлүүлэх нь зүйтэй.

Иймд цаашид гэмт хэргээс урьчилан сэргийлэх ажилд идэвх зүтгэл гаргаж ГХУСТХ-н 10.1.3-т тогтоосон иргэний үүргээ биелүүлсэн иргэн, байгууллагыг идэвхжүүлэх зорилготой урамшууллын тогтолцоог илүү тодорхой болгож эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай нь 2015 онд 2 иргэн урамшуулсан үзүүлэлтээр илэрхийлэгдэнэ. Энэ талаар бусад дүүрэг болон гадаадын улс орны туршлагаас судлах нь зүйтэй.

Тухайлбал: АНУ, Сингапур улсад авлигын гэмт хэргийн талаар мэдээлэл өгсөн иргэнийг тухайн авлигын 30%-р урамшуулдаг эрх зүйн зохицуулалттайгаас гадна тухайн иргэний амь нас, аюулгүй байдлыг хууль сахиулах байгууллагаас бүрэн хамгаалдаг.

Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх иргэдээс мэдээлэл авах үйл ажиллагаанд иргэдийн аюулгүй байдлыг хангаж, хамгаалах асуудлыг онцгой анхааран ажиллах механизмыг бүрдүүлэн ажиллах нь зүйтэй.

Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоотойгоор интернэт, мэдээллийн технологийг ашиглах тухай заалтын хувьд ч иргэдийн оролцоог ашиглахдаа мэдээллийн аюулгүй байдлыг нь хангах, тогтмол гэмт хэргийн гомдол мэдээлэл хүлээн авдаг **website** ажиллуулж, утсан сүлжээг тогтмолжуулах арга хэмжээ авахдаа иргэдийг урамшуулдаг тогтолцоог тодорхой болгосноор тэдний энэ ажилд оролцох идэвхийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

### **Зөвлөмж-3**

Багануур дүүргийн хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэргийг нийгэм, урлаг, спорт, олон нийтийн оролцоотой арга хэмжээнд тулгуурлан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтай уялдуулан зохион байгуулж бууруулах арга хэмжээ авна гэсэн заалтын хүрээний хийгдсэн ажлууд, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 4 төрлийн 400 ширхэг санамж сэрэмжлүүлгийн материалыг бэлтгэн иргэдэд тараасан, 10 иргэний санал хүсэлтийг

хүлээн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулан шийдвэрлэж ажилласан зэрэг амжилттай ажлууд байгаагийн дотор дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг бууруулах, иргэд, оршин суугчдын амар тайван, аюулгүй амьдрах нөхцөл бололцоог дээшлүүлэх, хороодын хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хөршийн холбоог сэргээн бий болгох, тэдний үйл ажиллагааг дэмжин тогтмолжуулах, идэвхжүүлэх зорилгоор “Хөрш” хөтөлбөр, “Бид буруугүй” зэрэг уралдаан нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан үр дүнтэй ажил болжээ.

Цаашид хөршийн холбоог сайжруулах дээрх ажиллагаанд гэр хорооллын өрхүүдийг бүлэг болгон хөршийн холбоод нийтэд нь байгуулан, үйл ажиллагааг нь тогтмолжуулж, үр дүнг улирал тутамд тооцож ажиллах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй. АНУ, Япон, Солонгос улсад “**хөршийгөө ажиглах**” гэсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр ихээхэн үр дүнтэй аргуудын нэг байдгийг дурдах нь зүйтэй.

#### **Зөвлөмж-4**

Нийтийн хэв журмын урамшуулалтай эргүүл, олон нийтийн Цагдаагийн орон тоог нэмэгдүүлж, урамшууллын хөлсийг хороодын Засаг дарга, цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн шийдвэрлэх ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт иргэдийн урамшуулалтай эргүүл ажиллуулсан тоон мэдээ байгаа боловч хүн ам харьцангуй өсөж байгаа дүүргийн хувьд хангалтгүй.

Иймд цаашид Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль болон ГХУСТХ-н 12.1.2-т зааснаар 12.3-т дүүргийн ИТХ-с хэв журмын урамшуулалтай эргүүл, олон нийтийн байцаагчийн тоо болон урамшууллын хэмжээг хангалттай хэмжээнд тогтоож энэ үйл ажиллагааг тогтмолжуулах нь зүйтэй.

Эргүүлд аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан албан хаагчдыг татан оролцуулах, урамшуулал олгох, хэрэгжилт, үр дүнг тооцон ажиллах заалтын хувьд сургуулийн орчинд бага насны хүүхдийг хуурч мэхлэн эд зүйлийг нь авах, дээрэмдэх, булаах, айлган сүрдүүлэх, архидан согтуурах, мансуурахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Багш нарын нийтийн эргүүл”-г 7 хоногийн баасан гарагуудад 19:00 цагаас 22:00 цагийн хооронд зохион байгуулах нь хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй ажил болох тул цаашид энэ ажлын тоо, чанарт анхаарч тогтмолжуулж ажиллах шаардлагатай.

#### **Зөвлөмж-5**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд нийтийн тээврийн болон таксины жолооч, зочид буудлын ажилтнууд зэрэг бусад хувийн хэвшлийг татан оролцуулж идэвхтэй хамтрах ажлыг зохион байгуулах санал гаргаж байна. Энэ нь хууль бус нийтийн тээвэр, такси үйлчилгээнд хамруулахгүй байх анхааруулгыг иргэдэд сурталчлах шаардлагатай.

**Гадаадын туршлага:** Лондон (2006) Хотын цагдаагийн газар 2001 оны 10 сараас 2002 оны 9 сарын хооронд хувийн такси үйлчилгээний жолоочтой холбогдон гарсан 212 бэлгийн хүчирхийллийг тогтоосон байна. Судлаачид эмэгтэйчүүдийн бэлгийн хүчирхийллийн хамгийн ноцтой гэмт хэргүүд нь зөвшөөрөлгүй хувийн жижиг таксинуудтай холбогдож байгааг тогтоосон байна. Энэхүү асуудал нь зөвшөөрөлгүй таксины хор холбогдлын талаар олон нийтийн мэдлэг дутуу байгаагаас болон замбараагүй хувийн таксинууд, шөнийн цагаар үйлчлүүлэх хууль ёсны тээврийн хэрэгсэл байхгүйгээс үүссэн байна. Эмэгтэйчүүдийн хувьд зөвшөөрөлгүй такси ашиглаж бэлгийн хүчирхийлэлд өртөх байдлыг бууруулахын тулд талууд цагдаагийн уламжлалт арга барил ашиглаж хууль бус таксинуудтай тодорой арга хэмжээнүүдийг авч, шөнийн цагаар аюулгүй тээврийн хэрэгслээр үйлчилж, хангалттай мэдээллээр хангаж, хууль бус такси ашиглахгүй байх талаар олон нийтийн ойлголтыг сайжруулсан байна. 2002 оноос хууль бус таксигаар

үйлчлүүлсэн эмэгтэйчүүдийн бэлгийн хүчирхийлэл сардаа 18 эмэгтэй байснаас 10 болж буурсан байна.

Иймд энэ хүрээнд дараах 3 үйл ажиллагааг бий болгох:

- Хууль бус нийтийн тээврийн болон такси ажиллуулахгүй байх;
- Хууль бус нийтийн тээврийн болон таксид хууль ёсны такси хяналт тавьж ажиллах;
- Албан ёсны таксины жолоочтой хамтран ажиллах.

#### **Зөвлөмж-6**

Архи, тамхи үйлдвэрлэх, худалдан борлуулахад тавих хяналтыг сайжруулах ажлын хүрээнд дүүргийн ЗДТГ, хороод, цагдаагийн байгууллага зэрэг бүхий л байгууллагууд хамтран олон ажлуудыг хийсэн нь харагдаж байна.

Статистик мэдээнд бага насны хүн гэмт хэрэгт оролцоогүй байгаа нь энэ талын ажил сайн зохион байгуулагдсан гэж дүгнэхийн зэрэгцээ ихээхэн ач холбогдол бүхий арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

Согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ нь гэмт хэрэг, зөрчилд голлон нөлөө үзүүлдэг. Гэр бүлийн хүчирхийлэл, танхайрах, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг зэрэг нь согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэснээс үүсдэг.

Иймд энэ хүрээнд цаашид дүүргийн архинд донтсон хүнийг сайн дурын болон албадан эмчилгээ үйлчилгээгээр хангах, тусгайлан сургалтаар тэдний бодит амьдралын түүхийг яриулах зэрэг арга хэмжээ авснаар гэмт хэргийн гаралт болон тээврийн ослыг бууруулахад чухал нөлөө үзүүлэх боломжтой.

Улсын хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн 48 хувийг согтуугаар үйлдэж байгаа бол тус дүүргийн хувьд гэмт хэрэг үйлдэгчдийн 11.8 хувь нь мөн согтуугаар гэмт хэрэг үйлдсэн тоон мэдээ байна.

**Гадаадын туршлага:** Аляска, Норт слоф борроу (1995) Аляска, Норт слоф борроу нь согтууруулах ундааны зүйлстэй холбогдсон нэлээд олон гэмт хэргийн болон нийгмийн хэв журмын зөрчил үйлдэгддэг байсан.

Согтууруулах ундаатай холбогдох ослуудыг бууруулах, таслан зогсоохоор нийтийн аюулгүй байдлын удирдлага ба хотын дарга нар тус орон нутагт согтууруулах ундааны зүйлс хэрэглэхээс татгалзах хөтөлбөр хэрэгжүүлсэн зэрэг боломжийг судлах хэрэгтэй<sup>34</sup>.

Залуучуудад зориулсан “архигүй” орчинг бий болгож, үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран олон нийтэд сурталчлах ажлыг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх нь зүйтэй.

Архи, согтууруулах ундааг худалддаг, үйлчилдэг дэлгүүр, цэнгээний газруудад зөвшөөрөл олгохдоо тэгээрийн байршил, хоорондын зайг зохистой байхаар зохицуулах, согтууруулах бүтээгдэхүүнээр үйлчлэх, худалдах хугацааг богиносгож өдрийг цөөрүүлэх асуудлыг дүүргийн удирдлагын зүгээс шийдвэрлэх шаардлагатай.

#### **Зөвлөмж-7**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчилж олон нийтэд сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хороодын Засаг дарга, нийгмийн ажилтан нартай хамтран хорооны иргэдийн дунд хуулийг ухуулан таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулж байгаа боловч ямар сургалт нь үр дүнтэй болж байгаа нь тодорхой бус тул гэр бүлийн

<sup>34</sup>Жоел Б.Плант, Майкл С.Скот, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба үр нөлөөтэй бодлогыг боловсруулах нь”, АНУ-н Хууль зүйн яам, 2009 он.

хүчирхийлэлд өртөх эрсдэлд орсон, гэр бүлийн хүчирхийлэлд өртөх магадлалтай хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах, тэдний хуулийн мэдлэгийг өргөжүүлэн нэмэгдүүлэх тал дээр илүү анхаарч тэдэнд мэргэжлийн хуульч, сургагч багш нартай хамтран албан бус сургалтыг тогтмолжуулж зохион байгуулах шаардлагатай.

Энэ ажил дээр хууль эрх зүйн чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах тухайлбал, Хууль сахиулахын их сургууль, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн сургагч багш нарыг урьж ажиллуулах зэргээр илүү үр дүнтэй байдлаар ажиллах нь зүйтэй.

#### **Зөвлөмж-8**

Хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэхэд зориулсан үйлчилгээний хэлбэрүүдийг өргөжүүлж, цахим тоглоомын газар, интернет төвүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хамтран ажиллана гэсэн заалтын хүрээнд хийгдсэн ажлын хувьд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй цахим тоглоом, интернет төвүүдийн мэдээллийн сан бүрдүүлж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж, хууль тогтоомж зөрчсөн газрын үйл ажиллагааг хязгаарлах, интернет тоглоомд донтохоос хүүхэд залуучуудыг сэргийлүүлэх арга хэмжээг цаашид авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн ЭМН-тэй хамтран ЕБС-н дунд болон ахлах ангийн сурагчдад интернэт тоглоомонд донтох болон хор уршгийн талаар хамтарсан сургалт зохион явуулсан боловч цаашид бусад ЕБС болон хүүхэд залуучуудыг хамруулах нь зүйтэй.

#### **Зөвлөмж-9**

Сургууль, цэцэрлэгийн орчинд зам тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана гэсэн заалт нь ЕБС-н хүүхдийг зам тээврийн ослоос сэргийлсэн сурталчилгааны хичээлийг замын Цагдаагийн тасагтай хамтран сургалт зохион байгуулсан, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, явган зорчигчдын хөдөлгөөнд оролцох сахилга соёлыг дээшлүүлэх, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний ачаалал ихтэй цэг, уулзваруудад хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллах туслах ажилтанг гэрээгээр ажиллуулах зэрэг ажлыг хэрэгжүүлэх, сургууль цэцэрлэгийн орчинд зам тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад зөвхөн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа бус орон нутгийн захиргааны байгууллага бусад ААНБ-н хамтын ажиллагааны үр дүн байдаг.

АНУ-д “Нөхцөл байдлын урьдчилан сэргийлэх арга” гэж тооцогддог ба эдгээр орчныг аюулгүйжүүлснээр аюулгүй орчин, аюулгүй бүтээгдэхүүн бий болгож гэмт хэргийг бууруулна гэж үздэг.

#### **Зөвлөмж-10**

Багануур дүүрэг нь байгалийн унаган төрхийг хадгалан байгаа бүс нутаг төдийгүй хөдөө аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлал, зүүн бүсийн автозамын хөдөлгөөний идэвхжилтэй дамжин өнгөрөх уулзвар тул байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор малчид, анчид, байгаль хамгаалагч, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах тусгай “хөтөлбөр” хэрэгжүүлэх шаардлагатай.

#### **Зөвлөмж-11**

НҮБ-н Хүн амын сангийн 2015 оны тайланд дэлхийн хүн амын 52 хувь нь том хотуудад, 47.6 хувь нь дагуул болон хаяа хотуудад, 0.4 орчим хувь нь алслагдсан сууринд амьдарч байна гэж дүгнэсэн. Иймд томоохон хот, дагуул хотуудад хүн ам төвлөрөх тусам сэтгэл гутрал, уур бухимдал, амьдралын хэрэгцээнээс үүдэлтэй бэрхшээлүүд улам нэмэгддэг тул зөвхөн зөрчил гаргагч төдий бус хохирогч, тэр ч бүү хэл хууль сахиулагчид, засаг захиргааны, үйлчилгээний ажилтан нарт сэтгэл зүйн болон буруу зан төлөв, зуршилаас татгалзах чиглэлийн албан болон албан бус сургалтуудыг мэргэжлийн сэтгэл

зүйч, сэтгэц оношлогч эмч, шашны байгууллага, бусад олон нийтийн байгууллагуудын мэрэгжилтэн нарыг урьж **“тусгай хөтөлбөрт”** сургалтыг тогтмол зохион байгуулах шаардлагатай.



## 4.2. ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГА, ХОРООДООС ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ, УЯЛДАА ХОЛБОО

Багануур дүүргийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллагуудын буюу Цагдаагийн хэлтэс, Замын цагдаагийн тасаг, Мэргэжлийн хяналтын хэлтэс, дүүргийн худалдаа үйлдвэр үйлчилгээний хэлтэс (согтууруулах ундаагаар үйлчилдэг байгууллагуудтай холбоотой), Прокурорын байгууллагаас тавих хяналт (гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тавих хяналт, сургалт зөвлөмж, хамтын ажиллагаа), Хороодын засаг дарга нар, хил залгаа сумдын чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, одоогийн нөхцөл байдлын талаар давуу болон сул талуудыг тодорхойлон дүгнэлт өгч, арга барилыг сайжруулах талаар дүүрэг болон нийслэлийн хэмжээнд эрх зүйн зохицуулалт хийж болох арга замыг тодорхойлохыг зорьлоо.

### 1. Цагдаагийн хэлтэс<sup>35</sup>

Цагдаагийн албаны тухай хууль<sup>36</sup>-д цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэгтэйг тодорхойлсон. Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг тодорхойлж түүний хүрээнд нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан үйл ажиллагаа, бүтцийг бий болгодог.

**Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх** (хэрэг бүртгэх, мөрдөн байцаах багтана) чиг үүргийн хүрээнд Цагдаагийн хэлтэсийн Хэв журмын алба хаагчдаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэж байна.

Автомашинт эргүүлүүд болон хэв журмын офицерууд иргэд, байгууллагаас ирүүлсэн дуудлага, мэдээллийг хүлээн авч шалгах, согтуурч хэв журам зөрчсөн хүмүүсийг саатуулах (эрүүлжүүлэх) байранд хүргэх, биеэ авч явах чадваргүй иргэнийг ар гэр асран хамгаалагчид нь хүлээлгэн өгсч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн байна.

**Өмгөөллийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг иргэд, байгууллагын оролцоо:**

Гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгаж, эцэслэн шийдвэрлэх, хүний эрхийг баталгаатай хангах болон урьдчилан сэргийлэх ажилд өмгөөллийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэж байгаа иргэд, байгууллагыг оролцуулсан, хамтран ажилласан талаар гарсан тайлан бүртгэл хангалттай байхгүй байгааг цаашид анхаарч ажиллах шаардлагатай.

Мөн сэтгэл судлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төвүүдийн дэмжлэг, туслалцааг авч хамтран ажиллах нь цаг үеийн шаардлага болж байна.

**Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах**

ГХУСТХ-н 12.1.1-д заасан иргэдийг нийтийн эргүүлд гаргах ажлын хүрээнд “Нийтийн эргүүл” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулагдсан ба “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” гэсэн хөтөлбөрийн хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор хороодын засаг дарга нартай хамтран иргэдийн нийтийн эргүүлийг амралт, баяр ёслолын өдрүүдэд зохион байгуулсан байна.

Гэмт хэрэг зөрчил ихээр үйлдэгддэг эмзэг цэгүүдийн судалгаанд түшиглэн эргүүлийн маршрутын хуваарь хийж 18:00 цагаас 20:00 цагийн хооронд иргэдийн, 20:00

<sup>35</sup> Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтсийн 2015 оны үйл ажиллагааны тайланг ашиглав.

<sup>36</sup>Цагдаагийн албаны тухай хуулийг 2013 оны 7 сарын 5-ны өдөр баталж, 2014 оны 1 сарын 1-с дагаж мөрдсөн.

цагаас 22:00 цаг хүртэлх хугацаанд эргүүлийн чиглэлд цагдаагийн албан хаагчийн хамт эргүүлийн үүрэг гүйцэтгүүлж хяналт тавьж ажилласан байна.

Эргүүлд 5 хорооны 30 орчим иргэн ажиллаж цагдаагийн алба хаагчтай хамтран 11 зөрчлийг илрүүлэн ажилласан байна.

Сургуулийн орчинд үйлдэгдэх гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургуулийн хичээл орох, тарах үед багш, эцэг эхчүүдийн эргүүлийг сургууль бүрээр гаргаж, цагдаагийн явган болон машинт эргүүлүүд өдөр бүр 07:00-08:00, 12:00-13:00, 17:00-18:30 цагуудад ерөнхий боловсролын 2 сургуулийн орчимд ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, иргэд, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагатай түншлэлийн гэрээг байгуулсан.

Үүнд: Сууц өмчлөгчдийн холбоо, өрхийн болон хувийн эмнэлэг, аж ахуйн нэгж, байгууллагууд хамрагдсан байна.

Насанд хүрээгүй хүмүүсийг хулгайлах, булаах, дээрэмдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрх, ашиг сонирхол хохирохоос хамгаалах зорилгоор 2014 оноос эхлэн дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн хичээл эхлэх, тарах үед хэв журмын тасгийн явган болон хөдөлгөөнт эргүүлийн албан хаагчид сургуулийн багш, нийгмийн ажилтнуудтай хамтарсан эргүүлийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж байна.

#### **Хорих ял эдлээд суллагдсан хүнд захиргааны хяналт тогтоох**

Цагдаагийн хэлтсийн хуулиар хүлээсэн үүргийг хэгжүүлж 2014 оноос эхлэн хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй, хорихоос суллагдсан, тэнсэн хариуцлага ногдуулсан хүмүүсийг нийгэмшүүлэх, гэмт хэрэгт дахин холбогдохгүй байх, мэргэшүүлж ажлын байраар хангах талаар “Итгэлийн захидал”-г гардуулах зорилгоор “ирээдүйд итгэнэ” арга хэмжээг дүүргийн ЗДТГ, дүүргийн ГХУСАЗСЗ, прокурор, шүүхийн байгууллага, Багануур дүүрэгтэй хил залгаа сумдын Цагдаагийн нэгж, шашны байгууллагатай хамтран зохион байгуулсан.

Цагдаагийн албаны “Захиргааны хяналт” арга хэмжээний хүрээнд шүүхээс хорих ял хойшлогдсон буюу насанд хүрээгүй этгээдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүмүүстэй хороо хариуцсан хэсгийн байцаагч нар уулзан, баталгаа гаргуулан авч, дүүргийн ЗДТГ, Хөдөлмөрийн хэлтэс хамтран “ирээдүйд итгэнэ” уулзалт, өдөрлөг, ажилд зуучлах уулзалтыг зохион байгуулж ажилласан.

#### **Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцсон иргэд, байгууллагыг урамшуулах**

Цагдаагийн хэлтэс “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр 2016 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулж дүүргийн ГХУСАЗ зөвлөлийн даргаар баталгаажуулан Дүүргийн ИТХТ-н дарга, Засаг даргад Цагдаагийн 2015 онд зохион байгуулах ажлын санал, алба хаагчдын ажиллах нөхцөл байдлын судалгаа, хөрөнгө зардлын тооцоо, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх урамшилт эргүүлээр ажиллах иргэдийн тоог гаргаж танилцуулсан.

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, нийтийн эргүүлд ажиллуулах Засаг даргын захирамжийн төслийг боловсруулж ЗДТГ-т хүргүүлсэн.

Дүүргийн иргэдийн хурал, Засаг даргатай зөвшилцөн 2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд нийт 30 орчим сая төгрөг шийдвэрлүүлж, үйл ажиллагаандаа зарцуулсан.

### **Гэмт хэргийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах**

Дүүргийн Цагдаагийн хэлтсийн нэгжүүд, Замын цагдаагийн тасгийн цахим хаяг, утас, фейсбүүк хуудсаар ирүүлсэн гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой мэдээллийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан боловч мэдээлэл өгсөн иргэдэд мөнгөн урамшуулал олгох, мэдээллийн төлбөртэй авсан тохиолдол байхгүй.

## **2. Дүүргийн Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн тасаг<sup>37</sup>**

### **Өргөдөл гомдол хүлээж авах**

Дүүргийн Цагдаагийн хэлтсийн нэгжүүд, Замын цагдаагийн тасгийн цахим хаяг, утас, фейсбүүк хуудсаар ирүүлсэн гэмт хэрэгтэй холбоотой мэдээллийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан. Засгийн газар, ХЗДХЯ (ХЗЯ), ЦЕГ, УБХЦГ, бусад газар хэлтсийн цахим хуудсаар ирүүлсэн өргөдөл<sup>8</sup> гомдлыг цаг хугацаанд нь шалган шийдвэрлэсэн.

### **Сургууль, цэцэрлэгийн орчинд зам тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах**

Хүүхдийн аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоор нийт цэцэрлэг, сургуулийн гадаа талбайд хичээл эхлэх, тарах үед гарч болзошгүй осол гэмтлээс сэргийлэх зорилгоор “Явган хүний гарц”, “Хүүхэд”, “Түр зогсох хориотой” тэмдгийг байрлууллаа. ЕБС-н хүүхдүүдэд зам тээврийн ослоос сэргийлсэн сурталчилгааны хичээлийг замын Цагдаагийн тасагтай хамтран “Хүүхэд замын хөдөлгөөн-аюулгүй орчин” сургалт зохион байгууллаа.

Цаашид цэцэрлэгүүд эцэг эхийг үйл ажиллагаанд татан оролцуулан замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээг хийлгэн, хүүхдийн сургалтанд хэрэглэн ашиглах чиглэлтэй ажиллаж байна. Сургууль, цэцэрлэгийн ойр орчимд авто замын тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагчийг тавих, бага ангийн сурагчдын харих замын маршрутыг хийж, цацруулагчтай цүнхний наалтыг хичээлийн жилийн турш үргэлжлүүлэн хэрэгжүүлж, тогтмолжуулахад хяналт тавин ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс гаргасан сургуулийн орчимд үүрэг гүйцэтгэх “School police” эргүүлийн ажиллах журмыг сургуульд хэрэгжүүлж нийт эцэг, эх ажилласан.

### **Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах**

Сургууль бүрийн орчны авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс сургуулийн багш, эцэг эх хамтран хуваарь гаргаж, өглөө, өдөр, орой түр зохицуулагчийг хуваарийн дагуу ажиллуулж байна.

Дүүргийн бүх сургууль, цэцэрлэгийн ойролцоох замд өглөө, өдөр, оройн цагуудаар багш, эцэг эхийн оролцоотой түр зохицуулагчийг ажиллуулж хэвшсэн.

Эрүүл мэндийн нэгдэл, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн орчимд ажилчин, нийтийн тээврийн буудлын урд явган гарцан дээр ажилтан, уулзваруудад зохицуулагч ажилтан онцгой хөдөлгөөний үед аюулгүй байдлын ажилтныг ажиллуулж байна.

## **3. Мэргэжлийн хяналтын хэлтэс, дүүргийн худалдаа үйлдвэр үйлчилгээний хэлтэс<sup>38</sup> (согтууруулах ундаагаар үйлчилдэг байгууллагуудын бүртгэлтэй холбоотой)**

<sup>37</sup>Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтсийн 2015 оны үйл ажиллагааны тайлангаас ашиглав.

## **РС тоглоомын газарт хяналт тавих**

Дүүргийн 5 хороонд интернет, тоглоомын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулж, хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа цахим тоглоом, интернетийн үйлчилгээний газарт шалгалт хийж, хамтран ажиллах “Түншлэлийн гэрээ” байгуулан сургууль, цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах зөвлөмжийг өгсөн байна.

### **Тамхины хяналтын тухай хуулийг хэрэгжүүлэх**

Тамхины хяналтын тухай хууль батлагдан 2013 оны 03 сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хууль хэрэгжүүлэх, сурталчлах сургалтыг 2015 онд дүүргийн бүх хороодын болон сургуулийн нийгмийн ажилтан нар, Цагдаагийн хэлтсийн хэв журмын ажилтан нарт зохион байгуулав.

Газрын албатай хамтран дүүргийн хэмжээнд ажиллаж байгаа бүх сургуулийн 500 м бүхий зураглалыг гаргаж, тамхи худалдаалахыг хориглосон байрлалыг тэмдэглэж хороонд хүргүүлсэн.

Тамхи худалдаалахыг хориглосон “Албан мэдэгдэл”-г Цагдаагийн хэлтсийн байцаагч нартай хамтран нийт хүнсний дэлгүүр, мухлаг, ТҮЦ-үүдэд тараан хяналт тавин ажилласан. Дүүргийн хэмжээнд хуулиар зөвшөөрөгдсөн дэлгүүрт тамхи худалдаалж байна. Дүүргийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хуулийг сурталчлах зорилгоор “Тамхины хэрэглээ-Хор уршиг” зурагт дэлгэмэл хуудас, “Утаат тамхи татахыг хориглоно” гэсэн плакат зэргийг бэлтгэж 400 ширхэгийг хэвлүүлэн аж ахуйн нэгжүүдээр тараасан.

### **Архидан согтуурах, зохисгүй хэрэглээтэй тэмцэх чиглэлээр**

Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх аж ахуйн нэгж, байгууллагуудад аттестатчиллын шалгалтыг 2015 онд ЗДТГ-н менежерийн баталсан удирдамжийн дагуу ЗАА-ны ХХҮХ-тэй хамтран явуулсан.

Аттестатчилалд нийтийн хоол, худалдаа үйлчилгээний салбар хамрагдсанаас, согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг сунгаж, стандартын шаардлага хангахгүй зөрчилтэй баар, ресторан, хүнсний дэлгүүрийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

Залуучуудад зориулсан архигүй цэнгээний жишиг газрыг бий болгож, сурталчлах, архи, тамхины зохист бус хэрэглээг бууруулах, залуучуудад зориулсан архигүй орчинг бий болгож, тэг градусын бүтээгдэхүүнээр үйлчлэх хэрэглээг нэвтрүүлэх, зорилгоор архигүй цэнгээний, биллярдын газрыг шинээр байгуулах, үйл ажиллагааг дэмжих ажлыг зохион байгуулсан.

**4. Прокурорын байгууллагаас тавих хяналт<sup>39</sup> (гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тавих хяналт, сургалт зөвлөмж, хамтын ажиллагаа)**

Багануур дүүргийн Прокурор нь 1980 оны 2-р сард байгуулагдаж, ерөнхий прокурор, ерөнхий хяналт хэрэгжүүлэх туслах прокурор, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн хяналтын прокурор, 2013 оны 05 дугаар сараас эхлэн дүүргийн 3 дугаар прокурорын газар гэж нэрлэгдэн хуулийн хэрэгжилтэнд хяналт хэрэгжүүлэн ажиллаж байна.

**Прокурорын байгууллагаас Цагдаагийн хэлтэстэй хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүрээнд хийсэн ажлууд:**

<sup>38</sup>Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтсийн 2015 оны үйл ажиллагааны тайлангаас ашиглав.

<sup>39</sup>Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсийн 2015 оны үйл ажиллагааны тайлангаас ашиглав.

“Захиргааны хяналт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд шүүхээс хорих ял хойшилсон хүнийг хамруулан Дүүргийн захиргааны хяналтын прокурор болон Хэв журмын тасгийн дарга, байцаагч нараар яриа таниулга хийлгэн, санамж сэрэмжлүүлэг тараан, захиргааны хяналтанд байгаа ялтнуудын хувийн хэрэгтэй нэгбүрчлэн үзэж танилцан, хянуулж, баяжуулалт хийсэн.

Прокурорын газрын улирлын төлөвлөгөөнд тусгагдсан “Түр саатуулах байр ажилуулах журам”-н хэрэгжилтийг дүүргийн Прокурорын газраас баталсан удирдамжийн дагуу 2015 оны тодорхой өдрүүдэд шалгасан шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг арилгуулж, дахин зөрчил дутагдал гаргахгүй байх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаа.

1. Мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, эрүүгийн төлөөлөгч, хэв журмын ажилтан нарт түр саатуулах байранд саатуулагдсан этгээдийн гэмт хэрэг, зөрчил үйлдсэн сэрдэгдсэн байдлыг тодорхой бичиж тэмдэглэх, хариуцлагатай зохицуулагч нарт бүртгэх дэвтрийг тогтмол хөтөлж хэвшүүлэх талаар үүрэгжүүлэв.

2. Зөрчил үйлдсэн хүнийг түр саатуулахдаа түр саатуулагдсан үндэслэлийг танилцуулж, гомдол гаргах эрхийг тайлбарлан өгч, гарын үсэг зуруулж хэвших талаар нийт алба хаагч нарт зааварчилга өгч ажилласан.

3. Жижүүрийн шуурхай албаны алба хаагчдад түр саатуулах хугацаа дуусмагц түр саатуулсан албан тушаалтанд мэдэгдэж мэдэгдсэн тухайгаа бүртгэлд тэмдэглэх хэв журам хамгаалах тасгийн даргад өдөр тутам дэвтрийг танилцуулан ажиллах талаар үүрэгжүүлэв.

4. Захиргааны журмаар түр саатуулагдсан хүн гомдол гаргасан тохиолдолд гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх материалыг тэмдэглэлд хавсарган зөрчил гаргасан этгээдийг захиргааны журмаар түр саатуулсан тэмдэглэлийг шалгаж буй материалд хавсаргаж байх үүргүүдийг өгөв.

## **5. Шүүх байгууллага**

Багануур дүүргийн шүүх 1980 оны 2-р сард байгуулагдаж, 2010 оноос шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх ажлын хүрээнд техник хэрэгслүүдийг бүрэн шинэчилж, эрүүгийн, иргэний шүүх хуралдааны нарийн бичгийн даргын орон тоо шинээр бий болгон ажиллаж байна. “Шинэ шүүх, шинэчлэгдсэн шүүгч” уриан дор “Шүүхийн шийдвэрийн цахим сан”, “Багануур дүүргийн шүүх” вэб сайтыг ашиглаж олон нийтэд шүүх хуралдааны зар, шийдвэр, тогтоолыг нээлттэй мэдээллээр хангаж байна.

Шүүх 2010 оноос эхлэн хүүхдийн өрөөг тохижуулан хүүхдийн эрхийг зохих түвшинд хангаж шүүх хуралдааны танхимд самбар, проектор ашиглах талуудын эрх нээлттэй, бодитой хэрэгжсэн ба нарийн бичгийн дарга дектафон ашиглаж байна. Шүүгч хэргийн оролцогчтой дангаар уулзахыг хориглосон “Шүүгчийн ёс зүйн дүрмийн заалтыг хэрэгжүүлэх, хэргийн оролцогч нарт хэргийн хөдөлгөөн, түүнд оролцох эрх үүргийг ойлгуулах, хэвлэл мэдээллийн албаар дамжуулан үйл ажиллагаагаа иргэдэд таниулах ажлыг тогтмолжууллаа. Шүүхүүдийн хооронд мэдээ, тайлан, судалгаа цахим хэлбэрээр шуурхай хүргэгдэж байна.

2012 онд шүүхийн багц хуулиуд УИХ-н чуулганаар батлагдсан нь шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх ажлын хэрэгжилт бидний өмнө байгааг харуулж байна.

Ийнхүү хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа бодитой хэрэгжихэд тус дүүргийн шүүх сэтгэл, зүтгэл гарган хувь нэмэрээ оруулж ирсэн.

**6. Хороодын засаг дарга<sup>40</sup>** (хуулиар хүлээсэн үүрэг, биелүүлэх арга зам, хэлбэрүүд)

<sup>40</sup>Хороодын 2015 оны үйл ажиллагааны тайлангаас ашиглав.

## **Нийтийн хэв журам сахиулах чиглэлээр**

Гэмт хэрэгт холбогдож болзошгүй болон холбогдсон хүн, хүүхдүүдийн судалгаа гаргаж ажилласан. Хороодын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ХХК, ААНБ-тай хамтран ажиллаж гадна болон дотор камерыг тавиулах ажлыг үе шаттай зохион байгуулахаар төлөвлөжээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хороодын засаг дарга, нийгмийн ажилтан нартай хамтран хорооны иргэдийн дунд хуулийг ухуулан таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулж байгаа төдийгүй гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эрсдэлд орсон, гэр бүлийн хүчирхийлэлд өртөх магадлалтай хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах, тэдний хуулийн мэдлэгийг өргөжүүлэн нэмэгдүүлэх, хүчирхийлэгчид сэтгэл зүйн болон хуулийн зөвөлгөө өгч баталгаа гаргуулах зэрэг ажилд илүү анхааран ажиллаж байгаа нь сайшаалтай.

## **Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хөл хөдөлгөөн ихтэй газар, автобусны буудлуудад сэрэмжүүлэг самбарыг байрлуулан иргэд олон нийтэд анхаарлуулга байрлуулан. “Санамж”, “Сэрэмжлүүлэг” боловсруулан олшруулж орцны мэдээллийн самбарт тавьж иргэдэд сурталчилсан. ГХУС самбар хийн гудамжуудад байршуулав

“Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийн хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор үйл ажиллагаа эрхэлдэг албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн 8 иргэнийг 4 чиглэлд 2 цагийн хугацаатай хариуцлагатай эргүүл жижүүрээр томилон зөрчилгүй тайван ажилласан.

Хөршийн холбоо байгуулан Багануур дүүргийн Засаг даргын захирамжийн хүрээнд хөршийн холбооны ахлагч томилж, үнэмлэхжүүлэн хорооны конторт болон орцонд урьдчилан сэргийлье уриатай мэдээллийн самбарыг хийж иргэдэд ГХУС талаарх мэдээ мэдээллийг хүргэж байна.

Шүүхээс тэнсэн харгалзахаар хариуцлага ногдуулсан хүнд хяналт тавьж сар бүр хууль зүйн зөвөлгөө өгч баталгаа гаргуулан авч ажиллаж Захиргааны хяналт “Нэгдсэн арга хэмжээний хүрээнд захиргааны хяналтанд байдаг хүнийг сургалтанд хамруулав.

Иргэдийн амар тайван аюулгүй байдлыг хангах зорилгоор хорооны нутаг дэвсгэрт нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж байна.

- Камержуулалт
- Архигүй өдөр
- Эргүүл шалгалт
- Монголын уламжлалт баяр наадмууд, Цагаан сар, Олон улсын эмэгтэйчүүдийн баяр, Цэргийн баяр, Монголын Үндэсний их баяр наадам болсонтой холбогдуулан УБХЦГ, Цагдаагийн хэлтэс, ХЖТ-с зохиогдсон “Сар шинэ”, “Шалгалт”, Эргүүл, Хяналт, Захиргааны хяналт зэрэг нэгдсэн арга хэмжээ болон хорооны хэмжээнд Шалгалт, РС тоглоом, Ломбард, Эргүүл хяналт, Сэрэмжлүүлэг, засаг даргын эргүүл, Гадаад иргэд, Түц, Тамхины хяналт, Албан мэдэгдэл зэрэг давхардсан тоогоор хэсэгчилсэн 30 орчим арга хэмжээг зохион явуулсан байна.

- Иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, үр дүнг дээшлүүлэхийн тулд хорооны хэсгийн байранд иргэдээс гаргасан санал хүсэлтийг авч, ирүүлсэн мэдээ мэдээлэлийн мөрөөр шалгаж шийдвэрлэж байна.

- Аж ахуй нэгж байгууллагуудыг аливаа зөрчил гаргахгүй байх талаар гэрээ байгуулж гэрээг зөрчсөн байгууллагад арга хэмжээ аван, тэдний байршил хаяг эзэн захирал, түрээслэгч нарын дэлгэрэнгүй судалгааг гарган, ААНБ-г хууль тогтоомжийн дагуу ажиллах хууль зөрчихгүй байх талаар мэдэгдэл зааврыг хүргүүлж албан мэдэгдэл зөрчсөн

тохиолдолд захиргааны хариуцлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ аван, зөрчил гаргуулахгүй байх талаар ажиллаж байна.

### **Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах**

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаа олон нийтийн хамтын ажиллагааны хүрээнд, хорооны Засаг даргын захирамж гарган хорооны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, хөршийн холбоотой хамтран олон нийтийн эргүүл гарган, аж ахуйн нэгж байгууллагыг ажлын хуваарьт оруулан тэдгээр иргэд аж ахуйн нэгж байгууллагыг гэмт хэрэг гарч болзошгүй цэгүүдэд маршрутын дагуу эргүүлд гаргаж удирдлагаар хангаж ажиллалаа.

- Сургуулийн насны хүүхдийг гэмт халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нутаг дэвсгэрт байрлах дунд сургуулийн удирдах зөвлөлийн гишүүдтэй хамтран төлөвлөгөө гарган доорх ажлыг хийж гүйцэтгэлээ.

- Төлөвлөгөөний дагуу эргүүлүүдийн хуваарийг гарган ажиллаж байна.

Эргүүлийн хуваарийн дагуу Хорооны Засаг даргын ажлын алба, Хорооны СӨХ-үүд, Сайн дурын эргүүлүүд байнга ажиллаж байна.

Эргүүлийн хувьд:

- Гэрэлтүүлэг арга хэмжээ;
- Камержуулалт нэгдсэн арга хэмжээ;
- Гудамж арга хэмжээ;
- Орц арга хэмжээ;
- Тусгай зөвшөөрөлтэй ААН;
- Интернэт, РС тоглоом арга хэмжээ;
- Байгаль хамгаалал;
- Ломбард зэрэг арга хэмжээг авч байнгын давтамжтай ажиллаж байна.

### **Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр хийсэн ажил**

Дүүргийн засаг даргын захирамжын дагуу хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хорооны засаг дарга, зохион байгуулагч, нийгмийн ажилтан, олон нийтийн байцаагч, нарын хамтарсан эргүүлийг сар бүр хийж, ИТХТ-н хурлын 91-р тогтоолын хэрэгжилтийг хангаж сар болгоны нэгний өдрийг “Архигүй өдөр” болгон хяналт шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцон хэвшсэн.

Архи согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдан борлуулдаг аж ахуйн нэгж байгууллагыг шалгаж хяналт тавьж, цагдаагийн үйлчилгээг иргэдэд ойртож хүргэх зорилгоор айл өрх, албан байгууллагаар орж иргэдтэй уулзан санал хүсэлтийг авч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж хамтран ажилласан.

### **Тамхины хяналтын тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр**

Тамхины хяналтын тухай хуулийн дагуу мэргэжлийн хяналтын байцаагч, хэсгийн байцаагч нартай хамтран ТҮЦ, дэлгүүрүүдэд шалгалт хийсэн. Тамхины эсрэг 3 төрлийн 480 ширхэг сурталчилгааны логог үйлчлүүлэгч нарын нүдэнд ил харагдахуйц газар байрлуулан ажиллаж, хуулийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж зөрчил гарган ажиллаж байсан автобусны буудлын ТҮЦ-н түрээслэгч иргэнийг торгож арга хэмжээ авсан.

## **УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ, ШИНЭ САНААЧИЛГА**

### **Хөршийн холбоо хөтөлбөр**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хороодод хөршийн холбоо байгуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Хөрш” ажиллагааны төлөвлөгөө гаргаж дүүргийн Засаг даргаар батлуулан эхлүүлэх.

#### **Камержуулах, цахим зураглал хөтөлбөр**

“Байгууллага, аж ахуйн нэгжийг камержуулах тухай” Дүүргийн Засаг даргын захирамж гаргуулах. Тухайлбал, Хэсгийн байцаагч нар хариуцсан хороонд байрлах хүн ам олноор төвлөрсөн зах, худалдааны төв, банк санхүүгийн болон бусад аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гаргаж, түүнээс камер тавигдаагүй аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гарган захирамжийг хэрэгжүүлэх чиглэлээр захирамж, албан мэдэгдлийг 2016 оны эхнээс хэрэгжүүлэх, ач холбогдлыг таниулах сурталчлагааг тараан өгч, үр дүнг тооцох.

Энэ ажлын хүрээнд цаашид камержуулах ажлыг үргэлжлүүлэн хөгжүүлсэнээр иргэдийн өмчийн эсрэг гэмт хэрэг буурах хандлагатай байна.

#### **“School police” арга хэмжээ**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс гаргасан сургуулийн орчимд үүрэг гүйцэтгэх “School police” эргүүлийн ажиллах журмыг ЕБС, цэцэрлэгүүдэд хэрэгжүүлэх.

#### **Хулгай, Илрүүлэлт, Анчин нэгдсэн арга хэмжээ**

Сахилга ёс зүй, мэдлэг чадвар, албаны сонор сэрэмжийг дээшлүүлэх, албаны бэлэн байдлын хангаж, иргэдтэй соёлтой хуулийн хүрээнд харилцах харилцааг төлөвшүүлж, иргэдийн амгалан тайван амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэхийн тулд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог дээшлүүлнэ. Иргэдийн санал хүсэлтийг авч түүний мөрөөр ажиллагаа зохиож удирдлагаас хэрэгжүүлж байгаа бодлого ажлын зааврын дагуу ажиллах.

#### **Гудамжны гэрэлтүүлэг, гэрэл**

Гэрэлгүй гудамж, байрны орчим газруудад гэмт хэрэг үйлдэгдэх магадлал их тул гудамны гэрэл шинээр ашиглалтанд оруулсанаар гэмт хэрэг үйлдэх явдал буурч, иргэдийн аюулгүй амьдрах байдалд их тус нэмэр болно.

#### **Өсвөрийн цагдаа**

ЕБС-н орчинд гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлж, ахлах ангийн сурагчдыг зохион байгуулан өсвөрийн цагдаа клуб байгуулан ажиллах.

### **7. Бүх хэлбэрийн ААН, байгууллагуудын уялдаа**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүрээнд хамтран ажиллах шаардлагатай төрийн байгууллагууд нь бүгд босоо тогтолцоо бүхий удирдлагатай байгаа нь Дүүргийн Засаг даргын “Аюулгүй амгалан Багануур” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарим бэрхшээлийг учруулдаг.

Тухайлбал: Дүүргийн цагдаагийн хэлтэс нь ЦЕГ, УБХЦГ-с өгсөн чиг үүргийн дагуу, харин Мэргэжлийн хяналтын хэлтэс, Худалдаа үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс нь Засгийн газрын тохируулагч агентлаг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон Нийслэлийн Худалдаа үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэсээс өгсөн чиг үүргийн дагуу үйл ажиллагаа явуулдаг нь Дүүргийн ЗДТГ-н зүгээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүрээнд шинэ санаачилга, бүтээлч ажил гарган дорвитой үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй асуудлын нэг байдаг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлж, гэмт хэрэг, захиргааны зөрчлийн гаралтыг бууруулахад дээрх байгууллагуудын уялдаа холбоог нэмэгдүүлж, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх нь нэн даруй авах шаардлагатай арга хэмжээ.



Дүүргийн захиргааны байгууллагуудын 2015 онд хэрэгжүүлсэн ажлын уялдаа, холбоог авч үзвэл: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүрээнд Цагдаагийн хэлтэс болон Худалдаа үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэсүүд архи согтууруулах ундаа болон Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, түүгээр үйлчилдэг ААНБ-дад тогтмол хяналт тавьж, хамтран ажилласан.

Үүнийг хэрэгжүүлэхдээ хорооны засаг даргын зөвлөлөөр эргүүлийн бүрэлдэхүүн гаргаж шалгалт хийх, хамтарсан аян өрнүүлэх, “Хууль сурталчлах” сургалт зохион байгуулах зэргээр уялдаа холбоотой хамтран ажиллажээ.

Аюулгүй байдлыг хангах буюу гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажилд уялдаа холбоотойгоор хамтран ажиллах шаардлага бүхий төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд: (Зураг.6)



Тус байгууллагуудад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийг хариуцсан тусгай орон тоог бий болгох, өөрөөр хэлбэл, дүүргийн хэмжээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар бусад байгууллагатай хамтран ажиллах, үйл ажиллагааны уялдаа холбооны асуудлыг хариуцсан мэргэжилтэнтэй болох асуудлыг судлан үзэх шаардлагатай.

ГХУСТХ-д иргэн, байгууллага, аж ахуй нэгжүүд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хүлээх үүргийг заасан хэдий ч тэдгээр заалтыг биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг тодорхой болгох, чангатгах талаар зааж өгөх шаардлагатай.

### **4.3. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БОЛОН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ДЭМЖЛЭГ, ХАМТЫН АЖИЛЛАГАА, ГАДААД УЛСУУДЫН ТУРШЛАГА**

Захиргааны төв болон орон нутгийн байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлдэг ажил, чиг үүрэг нь хуулиар тогтоосон.

Нийтийн аюулгүй байдлыг сайжруулах нь зөвхөн цагдаагийн байгууллагын үүрэг бус орон нутгийн захиргааны гүйцэтгэх үүрэг.<sup>41</sup>

Нийтийн аюулгүй байдлыг хангах гэдгийг олон хүмүүс зөвхөн цагдаагийн байгууллага, онцгой байдлын алба, яаралтай тусламжийн байгууллагууд гэх мэт нийтийн аюулгүй байдлын агентлагуудыг ойлгодог хэдий ч орон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс бүр нийтийн аюулгүй байдлын үйл ажиллагааг дэмжиж ажиллах чухамхүү үүрэгтэй. Эдгээр дэмжлэг үйл ажиллагаа нь:

#### **1. Барилга байгууламжид шалгалт хийх ба код сайжруулах:**

Барилга байгууламж дахь кодыг сайжруулах нь СӨХ болон бусад аж ахуйн нэгжийн байгууламж, эд хөрөнгийн өмчлөгч нарт өөрсдийн эд хөрөнгийг хариуцлагатай эзэмшихэд тусладаг бөгөөд гэмт хэрэг үйлдэх явдлыг багасгаж өгдөг талтай.

#### **2. Эдийн засгийн хөгжил:**

Тухайн орчинд худалдаа арилжаа бий болсноор хүмүүс янз бүрийн цаг хугацаа, өөр өөр өдөр, цагуудад ажиллах болсноор гэмт хэргийн нөлөөг арилгаж урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

#### **3. Сэтгэцийн эрүүл мэнд:**

Сэтгэцийн хувьд биеэ хянах чадваргүй хүмүүс нь гэмт хэрэг үйлдэх ба гэмт хэргийн хохирогч болж болзошгүй учраас тэдэнд анхаарал хандуулна.

#### **4. Авто зогсоол:**

Зогсоолуудын зохицуулалт, хяналт, ашиглалт ба нийтийн эзэмшлийн зогсоолын тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд замын хөдөлгөөний бөглөрөл бусад нөлөөллийг бий болгодог тул тээврийн хэрэгслүүдийн аюулгүй байдалд мөн нөлөөлдөг.

#### **5. Байгалийн цогцолборт, үзэсгэлэнт газар, амралт зугаалгын газар:**

Байгалийн цогцолборт, үзэсгэлэнт газруудын үйл ажиллагаа, тохижилт, ашиглалтыг хариуцан зохион байгуулах нь байгалийн цогцолборт газруудад гарах гэмт хэрэг, нийтийн хэв журмын зөрчлийг арилгахад нөлөөлдөг.

#### **6. Төлөвлөлт, орон нутгийн хөгжил:**

Тухайн газрын талбай, барилга, хөрш айлууд, ба олон нийт, орон нутгийн түвшинд оршин суугаа газрын төлөвлөгөөг баталдаг бөгөөд оршин суугаа газрын зөв төлөвлөгөө нь гэмт хэргийн гаралтыг бууруулж урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

#### **7. Нийтийн эрүүл мэнд:**

Халдварт өвчин дамжин халдварлахыг хянах болон хариуцах, гол төлөв хүчиндэх, хар тамхинд донтох, согтуурсан үед тархах бэлгийн замаар халдах халдварт өвчнүүдээс сэргийлэх.

#### **8. Нийтийн орон сууцанд:**

Оршин суугчдыг сайн удирдан чиглүүлэх ба стандартыг тогтоох, мөрдүүлэх

#### **9. Нийтийн номын сангууд:**

<sup>41</sup>Жоел Б.Плант, Майкл С.Скот, "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба үр нөлөөтэй бодлогыг боловсруулах нь", АНУ-н Хууль зүйн яам, 2009 он.

Номын санд үйлчлүүлэгчийг чиглүүлэн залуусыг аюулгүй байлгах ба үр бүтээлтэй орчноор хангах

#### **10. Олон нийтийн ажил хөдөлмөр:**

Гудамжийг гэрэлтүүлгээр хангах энэ нь шөнийн цагийн үед орон байранд нэвтэрсэн хулгайлах, хүчирхийллийн халдлага зэрэг маш олон гэмт хэрэгт нөлөөлдөг.

#### **11. Сургуулиуд:**

Сургуулийн барилга ба талбай, оюутнуудын ирц ба кампусаас гадуур байх эдлэх эрх, сургуулиас гадуурх үйл ажиллагаа, сургууль доторх оюутнуудын хяналт зэрэг зүйл нь оюутны ба тухайн орчны хүмүүсийн аюулгүй байдалд нөлөөлдөг.

#### **12. Нийгмийн үйлчилгээнүүд:**

Нийгмийн эмзэг хэсгийн хүмүүс болох хүүхдүүд, ахмад настан, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч нарыг анхаарах

#### **13. Замын хөдөлгөөний инженерчлэлийн хувьд:**

Замын загвар хийц, ачаалал, зохицуулалт, удирдлага, хурдны хязгаарлалтыг мөрдүүлэх эдгээр зүйлүүд нь замын хөдөлгөөний хурд, урсгал, осол аваар гарах эрсдлийг бууруулдаг.

**Гэмт хэрэг ба нийтийн хэв журмын зөрчлийг орон нутгийн захиргааны байгууллага хэрхэн хянаж урдчилан сэргийлэх талаар:**

#### **Орон нутагт суурилсан бодлого тодорхойлох арга, хандлага**

Цагдаагийн байгууллагад итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхийн тулд цагдаа нь иргэдтэй ойр ажиллах ба оршин суугчдын олон нийтийн аюулгүй байдлын санаа бодлыг судлах ажлыг оновчтой тодорхойлж, байнгын үйл ажиллагаатай болгох.

#### **Асуудалд суурилсан бодлого тодорхойлох арга**

Гэмт хэрэг, зөрчлийн асуудал бүрээс юуг шинээр сурч авах, тухайн асуудлын шинэлэг талаас үлгэр авч илүү үр дүнтэй стратегийг бий болгоход анхаарлаа хандуулдаг. Асуудалд суурилсан бодлого, үйл ажиллагаа нь урьдчилсан сэргийлэх ач холбогдлоороо өндөр үр дүнтэй бөгөөд зөвхөн эрүүгийн эрх зүйн системийн хүрээнд хамааралтай бус бусад нийтийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, олон нийтийн байгууллагын зайлшгүй оролцооны үед гэмт хэргийг бууруулдаг.

Асуудалд суурилсан бодлого нь гэмт хэрэг, нийтийн хэв журмын зөрчил ба олон нийтийн аюулгүй байдлыг хялбарчилсан хандлага биш харин дан ганц шийдлээр бүх асуудлыг шийдэхгүй өөр хувилбарыг бий болгодог.

#### **Нөхцөл байдлын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөл байдал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхдээ цагдаагийн үйл ажиллагаа бус илүү шинжлэх ухааны арга барилаар гэмт хэргийг илрүүлэхийг ойлгоно. Энэ хандлага нь гэмт хэргийг бууруулахдаа гол анхаарлаа хандуулахгүй харин аюулгүй орчин, илүү аюулгүй бүтээгдэхүүн бий болгож бууруулна гэж үздэг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөл байдал нь зөвхөн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарахгүй орон нутгийн захиргааны байгууллагын чухал үр нөлөөллийн нэг аюулгүй орчин бий болгох зорилго бүхий бүсүүдэд хуваах, төлөвлөх, газар ашиглалтын зохицуулалт хийх, түүнчлэн зарим хулгайлах гэмт хэргийн замаар ашиглагдсан бараа бүтээгдэхүүний худалдаа арилжааны нөлөөллийг ойлгоно.

#### **Мэдээлэлд суурилсан бодлого тодорхойлох арга**

Анх Их Британи Улсын Цагдаагийн байгууллагад ашиглаж байсан бол Америкийн Нэгдсэн Улсын Цагдаагийн байгууллагууд өнөөг хүртэл хөгжүүлэн ашиглаж байна. Мэдээлэлд суурилсан бодлого тодорхойлох нь цагдаагийн ахлах удирдлагуудад гэмт

хэргийн болон мэдээллийн шууд өгөгдлүүдийг илүү сайн ашиглах, зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээ, гэмт үйл ажиллагааг таслан зогсоох, гэмт хэрэгтнүүдийг баривчлахад туслах зориулалттай ашиглагдаж байсан.

Энэхүү загвар нь мэдээллүүдийн өгөгдлүүдийг цуглуулах ба дүн шинжилгээ хийж цагдаагийн үйл ажиллагаанд мэдээлэх ач холбогдолтой. Энэ хандлага нь ерөнхийдөө орон нутагт суурилсан бодлого ба асуудалд суурилсан бодлоготой тохирдог.

#### **Хагархай цонхны бодлого тодорхойлох арга**

Энэ бодлогын агуулга нь нийтийн аюулгүй байдалтай холбоотой жижиг мэт зөрчлүүд нь нийгэмд илүү ноцтой гэмт хэргийг бий болгодог гэдгийг баталдаг. АНУ-н цагдаагийн газрын сүүлийн хэдэн жилд энэ бодлого нөлөө үзүүлсээр ирсэн бөгөөд нийгмийн бага хэмжээний зөрчлүүдийг бүртгэж ирсэн байна. Зарим эрдэмтэн энэ байдлыг үгүйсгэж ирсэн боловч нийтийн хэв журмын зөрчил нь илүү ноцтой гэмт хэргийн шалтгаан болсоор ирснийг тогтоосон байна.

#### **Үл тэвчих бодлого тодорхойлох арга**

Үл тэвчих бодлого тодорхойлох нь цагдаагийн офицер хуулиар тогтоосон үүргийг хуулийн дагуу хатуу чанд мөрдөж ажиллахыг ойлгоно. Энэ үзэл санаа нь сэтгэл санаагаар унасан, айж балмагдсан иргэдийн хувьд түгээмэл ашигладаг бөгөөд цагдаагийн байгууллага өргөн цар хүрээнд хууль сахиулах нь орон нутгийн шүүхийн тогтолцоонд болон цагдаа-олон нийтийн хооронд сөрөг үр дагавартай гэж үздэг. Маш олон цагдаагийн албан хаагч болон эрдэмтэн энэ үзэл санаанд шүүмжлэлтэй ханддаг.

#### **КомпСтат арга**

КомпСтат (“компьютержсэн статистик мэдээ” гэдэг үгийн товчлол) нь 1990-ээд оны үед Нью-Йорк хотын цагдаагийн менежментийн хэрэгсэл болон үүссэн бодлого.

Энэ нь гэмт хэргийн хэв маяг, гэмт хэргийн илэрц илрэхэд цагдаа нарын нөөцийг түргэн шуурхай байршуулах, ба гэмт хэргийн мэдээлсэн тоог бууруулахын тулд цагдаагийн тушаалын тооцоолох чадварыг бий болгон статистик мэдээлэл дээр үндэслэн гэмт хэргийг бууруулах арга.

Маш олон тооны цагдаагийн байгууллагууд энэ загварыг ашигласан байдаг бөгөөд нөгөө талаас энэ нь гагцхүү олон нийтийн нийтлэг аюулгүй байдлын асуудлуудаас илүү цөөн хэдэн төрлийн мэдээлэгдсэн гэмт хэрэг дээр гол анхаарлаа хандуулах ба сонгож авсан гэмт хэргийн асуудалд богино хугацааны өндөр өртөгтэй аргыг ашигладаг.

#### **Уламжлалт загварын бодлого тодорхойлох арга**

Уламжлалт болон мэргэжлийн бодлого тодорхойлох загвар нь илрэх өндөр магадлалтай гэмт хэргийг ялгах, байнгын бус тохиолдлын цагдаагийн эргүүл бүхий, иргэд цагдаад хандахад маш хурдан хариу үйлдэл үзүүлдэг ба мөрдөн байцаагч нар гэмт хэргийн шалгалтыг гүйцэтгэх зэргийг онцлон үздэг арга. Эдгээр бүрэлдэхүүн хэсэг нь цагдаа нар гэмт хэрэгтнийг барихад чиглэгдсэн бөгөөд гэмт хэрэгтнүүдэд нь эрүүгийн мөрдөн шалгах процессоор ял оногдуулдаг. Мөн энэ аргад нотлох баримт маш чухал үүрэгтэй бөгөөд олон нийтийн аюулгүй байдалд хандах хандлага ба цагдаад итгэх олон нийтийн итгэл, орон нутгийн захиргааны байгууллага маш чухал үүрэгтэй.

#### **Хөршийн холбоо болон хөршийгөө ажиглах хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх**

1972 онд орон байрны хулгайн гэмт хэрэг ихээхэн өсөн нэмэгдэх болсонтой холбоотойгоор АНУ-н Үндэсний Шериффын Нийгэмлэг энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж

эхэлсэн байдаг.<sup>42</sup> АНУ-д хамгийн үр дүнтэй гэж тооцогддог гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга бол “**хөршийгөө харах**” (neighborhood watch) хөтөлбөр.

Хөтөлбөрийн хүрээнд оршин суугчдын дунд өөрийн хөршийг ажиглаж гэмт хэргийн шинжтэй үйлдэл илэрвэл орон нутгийн цагдаагийн ажилтнуудад мэдээлэх ажиллагааг явуулсан. Аймшигт террорист үйл ажиллагааны дараа тус хөтөлбөр АНУ-д улам өргөжиж хөршийгөө ажиглах үйл явц нь террорист ажиллагаанаас сэргийлэх, гэнэтийн аюул ослын үед бэлтгэлтэй байх зэрэгт ач холбогдол өгөх болжээ

---

<sup>42</sup> <http://www.usaonwatch.org/default.aspx>

## **Багануур дүүргийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зөвлөх нь**

Дүүргийн Засаг даргын “Нийгэм эдийн засгийн зорилт болон 2013-2016 оны Засаг даргын мөрийн хөтөлбөр”-г үндэслэн цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэх арга хэмжээнд энэ судалгааны эцсийн үр дүнг ашиглахыг зөвлөж байна.

Судалгааны ажлын хүрээнд Багануур дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ, гэмт хэргийн өнөөгийн байдал, төрөл, түүний шалтгаан, нөхцөл, “Аюулгүй амгалан Багануур” хөтөлбөр, төв орон нутгийн захиргааны байгууллагуудын гэмт хэрэгтэй тэмцэж түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч буй ажлын тайлан, гадаадын орны гэмт хэргээс урьдчилан сэргийлж байгаа туршлага зэргийг судалгааны зүйл болгон авч дүн шинжилгээ хийсний эцэст дүүргийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.

1. Дүүргийн хэмжээнд хамгийн ихээр үйлдэгдэж буй гэмт хэргийн төрлийг тодорхойлж, ГХУСТХ-н 6.3-т зааснаар тусгай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Эдгээр гэмт хэрэгт өмчлөх эрхийн эсрэг, хүний амь бие эрүүл мэндийн эсрэг, нийгмийн аюулгүй байдлын эсрэг хэрэг. Тухайлбал: Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, хулгайлах, танхайрах, зам тээврийн осол, хар тамхи, гэр бүлийн хүчирхийлэл, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэх мэт.

2. Эдийн засаг, нийгмийн 2017 оны зорилтод гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар дүүргийн хэмжээнд бүх төрийн байгууллагын үүрэг оролцоог нарийвчлан тодорхойлж оруулах,

Шүүх, цагдаа, прокурор, цагдаагийн хэлтсүүд, хороод, мэргэжлийн хяналт, худалдаа үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс, боловсрол, соёлын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага гэх мэт.

3. Дүүргийн иргэний бүртгэлийн ажилтан, хороодын нийгмийн ажилтнууд хамтран дүүргийн хүн амын болон дүүргийн нутагт оршин суугчид, шилжилт хөдөлгөөний бүртгэл хаягжуулалтын судалгааг нарийвчлан гаргах. Мэдээллийн сан нь цагдаагийн байгууллага болон бусад хууль сахиулах байгууллагатай харилцан холбоотой хамтран ажилладаг байх.

Ялангуяа түр оршин суугчид, орон гэргүй тэнэмэл хүмүүс, архи, мансууруулах бодисонд донтсон хүмүүсийг анхааралдаа авч бүртгэлжүүлэх, хянах нь зүйтэй.

**Гадны туршлага:** Калифорния, Санта Ана (1993)

Санта Ана дахь орон гэргүй хүмүүс нэмэгдэхийн хэрээр худалдааны дүүрэг дэх гэмт хэргийн гаралт ихсэж байсан байна. Цагдаа нар түр оршин суугчид, гэмт хэрэгтнүүд ба догшин ширүүн авиртай хүмүүсийг тухайн газраас зайлуулах арга хэмжээ авч, хотын эмх цэгц, орчны загвар хийцийг сайжруулан, дүүргийн иргэдийг спорт урлаг зэргээр хөгжүүлж, дэмжин ажиллахад аж ахуйн нэгж байгууллагууд татвар өсч, гэмт хэрэг ба нийтийн хэв журмын зөрчил багассан байна.

4. Дүүргийн хэмжээнд авто зогсоолыг сайжруулах.

Зогсоолуудын зохицуулалт, хяналт, ашиглалт ба нийтийн эзэмшлийн зогсоолын тоног төхөөрөмжийн аюулгүй байдал нь замын хөдөлгөөнд ихээхэн нөлөө үзүүлдэг бөгөөд энэ нь тээврийн хэрэгслүүдийн аюулгүй байдалд мөн нөлөөлдөг.

Ялангуяа автомашины хулгайн гаралт өндөртэй хороодыг анхааралдаа авч тэдгээр хороонд авто зогсоолуудыг шинээр бий болгох шаардлагатай.

5. Аюулгүй байдлыг илэрхийлэх шалгуур үзүүлэлт гаргаж, түүнийг бууруулах шаардлагыг 2017 оны мөрийн хөтөлбөртөө оруулж, хүрсэн үр дүнгээ үнэлэх (Гэмт хэрэг өснө, чанарын талаасаа буурсан эсэхийг үнэлэх асуудал)

Дүүргийн хэмжээнд хохирогчдын тоог нийт хүн амд харьцуулахад аюулгүй байдлыг илэрхийлэх шалгуур үзүүлэлт гарах ба аюулгүй амгалан дүүрэг байхын нэг илэрхийлэл нь энэхүү коэффициент нь бага байх нөхцөл болно. Иймд гэмт хэргийн хохирогчийг бууруулах, хохирсон иргэдийн эрхийг нөхөн төлүүлэх, сэргээх чиглэлээр тууштай арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

6. Орон сууц, байрны хаалгыг коджуулах, ингэснээр орон байранд нэвтэрч хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

Гадаад орны туршлагаас үзвэл барилга байгууламж дахь кодыг сайжруулах нь эд хөрөнгийн өмчлөгч нарт өөрсдийн эд хөрөнгийг хариуцлагатай эзэмшихэд тусалдаг бөгөөд гэмт хэрэг үйлдэх явдлыг багасгаж өгдөг байна. Камержуулсан, кодолсон байранд хуучны байртай харьцуулахад орон байранд нэвтэрч хулгайлах гэмт хэрэг бага гардаг нь олон оронд нотлогдсон байдаг.

7. Аюулгүй орчин бүхий сургуулиудыг бий болгох

Зам тээврийн хөдөлгөөн төдийгүй сургуулийн барилга байгууламж, талбайн загвар дизайн, засвар үйлчилгээ зэргийг сайжруулахад дүүргийн удирдлагын зүгээс хамтран ажиллах нь зүйтэй. Насанд хүрээгүй хүмүүс гэмт хэрэгт өртөх явдал ихэссэн өнөөгийн нийгэмд сургуулийн орчинг аюулгүйжүүлэх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэн чухал асуудлын нэг болдог.

8. Архи тамхины хяналт болон соёлтой хэрэглээг төлөвшүүлэх үйл ажиллагаанаас гадна мансууруулах бодисын хэрэглээг хянах арга хэмжээ авах, түүний хор хөнөөлийг сурталчлах

Сүүлийн үед хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ нийслэлд ихээхэн газар аваад байгаа бөгөөд 2011 оны НҮБ-н Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас (UNODC) гаргадаг тайланд Монгол Улс каннабисын өргөн тархалттай, героин, кокаин, экстазийн тархалттай оронд хамаарах болсон ба 2011 оны судалгаагаар 16000 хэрэглэгч манай улсад байна. Түүнчлэн АНУ-д үйлддэгдэг нийт гэмт хэргийн ихэнх хувь нь ямар нэгэн байдлаар хар тамхи, мансууруулах бодистой уялдан гарч байна. Иймд дүүргийн хэмжээнд хар тамхи мансууруулах бодистой тэмцэх чиглэлээр арга хэмжээ авах шаардлагатай.

9. **(Broken windows)** хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Зөрчлийг багаснаар гэмт хэрэг багасдаг гэдэг судалгаа гарсан. “Хагарсан цонх” (broken windows) хөтөлбөр 1982 онд Жеймс Вилсон болон Жеорж Келлинг энэ хандлагыг анх гаргасан бөгөөд тэд “нийгэмд буй эмх замбараагүй байдал, зөрчил, хөнгөн гэмт хэргээс ноцтой гэмт хэргүүд үүдэлтэй байдаг” гэсэн санааг дэвшүүлжээ.<sup>43</sup>

Зөрчил бүрийг тэмдэглэн хөтөлж анхаарч, гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх боломж бүрдүүлэх. Энэ аргын хувьд Нью-Йорк хотын метро болон түүний орчин тойронд туршигдсан ба метронд үнэгүй суух асуудал, метрогоор дэмий холхигч, хананд зураг эрээгчигч нарыг эмхлэн журамласнаар тэр хавьд үйлдэгддэг гэмт хэрэг эрс буурсан үзүүлэлт гарсан.

10. Хорих ангид ЕБС-н зан байдлын доголдолтой, хэрэг зөрчилд холбогдсон хүүхдүүдийг зочлуулж хорих ангийн бодит байдлыг мэдрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх (Энэ арга нь АНУ-д анх үүсч, БНСУ, Энэтхэг зэрэг олон улсад нэвтэрсэн арга).

<sup>43</sup>Давид Коллиер “АНУ-д гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга болон байгууллагыг сонгох нь” ЖСТФ Хууль зүйн болон нийгмийн шинжлэх ухааны сэтгүүл, 2012 оны №1

Дүүргийн хэмжээний ЕБС-н зарим сурагчдыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон цагдаагийн байгууллагатай хамтран хорих ангийн бодит байдлыг мэдрүүлэх хөтөлбөрт хамруулснаар тухайн хүүхдийг ирээдүйн гэмт хэрэгтэн болохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Гэмт хэрэгт холбогдох эрсдэл бүхий бүлгийн болон захиргааны зөрчилд шийтгүүлсэн насанд хүрээгүйчүүдийг энэхүү хөтөлбөрт хамруулж байсан ба тус ажлын хүрээнд 1978 онд “Айсан хүн” нэртэй баримтат киног хүртэл хийж байсан. Өмнөд Каролина мужийн томоохон хорих ангиудад насанд хүрээгүйчүүдийг зочлуулж хорих ангийн бодит байдал, тэрхүү хүнд хэцүү амьдралыг мэдрүүлэх энэхүү хөтөлбөрт нийт 8000 гаруй хүүхэд хамрагдсан байдаг.

11. Дүүргийн хэмжээнд гэмт хэргийг цахим зураглалын төсөл хэрэгжүүлэх. **Crime Mapping System** нь дэлхийн олон оронд хэрэгжиж байгаа систем бөгөөд гэмт хэргийн гаралтыг иргэдэд газрын зургаар мэдээллэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх өндөр үр дүнтэй арга технологи (ухаалаг утсанд суурилуулах боломж бүхий аппликейшн).

Аливаа улс нийт нутаг дэвсгэрийн, бүс нутгийн, хотуудын, хөдөө орон нутгийн түвшинд гэмт хэргийн гаралтыг газрын зурагт програмд тэмдэглэж, олон нийтэд нээлттэй мэдээлснээр гэмт хэргийн гаралт өндөр газруудад иргэд болгоомжтой зорчих, оройн цагаар аль болох нэвтрэхгүй байх гэх мэтээр гэмт хэргийн хохирогч болохоос өөрсдийгөө хамгаалдаг байна. Монгол Улсад нийслэлийн хэмжээнд энэхүү тогтолцоог нэвтрүүлэх ажлыг эхлүүлэхээр судалгааг Багануур дүүргээс энэ ажилд идэвхтэй оролцон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шинэлэг алхмыг туршин хэрэгжүүлэх нь зүйтэй.

12. ГХУСТХ, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хуульд заасан төрийн албан байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэгтгэж уялдуулж өгөх, ГХУСТХ-д иргэн байгууллага, аж ахуй нэгжүүд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хүлээх үүргийг заасан тул үүний дагуу арга хэмжээ авах, шаардлага хүргүүлдэг механизмтэй байх

Дүүргийн Засаг дарга болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагын зүгээс үр нөлөөтэй нэгдсэн бодлогыг боловсруулан, үүнд бусад байгууллагын үйл ажиллагааг уялдуулан хамтруулах талаар анхааран ажиллах шаардлагатай. Дүүргийн Засаг даргын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон Эдийн засаг, нийгмийн 2017 оны зорилтод гүйцэтгэх ажлуудыг төлөвлөхдөө дараах гадаад улс орнуудын сайн туршлага, бодлого, үйл ажиллагааг нэвтрүүлэх нь зүйтэй.



#### **4.4. БАГАНУУР ДҮҮРГИЙН ХОРООДЫН ЗАСАГ ДАРГА, ХУУЛЬ САХИУЛАХ, ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, ХӨРШ ЗЭРГЭЛДЭЭХ НУТАГ ДЭВСГЭРИЙН ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ**

Багануур дүүргийн хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судалж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар санал, зөвлөмж боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тодорхойлох зорилгоор:

- Багануур дүүргийн хороодын Засаг дарга нараас *“хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл, хэрэг, зөрчлийн тохиолдол, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой санал, шүүмж, зөвлөмж авах”*;
- Шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдал, мэргэжлийн хяналтын байгууллагаас *“Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн тохиолдол, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой үнэт санал, шүүмж, зөвлөмж авах”*,
- Баянзүрх дүүргийн Цагдаагийн III хэлтэс, Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс, Төв аймаг, Хэнтий аймгийн Цагдаагийн газраас *“Багануур дүүргийн нутаг дэвсгэрийн бүс орчимд гэмт хэрэг, зөрчилтэй хэрхэн тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль хяналтын байгууллагын хамтын ажиллагааны талаар санал, шүүмж, зөвлөмж, тодорхой баримт мэдээлэл авах”-р* судалгааны багаас албан бичгээр нийт 5 хорооны Засаг дарга, 9 байгууллагын удирдлагад хүсэлт тавьсанаас дараах саналуудыг ирүүлсэн байна.

#### **2 дугаар хорооны Засаг даргаас<sup>44</sup>:**

“Тус хороонд малтай 61 иргэн бүртгэлтэй ба малын хулгай болон мянганы зам дагуу авто тээврийн хэрэгсэлд мал дайрагдах гэмт хэрэг гардаг. 2016 оны 2 дугаар улиралд 1.1 км хатуу хучилттай зам шинээр байгуулж, зам дагуу гэрэлтүүлэг суурилуулсан бөгөөд авто тээврийн хэрэгсэл хурд хэтрүүлэх, иргэд гудамж талбайд архидан согтуурах магадлал их тул замын дагуу хяналтын камер, замын тэмдэг, тэмдэглэгээ суурилуулах санал” ирүүлжээ.

#### **3 дугаар хорооны Засаг даргаас<sup>45</sup>:**

“Тус хороонд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хорооны Засаг даргын захирамжаар 15 гишүүнтэй хамтарсан баг ажилладаг байна. Хөршийн хяналт, хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийг хорооны хэмжээнд хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, сургалт, сурталчилгааг явуулдаг гэжээ. Хороо, цагдаагийн хэлтэс иргэдийн уялдаа холбоог сайжруулах, малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, гэр, орон байрны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, илрүүлэхийн тулд гэр хорооллын гудамж, байр болгонд камер суурьлуулах, Дүүргийн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах байртай болох, хорооны хамтарсан багийг унаа тээвэр, шатахуун, сургалтын зардал шийдэж өгөх, түүний дотор мотоцикль авч өгөх, хорооны нийгмийн ажилтан болон цагдаагийн байцаагч нарт хохирогчтой уулзаж, сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх тусгай өрөө шийдэх, хөршийн холбоог сайржуулах боловсронгуй болгох, тэднийг урамшуулах, урамшилт эргүүлийг дахин ажиллуулах, гэр хороолол орчимд гэрэлтүүлэг тавих, гэмт хэрэг илрүүлсэн иргэн, алба

<sup>44</sup>Багануур дүүргийн 2-р Хорооны Засаг даргын 2016 оны 07 сарын 29-ний өдрийн 61 дугаар албан бичиг.

<sup>45</sup>Багануур дүүргийн 3-р Хорооны Засаг даргын 2016 оны 08 сарын 22-ны өдрийн 174 дүгээр албан бичиг.

хаагчдыг шагнаж урамшуулах, цагдаагийн алба хаагчид, хорооны хэсгийн цагдаа нарыг тогтвортой ажиллуулах” зэрэг саналыг ирүүлжээ.

#### **Төв аймгийн Цагдаагийн газраас<sup>46</sup>:**

“Тус аймгийн Эрдэнэ, Баяндэлгэр, Архуст, Мөнгөнморьт сумдад үйлдэгдэж байгаа гэмт хэргийн 60 орчим хувийг иргэдийн өмчийн хулгай эзэлж байдаг. Мөн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт амралт, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд олон байдаг, эдгээр газар нь хулгайлах гэмт хэрэгт өртөх явдаг их гардаг. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд хамтарсан эргүүл шалгалт зохион байгуулах, хяналтын пост гаргах, замын цагдаагийн хяналтын постыг нэмэгдүүлэх, улсын чанартай автозамын зарим хэсэгт дугаар илрүүлэгчтэй хяналтын камер байрлуулах, зам тээврийн осол, гэмтэл гардаг цэгүүдийг тодорхойлж, тухайн газарт анхааруулга, сэрэмжлүүлэг бүхий самбар байрлуулах, тэр цэг орчимд замыг засварлуулж стандартыг дагуу болгох, мал мах, түүхий эд авдаг ченж, цэг, аж ахуйн нэгжүүдийг бүрэн камержуулах, судалгаанд авах, мэдээлэл солилцох” зэрэг саналуудыг ирүүлжээ.

#### **Налайх дүүргийн Цагдаагийн хэлтсээс:**

Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судалж буйтай холбогдуулан тодорхой саналгүй гэжээ.

#### **Баянзүрх дүүргийн Цагдаагийн III хэлтсээс<sup>47</sup>:**

“Сүүлийн үед хулгайлах гэмт хэрэг үйлдэгчид нь бусдын орон байрыг урьдчилан судлах, автомашин, техник хэрэгсэл ашиглаж үйлдэх зэргээр зохион байгуулалтад орж байгаатай холбогдуулан хөршийн холбоог сайжруулан сэргээх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг тодорхой чиглэл, зорилготой, тусгай хөтөлбөр, төлөвлөгөө гарган иргэд, олон нийт, нутгийн захиргааны байгууллагуудын үүрэг оролцоо, дэмжлэг тусалцаа, хамтын ажиллагааг сайжруулах, гэрэлтүүлэг болон хяналтын камерыг гэр хороололд болон олон нийт ихээр цуглардаг газруудад байрлуулах ажлыг эрчимжүүлэх, хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийн хэрэгжилт, зохион байгуулж буй ажлын үр дүн, ололт амжилт, дутагдлыг тухай бүр иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах зэрэг саналыг” ирүүлжээ.

### **4.5. БАГАНУУР ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АСУУДАЛ**

Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрхийг хамгаалахтай холбогдсон Монгол Улсын болон Олон улсын хууль тогтоомж тус улсын нэгдэн орсон олон улсын конвенциудыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 276 дугаар тогтоол, ЦЕГ- даргын 2009 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 52 дугаар тушаалаар тус цагдаагийн хэлтсийн дэргэдэх дотоодын цэргийн тусгай салааг Нийслэлийн Багануур дүүрэг дэх ус хангамжийн эх үүсвэрийн объектуудыг гадны гэмт халдлагаас хамгаалуулах зорилготойгоор анх байгуулсан.

Монгол Улсын Их хурлаас 2013 онд шинэчлэн найруулж баталсан Цагдаагийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 174, 175 дугаар тушаалаар Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтсийн дэргэдэх дотоодын цэргийн тусгай салаа татан буугдаж, ЦЕГ-н Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын харьяа олон нийтийн аюулгүй

<sup>46</sup>Төв аймгийн Цагдаагийн газрын 2016 оны 08 сарын 18-ны өдрийн 45/02-2419 дугаар албан бичиг.

<sup>47</sup>Баянзүрх дүүргийн Цагдаагийн III хэлтсийн 2016 оны 08 сарын 17-ны өдрийн 8/01-1922 дугаар албан бичиг.

байдлын хангах хэсэг болон бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөд орж, үндсэн чиг үүргийн хүрээнд доор дурьдсан эрх хэмжээг хэрэгжүүлэх болсон. Үүнд:

- Дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал болон бусад объектыг хамгаалах, шаардлагатай үед зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх;
- Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед хорио цээрийн дэглэмийг сахиулах;
- Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах;
- Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль тогтоомжид заасан үүрэг гүйцэтгэх;
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах;
- Нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалт хийх;
- Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагааг гүйцэтгэдэг.

Цагдаагийн хэлтсийн Олон нийтийн аюулгүй байдлын хангах хэсэг 2016 оны 08 дугаар сарын 18-ны байдлаар тус хэсгийн 5 харуулын цэгийн хамгаалалтад “Багануур-Ус” ОНӨААТҮГ-н харьяа 500-1000 кубметрийн багтаамжтай өргөх станц бүхий усан сан 3, гүний 5 худаг байдаг бөгөөд хоногт 1 ахлагчийн удирдлага дор “Галуут-61, 62, 63” дугаар харуулын цэгт 12 харуулын цагдаа 24 цагаар, “Галуут-64, 65” дугаар харуулын цэгт 8 харуулын цагдаа 24 цагаар харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэдэг байна.

Олон нийтийн аюулгүй байдлын хангах хэсгийн хамгаалалтад байгаа объектууд хооронд 1-13 км-ын зайтай, хамгаалж байгаа объект нэг бүрийн онцлогоос шалтгаалж байрлал нь дүүргийн төвөөс 1 км - 14 км, төв болон зүүн бүсийг холбосон автомашины зангилаа замаас 200 м - 1500 м, орон сууцны хорооллоос 100 м зайтай байрлах ба зарим объектоос 20 м - 25 метр орчим зайнд дүүргийн “Ахмадын амралт”, 500 м -3000 метрийн зайнд дүүргийн болон Төв аймгийн Мөнгөнморьт, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумдын 10-50 орчим айл өрхүүдийн 50-200 иргэд тэдний 3000-4000 орчим толгой мал жилийн дөрвөн улиралд нутаглаж, мал нь улсын онц чухал объектын хамгаалалтын инженерийн торон саадыг таслан хариулгагүй бэлчээрлэж, өвлийн улиралд Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймаг руу зорчих иргэдийн автомашинууд харуулын цэгээс 2 км орчим зайтай газраар Хэрлэн голыг мөсөөр гарч нааш цааш зорчдог, хамгаалалтын бүсээс 20 м - 100 метрийн зайнд Хэрлэн голын хөвөөгөөр иргэд загасчлах, зугаалах, аялах, барилгын материалын хайрга бэлтгэх зэрэг байнгын хөдөлгөөн ажиллагаатай төдийгүй 18 км - 47 км-т ШШГЕГ-ын харьяа хорих 417, 427 дугаар ангиуд байрладаг зэрэг нь хамгаалж буй объектуудад янз бүрийн байдлаар халдлагын шинжтэй үйлдэл гарч болзошгүй, харуулын цагдаагаас өндөр сонор сэрэмжтэй үүрэг гүйцэтгэх шаардлагатай байна.

**Улсын онц чухал объектод** 2013-2016 онд шалган нэвтрүүлэх журмын дагуу байнгын нэвтрэх үнэмлэхээр 10503, түр нэвтрэх үнэмлэхээр 3300 хүн, тээврийн хэрэгсэл 5590, бараа материал 344 зохих зөвшөөрлийн дагуу шалган нэвтрүүлж, хамгаалалтын объектын орчинд илэрсэн 1370, гүний 1, 2, 6, 7 дугаар худаг руу нэвтэрсэн 1940, “Галуут-64” харуулын хамгаалалтын объектоос 10160 удаагийн рейссээр 6210129 тн усыг дүүргийн усан сангууд руу зөөвөрлөсөн хөдөлгөөн ажиллагаанд тус тус бүртгэл хяналт тавьж ажиллажээ.

Дээрх хугацаанд хамгаалалтын объектуудад зориулалтын бус газраар нэвтэрсэн 4, объектод архидан согтуурсан 3, харуулын цагдаагийн тавьсан шаардлага эсэргүүцсэн 4, тогтоосон дэглэм журам зөрчсөн 9 зөрчлийг илрүүлэн, 5 хүнд 85.000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авахуулан, зөрчил гаргасан 13 хүнийг албан байгууллагад нь мэдэгдэж, 3 хүнийг түр саатуулах байранд хүргүүлж шийдвэрлэсэн байна.

Дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн хэв журам хамгаалах цагдаагийн эргүүлд 19.00-01.00 цагт хэлтсийн нийтийн хэв журам хамгаалах тасгийн алба хаагчидтай хамтран давхардсан тоогоор тус хэсгийн 988 харуулын цагдаа эргүүл шалгалтанд 8325 цаг ажиллаж, зөрчил үйлдсэн 35 хүнд 120.000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авч, 914 хүнийг түр саатуулах байранд, 150 хүнийг ар гэрт нь хүргэн, 4766 аж ахуйн нэгж, албан байгууллагын энгийн харуул манааны үүрэг гүйцэтгэлтийг шалгаж ажилласан байна.

Засгийн газрын 34, 90, 100 дугаар тогтоол, Цагдаагийн байгууллагын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулийг үндэслэн 2013-2015 онуудад “Багануур-Ус” ОНӨААТҮГ-ын захиргаатай байгуулсан гэрээний дагуу тус байгууллагын төсөвт 30.9 сая төгрөгний хамгаалалтын зардлыг тусгуулан, зарцуулалтад хяналт тавьж ажилласан.

#### **Тулгамдаж буй асуудал:**

1. Хамгаалж байгаа объект нэг бүрийн онцлогоос шалтгаалж хамгаалалтын бүсээс 20 м - 1500 метрийн зайд орон сууцны хороолол, төв болон зүүн аймгуудыг холбосон төв зам, дүүргийн болон Төв аймгийн Мөнгөнморьт, Баяндэлгэр, Хэнтий аймгийн Цэнхэрмандал зэрэг сумын мал бүхий иргэд нутагладаг төдийгүй зарим объектоос 100 метрээс 47 км зайд Хятад-Монголын хамтарсан төмөр, мод боловсруулах үйлдвэр, ШШГЕГ-ын харьяа хорих анги зэрэг олон арван албан байгууллага аж ахуйн нэгжүүд байрладаг, хамгаалалтад хоногт 1 ээлжийн зохицуулагч, 5-6 харуулын цагдаа харуулын 5 цэгт 24, 8:16 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа /шөнийн цагт хосолсон манаагаар үүрэг гүйцэтгэх стандарттай/, харуулын цэгүүд хоорондоо 2 км - 9 км-ын зайд байрладаг, хүн хүч, холбоожуулалт хангалтгүй зэрэг нь харуулын цагдаа гэмт халдлагад өртөж болзошгүй байна.

2. Харуулчдын үүрэг гүйцэтгэж байгаа харуулын цэгийн байрууд нь 2009 онд хуучин ДЦШ-с баталсан CS11-0129:2010 байгууллагын стандартын дагуу баригдсан гэх боловч, ганц дан модон шалан дээр шилэн хөвөн, элслэг хавтан тавьж хулдаасалсан, өрөөний халаалтанд хүчин чадал муутай гар хийцийн усан халаагуур ашигладаг нь хүйтний улиралд (зарим өвөл шөнө-55 хэм хүртэл хүйтэрдэг) үүрэг гүйцэтгэхэд хүндрэлтэй, харуулын цэгүүдийн цахилгааны монтаж чанарын шаардлага хангахгүй байна.

3. Харуулын цэгийн байруудын тохижилт хангалтгүй, хамгаалуулагч байгууллага гэрээнд тусгасан эд зүйлээр хангахдаа чанарын шаардлага хангахуйц эд материалаар бус, байгууллагаас актлагдсан хуучин ширээ сандал болон бусад зүйлээр хангасан нь алба хаагчдын өдөр дутмын үүрэг гүйцэтгэлд сөрөгөөр нөлөөлж болзошгүй байна. Тухайлбал: Харуулын цэгүүдэд байгаа сандал, ширээ бүгд эвдэрч хэмхэрсэн, салж унахад бэлэн байна.

4. Улсын онц чухал объектуудын шалган нэвтрүүлэх ажиллагаа хэвийн явуулахад шийдвэрлэвэл зохих асуудал байна. Тухайлбал, “Галуут-62, 65” дугаар харуулын цэгүүдэд нэвтэрч буй тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийх зориулалтын тавцан, тольдуур байхгүй байна.

5. Улсын онц чухал объектын харуулын 5 цэгт суурин 3, гар станц 3 ашиглагдаж байгаа боловч ашиглалтын хугацаа дуусч шаардлага хангахгүй болсон, хамгаалалтад байгаа гүний худаг, усан сангууд дохиололгүй, “Галуут-61, 62” дугаар харуулын цэгийн объектыг цагдаагийн хэлтсийн жижүүрээс шууд хянах зориулалттай хяналтын теле-камер бүрэн ажиллахгүй, байнга доголдож байна.

6. **“Хэрлэн” станцын хамгаалалтын I, II бүсийн хамгаалалтын** инженерийн торон саад чанарын шаардлага хангахгүй, торон саадны модон шонгууд нь илжирч муудсан /1980-д оны үед хуучин ЗХУ-н мэргэжилтнүүдийн барьсан/ объектуудын 20 гэрэлтүүлэг байнгын цахилгааны гэмтэл эвдрэлтэй, объектуудыг шөнийн цагт хангалттай гэрэлтүүлдэггүй зэрэг асуудлууд байна.



#### 4.6. ЖИЖИГ ХОТУУДЫН ХӨГЖИЛ: АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АСУУДАЛ

Хотын захын дүүрэг болон алслагдмал газар орших хотын статустай нэгжийн тухайд аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх стратеги өөрийн гэсэн онцлогтой байдаг. Аливаа орон нутагт хамаарах газарт аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шууд ямар нэг судалгаанд үндэслэсэн баримжаа, чиглэлгүйгээр явуулах боломжгүй бөгөөд юуны түрүүнд бодлого боловсруулах хэрэгтэй. Үүнд:

- Танай аймаг, дүүрэгт ямар асуудлыг нэн тэргүүнд болон цаашид шийдвэрлэх шаардлагатай байна вэ?
- Нутаг дэвсгэрийн хэмжээнд аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэж байгаа ажиллагааны гол зорилго нь юу байх вэ? гэсэн хоёр асуултанд хариу авсан байна.

Энэ нь заавал бусад аймаг, дүүрэгтэй ижил байх албагүй бөгөөд гэмт хэрэг, зөрчил нь нутаг дэвсгэр, хүн ам, нийгэм соёлын онцлогоос шалтгаалаад өөр өөр байдаг онцлогийг бүрэн анхаарвал зохино. Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулахдаа тухайн аймаг, дүүрэгт байгаа бүхий л төлөөлүүдийг оролцуулан боловсруулбал үр дүнтэй. Үүнд:

Асуудлыг тодорхойлох: Үүнд танай аймаг, дүүргийн хэмжээнд гарч байгаа гэмт хэрэг, зөрчил юунаас үүдэн гарч байгаа болон үүнд нөлөөлж байгаа хамгийн гол хэд хэдэн хүчин зүйл, шалтгааныг гаргаж ирнэ. Ингэснээр асуудал тодорхойлогдоно.

Жишээлбэл: энэ онд танай аймгийн /дүүрэг/ хэмжээнд зам тээврийн гэмт хэрэг, осол аваар өсөх хандлагатай байгаа ба энэ танайд хамаарах цагдаагийн байгууллагаас ирүүлсэн танилцуулга мэдээлэл байж гэж бодъё. Үүний гол шалтгаан нь замын ачаалал, жолооч нарын буруутай үйл ажиллагаа, замын арчлалт стандарт бусаас байлаа гэсэн олон дүгнэлтээс асуудлыг тодорхойлох хэрэгтэй. Бидний шийдвэрлэх ёстой асуудал бол нэн тэргүүнд замын ачаалал, замын арчлалт стандарт бус байгаа нь илэрхий тохиолдолд жолооч болон явган зорчигдод чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх нь үр дүн багатай, хөрөнгө мөнгийг ашиггүй зүйлд зарцуулах болно.

Харин үүний оронд орон нутагт байгаа замын газар, мэргэжилтэнтэй холбогдон тухайн замыг барьсан байгууллагатай хамтран арчлах, тэднээс тодорхой хөрөнгө гаргуулан шийдвэрлэх арга замыг боловсруулах боломжтой эсэх, замын ачааллыг багасгах талаар өөр ямар арга зам бий эсэхийг тодорхойлох нь хамгийн оновчтой хувилбар байж болох юм.

Шийдвэрлэх асуудлыг гаргаж ирэх: Асуудлыг тодорхойлон гаргаж ирсэний дараа аймаг дүүргийн иргэдийн хурал тэр дундаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нь шийдвэрлэх асуудлыг хамгийн хэрэгцээтэйгээс нь хэрэгцээ багатай хүртэл нь жагсаан гарган хэлэлцэж болно. Энэ нь цаг хугацаа алдахгүй байх, үндсэн асуудалд хүч, нөөцийг чиглүүлээд хожим нь ашиг тустай.

Жишээлбэл аймагт гарч байгаа хулгайлах гэмт хэргийн гол шалтгаан нь ажигүйдэл байж болно. Гэхдээ энэ нь нийтлэг нөхцөл учраас бид хэт ерөнхий зүйлтэй тэмцэх хэрэгтэйг харуулж байна. Харин үүний оронд ажилгүй байгаа ямар насны ямар онцлогтой хүмүүсээс гэмт хэрэг үйлдэж байгааг харгалзан үзэж болно.

Тухайлбал танай дүүрэгт дээр дурдсан тохиолдолд хулгайлах гэмт хэрэгт хүүхэд оролцож байгаа эсвэл 18-с дээш 25 хүртэлх насны залуучууд энэ хэргийг хамгийн ихээр үйлдэж байвал бид энэ хэсэгт анхаарлаа хандуулна гэсэн үг. Үүнд нутаг дэвсгэрт түр оршин сууж байгаа оюутан сурагчид, хүн амын шилжилт хөдөлгөөн хэрхэн нөлөөж байгааг харгалзан үзэх хэрэгтэй.

Үйл ажиллагааны хүрээг гаргах: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд тухайн жилд ямар байгуулага ямар үүрэгтэй оролцохыг тодорхойлох нь энэ шатны гол зорилт юм. Шийдвэрлэх асуудлыг зөвлөл гаргаж ирсэний дараагаар бид ямар, ямар үүрэгтэй оролцож, ямар ажил хийвэл энэ гэмт хэрэг зөрчлийг бууруулах вэ? гэдэг хувилбаруудыг тус бүрд нь гаргаж болно.

Жишээ: Аймаг дүүргийн хэмжээнд тухайн жилд хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа хэрэгт анхаарал хандуулж байна хэмээн төсөөлье. Тэгвэл эхлээд цагдаагийн байгууллага хохирогч хүүхдэд яаж анхаарал хандуулах, нуугдмал байгаа гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрүүдийг таслан зогсоохын тулд төрийн бус байгууллагуудын дэмжлэг тусалцааг хэрхэн авах вэ?

Хамгаалах байранд яаж байлгах цаашид хүүхдийг ахин хүчирхийлэлд өртүүлэхгүйн тулд нийгмийн халамж үйлчилгээний төв хэрхэн оролцох талаар тусгаж, хүүхдийг хориглох ажлын байрыг багасгах чиглэлээр хөдөлмөрийн мэргэжлийн хяналт яаж оролцон ажиллах талаар чиглэл тус бүрд хийх ажлын талаарх төсөөлөл, бичиглэлийг хэлж болно.

Аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь: Дан ганц төрийн байгууллага тэр дундаа тусгай чиг үүрэг бүхий байгууллагын хүлээсэн хийх ажил биш бөгөөд тухайн нутаг дэвсгэрт амьдарч байгаа бүхий л субъект, хуулийн этгээд, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтран хийх олон талт үйл ажиллагаа гэдгийг ойлговол зохино.

## БҮЛЭГ 5. САНАЛ АСУУЛГААР АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

### 5.1. ДҮҮРГИЙН ОРШИН СУУГЧДААС САНАЛ АСУУЛГЫН АРГААР АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Иргэдийн аюулгүй байдлыг хангах, аюулгүй, тайван амьдрах орчин бүрдсэн эсэх, цагдаад итгэх олон нийтийн хандлагыг хэмжих хэд хэдэн онолын үзэл баримтлал хөгжиж ирсэний хамгийн түгээмэл нь инструментал, эспрессив онолууд юм.

Инструментал онол нь иргэдийн аюулгүй тайван амьдрах орчин нөхцөлийг цагдаад бүртгэгдсэн гэмт хэрэг, түүний өсөлт, бууралт, иргэдийн гэмт хэрэгт хохирох явдал, гэмт хэргээс айх түгшүүр зэргээр хэмжигдэнэ гэж үздэг.

Эспрессив онол нь иргэдийн аюулгүй байдлыг гэмт хэрэг, гэмт хэрэгт хохирох явдал, халдлагад өртөж болзошгүй гэсэн айдсын мэдрэмжээр хэмжих нь учир дутагдалтай гэж үзээд иргэдийн аюулгүй байдлыг орчны нөхцөл, оршин суугчдын хоорондын харилцааны нягтаршил, цагдаад итгэх олон нийтийн хандлага зэрэг өргөн хүрээнийн ойлголтуудаар тодорхойлдог.

Бид судалгааны ажлын хүрээнд Багануур дүүргийн оршин суугчдын аюулгүй байдлын түвшинг тодорхойлох төсөөллийн судалгааг 2016 оны 7 дугаар сард 14 хоногийн хугацаанд санал асуулгын явуулж дүгнэлт хийсэн.

#### Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн шинж

Судалгаанд Багануур дүүрэгт сүүлийн 1 жилийн хугацаанд оршин суусан 158 хүнийг санамсаргүй түүврийн аргаар сонгон оролцуулсан бөгөөд оролцогчдын 43.6 хувь нь эрэгтэй, 57.3 хувь нь эмэгтэй оршин суугч, 22 буюу 14.7 хувь нь 14-18, 46 буюу 30.6 хувь нь 19-30, 38 буюу 25.3 хувь нь 31-40, 24 буюу 16 хувь нь 41-50, 20 буюу 13.3 хувь нь 51-с дээш насны иргэд оролцсон байна. Судалгаанд оролцогчдын 2 буюу 3 хувь нь бага, 10 буюу 6.3 хувь нь бүрэн бус, 41 буюу 25.5 хувь нь бүрэн дунд, 7 буюу 4.4 хувь нь коллеж, 84 буюу 53.2 хувь нь дээд боловсролтой байсан бол 56 буюу 35.4 хувь нь гэрэлсэн, 96 буюу 60.8 хувь нь ганц бие, 3 буюу 1.9 хувь нь гэрэлсэн боловч ганцаараа амьдардаг оршин суугчид байна.

#### 5.1.1. Гэмт хэргийн нөхцөл байдлын талаар иргэдийн төсөөллийн судалгааны дүн

Тухайн нутаг дэвсгэр дэх гэмт хэргийн түвшинг цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн албан ёсны статистикийн мэдээллээр тодорхойлдог бол түүний бодит эсэхийг гэмт хэргийн талаарх иргэдийн төсөөллийн судалгаагаар шалгадаг. Энэ зорилгоор судалгаанд оролцогчдоос ирэх жил гэмт хэргийн чиг хандлагыг өнгөрсөн жилийнхтэй харьцуулвал хэрхэн төсөөлж байна бэ? гэсэн асуултыг нутаг дэвсгэрийн ялгаатай 3 түвшинд асууж, үр дүнг “хүснэгт 9”-т харуулсан болно. Судалгаанд оролцогчдын 21 хувь нь улсын хэмжээнд, 34 хувь нь Багануур дүүргийн хэмжээнд, 38 хувь нь оршин сууж буй нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэрэг буурна гэж тус тус үзжээ. Харин оролцогчдын 48 орчим хувь нь гэмт хэргийн чиг хандлага дунд зэрэг буурна гэж 3 түвшинд хариулсан нийтлэг шинжтэй байв.

(Хүснэгт 9.)

Гэмт хэргийн чиг хандлагыг өнгөрсөн жилийнхтэй харьцуулвал хэрхэн төсөөлж байна бэ?					
	Их буурна	Буурна	Дунд зэрэг	Өснө	Их өснө
Улсын хэмжээнд гэмт хэргийн түвшин	3 (1.9%)	34 (21.5%)	73 (46.2%)	39 (24.7%)	6(3.8%)
Багануур дүүргийн хэмжээнд гэмт хэргийн	6 (3.8%)	54	80	15 (9.5%)	1(0,6%)



түвшин		(34.2%)	(50.6%)		
Таны оршин сууж буй нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэргийн түвшин	9 (5.6%)	61(34%)	76 (48,6%)	11 (6.9%)	1 (0,6%)
<b>Дундаж</b>	<b>6 (3.7%)</b>	<b>49 (31.4%)</b>	<b>76 (48.3%)</b>	<b>39 (24.6%)</b>	<b>3 (1.7%)</b>

Дээрх судалгааны дүнгээс үзвэл Багануур дүүрэгт оршин суугчдын 80-с илүү хувь нь гэмт хэргийн чиг хандлагыг буурна гэж үзсэн байна. Энэ нь иргэдийн аюулгүй байдлын мэдрэмжийн төсөөлөлтэй шууд холбоотой тул Багануур дүүрэг дэх гэмт хэргийн нөхцөл байдлыг тодорхойлох үзүүлэлт юм. Түүнчлэн иргэдийн аюулгүй тайван байдлыг тодорхойлох нэг хэмжүүр нь иргэд гудамж тайлбай, олон нийтийн газарт болон гэртээ байх үедээ гэмт хэрэг халдлагад өртөж магадгүй гэж айх явдлаар илэрхийлэгддэг. Хүснэгт

Та доор дурдсан нөхцөлүүдэд айдсыг хэр зэрэг мэдэрдэг вэ ?					
	Огт айдасгүй	Айдасгүй	Дунд зэрэг	Айдастай	Айдас ихтэй
Оройн цагаар гэртээ ганцаараа байх үедээ	36 22.8	62 39.2	38 24.1	16 10.1	5 3.2
Оршин суудаг нутаг дэвсгэрийнхээ гудамжаар шөнийн цагаар ганцаараа явах үед	10 6.3	34 21.5	51 32.3	48 30.4	13 8.2

10-т үзүүлснээр иргэдийн 39

% нь “Оройн цагаад гэртээ ганцаараа байх үедээ”, 70 орчим хувь нь “Оршин суудаг нутаг дэвсгэрийнхээ гудамжаар шөнийн цагаар ганцаараа алхах үед” гэмт хэрэг халдлагад өртөж болзошгүй гэж айдаг гэж хариулсан байна.

(Хүснэгт 10.)

Дээрх судалгаанаас үзвэл Багануур дүүргийн хэмжээнд гудамж тайлбай, олон нийтийн газарт иргэдийн аюулгүй байдлыг хангах ажил төдийлөн сайн биш, иргэд түгшүүртэй амьдарч байгааг харуулж байна.

### 5.1.2. Иргэдийн гэмт хэрэгт хохирох явдлын судалгааны дүн

Иргэдийн гэмт хэрэгт хохирох явдлын түвшинг гэмт хэрэгт “шууд болон шууд бусаар” хохирсон байдлаар тодорхойлдог. Тиймээс бид судалгааны ажилдаа гэмт хэрэгт шууд болон шууд бусаар хохирох явдлыг нээн илрүүлэхэд чиглэгдсэн дараах асуултуудыг оролцогчдоос асууж дүн дүгнэлт хийсэн болно.

Гэмт хэрэгт шууд хохирох явдлын түвшинг тодорхойлох зорилгоор судалгаанд оролцогчдоос “Та өнгөрсөн жилийн хугацаанд ямар нэгэн байдлаар гэмт хэрэгт хохирч байсан уу? (хохирлын хэмжээ харгалзахгүй)” гэсэн асуултыг 9 төрлийн гэмт хэргийн нөхцөл дээр тавьж дүнг “хүснэгт 11”-т эрэмблэн үзүүлэв. Судалгаанд оролцогчдын 63 буюу 39,8 хувь нь ямар нэгэн байдлаар эд хөрөнгөө хулгайд алдаж байсан гэж үзсэн бол бусдаар доромжлуулж, гүтгүүлж байсан гэж 32 буюу 20,2 хариулсан байна. “Харин авлигын улмаас таны эрх ашиг сонирхол хөндөгдөж байсан эсэх” асуултанд нийт оролцогчдын 29 буюу 18,3 хувь нь тийм гэж хариулсан байна.

(Хүснэгт 11.)

“Та өнгөрсөн жилийн хугацаанд ямар нэгэн байдлаар гэмт хэрэгт хохирч байсан уу?”	Тийм	Мэдэхгүй эсвэл үгүй
--	------	---------------------

Бие махбодын хувьд хохирсон	27 (17%)	131 (83%)
Эд хөрөнгөө хулгайд алдаж байсан	63 (39.8%)	95 (61.2%)
Эд хөрөнгөө бусдад дээрмэдүүлж байсан	2 (1.2%)	156 (98.2%)
Эд хөрөнгөө бусдад залилан мэхэлүүлж байсан	19 (12.2%)	139 (89.7%)
Зам тээврийн осолд өртөж байсан	2 (1.2%)	156 (98.2%)
Хэн нэгэн этгээд таныг доромжлож, гүтгэж байсан эсэх	32 (20.2%)	126 (79.8%)
Хэн нэгэн этгээдэд хүчиндүүлж байсан эсэх	0 (0%)	158 (100%)
Хэн нэгэн этгээд таны эд хөрөнгийг эвдэж байсан эсэх	21 (13.2%)	137 (86.8%)
Авлигын улмаас таны эрх ашиг сонирхол хөндөгдөж байсан эсэх	29 (18.3%)	129 (81.7%)

Иргэд бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт хамгийн их хохирч байгаа бол авилгалын улмаас иргэдийн эрх ашиг сонирхол хөндөгдөж байгаа талаар дурдсан байгааг анхаарах шаардлагатай гэж дүгнэж байна. Гэмт хэрэгт шууд бусаар хохирох явдлын түвшинг тодорхойлох зорилгоор оролцогчдод “Өнгөрсөн жилийн хугацаанд таны гэр бүлийн гишүүд, төрөл садан, эсвэл сайн танил хүмүүсийн тань хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан уу?” гэсэн асуултыг хоёр төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал дээр тавьж үр дүнг “хүснэгт 12”-т үзүүлсэн болно. Судалгаанд оролцогчдын ойр дотны хүмүүсээс 51 буюу 32.3 хувь нь “Эд хөрөнгийн хувьд хохирсон” гэж хариулсан бол бие махбодын хувьд ямар нэгэн байдлаар хохирч байсан гэж 29 буюу 18,4 хувь нь тус тус хариулсан байна.

(Хүснэгт 12.)

Өнгөрсөн жилийн хугацаанд таны гэр бүлийн гишүүд, төрөл садан, эсвэл сайн танил хүмүүсийн тань хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан уу?		
	Тийм	Мэдэхгүй эсвэл үгүй
Бие махбодын хувьд хохирсон	29 (18.4%)	127 (80.4%)
Эд хөрөнгийн хувьд хохирсон	51 (32.3%)	103 (65.2%)
<b>Дундаж</b>	<b>40 (25.3%)</b>	<b>115 (72.8%)</b>

“Хэрэв та болон таны гэр бүлийн гишүүд гэмт хэрэгт ямар нэгэн байдлаар хохирч байсан тохиолдол байгаа бол цагдаагийн байгууллагад мэдэгдэж байсан уу?” гэсэн асуултанд гэмт хэрэгт өртөж байсан гэж хариулсан иргэдийн 86 хувь нь тийм гэж хариулжээ. Хэрэв цагдаад мэдээгүй бол яагаад гэсэн асуултанд “Жижиг гэмт хэрэг байсан тул цагдаад мэдэгдэх шаардлаггүй гэж үзсэн”, “Цагдаагийн байгууллаг гар утас алдсан, доромжлогдсон, эд хөрөнгө эвдсэн зэрэг хохирлын хэмжээ багатай хэрэг дээр анхаарал хандуулдаггүй”, “цагдаад мэдэгдэх ёстой гэж ойлгоогүй” гэж тус тус хариулсан байна. Эндээс үзэхэд Багануур дүүргийн иргэд цагдаагийн байгууллагадаа төдийлөн итгэдэггүй, цагдаагийн байгууллагад хүнд суртал ямар нэгэн хэмжээгээр байгааг илэрхийлж байгаа, нөгөө талаар иргэдийн эрх зүйн болон эрх ашгаа хамгаалах талаарх мэдлэг сул байгааг харуулж байна

### 5.1.3. Иргэд цагдаад итгэх хандлагын судалгааны дүн

Гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах нь цагдаагийн байгууллагын үндсэн үүрэг бөгөөд иргэдийн цагдаад итгэх хандлага, сэтгэл ханамжийг тодорхойлох хэмжүүр нь цагдаагийн байгууллага хуулиар хүүлсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаагаар тодорхойлогддог. Өөрөөр хэлбэл цагдаагийн байгууллага гэмт хэргийг бүрэн хяналтандаа байлгаж гэмт хэргийн гарлтыг бууруулж чадвал иргэдийн аюулгүй байдал хангагддаг.

Иргэдийн аюулгүй байдал хангагдаж, гэмт хэрэгт хохирох явдлын түвшин буурсан тохиолдолд иргэдийн цагдаад итгэх хандлага өсдөг байна. Багануур дүүрэг дэх цагдаагийн байгууллагын талаар оршин суугчдын үзэл бодлыг тодорхойлох зорилгоор явуулсан судалгааны үр дүнг “хүснэгт 13”-т харуулав. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цагдаа зохион байгуулах чадвартай гэж би итгэдэг” гэсэн асуултанд нийт оролцогчдын 59 буюу 37.7 хувь нь “Нийлнэ”, “Бүрэн нийлнэ” гэсэн хариултыг сонгосон бол “Гэмт хэргийг хянах ажиллагааг цагдаа оновчтой хэрэгжүүлдэг” гэсэн асуултанд хамгийн цөөн оролцогч “Нийлнэ”, “Бүрэн нийлнэ” гэж хариулжээ.

(Хүснэгт.13)

Дараах асуултууд нь орон нутгийн цагдаагийн байгууллагын талаарх таны үзэл бодлыг илэрхийлнэ

	Огт нийлэхгүй	Нийлэхгүй	Дунд зэрэг	Нийлнэ	Бүрэн нийлнэ
Цагдаа нар хариуцсан нутаг дэвсгэртээ эргүүлийн үйл ажиллагааг маш сайн гүйцэтгэдэг	12 (7.6%)	35 (22.2%)	67 (42.4%)	31 (19.6%)	13 (8.2%)
Цагдаагийн алба хаагч иргэдээс хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хурдан бөгөөд хуулийн дагуу шийдвэрлэдэг	15 (9.2%)	31 (19.6%)	73 (46.2%)	30 (19%)	7 (4.4%)
Иргэд гэмт хэрэг үйлдэгдсэн талаар мэдээлсэн тохиолдолд, цагдаа гэмт хэрэг үйлдсэн этгээдийг заавал олж баривчилдаг	13 (8.2%)	32 (20.3%)	75 (47.5%)	31 (19.6%)	6 (3.8%)
Гэмт хэргийг хянах ажиллагааг цагдаа оновчтой хэрэгжүүлдэг	7 (4.4%)	29 (18.4%)	81 (51.3%)	27 (17.1%)	9 (5.7%)
Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах мэргэжлийн ур чадвар болон тусгай мэдлэгтэй	7 (4.4%)	28 (17.4%)	72 (45.6%)	36 (22.8%)	14 (8.9%)
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цагдаа зохион байгуулах чадвартай гэж би итгэдэг	11 (7%)	19 (12%)	68 (43%)	41 (25.9%)	18 (11.4%)
Манай гэр бүлийн аюулгүй байдлыг цагдаа хангаж чадна	15 (9.5%)	29	65	33	14(

гэдэгт итгэдэг		(18.4%)	(41.1%)	(20.9%)	8.9%
<b>Дундаж</b>	<b>11.4 (7.2%)</b>	<b>29 (18.3%)</b>	<b>71.5 (45.2%)</b>	<b>32.3 (20.4%)</b>	<b>11.5 (7.2%)</b>

Нийт судалгаанд оролцогчдын хариулт өгсөн байдлыг дундажаар орон нутгийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамжийн байдалд тулгуурлан үнэлгээ өгвөл 7.2 хувь нь огт сэтгэл ханамжгүй, 18.3 хувь сэтгэл ханамжгүй, 45.2 хувь нь сэтгэл ханамж дунд зэрэг, 20.44 хувь сэтгэл ханамжтай, 7.2 хувь сэтгэл ханамж өндөр гэж хариулжээ.

Нийт оролцогчдын 25.5 хувь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлсэн бол оролцогчдын **74.5 хувь нь** ямар нэгэн хэлбэрээр итгэдэг гэж илэрхийлж байгаа нь дэлхийн болон Монгол Улсын дунджаас дээгүүр үзүүлэлт юм. АНУ- Мичиганы Их сургуулийн профессор Сяо 2012 онд цагдаад итгэх хандлагын судлагааг ардчилал хөгжсөн 50 улсын хүрээнд явуулсан бөгөөд судлааны үр дүн нь дэлхийн улсуудын цагдаад итгэх хандлага дунджаар 58 хувьтай байна гэж дүгнэсэн. Харин доктор, Б.Энхболд 2015 онд Монголчуудын цагдаад итгэх хандлагын судалгааг 1000 иргэдийн дунд явуулсан бөгөөд судалгааны үр дүн нь Монголчуудын цагдаад итгэх хандлага дунджаар 53 хувьтай байна гэж дүгнэгджээ.

Иргэдийн аюулгүй байдлыг хангах, цагдаад итгэх олон нийтийн хандлагыг тодорхойлоход орон нутгийн нөхцөл байдал, иргэд хоорондын харилцааны нягтаршил онцлох үүрэг гүйцэтгэдэг. Иргэдийн аюулгүй байдлыг хангах талаарх Экспрессив онолын агуулга нь орон нутгийн нөхцөл байдал, иргэд хоорондын харилцааны түвшин нь гэмт хэргийн гаралт, иргэдийн гэмт хэрэгт хохирох явдлын түвшингээс ихээхэн шалтгаалдаг гэж үздэг. Энэ нь цагдаад итгэх олон нийтийн хандлагад эерэг болон өсөр нөлөө үзүүлдэг. “Хүснэгт 14”-т орон нутгийн нөхцөл байдлын талаар иргэдийн санал бодолыг харуулсан болно.

(Хүснэгт 14.)

Дараах асуултууд нь таны оршин сууж буй нутаг дэвсгэрийн нөхцөл байдлын талаарх зарим мэдээллийг багтаасан болно. Та хамгийн оновчтой гэж үзэж байгаа нэг хариултыг дугуйлах замаар асуулт тус бүрт хариулна уу?

	Огт нийлэхгүй	Нийлэхгүй	Дунд зэрэг	Нийлнэ	Бүрэн нийлнэ
Миний оршин сууж буй нутаг дэвсгэр орчны бохирдол, хог хаягдал ихтэй	37 (23.4%)	75.(47.5%)	24 (15.2%)	13 (8.2%)	9 (5.7%)
Харанхуй, гэрэлтүүлэг муутай, ганцаараа явахад айдас төрөхүйц газар олон байдаг	13 (8.2%)	33 (20.9%)	54 (34.2%)	36 (22.8%)	22 (13.9%)
Эзэнгүй, хоосон байшин, хүн оргонох боломжтой хаягдал машин, граж гэх мэт зүйлс байдаг	9 (5.7%)	31 (19.6%)	53 (33.5%)	25 (15.8%)	38 (24.1%)
Хууль, журам зөрчдөг хүн олон байдаг. (Тухайлбал, замын хөдөлгөөний дүрэм зөрчих, хориглосон газар авто машинаа байрлуулах, бие засах гэх мэт)	10 (6.3%)	12 (7.6%)	41 (25.9%)	51 (32.3%)	44 (27.8%)

Би гэмт хэрэг үйлддэг, зөрчил гаргадаг тэнэмэл хүүхдүүдийн бүлэг, бөөгнөрлийг байнга хардаг	61 (38.6%)	53 (33.5%)	19 (12%)	16 (10.1%)	9 (5.7%)
Би хэрэлдэж эсвэл зодолж байгаа хүмүүсийг байнга хардаг	12 (7.6%)	49 (31%)	61 (38.6%)	23 (14.6%)	12 (7.6%)

Судалгааны дүнгээс харахад судалгаанд оролцогчид “Миний оршин сууж буй нутаг дэвсгэр орчны бохирдол, хог хаягдал ихтэй”, “Би гэмт хэрэг үйлддэг, зөрчил гаргадаг тэнэмэл хүүхдүүдийн бүлэг, бөөгнөрлийг байнга хардаг” гэсэн асуултуудад 70-с дээш хувь нь “санал нийлэхгүй” гэж хариулсан нь дүүргийн хэмжээнд орчны бохирдол, хараа хяалтгүй хүмүүс бараг байхгүй, тулгамдсан асуудал биш гэдгийг харуулж байна. Харин “Эзэнгүй, хоосон байшин, хүн оргонох боломжтой хаягдал машин, граж гэх мэт зүйлс байдаг”, “Хууль, журам зөрчдөг хүн олон байдаг (Тухайлбал, замын хөдөлгөөний дүрэм зөрчих, хориглосон газар авто машинаа байрлуулах, бие засах гэх мэт) зэрэг асуултуудад судалгаанд оролцогчдын 60-с дээш хувь нь санал нийлнэ гэж хариулжээ.

Энэ нь тус дүүрэгт нийгмийн хэв журам зөрчих явдал түгээмэл байгааг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд иргэдийн аюулгүй байдал төдийлөн хангагдаагүй байгааг харуулж байна. Түүнчлэн 1990-д оноос өмнө тус дүүргийн нутаг дэвсгэрт ОХУ-н цэргийн анги, байгууллагууд байрлаж байсан хуучны нурж, эвдэгдсэн барилга байшин цөөнгүй байдаг нь иргэдийн сэтгэл зүйд тааламжгүй мэдрэмж төрүүлдэг байна.

Олон нийт, хөршийн харилцаа нягтарших, нийгмийн тулгамдсан асуудлыг хамтаараа шийдвэрлэх хандлага иргэдэд төлөвших нь гэмт хэрэг, зөрчлийг хяналтандаа авах, улмаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжтой бүрддэг. “Хүснэгт 15”-т тус дүүргийн иргэд хоорондын харилцааны түвшинг илрэхийлэх үзүүлэлтүүдийн үр дүнг харуулсан байна.

(Хүснэгт 15.)

	Огт нийлэхгүй	Нийлэхгүй	Дунд зэрэг	Нийлнэ	Бүрэн нийлнэ
Манай хөрш оршин суугчид бие биенээ сайн мэддэг	15 (9.5%)	30 (19%)	71 (44.9%)	34 (21.5%)	8 (5.1%)
Манай хөрш оршин суугчид олон нийтийн асуудлын талаар ярилцдаг	27 (17.1%)	49 (31%)	52 (32.9%)	23 (14.6%)	4 (2.5%)
Манай хөрш оршин суугчид хүнд хэцүү үед бие биедээ тусалдаг	30 (19%)	46 (29.1%)	59 (37.3%)	18 (11.4%)	3 (1.9%)
Манай хөрш оршин суугчид олон нийтийн арга хэмжээ болон цуглаанд оролцдог	17 (10.8%)	62 (39.2%)	49 (31%)	23 (14.6%)	5 (3.2%)
Манай хөрш оршин суугчид гэмт халдлагад өртөж буй хүүхдэд туслахад бэлэн байдаг	18 (11.4%)	33 (20.9%)	55 (34.8%)	40 (25.3%)	9 (5.7%)
Манай хөрш оршин суугчид гэмт хэргийн талаар харсан тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдээлэл өгдөг	9 (5.7%)	28 (17.7%)	48 (30.4%)	51 (32.3%)	20 (12.7%)
Манай хөрш оршин суугчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сайн дурын эргүүлийн арга хэмжээнд оролцоход бэлэн байдаг	30 (19%)	40 (25.3%)	43 (27.2%)	34 (21.5%)	7 (4.4%)

Дундаж	18 (11.5%)	35 (22.7%)	46 (29.8%)	27 (17.6%)	4 (4.4%)
--------	------------	------------	------------	------------	----------

Судалгааны дүнгээс үзвэл “Манай хөрш оршин суугчид гэмт хэргийн талаар харсан тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдээлэл өгдөг” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 45 хувь нь “Санал нийлнэ” гэсэн хариултыг сонгосон нь хамгийн өндөр байгаа үзүүлэлт байсан бол “Манай хөрш оршин суугчид хүнд хэцүү үед бие биедээ тусалдаг” гэсэн асуултанд 13 орчим хувь нь санал нийлэхгүй гэж хариулсан нь хамгийн бага үзүүлэлт болж байна. Багануур дүүргийн иргэд хоорондын харилцааны түвшинг ерөнхийд нь авч үзвэл 50 орчим хувь нь олон нийтийн арга хэмжээнд оролцдог, хөршөө танидаг, бие биедээ туслахад бэлэн байдаг хандлага ажиглагдаж байгаа харьцангуй доогуур үзүүлэлт юм.



## 5.2. ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БОЛОН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН АЛБА ХААГЧДААС САНАЛ АСУУЛГЫН АРГААР АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Багануур дүүргийн хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судалж, урьдчилан сэргийлэх талаар санал, зөвлөмж боловсруулах зорилгоор явуулсан санал асуулгын үр дүнд хийсэн шинжилгээ.

### 5.2.1. Багануур дүүргийн Шүүхийн 28 шүүгч, шүүгчийн туслах, бусад ажилтны (тахарын ерөнхий газрын албан хаагч, эвлэрүүлэн зуучлагчийн туслах) дунд явуулсан санал асуулгын дүн


Санал асуулгад оролцогчдын ерөнхий мэдээлэл

1. Насны байдал. График 23. Насны байдал



2. Хүйс. График

102



24.



## СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮНГҮҮД

### 4. Багануур дүүрэгт ямар гэмт хэрэг, зөрчил хамгийн их үйлдэгддэг талаарх асуултанд (3 хүртэлх сонголтоор): (Хүснэгт 16.)

Эрэмбэ	Гэмт хэрэг, зөрчлийн төрөл	Дүн
1.	Танхайрах	19
2.	Хулгайлах	18
3.	Бусдын бие махбодод гэмтэл санаатайгаар учруулах	15
4.	Залилан мэхлэх	6
5.	Бусад (зам тээврийн осол зөрчил, хүчиндэх)	6
6.	Дээрэмдэх	2
7.	Хүнийг санаатай алах	1

### 5. Багануур дүүрэгт гарсан гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг юу гэж тодорхойлох талаарх асуултанд (3 хүртэлх сонголтоор): (Хүснэгт 17.)

Эрэмбэ	Шалтгаан, нөхцөл	Дүн
1.	Архидан согтуурал ихтэй	22
2.	Ядуурал, ихэнх нь амьдралын баталгаажих түвшингээс доогуур амьдралтай	16
3.	Иргэдийн тодорхой хэсэг нь тодорхой эрхэлсэн ажилгүй, тогтмол орлогогүй байдал	15
4.	Амар хялбар аргаар амьдрах хүсэл эрмэлзлэлтэй хүмүүс их байдаг	11
5.	Гудамж, талбайг камержуулалт бүрэн хийгдээгүй, хийгдсэн нь ашиглалтын шаардлага хангадаггүй	10
6.	Хөдөө, орон нутгаас шилжин ирэгсэд ихээр оршин суудаг	7
7.	Урьдчилан сэргийлэх ажилд төсөв хөрөнгө бага хуваарилж, зарцуулагддаг	4
8.	Урьдчилан сэргийлэх ажлын үр дүн хангалтгүй	4
9.	Хаягийн бүртгэлгүй хүмүүс ихээр амьдардаг буюу түр оршин суугч ихтэй	3
10.	Тус дүүрэгт амьдардаг захиргааны хяналтанд байгаа болон рецидив этгээдүүдэд тавих хяналт сул	3
11.	Гудамж, талбай гэрэлтүүлэггүй байдал	2
12.	Гэмт этгээдүүдэд оногдуулж буй ял шийтгэл сул, оновчгүй, шударга бус	1
13.	Бусад	0

### 6. Багануур дүүргийн хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад ямар арга хэмжээ зохион байгуулвал илүү үр дүнтэй талаарх асуултанд гэж үзэж байгаа талаарх асуултанд (4 хүртэлх сонголтоор): (Хүснэгт 18.)

Эрэмбэ	Арга хэмжээ	Дүн
1.	Гудамж, талбай, олон нийтийн газрыг нэгдсэн байдлаар “камержуулах”	21



2.	Архидан согтууралтай бүх нийтээр нэгдсэн бодлогоор тэмцэх, архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчилдэг цэгийн тоог багасгах, худалдаа, үйлчилгээнд тавих хяналтыг сайжруулах	19
3.	Сэрэмжлүүлэг мэдээллийг тогтмол мэдээлж байх	11
4.	Цагдаагийн байгууллагын орон тоог нэмэгдүүлэх, ялангуяа эзэнгүй байгаа нутаг дэвсгэрт цагдаагийн төлөөлөл ажиллуулах	9
5.	Хороо, нийгмийн ажилтан, хэсгийн ахлагчийн үйл ажиллагааг идэвхжүүлж, айл өрх бүртэй тулж ажиллах	7
6.	Хүн ам, өрх, аж ахуйн нэгжийн чиглэлийн бүртгэл, судалгааг сайжруулах	7
7.	Төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах замаар олон нийтийн оролцоог идэвхжүүлэх	6
8.	Хууль тогтоомж, журмыг боловсронгуй болгох, сурталчлах ажиллагааг шинэ шатанд гаргах	6
9.	Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх нэгдсэн хөтөлбөр гарган үр дүнтэй тэмцэх	5
10.	Иргэдээс гэмт хэрэг, зөрчлийн талаар өгсөн мэдээллийг төлбөртэйгээр авах, үнэлэх тогтолцоог дүүргийн хэмжээнд жишиг байдлаар нэвтрүүлэх	5
11.	Цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын оновчтой болгох	4
12.	Ял эдлүүлж буй механизмыг сайжруулах, тухайлбал цагаар ажил хийлгэх ялыг Багануур дүүргийн хөгжилд үр ашигтай байдлаар хэрэгжүүлэх	4
13.	Гэмт хэргийн цахим газрын зураглал буюу crime mapping төсөл хэрэгжүүлж, дүүргийн нөхцөл байдлыг цахим сайтаар хяналтанд авах ажлыг үе шаттай зохион байгуулах	3
14.	“Гэрэлтэй Багануур” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	2
15.	Шүүхээс тухайн гэмт хэрэг, зөрчилд тохирсон ял шийтгэл оногдуулах	1
16.	Бусад (орлого нэмэгдүүлэх, ажилгүйдэл бууруулах, сургалт, эрх зүйн сурталчилгааг оновчтой хэлбэрээр зохион байгуулах)	-

**7. Багануур дүүргийн газар, нутаг, гэмт хэрэг, зөрчил үйлдэгддэг онцлогийн талаарх нээлттэй асуултанд:**

- Архидалт, ажилгүй иргэд их байгаатай холбоотой;
- Хөдөө, орон нутгаас шилжилт хөдөлгөөн ихтэй, бусад аймаг, сумдуудад маш ойрхон зайд оршдог;
- Иргэд гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг идэвхтэй өгч хэвших;
- Баар, ресторан, зочид буудал ихтэй;
- Гэр бүл салалт, ядуурал их;
- Мянганы зам дагуух хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой хэрэг, зөрчил их;
- Нутаг дэвсгэр дамнасан мал хулгайлах гэмт хэрэг их гардаг;
- Хууль, эрх зүйн сурталчилгаа муу;
- Гэр хорооллын хэсэгт цагдаагийн эргүүл шалгалт, хяналт сул;
- Архи, согтууруулах ундаа зардаг аж ахуйн нэгж, байгууллага их байдаг.

**8. Гэмт этгээдэд оногдуулж буй ял, шийтгэлийн төрөл, хэмжээ нь оновчтой, шударга эсэх талаарх нээлттэй асуултанд:**

- Оновчтой, шударга;

- Хууль тогтоомжийн хүрээнд ялыг тохируулан оноодог;
- Зохих ял шийтгэл шудрагаар оноодог;
- Зарим зүйл, ангид хэтэрхий хөнгөн, хүнд ял оногдуулдаг;
- Эрүүгийн хууль дэндүү модон хууль санагддаг;
- Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэхэд болон ялтанд тавих прокурорын хяналтыг чангатгах, хяналт зөрчвөл шат дараалан арга хэмжээ авч байх;
- Шүүхийн шийдвэг гүйцэтгэх байгууллагын тогтоол гүйцэтгэгч нарын орон тоог нэмэгдүүлэх.

**9. Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх, ял эдлүүлэх ажиллагааны талаар санаачлан хэрэгжүүлэх ажлын талаарх нээлттэй асуултанд:**


- Нийгэмд тустай албадан ажил хийлгэх ялыг зүй зохистой хийлгэх;
- Ялтнуудад үзүүлж буй нийгмийн ажил, сэтгэл зүйн сургалтыг чанаржуулах, харуул, хамгаалалтын үйл ажиллагааг зөв зохион байгуулах, ялтнуудад дүрмийн дагуу шаардлага тавих;
- Нийгмийн тустай ажилд хамруулах ажлыг орон нутгийн захиргаа ач холбогдол өгч ажиллах.

**10. Шүүхээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаарх нээлттэй асуултанд:**


- Шүүх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил эрхлэхгүй;
- Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар бусад байгууллагатай хамтран ажиллах;
- Шинээр гарсан хууль тогтоомжийг сурталчлах;
- Байгууллага, иргэдэд хууль сурталчлах ажлыг зохион байгуулах;
- Аливаа байгууллагын удирдлага албан хаагч, ажилтныхаа амьдралын нөхцөл байдал, гэр бүлдээ хэр тогтвортой, цаг зарцуулж байгааг анхаардаг байх;
- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээ, мэдээлэл хийх;
- Зохих түвшинд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хийгдэж байгаа;
- Иргэдэд мэдээлэл өгөх;
- Прокурорын байгууллагын ял эдлэж буй ялтнуудад тавих хяналт сайжруулах, зөрчил гаргасан ялтнуудад ял нэмэх бодлогыг хүчтэй болгох;
- Шүүх хуралдааныг нээлттэй явуулах;
- Шүүгч нарт өөрөөрөө ажиллах боломж нь хуулиар хязгаарлагдсан;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил дутмаг хийгдэж байгаа.
- Спортын арга хэмжээ зохион байгуулах, шүүхийн үйл ажиллагааг сурталчлах.

## 5.2.2. БАГАНУУР ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН 14 ПРОКУРОР, АЛБАН ХААГЧААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ДҮН


1. Насны байдал. График 26.



2. Хүйс. График 27.



3. Албан тушаал. График 28.



### 4. Багануур дүүрэгт ямар төрлийн гэмт хэрэг, зөрчил хамгийн их үйлдэгддэг талаарх нээлттэй асуултанд:

- Хулгайлах-9;
- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг-6;
- Бусдын биед хөнгөн гэмтэл учруулах-6
- Танхайрах-4;
- Хүчиндэх-3;
- Залилан мэхлэх-3;
- Дээрэмдэх-2;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг-2;
- Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх;
- Алдуул мал, гээдэл буюу санамсаргүй олсон эд хөрөнгө завших-2;
- Гэр бүлийн хүчирхийлэл-1;

### 5. Багануур дүүргийн аль хорооны нутаг дэвсгэрт ямар төрлийн гэмт хэрэг их үйлдэгддэг талаарх нээлттэй асуултанд: (Хүснэгт.19)

1-р хороо

3-р хороо

4-р хороо

5-р хороо

2-р хороо

**Гэмт хэрэг, зөрчлийн төрөл**

- Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (Бусдын биед хөнгөн гэмтэл санаатай учруулах, Тарчлаах);

- Хулгайлах гэмт хэрэг;

- Орон байрнаас эд хөрөнгө хулгайлах гэмт хэрэг;

- Танхайрах гэмт хэрэг;

- Дээрэмдэх гэмт хэрэг;

- Гэр бүлийн хүчирхийлэл;

- Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (Бусдын биед хөнгөн гэмтэл санаатай учруулах, Тарчлаах);

- Хулгайлах гэмт хэрэг;

- Орон байрнаас эд хөрөнгө хулгайлах гэмт хэрэг;

- Танхайрах гэмт хэрэг;

Дээрэмдэх гэмт хэрэг;

- Ахуйн хүрээний архидалт;

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал зөрчих гэмт хэрэг;

- Хулгайлах гэмт хэрэг;

- Танхайрах гэмт хэрэг;

- Дээрэмдэх гэмт хэрэг;

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал зөрчих гэмт хэрэг;

- Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;

- Хулгайлах гэмт хэрэг;

- Танхайрах гэмт хэрэг;

- Ахуйн хүрээний архидалт;

- Гэр бүлийн хүчирхийлэл;

-Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг;

- Мал хулгайлах гэмт хэрэг

**Шалтгаан, нөхцөл**

- Архидан согтуурдаг, Гэр бүлийн болон хүний зан харилцаанаас үүдэлтэй;

- Эдийн засгийнхолбогдолтой шалтгаан;

- Ядуурал;

- Эдийн засгийнхолбогдолтой шалтгаан;

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил муу;

- Гэр, сууц, хашаагаа эзэнгүй орхих;

- Камерын хяналттай цэг цөөхөн

- Эдийн засгийнхолбогдолтой шалтгаан;

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил муу;

- Гэр, сууц, хашаагаа эзэнгүй орхих;

- Архидан согтуурдаг, Гэр бүлийн болон хүний зан харилцаанаас үүдэлтэй

- Эдийн засгийнхолбогдолтой шалтгаан;

- Ядуурал;

- Камерын хяналттай цэг цөөхөн

- Замын тэмдэг, тэмдэглэгэ э, замын хяналт муу;

- Малчдын хариуцлага гүй байдлаас бол мал бэлчээрээс алдагддаг;

- Багануур дүүргийн нутаг дэвсгэр дээгүүр дайран өнгөрдөг

босоо  
тэнхлэгийн  
хатуу  
хучилттай  
замын  
нөхцөл  
харьцангуй  
муу

- Хялбар аргаар мөнгө олох сонирхол ихтэй
- Олон нийтийн үйлчилгээний газар ихтэй

**6. Багануур дүүрэгт гарсан гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг юу гэж тодорхойлох талаарх асуултанд (3 хүртэлх сонголтоор): (Хүснэгт 20.)**

Эрэмбэ	Шалтгаан, нөхцөл	Дүн
1.	Архидан согтуурал ихтэй	13
2.	Иргэдийн тодорхой хэсэг нь тодорхой эрхэлсэн ажилгүй, тогтмол орлогогүй байдал	8
3.	Гудамж, талбайг камержуулалт бүрэн хийгдээгүй, хийгдсэн нь ашиглалтын шаардлага хангадаггүй	7
4.	Ядуурал, ихэнх нь амьдралын баталгаажих түвшингээс доогуур амьдралтай	6
5.	Урьдчилан сэргийлэх ажлын үр дүн хангалтгүй	6
6.	Согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдаалдаг газар олон	5
7.	Амар хялбар аргаар амьдрах хүсэл эрмэлзлэлтэй хүмүүс их байдаг	4
8.	Урьдчилан сэргийлэх ажилд төсөв хөрөнгө бага хуваарилж, зарцуулагддаг	4
9.	Хөдөө, орон нутгаас шилжин ирэгсэд ихээр оршин суудаг	2
10.	Цагдаа хууль, хяналтын байгууллагын хүн хүч дутмаг	2
11.	Гудамж, талбай гэрэлтүүлэггүй байдал	1
12.	Гэмт этгээдүүдэд оногдуулж буй ял шийтгэл сул, оновчгүй, шударга бус	1
13.	Бусад (Дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хангалтгүй ажилладаг)	1
14.	Тус дүүрэгт амьдардаг захиргааны хяналтанд байгаа болон рецидив этгээдүүдэд тавих хяналт сул	0
15.	Хаягийн бүртгэлгүй хүмүүс ихээр амьдардаг буюу түр оршин суугч ихтэй	0

**7. Багануур дүүргийн хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад ямар арга хэмжээ зохион байгуулвал илүү үр дүнтэй талаарх асуултад (4 хүртэлх сонголтоор): (Хүснэгт 21.)**

Эрэмбэ	Арга хэмжээ	Дүн
1.	Гудамж, талбай, олон нийтийн газрыг нэгдсэн байдлаар “камержуулах”	11
2.	Архидан согтууралтай бүх нийтээр нэгдсэн бодлогоор тэмцэх, архи,	9

	согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчилдэг цэгийн тоог багасгах, худалдаа, үйлчилгээнд тавих хяналтыг сайжруулах	
3.	Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх нэгдсэн хөтөлбөр гарган үр дүнтэй тэмцэх	7
4.	Хороо, нийгмийн ажилтан, хэсгийн ахлагчийн үйл ажиллагааг идэвхжүүлж, айл өрх бүртэй тулж ажиллах	6
5.	Төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах замаар олон нийтийн оролцоог идэвхжүүлэх	5
6.	Цагдаагийн байгууллагын орон тоог нэмэгдүүлэх, ялангуяа эзэнгүй байгаа нутаг дэвсгэрт цагдаагийн төлөөлөл ажиллуулах	4
7.	Сэрэмжлүүлэг мэдээллийг тогтмол мэдээлж байх	4
8.	Иргэдээс гэмт хэрэг, зөрчлийн талаар өгсөн мэдээллийг төлбөртэйгээр авах, үнэлэх тогтолцоог дүүргийн хэмжээнд жишиг байдлаар нэвтрүүлэх	3
9.	Ял эдлүүлж буй механизмыг сайжруулах, тухайлбал цагаар ажил хийлгэх ялыг Багануур дүүргийн хөгжилд үр ашигтай байдлаар хэрэгжүүлэх	2
10.	Гэмт хэргийн цахим газрын зураглал буюу crime mapping төсөл хэрэгжүүлж, дүүргийн нөхцөл байдлыг цахим сайтаар хяналтанд авах ажлыг үе шаттай зохион байгуулах	2
11.	Хууль тогтоомж, журмыг боловсронгуй болгох, сурталчлах ажиллагааг шинэ шатанд гаргах	2
12.	Цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын оновчтой болгох	1
13.	Хүн ам, өрх, аж ахуйн нэгжийн чиглэлийн бүртгэл, судалгааг сайжруулах	1
14.	Шүүхээс тухайн гэмт хэрэг, зөрчилд тохирсон ял шийтгэл оногдуулах	1
15.	Бусад (иргэдэд хууль тогтоомж, шинээр батлагдсан хуулиудаар үнэ төлбөргүй хичээл сургалт зохион байгуулах, боловсрол олгох)	1

**8. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчлан сэргийлэх ажиллагаанд Багануур дүүргийн төрийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа ямар хэмжээнд байгаа талаарх асуултанд:** (Хүснэгт.22)

Сайн	Дунд	Муу
0 буюу 0%	6 буюу 43%	8 буюу 57%

**9. Багануур дүүргийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнгийн үнэлгээ:** (Хүснэгт.23)

Арга хэмжээ	Сайн	Дунд	Муу	Үнэлгээ өгөөгүй
Ерөнхий арга хэмжээ	0	8 буюу 57%	4 буюу 29%	2 буюу 14%
Тусгай арга хэмжээ	0	8 буюу 57%	4 буюу 29%	
Нэг бүрчилсэн арга хэмжээ	0	8 буюу 57%	4 буюу 29%	

**10. Прокурорын байгууллагын бүтэц орон тоо, зохион байгуулалтын талаарх санал бодлоо хуваалцах нээлттэй асуултанд:**


- Бүтэц, орон тоо томорсон боловч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан прокурор томилох;
- Бүтэц, орон тооны хувьд орон нутгийн хэмжээнд зохимжтой байсан боловч өөрчлөлт хийх, прокурорын тоог нэмэгдүүлэх;
- Бүтэц, орон тоо, зохион байгуулалтын хувьд боломжийн;
- Орон тоо цөөн, ачаалал их;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг судладаг бие даасан бүтэц, орон тооны нэгжтэй болгох.

**11. Прокурорын байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх шинэлэг ажлын талаар санал бодлоо хуваалцах нээлттэй асуултанд:**


- Камержуулах;
- Цагдаагийн байгууллага, төрийн захиргааны болон төрийн бус байгууллагатай хамтран аж ахуйн нэгжүүд дээр сургалт зохион байгуулах, телевиз, хэвлэл, мэдээллийн хэрэгслийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд их оролцуулах;
- Телевиз, сонин хэвлэл, фэйсбүүк зэрэг мэдээллийн хэрэгслээр нөлөөллийн нэвтрүүлэг, хууль сурталчлах, гэмт хэрэг, зөрчлийн ойлголт, түүнд хүлээлгэх хариуцлага, хор уршиг зэргээр яриа таниулга хийж байх;
- Тус дүүргийн нутаг дэвсгэрт хамаарах хэвтээ тэнхлэгийнхатуу хучилттай замын тэмдэг, тэмдэглэгээг сайжруулах, онцгой содон байдлаар анхааруулга, 3D саад хийх;
- Прокурорын байгууллагын дотоод асуудал тул хариулах боломжгүй;
- Шөнийн цагаар согтууруулах ундаагаар үйлчилдэг (Соронз, Их суудал) гэх мэт бааруудад хөдөлгөөнт эргүүлийг цагийн хуваарийн дагуу байнга, тогтмол явуулах;
- Төрийн байгууллагатай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, шалтгаан, нөхцөлийг судлах ажлыг хийх;
- “Архигүй-Багануур” хөтөлбөр хэрэгжүүлэх.

### 5.2.3. БАГАНУУР ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН 55 АЛБАН ХААГЧДИЙН ДУНД ЯВУУЛСАН САНАЛ АСУУЛГЫН ДҮН

1. Насны байдал: График 29.




2. Хүйс: График 30.



3. Боловсрол: График 31.


- Дээд - 38 буюу 69 хувь
- Бүрэн бус дунд - 3 буюу 5 хувь
- Тусгай дунд - 5 буюу 9 хувь
- Бүрэн дунд - 7 буюу 12 хувь
- Бага - 0
- Боловсролгүй - 0

3. Багануур дүүргийн хэмжээний эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг та хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултанд: График 32.



4. Судалгаанд оролцсон хүмүүсээс тус дүүрэгт ажиллаж, амьдарч буй ард иргэдийн аюулгүй байдлын баталгаа хэрхэн хангагдаж байгаа вэ? гэсэн асуултанд: (График 33).





**5. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд цагдаагийн байгууллагад тулгамдсан ямар асуудал байна гэж та үзэж байна вэ? гэсэн асуултанд (3 хүртэлх сонголтоор):**  
(Хүснэгт.24)

Эрэмбэ	Тулгамдсан асуудал	Дүн
1.	Цагдаагийн алба хаагчдын нийгэм, эдийн засгийн баталгаа муу	39
2.	Цагдаагийн байгууллагын эрх зүйн орчин хангалтгүй	20
3.	Нутаг дэвсгэрийн нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа, тэднээс цагдаагийн байгууллагад үзүүлэх дэмжлэг дутмаг	20
4.	Цагдаагийн байгууллагад шаардлагатай техник хэрэгсэл хүрэлцэхгүй	18
5.	Цагдаагийн алба хаагчдын зан байдал, харьцаа, харилцааны доголдолтой байдал нөлөөлнө	15
6.	Цагдаагийн албан хаагч ачаалал ихтэй ажиллаж, түүнээс үүдэн хор уршиг их байна	14
7.	Цагдаагийн байгууллагад сэтгэлтэй, зүтгэлтэй хүмүүс дутагдалтай байна	14
8.	Тус дүүрэгт ажиллаж буй цагдаагийн орон тоо хүрэхгүй	13
9.	Цагдаагийн байгууллагаас баримтлах төр засгийн бодлого тогтвортой бус, үр нөлөө бага	13
10.	Цагдаагийн албан хаагчдийн мэдлэг, боловсрол дутмаг байдал	11
11.	Цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт оновчгүй хийгдсэн	9
12.	Нутаг дэвсгэр дэх, ялангуяа дүүрэг дэх цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, тогтолцоо буруу төлөвлөлттэй	6
13.	Бусад (Согтуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодож зорчих)	1

**6. Багануур дүүрэгт ямар төрлийн гэмт хэрэг хамгийн их гардаг вэ? гэсэн асуултанд:**

- Гэр хорооллын айл өрх, байшин, гэрт халдсан 47 буюу 85 хувь
- Танхайрах 38 буюу 69 хувь
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 14 буюу 25 хувь
- Залилан мэхлэх 12 буюу 21 хувь
- Мал хулгайлах 10 буюу 18 хувь
- Алт мөнгө, үнэт эдлэл хулгайлах 10 буюу 18 хувь
- Орон сууцны хорооллын айл өрхөд халдсан 9 буюу 16 хувь
- Тээврийн хэрэгсэл хулгайлах 6 буюу 10 хувь
- Аж ахуй нэгж байгууллагад халдсан 4 буюу 7 хувь

- Дээрэмдэх 4 буюу 7 хувь
- Байгаль орчны эсрэг 2 буюу 3 хувь
- Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг 1 буюу 1 хувь

**7. Багануур дүүргийн аль хорооны нутаг дэвсгэрт ямар төрлийн гэмт хэрэг их үйлдэгддэг талаарх нээлттэй асуултанд: (Хүснэгт.25)**

1-р хороо	3-р хороо	4-р хороо	5-р хороо	2-р хороо
<b>Гэмт хэрэг, зөрчлийн төрөл</b>				
-Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (Бусдын биед хөнгөн гэмтэл санаатай учруулах, Тарчлаах);	-Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (Бусдын биед хөнгөн гэмтэл санаатай учруулах, Тарчлаах);	-Хулгайлах гэмт хэрэг;	- Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;	-Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
-Хулгайлах гэмт хэрэг;	-Хулгайлах гэмт хэрэг;	-Орон байрнаас эд хөрөнгө хулгайлах гэмт хэрэг;	- Хулгайлах гэмт хэрэг;	-Мал хулгайлах гэмт хэрэг
-Орон байрнаас эд хөрөнгө хулгайлах гэмт хэрэг;	-Орон байрнаас эд хөрөнгө хулгайлах гэмт хэрэг;	-Танхайрах гэмт хэрэг;	-Танхайрах гэмт хэрэг;	-Ахуйн хүрээний архидалт;
-Танхайрах гэмт хэрэг;	-Танхайрах гэмт хэрэг;	-Дээрэмдэх гэмт хэрэг;	-Ахуйн хүрээний архидалт;	-Гэр бүлийн хүчирхийлэл;
-Дээрэмдэх гэмт хэрэг;	Дээрэмдэх гэмт хэрэг;	-Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал зөрчих гэмт хэрэг;	-Гэр бүлийн хүчирхийлэл;	
-Гэр бүлийн хүчирхийлэл;	-Ахуйн хүрээний архидалт;	-Гудамж талбайд гэмт хэрэг үйлдэгдэх		
	-Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал зөрчих гэмт хэрэг;			
<b>Шалтгаан, нөхцөл</b>				
-Архидан согтуурдаг, Гэр бүлийн болон хүний зан харилцаанаас үүдэлтэй;	-Эдийн засгийнхолбогдолтой шалтгаан;	-Иргэдийн эдийн засгийн хүндрэл;	-Архидан согтуурдаг, Гэр бүлийн болон хүний зан харилцаанаас үүдэлтэй	-Замын тэмдэг, тэмдэглэгээ, замын хяналт муу;
-Иргэдийн эдийн засгийн хүндрэл;	-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил муу;	-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил муу;	-Иргэдийн эдийн засгийн хүндрэл;	-Малчдын хариуцлагагүй байдлаас бол мал бэлчээрээс алдагддаг;
-Ядуурал;	-Гэр, сууц, хашаагаа эзэнгүй орхих;	-Гэр, сууц, хашаагаа эзэнгүй орхих;	Ядуурал;	
-Сургууль завсардсан болон эцэг, эхээсээ	-Камерын хяналттай цэг цөөхөн	-Баар цэнгээний газрын ажиллах цагийн	-Камерын хяналттай цэг цөөхөн;	-Багануур дүүргийн нутаг дэвсгэр дээгүүр дайран
			-Албад хоорондын	

тусдаа айлд амьдардаг хүүхэд их байдаг;

-Хулгайлах гэмт хэрэг үйлдэж, ял эдэлсэн хүн их байдаг;

-Архаг архичин олон байдаг

хуваарийг шөнийн 04 цаг болгосон;

-Шөнийн цагаар ажилладаг дэлгүүр олон

ажлын уялдаа холбоо хангалтгүй;

-Амжиргааны баталгаажих түвшингээс доогуур айл өрх их;

-Хүн амын тоо харьцангуй олон;

- Архаг архичин олон байдаг

өнгөрдөг босоо тэнхлэгийн хатуу хучилттай замын нөхцөл харьцангуй муу

**8. Тус дүүргийн хэмжээнд нуугдмал гэмт явдлын цаашдын чиг хандлага ямар байна вэ? гэсэн асуултанд (2 хүртэлх сонголтоор): (Хүснэгт.26)**

Эрэмбэ	Гэмт хэрэг, зөрчлийн төрөл	Дүн
1.	Хулгайлах гэмт явдал нуугдмал хэвээр байх	37
2.	Байгалийн баялагийг хууль бусаар ашиглах, бохирдуулах гэмт явдал хүрээгээ тэлэх	18
3.	Биеэ үнэлэхэд татан оролцуулах зохион байгуулах гэмт явдал өсөх	9
4.	Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт явдал нэмэгдэх	4
5.	Терроризмын үйлдэл гарч болзошгүй хандлага бий	1
6.	Бусад	1
7.	Шашны хууль бус харгис бодлого, түүнийг дагасан гэмт явдал үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдал бүрдэж байна	0

**9. Багануур дүүрэгт гарсан гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг юу гэж тодорхойлох талаарх асуултанд (3 хүртэлх сонголтоор): (Хүснэгт.27)**

Эрэмбэ	Шалтгаан нөхцөл	Дүн
1.	Архидан согтуурал ихтэй	40
2.	Ядуурал, ихэнх нь амьдралын баталгаажих түвшингээс доогуур амьдралтай	34
3.	Гудамж, талбайг камержуулалт бүрэн хийгдээгүй, хийгдсэн нь ашиглалтын шаардлага хангадаггүй	16
4.	Иргэдийн тодорхой хэсэг нь тодорхой эрхэлсэн ажилгүй, тогтмол орлогогүй байдал	14
5.	Хөдөө, орон нутгаас шилжин ирэгсэд ихээр оршин суудаг	13

6.	Амар хялбар аргаар амьдрах хүсэл эрмэлзлэлтэй хүмүүс их байдаг	12
7.	Урьдчилан сэргийлэх ажлын үр дүн хангалтгүй	12
8.	Урьдчилан сэргийлэх ажилд төсөв хөрөнгө бага хуваарилж, зарцуулагддаг	8
9.	Гудамж, талбай гэрэлтүүлэггүй байдал	6
10.	Хаягийн бүртгэлгүй хүмүүс ихээр амьдардаг буюу түр оршин суугч ихтэй	2
11.	Гэмт этгээдүүдэд оногдуулж буй ял шийтгэл сул, оновчгүй, шударга бус	1
12.	Тус дүүрэгт амьдардаг захиргааны хяналтанд байгаа болон рецедив этгээдүүдэд тавих хяналт сул	0
13.	Бусад	0

**10. Багануур дүүргийн эрүүгийн нөхцөл байдалд ямар хүчин зүйлс нөлөөлж байна вэ? гэсэн нээлттэй асуултанд:**

- Архидан согтуурч, танхайрах;
- Хөдөө орон нутагаас шилжин ирэгсэд их, эрхэлсэн тодорхой ажил, орлогогүй иргэд их;
- Авлигал;
- Хулгайлах гэмт хэрэг их үйлдэгддэг;
- Ажилгүйдэл, ядуурал;
- Баар цэнгээний газрын ажиллах цаг урт;
- Гадна камержуулалт, гэрэлтүүлэгмуу.

**11. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагаанд Багануур дүүргийн төрийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа ямар хэмжээнд байна вэ? гэсэн үнэлгээний асуултанд: (Хүснэгт.28)**

Сайн	Дунд	Муу
6 буюу 11%	32 буюу 58%	17 буюу 31%

**12. Гэмт хэрэг, зөрчилтэй оновчтой байдлаар тэмцэхэд цагдаагийн байгууллагын өнөөгийн бүтэц, зохион байгуулалт оновчтой байга эсэх талаар асуултанд:(Хүснэгт.29)**

Оновчтой	Оновчтой бус	Мэдэхгүй
13 буюу 24%	22 буюу 40%	20 буюу 36%

**13. Цагдаагийн байгууллагын ажлын ачаалал хир байна вэ? гэсэн асуултанд: (Хүснэгт.30)**

Маш их	Их	Дунд зэрэг	Бага	Маш бага
9 буюу 16%	27 буюу 49%	18 буюу 33%	1 буюу 2%	0 буюу 0%

**14. Багануур дүүргийн хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад ямар арга хэмжээ зохион байгуулвал илүү үр дүнтэй талаарх асуултад (4 хүртэлх сонголтоор): (Хүснэгт.31)**

Эрэмбэ	Арга хэмжээ	Дүн
1.	Архидан согтууралтай бүх нийтээр нэгдсэн бодлогоор тэмцэх, архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчилдэг цэгийн тоог багасгах, худалдаа, үйлчилгээнд тавих хяналтыг сайжруулах	46
2.	Гудамж, талбай, олон нийтийн газрыг нэгдсэн байдлаар “камержуулах”	32
3.	Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх нэгдсэн хөтөлбөр гарган үр дүнтэй тэмцэх	25
4.	Сэрэмжлүүлэг мэдээллийг тогтмол мэдээлж байх	19
5.	“Гэрэлтэй дүүрэг” хөтөлбөр хэрэгжүүлж, ялангуяа захын гэр хорооллыг гэрэлтүүлэгтэй болгох	15
6.	Шүүхээс тухайн гэмт хэрэг, зөрчилд тохирсон ял шийтгэл оногдуулах	14
7.	Иргэдээс гэмт хэрэг, зөрчлийн талаар өгсөн мэдээллийг төлбөртэйгээр авах, үнэлэх тогтолцоог дүүргийн хэмжээнд жишиг байдлаар нэвтрүүлэх	12
8.	Цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын оновчтой болгох	12
9.	Цагдаагийн байгууллагын орон тоог нэмэгдүүлэх, ялангуяа эзэнгүй байгаа нутаг дэвсгэрт цагдаагийн төлөөлөл ажиллуулах	11
10.	Хүн ам, өрх, аж ахуйн нэгжийн чиглэлийн бүртгэл, судалгааг сайжруулах	11
11.	Төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах замаар олон нийтийн оролцоог идэвхжүүлэх	11
12.	Ял эдлүүлж буй механизмыг сайжруулах, тухайлбал цагаар ажил хийлгэх ялыг Багануур дүүргийн хөгжилд үр ашигтай байдлаар хэрэгжүүлэх	8
13.	Хороо, нийгмийн ажилтан, хэсгийн ахлагчийн үйл ажиллагааг идэвхжүүлж, айл өрх бүртэй тулж ажиллах	7
14.	Гэмт хэргийн цахим газрын зураглал буюу crime mapping төсөл хэрэгжүүлж, дүүргийн нөхцөл байдлыг цахим сайтаар хяналтанд авах ажлыг үе шаттай зохион байгуулах	6
15.	Хууль тогтоомж, журмыг боловсронгуй болгох, сурталчлах ажиллагааг шинэ шатанд гаргах	6
16.	Бусад (Хяналтын камерын систем)	1


**15. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах талаар Таны санал гэсэн нээлттэй асуултанд:**

- Гэр хорооллын гудамж, талбайн гэрэлтүүлгийг нэмэх;
- Иргэдэд урамшуулал олгох;
- 24 цагаар эргүүлийн цагдааг ээлжээр үүрэг гүйцэтгүүлж, тасралтгүй хороо тус бүрээр явуулан дуут дохио өгч сонор сэрэмж төрүүлэх;
- Хамтарсан баг байгуулах;
- Хөршийн холбоог яг хүн бүртэй тулж уулзан сайжруулах, хяналтыг нь газар дээр нь дарга ахлах нь шалгах;
- Баар цэнгээний газар, архи, согтууруулах ундаа борлуулдаг цэгийн ажиллах цагийн хуваарийг багасгах талаар зохих шатны байгууллагад хандан цагийн хуваарийг хумьж гарсан үр дүнг тооцож ажиллан, таниулга хийх;
- Бусад албадтай хамтран шаардлага хангасан хяналтын камер, техник хэрэгслийг нэмэгдүүлж, дүүргээ нийтэд нь камерийн хяналтанд авах;
- Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах. Уг ажилд иргэдийн хүчийг татан оролцуулах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төсөв хангалттай гаргаж, иргэд байгууллагатай хамтран ажиллаж, үр дүнг сайжруулах;
- Архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг цэгийн тоог багасгах;
- Албахаагчдыг залхаах бус ажлын бүтээмжтэй, оновчтой ажиллуулах;
- Субъектийн бүртгэл судалгааг сайжруулах;

- Одоогийн нийгмийн хөгжил дэвшилд уялдуулан цахим хяналтыг өндөр түвшинд хөгжүүлэх нь урьдчилан сэргийлэх ажлын зөв шийдэл болно;

**5.3. БАГАНУУР ДҮҮРГИЙН 1, 3, 4 ДҮГЭЭР ХОРООНЫ 19 ЗОХИОН БАЙГУУЛАГЧ, ХЭСГИЙН АХЛАГЧ, НИЙГМИЙН АЖИЛТАН, БУСАД АЖИЛТНААС САНАЛ АСУУЛГЫН АРГААР АВСАН СУДАЛГААН ДҮН**

Санал асуулгад оролцогчдын ерөнхий мэдээлэл (График.34-38)



**1. Танай хороонд ямар төрлийн гэмт хэрэг зөрчил ихээр гардаг бэ гэсэн нээлттэй асуултанд:**

- Архидан согтуурдаг;
- Гэр бүлийн хүчирхийлэл;
- Хулгайн гэмт хэрэг;
- Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг;
- Ахуйн хүрээнд үйлдэгдсэн гэмт хэрэг;
- 27-р байр болон Болор дусал дэлгүүрийн үүдээр архи уудаг хүмүүс ихтэй тул хяналт тавих шаардлагатай гэж тус тус хариулсан байна.

**2. Багануур дүүргийн хэмжээнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг юу гэж тодорхойлох талаарх асуултанд (3 хүртэлх сонголтоор): (Хүснэгт.32)**

Эрэмбэ	Гэмт хэрэг, зөрчлийн төрөл	Дүн
1.	Архидан согтуурал ихтэй	15
2.	Ядуурал, ихэнх нь амьдралын баталгаажих түвшингээс доогуур амьдралтай	9
3.	Иргэдийн тодорхой хэсэг нь тодорхой эрхэлсэн ажилгүй, тогтмол орлогогүй байдал	8
4.	Гудамж, талбайг камержуулалт бүрэн хийгдээгүй, хийгдсэн нь ашиглалтын шаардлага, хангадаггүй	6
5.	Урьдчилан сэргийлэх ажилд төсөв хөрөнгө бага хуваарилж, зарцуулагддаг	3
6.	Хаягийн бүртгэлгүй хүмүүс ихээр амьдардаг буюу түр оршин суугч ихтэй	3
7.	Хөдөө, орон нутгаас шилжин ирэгсэд ихээр оршин суудаг	3
8.	Амар хялбар аргаар амьдрах хүсэл эрмэлзлэлтэй хүмүүс их байдаг	3
9.	Гудамж, талбай гэрэлтүүлэггүй байдал	3
10.	Гэмт этгээдүүдэд оногдуулж буй ял шийтгэл сул, оновчгүй, шударга бус	2
11.	Урьдчилан сэргийлэх ажлын үр дүн хангалтгүй	2
12.	Тус дүүрэгт амьдардаг захиргааны хяналтанд байгаа болон рецидив этгээдүүдэд тавих хяналт сул	1
13.	Бусад	0

**3. Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаарх үнэлгээний асуултанд: (Хүснэгт.33)**

Сайн	Дунд	Муу
8 буюу 42%	9 буюу 47%	2 буюу 11%

**4. Багануур дүүргийн хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад ямар арга хэмжээ зохион байгуулвал илүү үр дүнтэй талаарх санал асуулгад (4 хүртэлх сонголтоор): (Хүснэгт.34)**

Эрэмбэ	Гэмт хэрэг, зөрчлийн төрөл	Дүн
1.	Гудамж, талбай, олон нийтийн газрыг нэгдсэн байдлаар “камержуулах”	17
2.	Архидан согтууралтай бүх нийтээр нэгдсэн бодлогоор тэмцэх, архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчилдэг цэгийн тоог багасгах, худалдаа, үйлчилгээнд тавих хяналтыг сайжруулах	10
3.	“Гэрэлтэй дүүрэг” хөтөлбөр хэрэгжүүлж, ялангуяа захын гэр хорооллыг гэрэлтүүлэгтэй болгох	7
4.	Цагдаагийн байгууллагын орон тоог нэмэгдүүлэх, ялангуяа эзэнгүй байгаа нутаг дэвсгэрт цагдаагийн төлөөлөл ажиллуулах	6
5.	Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх нэгдсэн хөтөлбөр гарган үр дүнтэй	6



	тэмцэх	
6.	Хууль тогтоомж, журмыг боловсронгуй болгох, сурталчлах ажиллагааг шинэ шатанд гаргах	5
7.	Цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын оновчтой болгох	4
8.	Хороо, нийгмийн ажилтан, хэсгийн ахлагчийн үйл ажиллагааг идэвхжүүлж, айл өрх бүртэй тулж ажиллах	4
9.	Сэрэмжлүүлэг мэдээллийг тогтмол мэдээлж байх	4
10.	Төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах замаар олон нийтийн оролцоог идэвхжүүлэх	3
11.	Иргэдээс гэмт хэрэг, зөрчлийн талаар өгсөн мэдээллийг төлбөртэйгээр авах, үнэлэх тогтолцоог дүүргийн хэмжээнд жишиг байдлаар нэвтрүүлэх	2
12.	Шүүхээс тухайн гэмт хэрэг, зөрчилд тохирсон ял шийтгэл оногдуулах	1
13.	Ял эдлүүлж буй механизмыг сайжруулах, тухайлбал цагаар ажил хийлгэх ялыг Багануур дүүргийн хөгжилд үр ашигтай байдлаар хэрэгжүүлэх	1
14.	Гэмт хэргийн цахим газрын зураглал буюу crime mapping төсөл хэрэгжүүлж, дүүргийн нөхцөл байдлыг цахим сайтаар хяналтанд авах ажлыг үе шаттай зохион байгуулах	0
15.	Хүн ам, өрх, аж ахуйн нэгжийн чиглэлийн бүртгэл, судалгааг сайжруулах	0
16.	Бусад	0

**5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар санал бодлоо хуваалцах нээлттэй асуултанд:**

- Их хэмжээгээр архи ууж, согтуурдаг иргэдийг 3 сараас дээш хугацаагаар хөдөлмөр эрхлүүлж, эмчилгээнд хамруулан архинаас холдуулах;
- Архидан согтуурахтай цогц бодлогоор тэмцэж, ажилгүй иргэдийг ажлын байраар хангах, такси үйлчилгээ эрхэлдэг жолооч нар сар бүрийн 17, 20-ны өдрүүдэд архи шаглаж зардагыг таслан зогсоох;
- Шөнийн эргүүлийг сайжруулах, баар, цэнгээний газрыг 00 цагаас хойш ажиллуулахгүй байх, шагын архийг иргэдээр худалдаалуулахгүй байх;
- Хорооны гудамж талбайг камержуулах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон байнга архидан согтуурдаг иргэдэд сургалт явуулах, бусад арга хэмжээ авах;
- Урамшуулал олгох;
- Иргэдийн нийгмийн оролцоог идэвхтэй болгох;
- Захын гэр хорооллыг гэрэлтүүлэгтэй болгох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эргүүл гаргах (үйлдвэр хэсэг орчимд);
- Хөршийн хяналтын хөтөлбөрийг үе шаттай сайтар зохион байгуулах;
- 1 хороог 2-с доошгүй олон нийтийн цагдаатай болгох, түүгээр дамжуулж эргүүл хийлгэх;
- Цагдаа нарыг идэвхтэй ажиллуулах;
- Олон нийтийн цагдаагийн орон тоог нэмэгдүүлж, сайн ажиллуулах.

## НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Багануур дүүрэг дэх гэмт хэргийн гаралтын тоон үзүүлэлт бусад дүүрэгтэй харьцуулахад Багахангай дүүргийн өмнө орж байгаа боловч 10000 хүн амд ногдох түвшингээр Багахангай, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргүүдийн урд орж байгаагаас үзэхэд гэмт хэргийн хүн амд ногдох эрсдэл, аюулгүй байдлын түвшин өндөр байгаа нь судалгаагаар тогтоогдлоо.

Өөрөөр хэлбэл, сүүлийн 25 жилийн өгөгдлөөс үзэхэд гэмт хэргийн гаралт тоон үзүүлэлтийн хувьд буурсан ч түүнээс үүдэн гарсан хор уршиг болох эд материалын хохирлын хэмжээ, эрдэнэт хүн амь насаа алдах, эрүүл мэндээрээ хохирох явдал төдийлөн буураагүй байна.

Нийслэлийн дүүргүүдэд бүртгэгдсэн гэмт хэргийн 1.6%-2% нь тус дүүрэгт гарсан бол харин захиргааны зөрчлийн 6% ногдож, үүний 80-90 хувь нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийг зөрчсөн зөрчлүүд байгаагаас үзэхэд тус дүүргийн төв зам дагуу тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдсэн хяналт шалгалт, зөрчил илрүүлэлт их байна.

Судалгааны явцад иргэдээс авсан судалгаагаар 74.5 хувь нь ямар нэгэн хэлбэрээр итгэдэг нь дэлхийн болон Монгол Улсын дунджаас дээгүүр үзүүлэлт юм. Энэ нь тус дүүргийн хууль сахиулах байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагаас явуулж буй үйл ажиллагааны үр дүнг үнэлсэн үнэлгээ юм. Гэхдээ бидний баримт бичигт хийсэн судалгаагаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил өргөн цар хүрээнд явагддаггүй, дан ганц цагдаагийн байгууллагын ажил мэтээр явагддаг, засаг захиргаа, хуулийн байгууллагуудын хамтын ажиллагаа дутмаг байгаа нь ажиглагдсан.

Багануур дүүрэг нь зүүн аймгуудын чиглэлийн хэвтээ тэнхлэгийн автозам дагуу оршдог, цаашид цахилгаан-эрчим хүч, үйлдвэрлэл-үйлчилгээ, уул уурхай, оюутны хотхон хэлбэрээр хөгжих, соёл боловсролын нэгдсэн сүлжээ бүхий байрлалтай бүс болон дагуул хотын чиг хандлагаар хөгжихөөр болжээ.

Тус дүүрэгт өрнөх гэж буй үйлдвэрлэл-технологийн бүтээн байгуулалт, нийгэм, эдийн засаг, байгаль цаг уурын онцлогийг дагаад гэмт хэргийн гаралт нэмэгдэх, шинэ төрлийн зохион байгуулалттай гэмт хэргүүд өсөн нэмэгдэх, олон улсын эрх зүйн харилцааны бүс нутаг болох прогноз харагдаж байна.

Ийм учраас дүүргийн болон бүс нутаг дэвсгэрийн иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тус дүүргийн хэмжээнд үр дүнтэй явуулж, аюулгүй дагуул хотын жишгээр хөгжихийн тулд хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, материаллаг баазыг сайжруулах, өндөр мэдлэг, боловсролтой хүний нөөцөөр бэхжүүлэх, тэднийг мэргэшүүлэн сургах, үйл ажиллагаандаа орчин үеийн дэвшилтэт техник, технологийг өргөнөөр нэвтрүүлэх шаардлага байгаа нь судалгаагаар дүгнэгдэж байна.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны ажлын хүрээнд Багануур дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ, гэмт хэргийн өнөөгийн байдал, төрөл, түүний шалтгаан, нөхцөл, “Аюулгүй амгалан Багануур” хөтөлбөр, төв орон нутгийн захиргааны байгууллагуудын гэмт хэрэгтэй тэмцэж түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч буй ажлын тайлан, гадаад улс орны гэмт хэргээс урьдчилан сэргийлж байгаа туршлага зэргийг судалгааны зүйл болгон авч дүн шинжилгээ хийсний эцэст дүүргийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зөвлөмжийг хүргүүлж байна.

Судалгааны ажлын хүрээнд зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хурлаас гарсан зөвлөмжөөс гадна дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Эдгээр санал, зөвлөмжийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөнд 2017 оноос эхлэн тусган хэрэгжүүлэх боломжтой. Санал, зөвлөмжийг төлөвлөгөө хэлбэрээр боловсруулав. Үүнд:

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах, хамтрах нь
<b>Нэг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:</b>			
1.	Багануур дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, энэ ажлыг хариуцах орон тооны ажилтан бий болгож, дүүргийн хэмжээнд урьдчилан сэргийлэх ажлыг нэгтгэн зохион байгуулж, үйл ажиллагааг идэвхжүүлэх	2016-2017 оны I улирал	Багануур дүүргийн ИТХ-н Ажлын алба
2.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг бодитой, үр дүнтэй хэлбэрээр өргөн хүрээнд хууль сахиулах, прокурор, шүүх болон төрийн захиргааны байгууллага, хороодын засаг дарга, аж ахуйн нэгж, иргэдийн тэгш оролцоотойгоор зохион байгуулж ажиллах	Тогтмол	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
3.	Эдийн засаг, нийгмийн 2017 оны зорилтод гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар дүүргийн хэмжээнд бүх төрийн байгууллагын үүрэг оролцоог нарийвчлан тодорхойлж оруулах, шүүх, цагдаа, прокурор, цагдаагийн хэлтэс, хороод, мэргэжлийн хяналт, худалдаа үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс, боловсрол, соёлын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага гэх мэт.	Тогтмол	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
4.	Нийслэлийн харьяа шүүх, прокурор, хуулийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах	Тогтмол	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
5.	ХЗДХЯ-ны дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Нийслэлийн салбар зөвлөл, бусад аймаг, дүүргийн зохицуулах зөвлөлтэй хамтын ажиллагааг өргөжүүлж, ажиллах	2017 оноос	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
6.	“Нийслэл хотын телекамерын хяналтын техник, технологийн өнөөгийн байдлыг эрс шинэчилж, найдвартай байдлыг хангах, шинээр гудамж, талбай, объектуудыг телекамерын хяналтад оруулж, нийслэл хотоо бүрэн камерын хяналтын системд оруулах зорилгоор Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс “Аюулгүй хот” төслийг удахгүй боловсруулан батлуулж, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулна, үүнд	2017 он	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар, ГХУСАЗСЗ

	<p>зарцуулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэнэ”<sup>48</sup> гэсний дагуу <b>“Аюулгүй Багануур хот”</b> дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах,          - Нэг хороог сонгон авч, <b>“Аюулгүй Баянбүрд”</b>-г бодлого болгон хэрэгжүүлэх</p>		
7.	<p>“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж талбай, гэр хорооллыг телекамерын системд хамруулж, гэрэлтүүлгийг сайжруулна” гэж төлөвлөсөн ажлын хүрээнд Улаанбаатар хотын Цагдаагийн газраас 2017 он гарангуут хэрэгжүүлэх <b>“Телекамер”</b>, <b>“Эргүүл”</b> хөтөлбөрийг дүүргийн хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах, үүнд шаардлагатай хөрөнгө мөнгийг төсөвлөж, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх          - Нийслэлээс гаргасан эрүүл, аюулгүй байдлын индексийн үзүүлэлтэд хувь хүний аюулгүй байдлыг хангах чиглэлээрх үзүүлэлтүүд доогуур байгаа тул үүнийг нэмэгдүүлэх ажлыг бодлого болгон хэрэгжүүлэх</p>		
8.	<p>ЦЕГ-н хэмжээнд туршигдаж буй <b>Crime mapping</b> болон Улаанбаатар хотын цагдаагийн газраас хэрэгжүүлэх гэж буй гэмт хэргийн хяналтын цогц системийг Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэст нэвтрүүлэх бэлтгэлийг хангаж, мэргэшсэн алба хаагчийг ажиллуулах, холбогдох төсөв хөрөнгийг асуудлыг шийдвэрлүүлэх          - Телекамерын системд нэвтрүүлэх ажилтай хамтатган гэмт хэргийг цахим зурагжуулах систем (Crime mapping system)-г нэвтрүүлэх</p>	2017 оноос	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ, Цагдаагийн хэлтэс
9.	<p><b>Камержуулах, цахим зурагжуулах хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх.</b>          - Эхний ээлжинд камер байршуулах цэгийг судалгааны үндэслэлтэй тодорхойлох ажлыг <b>сонгон шалгаруулалт явуулан хийлгүүлж, төслийн баримт бичиг боловсруулах</b>, улмаар хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх          - Камерын хяналтын системийн өрөө байрны асуудлыг шийдвэрлэх, стандартын байртай болох          - Багануур дүүрэгт төв зам дагуу камерын хяналтын нэгдсэн системтэй <b>“Шуурхай удирдлагын төв”</b> байгуулах төслийн баримт бичиг боловсруулж, бусад дүүргүүдэд жишиг байдлаар хэрэгжүүлэх          - <b>“Байгууллага, аж ахуйн нэгжийг камержуулах тухай”</b> Дүүргийн Засаг даргын захирамж гаргуулах. Тухайлбал, Хэсгийн байцаагч нар хариуцсан хороонд байрлах хүн ам олноор төвлөрсөн зах, худалдааны төв, банк санхүүгийн болон бусад аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гаргаж, түүнээс камер тавигдаагүй аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гарган захирамжийг хэрэгжүүлэх чиглэлээр захирамж, албан мэдэгдлийг 2017 оны эхнээс хэрэгжүүлэх, ач холбогдлыг</p>	2017 он	Багануур дүүргийн ЗДТГ, ГХУСАЗСЗ

<sup>48</sup> <http://ulaanbaatar.mn/content/show/18112>

	таниулах сурталчлагааг тараан өгч, үр дүнг тооцох		
10.	ГХУСТХ, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хуульд заасан төрийн албан байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэгтгэж уялдуулж өгөх, ГХУСТХ-д иргэн байгууллага, аж ахуй нэгжүүд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хүлээх үүргийг заасан тул үүний дагуу арга хэмжээ авах, шаардлага хүргүүлдэг механизмтэй байх	Тогтмол	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
11.	“Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, иргэд, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 96 аж ахуйн нэгж, байгууллагатай түншлэлийн гэрээ байгуулж “Гэмт хэргээс урьчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх үйл ажиллагаанд идэвх санаачлагатай ажилласан иргэд байгууллагын урамшуулах тогтолцоог бий болгох” ажлыг эхлүүлэх	Тогтмол	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
12.	Гэмт хэргээс урьчилан сэргийлэх ажилд идэвх зүтгэл гаргаж ГХУСТХ-н 10.1.3-т тогтоосон иргэний үүргээ биелүүлсэн иргэн, байгууллагыг идэвхжүүлэх зорилготой урамшууллын тогтолцоог илүү тодорхой болгож эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай нь 2015 онд 2 иргэн урамшуулсан үзүүлэлтээр илэрхийлэгдэнэ. Энэ талаар бусад дүүрэг болон гадаадын улс орны туршлагаас судлах. Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэдээс мэдээлэл авах үйл ажиллагаанд иргэдийн аюулгүй байдлыг хангаж, хамгаалах асуудлыг онцгой анхааран ажиллах механизмыг бүрдүүлэн ажиллах	2017 оноос	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
13.	Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтсийн түр саатуулах байр нь 3 дугаар хороо Уурхайн нийтийн байрны 1 давхарт байралдаг бөгөөд хоногдоо 6-16 хүнийг хүлээн авч саатуулдаг, согтуугаар ирсэн хүмүүс чимээ их гаргаж агсам согтуу тавьдаг, архи, согтууруулах ундааны үнэр их байдаг. Гэтэл тухайн нийтийн байранд 54 өрхийн 170 иргэн амьдардаг тул иргэдийн амар тайван байдлыг хангах зорилгоор “Түр саатуулах байр”-г стандартын дагуу тусад нь барьж ажиллуулах	2017 оноос	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
14.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоотойгоор интернэт, мэдээллийн технологийг ашиглах тухай заалтын хувьд ч иргэдийн оролцоог ашиглахдаа мэдээллийн аюулгүй байдлыг нь хангах, тогтмол гэмт хэргийн гомдол, мэдээлэл хүлээн авдаг <b>web site</b> ажиллуулж, утсан сүлжээг тогтмолжуулах арга хэмжээ авахдаа иргэдийг урамшуулдаг тогтолцоог тодорхой болгосноор тэдний энэ ажилд оролцох идэвхийг нэмэгдүүлэх	2017 оноос	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
15.	Хил залгаа аймаг, сумдын засаг захиргааны хамтын ажиллагааны хэлбэр, төрлийг өргөжүүлэх	Тогтмол	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
16.	Цаашид хөршийн холбоог сайжруулах дээрх ажиллагаанд гэр хорооллын өрхүүдийг бүлэг болгон	2017 оноос	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ

	хөршийн холбоод нийтэд нь байгуулан, үйл ажиллагааг нь тогтмолжуулж, үр дүнг улирал тутамд тооцож ажиллах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хороодод хөршийн холбоо байгуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Хөрш” ажиллагааны төлөвлөгөө гаргаж дүүргийн Засаг даргаар батлуулан эхлүүлэх.		
17.	Нийтийн хэв журмын урамшуулалтай эргүүл, олон нийтийн Цагдаагийн орон тоог нэмэгдүүлж, урамшууллын хөлсийг хороодын Засаг дарга, цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн шийдвэрлэх ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт иргэдийн урамшуулалтай эргүүл ажиллуулсан тоон мэдээ байгаа боловч хүн ам харьцангуй өсөж байгаа дүүргийн хувьд хангалтгүй. Иймд цаашид Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль болон ГХУСТХ-н 12.1.2-т зааснаар 12.3-т дүүргийн ИТХ-с хэв журмын урамшуулалтай эргүүл, олон нийтийн байцаагчийн тоо болон урамшууллын хэмжээг хангалттай хэмжээнд тогтоож энэ үйл ажиллагааг тогтмолжуулах нь зүйтэй. Эргүүлд аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан албан хаагчдыг татан оролцуулах, урамшуулал олгох, хэрэгжилт, үр дүнг тооцон ажиллах заалтын хувьд сургуулийн орчинд бага насны хүүхдийг хуурч мэхлэн эд зүйлийг нь авах, дээрэмдэх, булаах, айлган сүрдүүлэх, архидан согтуурах, мансуурахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Багш нарын нийтийн эргүүл”-г 7 хоногийн баасан гарагуудад 19:00 цагаас 22:00 цагийн хооронд зохион байгуулах нь хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй ажил болох тул цаашид энэ ажлын тоо, чанарт анхаарч тогтмолжуулж	2017	Багануур дүүргийн ЗДТГ
18.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд нийтийн тээврийн болон таксины жолооч, зочид буудлын ажилтнууд зэрэг бусад хувийн хэвшлүүдийг татан оролцуулж идэвхтэй хамтрах ажлыг зохион байгуулах	2017	Багануур дүүргийн ЗДТГ
19.	Багануур хот нь стратеги бодлогын түвшиний судалгааг хийлгүүлэх шаардлагатай, үүнд аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах	2017	Багануур дүүргийн ЗДТГ
20.	Иргэдээс гэмт хэрэг, зөрчлийн талаарх өгсөн мэдээллийг төлбөртэйгээр авах, үнэлэх тогтолцоог дүүргийн хэмжээнд жишиг байдлаар нэвтрүүлэх, үүнд мөнгө төсөвлөж, зарцуулах		Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
21.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас мөрдүүлж буй “Эрүүл аюулгүй байдлын индекс”-т хамаарах хувь хүний аюулгүй байдлын үзүүлэлт, улмаар гэмт хэрэг, зөрчлийн хүчин зүйл болдог үзүүлэлтийг сайжруулах ажлыг бодлого, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх	Тогтмол	Багануур дүүргийн ЗДТГ
22.	Багануур дүүргийн гэмт хэргийн статистикийн судалгааг жил бүр сүүлийн 5 жилийн байдлаар хийж, Дүүргийн удирдлагад танилцуулж, сайтаар нийтийн хүртээл болгож байх, Нийслэлийн	Жил бүр	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ, Статистикийн хэлтэс

	Статистикийн хэлтсээс хуулийн байгууллагатай нягт хамтран ажиллах		
	<b>Төлөвлөлтийн тогтолцоо /planning system/ бүрдүүлэх. Жижиг хотын аюулгүй байдлыг хангах асуудлыг (Small city policing) хотын дэд бүтэц, төлөвлөлт, бүтээн байгуулалтыг хийхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс</b>		
23.	урьдчилан сэргийлэх асуудлыг заавал давхар авч үзэх, хотын төлөвлөлт, ирээдүйн бодлогод гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлыг тогтмол авч үздэг байх, шинээр баригдаж байгаа хорооллол, барилга байгууламжид нэмэлт шаардлага тавих	Тогтмол	Багануур дүүргийн ЗДТГ
	<b>“Гэрэлтэй Багануур хөтөлбөр” боловсруулж хэрэгжүүлэх.</b>		
24.	- Захын гудамж талбай болон авто замын гэрэлтүүлэггүйн улмаас гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдэж байна. Өнөөдөр 2015 онд үйлдэгдсэн гэмт хэргийн 45-50 хувь нь оройн 22:00 цагаас өглөөний 06:00 цагийн хооронд үйлдэгдэж байна.	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ
	Байгууллага, өрх бүрийг хаягжуулах, <b>“Хаягжилт”</b> төсөл хэрэгжүүлэх;		
25.	- Дүүргийн иргэний бүртгэлийн ажилтан, хороодын нийгмийн ажилтнууд хамтран дүүргийн хүн амын болон дүүргийн нутагт оршин суугчид, шилжилт хөдөлгөөний бүртгэл хаягжуулалтын судалгааг нарийвчлан гаргах. Мэдээллийн сан нь цагдаагийн байгууллага болон бусад хууль сахиулах байгууллагатай харилцан холбоотой хамтран ажилладаг байх. Ялангуяа түр оршин суугчид, орон гэргүй тэнэмэл хүмүүс, архи, мансууруулах бодисонд донтсон хүмүүсийг анхааралдаа авч бүртгэлжүүлэх, хянах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Бүртгэлийн хэлтэс, Хороодын Засаг дарга
	- Хороод, бүртгэлийн ажилчдын чадавхийг сайжруулж, албан бус оршин суугч хүн амын бүртгэлийг бодитой гаргаж, судалгаанд хамруулах,		
26.	Орон сууц, байрны хаалгыг коджуулах, ингэснээр орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх. Гадаад орны туршлагаас үзвэл барилга байгууламж дахь кодыг сайжруулах нь эд хөрөнгийн өмчлөгч нарт өөрсдийн эд хөрөнгийг хариуцлагатай эзэмшихэд тусалдаг бөгөөд гэмт хэрэг үйлдэх явдлыг багасгаж өгдөг байна. Камержуулсан, кодолсон байранд хуучны байртай харьцуулахад орон байрны хулгайн гэмт хэрэг гарах нь бага байдаг нь олон оронд нотлогдсон байдаг.	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Бүртгэлийн хэлтэс, Хороодын Засаг дарга
	<b>Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн хэмжээг багасгах,</b> экспортыг түлхүү бодлоор дэмжих, Согтууруулах ундааг худалдаалдаг, түгээдэг, үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллагуудыг цөөлөх		
27.	-дүүргийн архинд донтсон хүнийг сайн дурын болон албадан эмчилгээ үйлчилгээгээр хангах, тусгайлан сургалтаар тэдний бодит амьдралын түүхийг яриулах зэрэг арга хэмжээ авснаар гэмт хэргийн гаралт болон тээврийн ослыг бууруулахад	Тухай бүр	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн хэлтэс

	<p>чухал нөлөө үзүүлэх боломжтой.</p> <p>-Залуучуудад зориулсан “архигүй” орчинг бий болгож, үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран олон нийтэд сурталчлах ажлыг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх,</p> <p>-Архи, согтууруулах ундааг худалддаг, үйлчилдэг дэлгүүр, цэнгээний газруудад зөвшөөрөл олгохдоо тэгээрийн байршил, хоорондын зайг зохистой байхаар зохицуулах, согтууруулах бүтээгдэхүүнээр үйлчлэх, худалдах хугацааг богиносгож, өдрийг цөөрүүлэх асуудлыг дүүргийн удирдлагын зүгээс шийдвэрлэх</p>		
28.	<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчилж олон нийтэд сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хороодын Засаг дарга, нийгмийн ажилтан нартай хамтран хорооны иргэдийн дунд хуулийг ухуулан таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулж байгаа боловч ямар сургалт нь үр дүнтэй байгаа нь тодорхой бус байгаа тул гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эрсдэлд орсон, гэр бүлийн хүчирхийлэлд өртөх магадлалтай хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах, тэдний хуулийн мэдлэгийг өргөжүүлэн нэмэгдүүлэх тал дээр илүү анхаарч тэдэнд мэргэжлийн хуульч, сургагч багш нартай хамтран албан бус сургалтыг тогтмолжуулж зохион байгуулах шаардлагатай. Энэ ажил дээр хууль эрх зүйн чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах тухайлбал, Хууль сахиулахын их сургууль, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн сургагч багш нарыг урьж ажиллуулах зэргээр илүү үр дүнтэй байдлаар ажиллах нь зүйтэй.</p>	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Гэр бүл, хөгжлийн хэлтэс
29.	<p>Хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэхэд зориулсан үйлчилгээний хэлбэрүүдийг өргөжүүлж, цахим тоглоомын газар, интернет төвүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хамтран ажиллана гэсэн заалтын хүрээнд хийгдсэн ажлын хувьд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй цахим тоглоом, интернет төвүүдийн мэдээллийн сан бүрдүүлж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж, хууль тогтоомж зөрчсөн газрын үйл ажиллагааг хязгаарлах, интернет тоглоомд донтохоос хүүхэд залуучуудыг сэргийлүүлэх арга хэмжээг цаашид авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн ЭМН-тэй хамтран ЕБС-н дунд болон ахлах ангийн сурагчдад интернэт тоглоомонд донтох болон хор уршгийн талаар хамтарсан сургалт зохион явуулсан боловч цаашид бусад ЕБС болон хүүхэд залуучуудыг хамруулах</p>	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Гэр бүл, хөгжлийн хэлтэс
30.	<p>Архи тамхины хяналт болон соёлтой хэрэглээг төлөвшүүлэх үйл ажиллагаанаас гадна мансууруулах бодисын хэрэглээг хянах арга хэмжээ авах, түүний хор хөнөөлийг сурталчлах. Сүүлийн үед хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ</p>	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн хэлтэс



	<p>нийслэлд ихээхэн газар аваад байгаа бөгөөд 2011 оны НҮБ-н Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас (UNODC) гаргадаг тайланд Монгол Улс каннабисын өргөн тархалттай, героин, кокаин, экстазийн тархалттай оронд хамаарах болсон ба 2011 оны судалгаагаар 16000 хэрэглэгч манай улсад байна. Түүнчлэн АНУ-д үйлддэгдэг нийт гэмт хэргийн ихэнх хувь нь ямар нэгэн байдлаар хар тамхи, мансууруулах бодистой уялдан гарч байна. Иймд дүүргийн хэмжээнд хар тамхи мансууруулах бодистой тэмцэх чиглэлээр арга хэмжээ авах шаардлагатай.</p>		
31.	<p>Сургууль, цэцэрлэгийн орчинд зам тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана гэсэн заалт нь ЕБС-н хүүхдийг зам тээврийн ослоос сэргийлсэн сурталчилгааны хичээлийг ЗЦТ-тай хамтран сургалт зохион байгуулсан, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, явган зорчигчдын хөдөлгөөнд оролцох сахилга соёлыг дээшлүүлэх, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний ачаалал ихтэй цэг, уулзваруудад Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллах туслах ажилтанг гэрээгээр ажиллуулах зэрэг ажлыг хэрэгжүүлэх, сургууль цэцэрлэгийн орчинд зам тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад зөвхөн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа бус орон нутгийн захиргааны байгууллага бусад ААНБ-н хамтын ажиллагааны үр дүн байдаг. АНУ-д “Нөхцөл байдлын урьдчилан сэргийлэх арга” гэж тооцогддог ба эдгээр орчныг аюулгүйжүүлснээр аюулгүй орчин, аюулгүй бүтээгдэхүүн бий болгож гэмт хэргийг бууруулна гэж үздэг.</p>	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Гэр бүл, хөгжлийн хэлтэс
32.	<p>Ял эдлүүлж буй механизмыг сайжруулах, тухайлбал цагаар ажил хийлгэх ялыг хотын хөгжилд үр ашигтай байдлаар хэрэгжүүлэх, энэ чиглэлээр Шүүхийн шийдвэр, Нийтийн үйлчилгээний албыг хамтран ажиллуулах (зам арчилгаанд дайчлах, хог цэвэрлэгээ гэх мэт);</p>	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба
33.	<p>Хорих ангид ЕБС-н зан байдлын доголдолтой, хэрэг зөрчилд холбогдсон хүүхдүүдийг зочлуулж хорих ангийн бодит байдлыг мэдрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх (Энэ арга нь АНУ-д анх үүсч, БНСУ, Энэтхэг зэрэг олон улсад нэвтэрсэн арга)</p>	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба
34.	<p>Дүүргийн хэмжээний ЕБС-н зарим сурагчыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон цагдаагийн байгууллагатай хамтран хорих ангийн бодит байдлыг мэдрүүлэх хөтөлбөрт хамруулснаар тухайн хүүхдийг ирээдүйн гэмт хэрэгтэн болохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Гэмт хэрэгт холбогдох эрсдэл бүхий бүлгийн болон захиргааны зөрчилд шийтгүүлсэн насанд хүрээгүйчүүдийг энэхүү хөтөлбөрт хамруулж байсан ба тус ажлын хүрээнд 1978 онд “Айсан хүн” нэртэй баримтат киног хүртэл хийж байсан. Өмнөд Каролина мужийн томоохон хорих ангиудад насанд хүрээгүйчүүдийг зочлуулж хорих ангийн бодит байдал, тэрхүү хүнд</p>	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба

	хэцүү амьдралыг мэдрүүлэх энэхүү хөтөлбөрт нийт 8000 гаруй хүүхэд хамрагдсан байдаг.		
35.	Эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, төв, их, дээд сургууль, төрийн бус байгууллага, судалгааны байгууллагуудын оролцоог дэмжих, тэдний шинэлэг саналуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ашиглах /Think thank/;	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, ГХУСАЗСЗ ХСИС
36.	Багануур дүүргийн хууль сахиулах байгууллагууд болон “ХСИС хамтран клиник сургалт, бүсийн сургалтуудыг явуулах” түшиц газар байгуулж, Хууль сахиулахын их сургуультай “судалгаа, сургалт, инновацийн бүтээгдэхүүн туршин үйлдвэрлэх” хэлбэрээр нятгт хамтран ажиллах	2017 оноос	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ, Хууль сахиулах байгууллагууд, ХСИС
37.	Хэвлэл, мэдээллийн байгууллага, телевизийн нийгмийн хариуцлага, ухамсрыг дээшлүүлэх, хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлөх мэдээлэл, нэвтрүүлэг түгээхгүй байх, Сургалт, соён гэгээрүүлэх, мэдлэгжүүлэх, хүмүүжлийн чиглэлээр түлхүү явуулах;	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, ГХУСАЗСЗ
38.	Аюулгүй байдлыг хангах, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэн телефоны оператор компаниудтай (Mobicom, Skytel, Unitel, G-Mobile гэх мэт), түүнчлэн хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах -жишээ нь: Дүүргийн бүс нутагт нэвтрэн ороход аюулгүй байдлаа хангаж явахыг сануулсан захидал ирүүлдэг байх	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ
39.	Хүүхдийн хүмүүжил, ухамсар сэтгэхүйг сайжруулахад үйл ажиллагааг чиглүүлэх; • Цэцэрлэг, сургуульд бага насны хүүхдүүдийн хүмүүжилд нь анхаарах; • Боловсролын салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх; • Цэцэрлэг, сургуулийг олноор төлөвлөлттэйгээр тархаан байгуулах; • Боловсролын байгууллагын мэргэжилтнүүдийг нэмэгдүүлэх;	Тогтмол	Багануур дүүргийн ЗДТГ, Боловсролын хэлтэс
40.	ГХУСАЗСЗ-с гаргасан сургуулийн орчимд үүрэг гүйцэтгэх “School police” эргүүлийн ажиллах журмыг ЕБС, цэцэрлэгүүдэд хэрэгжүүлэх	Тогтмол	Багануур дүүргийн ЗДТГ, Боловсролын хэлтэс
41.	<b>Аюулгүй орчин бүхий сургуулиудыг бий болгох.</b> Зам тээврийн хөдөлгөөн төдийгүй сургуулийн барилга байгууламж, талбайн загвар дизайн, засвар үйлчилгээ зэргийг сайжруулахад дүүргийн удирдлагын зүгээс хамтран ажиллах нь зүйтэй. Насанд хүрээгүй хүмүүс гэмт хэрэгт өртөх явдал ихэссэн өнөөгийн нийгэмд сургуулийн орчинг аюулгүйжүүлэх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэн чухал асуудлын нэг болдог.	Тогтмол	Багануур дүүргийн ЗДТГ, Боловсролын хэлтэс
42.	ЕБС-н орчинд гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлж, ахлах ангийн сурагчдыг зохион байгуулан өсвөрийн цагдаа клуб байгуулан ажиллах	Тогтмол	Багануур дүүргийн ЗДТГ, Боловсролын хэлтэс, сургуулиуд
43.	Иргэдийн <b>бухимдал, стрессийг арилгах</b> зорилгоор Нийгмийн сэтгэлгээг өөрчлөх менежмент	Тогтмол	Багануур дүүргийн ЗДТГ, Гэр бүл,

	хийх зайлгүй шаардлагатай байна. <b>Сэтгэл судлалын төв, төрийн бус байгууллагыг дэмжиж, иргэдийг соён гэгээрүүлэх талаар хамтран ажиллах;</b> <ul style="list-style-type: none"> <li>• Нийгэмд буй бухимдал, стрессийг багасгах шинэ менежмент хийх;</li> <li>• Нийгэм, амьдрал өөрөө системээр гэр бүлд нөлөөлсөнөөс үүдэн хүчирхийлэл бий болж байна.</li> </ul>		хүүхдийн хөгжлийн хэлтэс
44.	НҮБ-н Хүн амын сангийн 2015 оны тайланд дэлхийн хүн амын 52 хувь нь том хотуудад, 47.6 хувь нь дагуул болон хаяа хотуудад, 0.4 орчим хувь нь алслагдсан сууринд амьдарч байна гэж дүгнэсэн. Иймд томоохон хот, дагуул хотуудад хүн ам төвлөрөх тусам сэтгэл гутрал, уур бухимдал, амьдралын хэрэгцээнээс үүдэлтэй бэрхшээлүүд улам нэмэгддэг тул зөвхөн зөрчил гаргагч төдий бус хохирогч тэр ч бүү хэл хууль сахиулагчид, засаг захиргааны, үйлчилгээний ажилтан нарт сэтгэл зүйн болон буруу зан төлөв, зуршлаас татгалзах чиглэлийн албан болон албан бус сургалтуудыг мэргэжлийн сэтгэл зүйч, сэтгэц оношлогч эмч, шашны байгууллага, бусад олон нийтийн байгууллагын мэрэгжилтэн нарыг урьж <b>“тусгай хөтөлбөр”</b> сургалтыг тогтмол зохион байгуулах	Тогтмол	Багануур дүүргийн ЗДТГ, Гэр бүл, хүүхдийн хөгжлийн хэлтэс
45.	Багануур дүүрэг нь байгалийн унаган төрхийг хадгалан байгаа бүс нутаг төдийгүй хөдөө аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлал, зүүн бүсийн автозамын хөдөлгөөний идэвхжилтэй дамжин өнгөрөх уулзвар тул Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор малчид, анчид, байгаль хамгаалагч, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах тусгай <b>“хөтөлбөр”</b> хэрэгжүүлэх	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн хэлтэс
<b>Хоёр. Багануур дүүргийн хууль сахиулах байгууллагуудыг чадавхжуулах чиглэлээр:</b>			
46.	Багануур дүүргийн хөгжлийн бодлоготой уялдуулан <b>Цагдаагийн хэлтсийг</b> өргөжүүлэх, мэргэшсэн хүний нөөцөөр бэхжүүлэх асуудлыг одооноос судалж, холбогдох шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангалт хийж, орон тоог нэмэгдүүлэх -Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолд нийцүүлэх	2017	Багануур дүүргийн ЗДТГ, Цагдаагийн Ерөнхий газар
47.	Багануур дүүргийн хөгжлийн бодлоготой уялдуулан <b>Цагдаагийн хэлтсийн байрыг шинэчлэн бариулах</b> хөрөнгийг асуудлыг шийдвэрлэх	2017	Багануур дүүргийн ЗДТГ, Цагдаагийн Ерөнхий газар
48.	Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр, Багануур дүүргийн хөгжлийн бодлого, чиг хандлагатай уялдуулан <b>“Багануур дүүрэг дэх Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги”</b> боловсруулж, хэрэгжүүлэх	2017-2028 он	Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс
49.	Албаны, мэргэжлийн, ажлын байрны орчинд сэтгэл зүйн бэлэн байдал, албаны бэлтгэлийг хангах зорилгоор эрх зүй, эдийн засаг, нийгэм соёлын чиглэлээр хууль сахиулагч, гэмт хэргээс	2017	Багануур дүүргийн ЗДТГ, ГХУСАЗСЗ

	урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий ажилтнуудад шат дараалсан сургалтыг зохион байгуулах		
50.	Дүүргийн хэмжээнд хамгийн ихээр үйлдэгдэж буй гэмт хэргийн төрлийг тодорхойлж, ГХУСТХ-н 6.3-т зааснаар тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх. Эдгээр гэмт хэрэгт өмчлөх эрхийн эсрэг, хүний амь бие эрүүл мэндийн эсрэг, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг. Тухайлбал: Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, хулгайлах, танхайрах, зам тээврийн осол, хар тамхи, гэр бүлийн хүчирхийлэл, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэх мэт. Хулгай, Илрүүлэлт, Анчин нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, ажиллах	2017 оноос	Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс
51.	Иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, мэдээлэл бүрийг бүртгэлдээ оруулж, бодит нөхцөл байдлыг илэрхийлэхэд анхаарч ажиллах	2017 оноос	Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс
<b>Гурав. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажлыг сайжруулах чиглэлээр:</b>			
52.	Байцаан шийтгэх ажиллагааны бланк нэгэн хэвийн бус, тогтсон загвар байхгүй байгаа нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар өөр өөр тогтоол, санал үйлдэж, улмаар ЭБШХ зөрчигдөх үндэс болж байгаа тул цагдаагийн байгууллагын хэмжээнд нэгдсэн загварыг гаргаж, хэрэгжүүлэх	2017 оноос	ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
53.	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад зайлшгүй дагаж мөрдөх дүрэм, журам, гаргаж байгаа хэдий ч тухайн дүрэм, журмыг хэрэгжүүлэх тоног төхөөрөмж, нөхцөл бололцоогоор хангахгүй байгаа нь эрүүгийн хэрэг, гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж байгаа тул хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах тоног төхөөрөмжийг шийдвэрлэх	2017 оноос	ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
54.	Алба хаагчдын үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа компьютер болон бусад техник хэрэгсэл хуучирсан, бичиг хэрэг болон бусад төрлийн зардал бага байгаа тул техник хэрэгслийг шинэчлэх, бичиг хэрэг болон бусад төрлийн зардлыг нэмэгдүүлэх;	2017 оноос	ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
55.	Улаанбаатар хотын төвийн дүүргүүдэд жижүүрийн мөрдөн байцаагчийн орон тоог баталсан боловч алсын дүүргүүдэд тухайн орон тоог батлаагүй нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт өдөр тутмын ажил хийхийн хажуугаар жижүүрийн үүрэг гүйцэтгэж, улмаар жижүүрээс буусан өдрөө амарч чадахгүй ажил үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. Иймээс хойшлуулшгүй ажиллагаа, ялангуяа хэргийн газрын үзлэгт мэргэшсэн жижүүрийн мөрдөн байцаагчийн орон тоог нэмэгдүүлж, батлуулах	2017 оноос	ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
56.	Сүүлийн жилүүдэд БША-ны зардлыг төрөөс баталж өгөөгүйн улмаас эрүүгийн хэрэгт хөрөнгө мөнгө шаардсан ажиллагаа хийгдэж чадахгүй, гадны мэргэшсэн байгууллагаар шинжилгээ хийлгэх болон бусад төрлийн нотломж бүрдүүлэх ажиллагаа хийлгэхэд хүндрэл ихээхэн тулгарч байгаа тул	2017 оноос	ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх

<b>ЭБША-ны зардлыг шийдвэрлүүлэх</b>			
57.	Цагдаагийн алба хаагч, түүний дотор хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар байнгын стресст ордог учир Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэст мэргэшсэн сэтгэл зүйчийг ажиллуулах;	2017 оноос	ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
58.	Алба хаагчдын албаны сургалтын чанарыг сайжруулах зорилгоор үе шаттай сургалтыг тогтмол ажлын байранд мэргэшсэн багшаар оруулдаг болох	2017 оноос	ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх

**Дөрөв. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:**

59.	Багануур дүүрэгт <b>“Зүүн бүсийн цахилгаан түгээх сүлжээ”, “Багануур уурхай”, “Мон маг”</b> хими болон уурхайн тэсэрч дэлбэрэх бодис бэлтгэх, ашиглах байгууллага нь энгийн харуул, манаагаар аюулгүй байдлаа хангуулж байгаа нь улсын аюулгүй байдлыг алдагдуулж болзошгүй нөхцөл байгаа тул <b>эдгээр газруудыг улсын онц чухал объектын хамгаалалтын жагсаалтад оруулж, цагдаагийн байгууллагын хамгаалалтанд авах</b> асуудлыг судалж, шийдвэрлэх	2017 оноос	Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс, ЦЕГ-т санал хүргүүлж шийдвэрлүүлэх
60.	Олон нийтийн аюулгүй байдлын хангах хэсгийн харуулын цэгүүдэд ашиглагдаж байгаа богино долгионы радио станцуудыг шинэчлэх, дахин дамжуулагчаар хангах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
61.	Хамгаалалтын объектуудыг иж бүрэн дохиолол, камерын хяналтанд авах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
62.	Тусгай хэрэгслээр алба хаагч нэг бүрийн тоогоор хангах, одоогоор нөөцгүй байгааг анхаарч, шийдвэрлэх	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх

**Тав. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:**

63.	Авто машины түгжрэл бий болох учраас хотын замын зохион байгуулалтыг хийж өгөх	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ
64.	Дүүргийн хэмжээнд авто зогсоолыг сайжруулах. Зогсоолуудын зохицуулалт, хяналт, ашиглалт ба нийтийн эзэмшлийн зогсоолын тоног төхөөрөмжийн аюулгүй байдал нь замын хөдөлгөөнд ихээхэн нөлөө үзүүлдэг бөгөөд энэ нь тээврийн хэрэгслүүдийн аюулгүй байдалд мөн нөлөөлдөг. Ялангуяа автомашины хулгайн гаралт өндөртэй хороодыг анхааралдаа авч, тэдгээр хороонд авто зогсоолуудыг шинээр бий болгох нь шаардлагатай.	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ
65.	Дамжин өнгөрдөг болон бүс нутаг дамнан амьдардаг хөдөлгөөний эрчимийг тооцоолох тогтолцоог бий болгох,	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ
66.	Багануур дүүргээс Улаанбаатар хот явах замд байнгын хяналтын постод ажиллах, мөн Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Төв аймгийн Мөнгөнморьт, Баяндэлгэр сумдад гарсан зам тээврийн осол, хэргийн дуудлагыг хүлээн авч шийдвэрлэх, тухайн сумдад урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шалгалт явуулахад хүн, хүч дутмаг зэргээс шалтгаалан тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавихад алба хаагчдын хүрэлцээ хангалтгүйгээс орон нутгийн замд гардаг осол,	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх

	<p>хэргийн гаралт өдөр бүр нэмэгдэх хандлагтай байна. Улсын хэмжээнд 1 алба хаагчид 300 тээврийн хэрэгсэл ногдох норматив байхад тус тасгийн хэмжээнд дүүргийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байгаа болон дүүрэгт хөдөлгөөнд оролцож байгаа “УБ” серийн улсын дугаартай тээврийн хэрэгслийг оруулахгүйгээр зөвхөн “БРА” серийн улсын дугаартай тээврийн хэргслийн тоо 5850 байна, мөн дүүргийн нутаг дэвсгэрээр хоногт дайран өнгөрч буй тээврийн хэрэгслийн тоо нэг хоног буюу 24 цагийн туршид тооллого хийхэд давхардсан тоогоор 1550-1680 тээврийн хэрэгсэл өнгөрч байна. Иймд 1 алба хаагчид 490 тээврийн хэрэгсэл ноогдож байгаа зэргийг харгалзан Дүүрэгт хүн ам, тээврийн хэрэгслийн тоо эрчимтэй өсөж байгааг харгалзан алба хаагчдын ажлын ачаалалыг бууруулах, орон нутгийн замд тавих хяналтыг сайжруулах, хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажилд хүн хүчийг ашиглах, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор ЗЦТ-н алба хаагчийн 4-с доошгүй орон тоог нэмэгдүүлэх</p> <p>- Дархан цаазтай Бурхан халдун уул руу хууль бусаар аялагчдыг хянах шаардлага зайлшгүй тулгардаг.</p>		
67.	<p>Дүүргийн болон орон нутгийн замд автомашинаар хөдөлгөөнт эргүүлээр хяналт шалгалт хийх, мал хулгайлах болон байгаль орчны эсрэг гэмт хэргийг илрүүлэх зорилгоор хяналтгүй баталгаат бус авто замуудад хяналт шалгалт хийх, гэмт хэргийг хурдан шуурхай илрүүлэх чиглэлээр хоногт 288 км зам туулахад шаардагдах шатах, тослох материалын лимитийг нэмэгдүүлэх</p>	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
68.	<p>Тасгийн хэмжээнд хөдөө орон нутгийн замд хамгаалалт болон арга хэмжээний үед ажиллахад тохиромжтой туулах чадвар сайтай автомашин, зөөврийн хяналтын цэг /чиргүүл/, тээврийн хэрэгсэл албадан зогсоох зараа, тусгай дуут дохиогоор тоноглогдсон мотоцикль, согтуурал шалгагч танадагч багаж, замын нөхцөл байдлын талаар болон жолооч зорчигч нарт мэдээлэл өгөх цахилгаан самбар зэрэг техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах</p>	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
69.	<p>Мотоцикльтой холбоотой зам тээврийн осол хэргийг бууруулах үүднээс дүүргийн болон орон нутгийн замд мотоцикльт хөдөлгөөнт эргүүл ажиллуулах шаардлагатай байгаа тул албан ажлын хэрэгцээнд зориулж тусгай дуут гэрэл дохио бүхий 2 ширхэг мотоциклоор хангуулах саналыг дүүргийн төр захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх</p>	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
<b>Зургаа. Мэргэжлийн хяналтын байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр:</b>			
70.	Дүүргийн хэмжээнд архи, согтууруулах ундаа	2017	Багануур дүүргийн

	худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоо дүүргийн хүн амын тоотой харьцуулахад 14 дахин их байна. Иймд тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоог бууруулахад холбогдох байгууллагатай хамтрах ажиллах	оноос	ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс
71.	Архи, согтууруулах ундаагаар үйлчилдэггүй 1, 7, 20-ны өдрүүдэд гар дээрээс архи худалдаалах зөрчил гарч байгаа тул үүнд тавих хяналтыг сайжруулах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс
72.	Архи, согтууруулах ундаа худалдаалах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгүүдэд хамтран сургалтыг үр дүнтэй зохион байгуулах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс
73.	Зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт зөвшөөрөлгүй ил задгай худалдааг гар дээрээс худалдах явдал их гарч байгаа тул хяналт шалгалтыг сайжруулах, чангатгах, Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс
74.	Хууль бусаар модны тээвэрлэлт, боловсруулалтын байдалд цагдаагийн байгууллагатай хамтран хяналт шалгалтыг сайжруулах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс
75.	Хууль бусаар нэн ховор, ховор болон агнуурын амьтан агнаж байгаатай хийх тэмцлийг эрчимжүүлж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг сайжруулах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс
76.	Багануур дүүргийн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллага, хороодын гадна талбай гэрэлтүүлгийг сайжруулахад болзолт уралдаан гарган, хэрэгжүүлэх	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс
77.	Хэрлэн худалдааны төвийн урьд талбайн явган хүний зам дээрх автомашиныг журманд оруулах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Цагдаагийн хэлтэс
78.	Гамшгаас хамгаалах, газар хөдлөлт, зам гүүр нурах, үер, ган зуд, хөлдөлт, бороо болон цасан ба шороон шуургатай тэмцэх талаар хууль сахиулах албаны үйл ажиллагаа, авто замын бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн голомт бүхий газарт орон тооны бус удирдлагын болон мэргэжлийн багийн томилгоот бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадвар, сэтгэл зүйн бэлтгэлийн чадварыг сайжруулах, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгоход харилцан ажиллах шуурхай ажиллагааны бэлэн байдлыг хангах зорилготой сургалт зохион байгуулах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Онцгой байдлын хэлтэс
79.	Байгаль орчин, болзошгүй гамшгын үед хууль сахиулах байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааны талаар сургалт явуулах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Онцгой байдлын хэлтэс
80.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон улс, гадаадын болон үндэсний <b>донор байгууллагаас санхүүжилт авах санаачилга</b> гаргаж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	2017 оноос	Бүх байгууллага

---

81.	<p>Гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгаж, эцэслэн шийдвэрлэх, хүний эрхийг баталгаатай хангах болон урьдчилан сэргийлэх ажилд <b>өмгөөллийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэж байгаа иргэд, байгууллагыг оролцуулсан</b>, хамтран ажилласан талаар гаргасан тайлан бүртгэл хангалтгүй байгааг цаашид анхаарч ажиллах шаардлагатай.</p>	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Хуулийн хэлтэс
-----	--	---------------	--



**“БАГАНУУР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ: ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ” СЭДЭВТ ОНОЛ, ПРАКТИКИЙН АНХДУГААР БАГА ХУРЛААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ**

2016.07.06

Багануур дүүрэг

Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсээс санаачлан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс, Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнтэй хамтран **“Багануур дүүргийн иргэдийн аюулгүй байдал: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам”** сэдэвт онол,практикийн анхдугаар бага хурлыг 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдөр “Өргөө” соёлын төвд амжилттай зохион байгуулав.



Тус онол, практикийн анхдугаар бага хуралд Улаанбаатар хотын цагдаагийн газар, Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэн, хөрш зэргэлдээ Хэнтий аймаг, Төв аймаг, Баянзүрх дүүрэг, Налайх дүүргийн хууль хяналтын байгууллага, Багануур дүүргийн нутгийн захиргаа, хууль хяналтын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, хөршийн хяналтын бүлгийн төлөөлөл, иргэд зэрэг нийт 200 гаруй хүн оролцов.

Онол, практикийн анхдугаар бага хурлаас тус дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, уг ажилд төр захиргаа, хууль хяналтын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулах, тэдний хамтын ажиллагааг сайжруулах, Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 126 дугаар тогтоолоор батлагдсан “Хөршийн хяналт хөтөлбөр”, кримнологи судалгааны үр дүнг ажил хэрэг болгох зорилгоор дараах **ЗӨВЛӨМЖ**-г гаргаж байна. Үүнд:

### 1. Багануур дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд

1. Мэргэжлийн судалгааны байгууллагаар захиалгаар гүйцэтгүүлж буй Багануур дүүргийн криминологи судалгааны тайланд туссан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2. “Гэмт хэрэг зөрчилгүй хамт олон, гэмт хэрэг зөрчилгүй орчин бүрдүүлэх” аянг дүүргийн ерөнхий боловсролын сургууль, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд жил бүр зохион байгуулан шалгаруулж урамшуулах ажлыг зохион байгуулах;

3. Архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдож байгаа иргэдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Архигүй Монголын төлөө” үндэсний сүлжээтэй хамтран тодорхой арга хэмжээ зохиох;

4. Гэмт хэрэг илрүүлэх ажиллагаанд дэвшилтэт техник, технологи, зарим гадаадын орнуудын туршлагыг нэвтрүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр төсөвт тусгуулж шийдвэрлэж байх;

5. Согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллагын ажиллах цагийн хуваарийг өөрчлөн багасгах асуудлыг судлах.

### 2. Багануур дүүргийн засаг даргын тамгын газарт

1. Дүүргийн Засаг даргатай байгуулж байгаа удирдлагуудын үр дүнгийн гэрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн хөтөлбөр, төлөвлөгөөний үр дүнг тооцдог байх багц заалт оруулах;

2. Хөршийн хяналт хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулж, орц, гудамжны ахлагчаар ажиллах иргэдийн нэрсийг СӨХ болон хэсгийн ахлагч нартай хамтран гаргаж, урамшуулал олгох асуудлыг судалж шийдвэрлүүлэх;

3. Хороодтой хамтран “Сайн хөрш” арга хэмжээг зохион байгуулах;

4. Олон нийтийн цагдааг сонгон шалгаруулж, ажиллах нөхцөл, боломжоор хангах, урамшууллын асуудлыг шийдвэрлэх;

5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох хууль, хяналтын байгууллагуудтай нягт хамтарч ажиллах;

6. Нийгмийн хэв журам зөрчих явдлыг бууруулах зорилгоор хүүхэд, залуучууд, иргэдийн соёл, амьдралын ухаалаг зөв хэв маягийн талаарх мэдээллийг холбогдох байгууллагуудтай хамтран хийж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах ажлыг зохион байгуулах.

### 3. Багануур дүүргийн прокурорын газарт

1. Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг жил бүр судалж, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд танилцуулж холбогдох шийдвэр гаргуулж байх;

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх;

3. Тус Прокурорын газраас санаачилсан “Архигүй Багануур” хөтөлбөрийг баталж, авч хэрэгжүүлэх, архи, тамхинаас хамаарал бүхий хүмүүсийн сэтгэлгээнд өөрчлөлт оруулах сургалтыг үе шаттай зохион байгуулах.

### 4. Багануур дүүргийн шүүхэд

1. Шүүхээр шийдвэрлэгдэж буй гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг бодитой тодорхойлж, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах.

#### 5. Багануур дүүргийн цагдаагийн хэлтэст:

1. Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг жил бүр судалж, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд танилцуулж холбогдох шийдвэр гаргуулж байх;

2. Хуулийн байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой үе шаттай ажлуудыг зохион байгуулж үр дүнг танилцуулж байх;

3. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд мансууруулах болон ахуйн хэрэглээний хийн газ үнэрлэх, бие биенээ дарамталж дээрэлхэх, гар утас, эд зүйлийг дээрэмдэх, булаах байдал далд хэлбэртэй оршиж байгаад анхаарч сурагчдын эцэг, эхтэй хамтран урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

4. Цагдаагийн алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэх явцад иргэдтэй хүндэтгэлтэй харьцах хуулиар хүлээсэн үүрэг, ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх;

5. “Архи мансуурлын эсрэг ассоциаци” төрийн бус байгууллалатай хамтран архинаас хамааралтай иргэдэд яриа, таниулга хийх ажлыг төр захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

6. Аж ахуйн нэгж, байгууллагуудыг “Нийтийн эргүүл”-д татан оролцуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох.

#### 6. Багануур дүүргийн онцгой байдлын албанд

1. Багануур дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг хангах, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.

#### 7. Багануур дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтэст

1. Багануур дүүргийн аюулгүй байдлыг хангах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх.

#### 8. Аж ахуйн нэгж, байгууллагуудад

1. Стандартчилал хэмжил зүйн газраас 2013 онд баталсан “Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер ерөнхий шаардлага MNS 6423:2013 стандартын дагуу шаардлага хангасан камерыг байгууллагадаа байршуулах ажлыг зохион байгуулах;

2. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагууд гэмт хэрэгтэйтэмцэх чиг үүрэг бүхий алба хаагч нарт камерын бичлэгийг ашиглуулах боломжийг хангаж ажиллах;

3. Байгууллагын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг жилд хоёроос доошгүй зохион байгуулж, үр дүнг тооцож байх;

4. Байгууллагын орчинд иргэдэд гэм хор, эрсдэл учруулж болзошгүй хүчин зүйлүүдийг арилгах чиглэлээр тогтмол хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллах;

5. Байгууллагын эргэн тойронд 50м тойрогт гэрэлтүүлэг хийх ажлыг зохион байгуулах;

6. Урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа гаргаж цагдаагийн хэлтэст хүргүүлж хэвших.

#### 9. Хорооны засаг дарга, иргэдэд:

1.Өөрийн болон хөршийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд онцгой анхаарч, тэмдэг тэмдэглэгээжүүлэх арга зүйд суралцах, сонор сэрэмжийг дээшлүүлэх;

2. Аюулгүй орчин бий болгох, амгалан тайван байдлыг хангахад чиглэсэн зохион байгуулалттай нийгмийн сүлжээ, үйл ажиллагаанд идэвхтэй оролцож дэмжих;

3. Гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг боломжтой хэлбэрээр баримтжуулж цагдаагийн байгууллагад мэдээлэх;

4. Бусдад гэм хор учруулах, бусдын аюулгүй, амгалан тайван байдлыг алдагдуулахад хүргэх болон амьдарч буй орчиндоо зөрчил үүсгэх аливаа зан үйл, үйлдлээс татгалзах;

5. Байр, орц, гудамж бүрт ажиллаж байгаа хөршийн хяналтын бүлгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох:

#### 10. Цагдаагийн ерөнхий газар, Улаанбаатар хотын цагдаагийн газарт

1. Цагдаагийн албаны тухай хууль, Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоол, Цагдаагийн байгууллагын шинэчлэлд нийцүүлэн Багануур дүүргийн цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг чадавхжуулж, цагдаагийн орон тоо, хүчийг үе шаттайгаар нэмэгдүүлэх;

2. Багануур дүүргийг дагуул хотын хэмжээнд хөгжүүлэх үйл явцтай уялдуулан Цагдаагийн газар болгон өргөтгөх.

#### 11. Хууль сахиулахын их сургуульд

1. Багануур дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулж, үр дүнгээр практикт зөвлөмж болгох.

### **ХУРАЛД ОРОЛЦОГЧИД**

2016 оны 07 сарын 06

#### **Зохион байгуулагч:**

1. Багануур дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
2. Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс

#### **Хамтран зохион байгуулагч:**

1. Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
2. Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэн

#### **Оролцсон байгууллага:**

1. Улаанбаатар хотын Цагдаагийн газар
2. Багануур дүүргийн Шүүх
3. Багануур дүүргийн Прокурорын газар
4. Багануур дүүргийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба
5. Багануур дүүргийн Онцгой байдлын алба
6. Багануур дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс
7. Төв аймгийн Цагдаагийн газар
8. Хэнтий аймгийн Цагдаагийн газар
9. Баянзүрх дүүргийн Цагдаагийн III хэлтэс
10. Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс
11. Багануур ХК
12. Мон Маг ХХК
13. Багануур Дулааны станц ТӨХК
14. Хороодын засаг дарга, ажлын алба
15. Тахарын 10 дугаар тойрог
16. Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төв
17. Авто жим ОНӨААТҮГ

18. Багануур ус НӨААТҮГ

19. БМХЭХТН

---

## **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

### **Хууль тогтоомж**

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль 1997 он
3. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 2006 он
4. Төсвийн тухай хууль 1993 он
5. Цагдаагийн албаны тухай хууль 2013 он
6. Прокурорын байгууллагын тухай хууль 2002 он
7. Шүүхийн багц хууль 2012 он
8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2002 он
9. Хилийн боомтын тухай хууль 2013 он
10. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албаны дүрэм 2014 он
11. Татварын багц хууль 2008 он
12. Гаалийн тухай хууль 2008 он
13. Төмөр замын тээврийн тухай хууль 2007 он
14. Тамхины хяналтын тухай хууль 2005 он
15. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль 2000 он
16. Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995 он
17. Авто тээврийн тухай хууль 1999 он
18. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль 2015 он

### **Бодлогын баримт бичиг**

19. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө
20. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө
21. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2012-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө
22. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
23. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө
24. УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталгдсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртлэх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”
25. “Эрүүл аюулгүй байдлын индекс тооцох аргачлал”, /нэмж сайжруулсан 2 дах хэвлэлт/, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, УБ, 2014

### **Ном бүтээл, эмхэтгэл**

26. Б.Энхболд, “Хотжилт ба гэмт явдал”, УБ, 2011 он
27. Б.Гүнбилэг, Г.Оюунболд, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба хот төлөвлөлтийн гарын авлага”, УБ, 2013
28. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хууль сахиулахын их сургууль хамтран 2013 оны 11 дүгээр сарын 17-нд зохион байгуулсан “Нийслэл хотын аюулгүй байдлыг хангахад нийслэлийн төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа” зөвлөгөөний илтгэлийн эмхэтгэл, 2014
29. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хууль сахиулахын их сургууль хамтран 2014 оны 6 дугаар сард зохион байгуулсан “Нийслэл хотын аюулгүй байдлыг хангахад иргэдийн үүрэг оролцоо” зөвлөгөөний илтгэлийн эмхэтгэл, 2014
30. ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төв, “Монгол Улсад 2015 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал”, УБ, 2016

31. ЦЕГ-ын Мэдээлэл, нэгтгэн боловсруулах газар /Мэдээлэл, судалгааны төв/, Гэмт хэргийн статистикийн мэдээлэл, 1991-2015, 2016 оны эхний 10 сарын байдлаар,
  32. ЦЕГ-ын ЗЦГ, Ц.Эрдэнэчимэг, “Монгол Улс дахь Зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт”, УБ, 2012, 2015, 2016
- Судалгааны тайлан, өгүүлэл, илтгэл**
33. МУИС-ийн Социологийн тэнхим, “Хот суурин газар дахь гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал”, УБ, 2006
  34. Сонгинохайрхан дүүргийн ГХУСАЗСЗ, Их засаг олон улсын их сургуулийн төгсөгчдийн холбоо, “Сонгинохайрхан дүүргийн гэмт хэргийн нөхцөл байдал ба иргэдийн санаа бодол”, УБ, 2011
  35. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Б.Одонгэрэл, Б.Доржпагма, “Баянгол дүүрэгт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх нь” бодлогын судалгаа, УБ, 2013
  36. Б.Мөнхдорж, “Нийслэл хот дахь гэмт явдлын чиг хандлага, урьдчилан сэргийлэх арга зам”, УБ 2013 он. Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл, 2013 оны №04
  37. Монголын Криминологичдын Холбоо, “Сонгинохайрхан дүүргийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл” сэдэвт криминологийн судалгааны тайлан, УБ, 2014
  38. Баянзүрх дүүргийн Статистикийн хэлтэс, “Баянзүрх дүүргийн гэмт хэргийн танилцуулга”, УБ, 2014
  39. Чингэлтэй дүүргийн Статистикийн хэлтэс, “Дүүргийн оршин суугчдын аюулгүй байдал” судалгаа, УБ, 2013, 2015
  40. Хан-Уул дүүргийн Статистикийн хэлтэс, “Хан-Уул дүүргийн гэмт хэрэг, аюулгүй байдал” судалгаа, УБ, 2012, 2016
  41. Чингэлтэй дүүргийн Статистикийн хэлтэс, “Чингэлтэй дүүргийн гэмт хэрэг, аюулгүй байдал” судалгаа, УБ, 2016
- Интернэт сайт**
43. Монголын Криминологичдын Холбоо, [www.criminology.mn](http://www.criminology.mn)
  44. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, [www.ulaanbaatar.mn](http://www.ulaanbaatar.mn)
  45. Цагдаагийн ерөнхий газар, [www.police.gov.mn](http://www.police.gov.mn)
  46. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
  47. Үндэсний статистикийн хороо, [www.nso.mn](http://www.nso.mn)
  48. Нийслэлийн Статистикийн газар, [www.ubstat.mn](http://www.ubstat.mn)